



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9-168
<hr/>	
<i>1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/</i>	10-11
<i>2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/</i>	11-12
<i>3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	13-49
<i>4.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/</i>	49-168

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
12 дугаар сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 58 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, Т.Доржханд, Г.Лувсанжамц, Ч.Номин, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Ж.Галбадрах, Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, А.Ганбаатар, Д.Ганбат, С.Лүндэг;

Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Баттулга;

Хоцорсон: Н.Алтаншагай -1 цаг 20 минут, С.Амарсайхан -08 минут, Ч.Анар -01 минут, Т.Аубакир -02 минут, Х.Баасанжаргал -11 минут, Ц.Баатархүү -01 минут, Б.Батбаатар -11 минут, Д.Батлут -02 минут, Х.Болормаа -02 минут, Х.Булгантуяа -03 минут, П.Ганзориг -01 минут, Д.Ганмаа -03 минут, М.Ганхүлэг -11 минут, Ц.Даваасүрэн -01 минут, Б.Дэлгэрсайхан -09 минут, Б.Жавхлан -02 минут, Х.Жангабыл -01 минут, Б.Жаргалан -11 минут, Д.Жаргалсайхан -07 минут, Б.Заяабал -11 минут, Ч.Лодойсамбуу -01 минут, Н.Наранбаатар -11 минут, П.Наранбаяр -01 минут, Н.Номтойбаяр -02 минут, Д.Пүрэвдаваа -11 минут, Ц.Туваан -1 цаг 40 минут, Г.Тэмүүлэн -02 минут, А.Ундраа -01 минут, Н.Учрал -04 минут, Да.Цогтбаатар -08 минут, Л.Энх-Амгалан -11 минут, Б.Энхбаяр -01 минут, Ж.Энхбаяр -11 минут, Д.Энхтүвшин -11 минут.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./10:00/

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга

бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

**Д.Амарбаясгалан:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	81
Татгалзсан:	9
Бүгд:	90

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Баярбаатар, Б.Бейсен, Ж.Баярмаа, Х.Болормаа, Ж.Баясгалан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны

төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

**Д.Амарбаясгалан:** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 86  
Татгалзсан: 7  
Бүгд: 93  
92.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Хэрлэн, Т.Аубакир, Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

*Төсвийн байнгын хороо хуралдах тул хуралдаан 10 цаг 09 минутад завсарлав.*

*Хуралдаан 14 цаг 16 минутаас үргэлжлэв.*

**Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны

ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, О.Цогтгэрэл, С.Эрдэнэбат, П.Сайнзориг, Г.Дамдинням, Х.Ганхуяг, М.Мандхай, Э.Болормаа, Д.Үүрийнтуяа, Ж.Баярмаа, Г.Очирбат, Д.Ганмаа, Да.Цогтбаатар, Б.Заяабал, Б.Батбаатар, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Д.Ганмаа, Ж.Баярмаа нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	40
Бүгд:	106

62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад



харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Л.Мөнхцацрал, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хяналт, үнэлгээ, аудитын газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, 20 минутын хот Үндэсний хорооны ахлах шинжээч С.Баярбаатар, Ц.Батгэрэл, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандын Ажлын албаны дарга З.Лхагвадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан товлосон асуудлыг хэлэлцэж дуустал хуралдааны цагийг сунгав./17:00/

Илтгэл болон төрийн аудитын төв байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Б.Пүрэвдорж, Б.Найдалаа, Г.Ганбаатар, Ж.Золжаргал, О.Цогтгэрэл, Ж.Алдаржавхлан, С.Эрдэнэбат, П.Сайнзориг, Р.Батболд, Б.Пунсалмаа, Г.Дамдинням, С.Зулпхар, Э.Батшугар, П.Мөнхтулга, О.Батнайрамдал, Б.Түвшин, Ж.Батжаргал, Ө.Шижир, О.Номинчимэг, Л.Энхнасан, Л.Соронзонболд, М.Мандхай, Ц.Идэрбат, Д.Бум-Очир, Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл, Б.Уянга, Х.Жангабыл, Ч.Лодойсамбуу, Т.Аубакир, Д.Батлут, Д.Жаргалсайхан, М.Ганхүлэг, Д.Энхтүвшин, Н.Наранбаатар, Х.Баасанжаргал, Б.Жаргалан, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 18 цаг 45 минутаас 19 цаг 30 минутад хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, П.Сайнзориг, П.Мөнхтулга, О.Номинчимэг, Ж.Баярмаа, Т.Аубакир, Х.Булгантуяа нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 32  
Бүгд: 104  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.



*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Хэрлэн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гишүүдийн олонх дэмжсэн тул хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 23 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 9 цаг 19 минут үргэлжилж, 126 гишүүнээс 106 гишүүн хүрэлцэн ирж, 84.1 хувийн ирцтэйгээр 23 цаг 24 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
09 цаг 58 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Нийт 65 гишүүн ирж ирц 51.6 хувь болсон байна. 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Гуравдугаарт, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг хийсний дараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүл мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд хуваарилсан. Хэлэлцэх асуудалдаа оръё.

***Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/***

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хурал бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Санал хураалт. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Минийх бас улаан асчихлаа. 88 гишүүн санал хураалтад оролцож, 72 гишүүн 81.8 хувиар санал дэмжигдлээ.

Би бас саналаа өгч чадсангүй, протоколд дэмжсэнээр тэмдэглүүлье. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал гишүүнд микрофон өгье. Микрофон дээр протокол тэмдэглүүлэх нь зүйтэй дэмжсэнээр. Ням-Осорын Учрал гишүүний микрофоныг өгье.

**Н.Учрал:** Энэ төхөөрөмж ажилласангүй. Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

**Д.Амарбаясгалан:** Баярмагнайн Баярбаатар гишүүн микрофон өгье.

**Б.Баярбаатар:** Өөрөө, өөрийн буруугаас болоод санал хураалтаасаа хоцорчихлоо. Протоколд дэмжсэнээр тэмдэглүүлье.

**Д.Амарбаясгалан:** Бейсен гишүүн. Даралгүй байж байгаарай. Бейсен гишүүний микрофоныг өгье. Ирцэд.

**Б.Бейсен:** Энэ төхөөрөмж ерөөсөө ажиллахгүй байна. Уг нь дэмжсэн.

**Д.Амарбаясгалан:** Жудагийн Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж өгч чадсангүй, хожигдсон.

**Д.Амарбаясгалан:** Хөххүүгийн Болормаа гишүүн.

**Х.Болормаа:** Өөрийн буруутайгаас микрофон, төхөөрөмж ажилласангүй.

**Д.Амарбаясгалан:** Баясгалан гишүүн.

**Ж.Баясгалан:** Төхөөрөмжийн буруугаас болоод ирцэд орж, юу саналаа өгч чадсангүй.

**Д.Амарбаясгалан:** Батболд гишүүн. Батболд гишүүний микрофоныг өгье.

**Р.Батболд:** Төхөөрөмж гацчихлаа, дэмжсэнээр бүртгэж болох уу.

**Д.Амарбаясгалан:** Болсон уу? Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Хоцроод төхөөрөмжид юу орж чадсангүй.

**Д.Амарбаясгалан:** Гишүүдийг дэмжиж санал өгснөөр протоколд тэмдэглэе. Нэмж тэмдэглэе. Ингээд 81.8 хувиар санал дэмжигдсэн байгаа. Нэмээд гишүүдийн гаргасан саналаар протоколд тэмдэглэе. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.05 цаг

***Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/***

Дараачийн асуудалд оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэхийг, хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-

ний өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Одоо хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 81 гишүүн буюу 87.1 хувиар санал дэмжигдлээ. Отгоншарын Батнайрамдал гишүүнд микрофон өгье.

**О.Батнайрамдал:** Төхөөрөмж ажилласангүй. Тэгээд дэмжихээр санал өгсөн болно, протокол тэмдэглүүлье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Б.Хэрлэн гишүүн микрофон өгье.

**Б.Хэрлэн:** Дэмжсэнээр протоколд тэмдэглэж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Тилеуханы Аубакир гишүүн микрофон өгье.

**Т.Аубакир:** Санал өгч амжсангүй даргаа, дэмжиж байгаагаар авч өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** 3 гишүүн, Б.Бейсен гишүүн микрофон өгье.

**Б.Бейсен:** Энэ миний төхөөрөмж ерөөсөө ажиллахгүй байна. Техникч дуудсан. Би дэмжсэнээр тэмдэглүүлье.

**Д.Амарбаясгалан:** Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн микрофон өгье.

**Д.Үүрийнтуяа:** Хурууны хээгээ уншуулж амжсангүй. Дэмжсэнээр протоколд тусгаж өгөхийг хүсье.

**Д.Амарбаясгалан:** 4 гишүүн нэмж протоколд тэмдэглүүлэх хүсэлт гаргалаа. Хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.09 цаг

Одоо Төсвийн байнгын хороо хуралдаж төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл хэлэлцэх тул чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулна.

Улс төрийн намын бүлгүүд 10 цаг 30 минутаас өөрсдийн танхимдаа хуралдана. 12.00 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Түр завсарлуулъя.

*2024 оны 12 дугаар сарын 05, Пүрэв гараг,  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 16 минут.*

## **ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Амарбаясгалан:** Хэлэлцэх асуудалд орьё. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаа эхлүүлъя.

***Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Гантөмөр:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах нь зүйтэй гэж, манай гишүүд суугаад хэлж байгаа үгэнд анхаарах уу? Учралаа суугаарай. Төсвийн хуульд бүхэлд нь хориг тавьж, Улсын Их Хурал уг хоригийг хүлээн авч хуулийг хүчингүй болгосон. Төсвийг алдагдалгүй батлах хүрээнд төсвийн зарлагыг 2,3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2,4 хувьтай тэнцэх дүнгээр бууруулах, төсвийн зарлагыг, Даваасүрэн даргаа, бууруулсантай холбогдуулан төсвийн орлогыг 395 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0,4 хувьтай тэнцэх дүнгээр бууруулах шаардлага үүссэн. Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2025-аас 2027 онд алдагдалгүй байхаар, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2025 онд ДНБ-ий 3,5 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай, 2026-аас 2027 онд ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар тооцож тусгалаа. Инфляц 2023 оны эцэст 7,9 хувь байсан бол энэ оны 10 дугаар сарын байдлаар 7 хувьтай байна. Бид төсвийн хүрээний мэдэгдэлд 2025 оны жилийн дундаж инфляцыг 7,5 хувь гэж тооцож байсан бол төсвийн зарлагыг 2,3 их наяд төгрөгөөр бууруулж байгаатай уялдуулан 2025 оны дундаж инфляцыг өмнөх оны төсөөллөөс 0,3 нэгж хувиар бууруулж, 7,2 хувь байхаар хуулийн төсөлд тусгалаа. Төсвийн зардал буурснаар эрэлтээс үүдэлтэй инфляц өсөх дарамт буурч, мөнгөний бодлогын орон зай нэмэгдэхээр байгаа хэдий ч геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байгааг энд тэмдэглэн хэлье.



Улсын Их Хурлаас баталсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 2025 оны эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэх зорилт тавьсан учир төсвийн хүрээний мэдэгдэл дэх ДНБ-ий төсөөллийг өөрчлөхгүй хэвээр хадгалсан болно. Төсвийн зардлыг бууруулж байгаа нь зарим салбаруудын өсөлтийг хязгаарлах хэдий ч бид дараах хүчин зүйлсийн нөлөөгөөр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан 8 хувийн эдийн засгийн өсөлтийг хангах бүрэн боломжтой гэж үзэж байна. Энэ онд үйлдвэрлэлийн зориулалттай машин тоног төхөөрөмж, ачаа, тээврийн хэрэгслийн импорт өмнөх оноос 34 хувиар өсөж, 2,9 тэрбум ам.доллар буюу нэрлэсэн ДНБ-ий 15 орчим хувьд хүрсэн нь цаашдын эдийн засгийн потенциал хүчин чадлыг нэмэгдүүлэхээр байна. Экспортын хувьд энэ онд 78 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн бөгөөд 2024 оны 12 сарын 3-ны өдрийн байдлаар нүүрсний экспорт 78 сая тоннд хүрээд байна.

Цаашид экспорт энэ хурдаар он дуустал үргэлжлэхэд нүүрсний экспорт 2024-өөс, 24 онд 83-аас 84 сая тоннд хүрч төлөвлөгөөнөөс 6-аас 7 хувиар давж биелэхээр байна. Энхбаяр сайдаа суухгүй болохоор таны ярьж байгаа надад сонсогдоод. Ирэх 2025 онд бид 83 сая тонн нүүрс экспортлох зорилт тавьсан бөгөөд төлөвлөгөөг мөн давуулан биелүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байгаа. Мөн зэсийн баяжмалын экспорт өнөөдрийн байдлаар өмнөх оны мөн үеэс 9 орчим хувиар өндөр байна. Уул уурхайн салбар энэ оны эхний 3 улирлын байдлаар 11,4 хувиар өсөөд байгаа гэдгийг тэмдэглэн хэлье. Энэ онд уул уурхайн салбарт ашиглагддаг хүнд машин механизмуудын импорт өмнөх оноос 2 дахин, ачааны тээврийн хэрэгсэл 85 хувиар тус тус өссөн зэрэг нөлөөгөөр 2025 онд уул уурхай болон тээврийн салбарын өсөлт өндөр байхаар байгаа юм.

Худалдаа хөгжлийн салбар, худалдаа, үйлчилгээний салбар 2024 оны эхний 3 улиралд 8,8 хувиар өслөө. Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-ийн тоо 6,2 хувиар, хөдөлмөр эрхлэлт 13 хувиар, зээл олголт 47 хувиар тус тус өссөн нь ирэх онд үйлчилгээний салбарын өсөлт тогтвортой хадгалагдах нөхцөлийг бүрдүүлж байна. Эрчим хүчний салбар энэ оны эхний 3 улиралд 5,2 хувиар өслөө. Тус салбарт хэрэгжиж байгаа Бөөрөлжүүт, Чойбалсангийн станц, Багануурын батарей хуримтлуурын бүтээн байгуулалтууд нийт эдийн засгийн потенциал хүчин чадлыг дэмжинэ гэж тооцож байна.

Мөн эрчим хүчний либералчлалыг цогцоор нь алгуурлалгүй хэрэгжүүлснээр тус салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэх үндэс болно. Хөдөө аж ахуйн салбар байгаль цаг уурын нөлөөгөөр 2023 онд 8,9 хувиар, 2024 оны эхний 3 улиралд 25 хувиар дараалан унасан бөгөөд тус салбар 2025 оноос сэргэж эхлэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл 2023 он болон 2024 онд эдийн засгийн өсөлтийг доош татаж байсан хөдөө аж ахуйн салбар ирэх оноос эдийн засгийн өсөлтийг дэмжиж эхэлнэ гэж тооцож байна. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног, төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлсний үр дүнд хүнсний үйлдвэрлэлийн зориулалттай тоног, төхөөрөмжийн импорт энэ онд 56 хувиар нэмэгдлээ. Тоног, төхөөрөмжийн импортын өсөлт болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт нь цаашид боловсруулах салбарын өсөлтийг дэмжихээр байна. Эдийн засгийн бодит салбарууд дээр бий болж байгаа дээрх боломжуудыг 2025 онд бүрэн ашиглаж, эдийн засгийн өсөлтийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан 8 хувьд хүргэх зорилтыг хангах бүрэн боломжтой гэж үзэж байгааг энд дахин тэмдэглэн хэлье.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд танилцуулж байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг бүрэн хангасан болно. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Дамдинням:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл болон бусад үзүүлэлтүүдийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгахаар заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг,

хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Асуулт, үг тусдаа шүү. Ингээд нийт 33 гишүүнээр тасаллаа. Нарантуяа-Нара гишүүн хурууныхаа хээг уншуулаарай, төхөөрөмж таниагүй болохоор суудлын дугаар гараад, нэр гарахгүй байна дэлгэц дээр. Төсвийн хүрээ. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

**М.Нарантуяа-Нара:** Сайн байцаана уу. Хамгийн сүүлд дарсан чинь хамгийн түрүүнд орчихлоо. Аз юм болов уу даа. Тэгэхээр ямар ч байсан юу хийж байна төсвийг нэлээн танаж орж ирсэн сайн үзүүлэлт байгаа болов чиг нөгөө талаар зарим нэгэн хуулиудаа хүртэл хүчингүй болгож байгаад тэр төсвийг хасаж байгаа байдлыг эмзэглэж хүлээж авч байна. Ер нь цаашдаа яах юм бэ өмнөх, өмнөх Улсын Их Хурлынхаа баталсан хуулиудыг цуцлаад, төсөв хүрэлцэхгүй байна гэдэг байдлаар ингээд яваад байх юм уу 1 дүгээрт?

2 дугаарт ер нь Монголчууд хүүхдэдээ яаж ханддагийг энэ Улсын Их Хуралд, энэ Засгийн газраас энэ танаж байгаа энэ хэсгээс нь ч гэсэн харахад маш ойлгомжтой харагдаж байгаа. Хэрвээ ахмад настны ямар нэгэн зүйлээс хассан бол жагсаал цуглаан болно. Ээжүүдээс хассан бол жагсаал цуглаан болно. Хүүхдүүд хэзээ ч өөрсдийнхөө эрхийн төлөө өөрсдийнхөө эрхийг хамгаалж үг хэлж чаддаггүй учраас тэр байдлыг нь ашиглаад төр засагт хүртэл ингэж хандаж байгаад нь маш эмзэглэж байна. Дээрээс нь ер нь бид бүхэн энэ соёлын асуудал бол бид бүхэн чинь ер нь сүүлийн үед соёл гэдэг зүйлийг зөвхөн урлаг, уран сайхнаар төсөөлдөг болоод байгаад их эмзэглэж байна. Тэгээд энэ соёлын ваучер энэ бол маш том шалтгаанд суурилсан, маш том судалгаа. Тэгээд дээрээс нь маш том эмгэнэлтэй үзүүлэлт, статистик судалгаа дээр суурилж орж ирсэн ийм хөтөлбөр байсан.

Харамсалтай нь ингээд хэн нэгэн хүмүүс нэг сайхан буруу сэвснээр улбаалаад олон нийтэд маш сайн өрнөлийг авч чадаад бүрэн хасаж байгаад нь эмзэглэж байна. Тэгээд ер нь цаашдаа залуучуудын салбарт ялангуяа 16-аас 18 насны хүүхэд залуучууд дээр манай улс, төр засаг ямар бодлого баримтлах юм бол? Соёлын яам энэ залуучуудын хөтөлбөр нь хасагдчихаар яг энэ насны залуучууд дээр өөр хийж бүтээн байгуулах, хөгжүүлж дэвшүүлэх ямар бодлого үйлдэж байгаа юм бол гэдэг дээр асуулт асуумаар байна.

Тэгээд дээрээс нь бид ингээд хэдийгээр 25 оны төсвийг хэлэлцэж байгаа ч гэсэн 24 оныхоо төсөв дээр нэгэн тодруулах зүйлүүд байна. Энэ ЭМД-ын сангийн энэ Чингис хаан банк, Капитал банканд хуваарилагдаад алга болчихоод байгаа энэ мөнгө чинь ер нь тэгээд яг яах юм бэ? Хэн хариуцлага хүлээх юм бэ? Банканд хүүлүүлсэн хүн нь хэн юм бэ, хэн хариуцлага хүлээх юм бэ? Банк нь хохирлыг барагдуулах юм уу эсхүл иргэд өөрсдийнхөө энэ байгаа юмнаасаа төлөх юм уу эсхүл энэ банканд нь байршуулсан улс төрчид нь төлж барагдуулах юм уу? Ийм асуудлыг үнэхээр шийдмээр байна.

Дээрээс нь яг микрофон асчихсан байгаа дээр нэг юм асуумаар байна. Энэ Эрүүл мэндийн яамны сайд ер нь сайд болсон цагаасаа хойш 7 том эмнэлгийн ерөнхий удирдлагыг солилоо. Тэр дундаа Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал эмэгтэй гишүүд бид очиж үйл ажиллагаатай нь танилцсан. Энэ том засвар үйлчилгээ, их засварын ажлыг маш сайн амжилттай зохион байгуулж

байсан энэ сайн удирдлагыг яг энэ өвчлөл, энэ эмнэлгийн ачаалал, тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүдийн өвчлөлийн хамгийн оргил үед нь энэ удирдлагыг халдаг нь яг ямар учиртай юм бэ? Тэгээд энэ түр орлон гүйцэтгэгчээр тавиад байдаг чинь ямар учиртай юм бэ? Ер нь захаасаа энэ эмнэлгийн ажилтан, эмч нар, сувилагч чинь энэ ямар ч салбарын бус, ямар ч салбараа мэдэхгүй ийм хүмүүс тавиад байгаад маш их эсэргүүцэлтэй тулгарч та байгаа юм байна лээ шүү.

Одоо тэгээд энэ хэрвээ эрүүл мэндийн ажилчид тэртээ тэргүй хүнд ачаалал, цалин багатай энэ нөхцөлд ажилладаг хүмүүс удирдлагатайгаа нийцэхгүй байдлаар ажил хаялт явагдаад эхэлбэл энэ хүүхэд нялхсын өвчлөлийг та яаж хариуцах вэ? Тэгээд энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хэдүүлээ өнөөдөр Төсвийн хүрээ, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн талаар эхлээд хэлэлцэж байгаа. Энэ асуудлаа хэлэлцэж дууссаны дараа шинээр өргөн мэдүүлсэн төсвийн 1 дүгээр хэлэлцүүлгийг хийхээр байгаа. Тэгэхээр гишүүд маань сая төсөв гэж андуураад нэрсээ нэлээн өгчих шиг боллоо. Энэ 2 асуудлыг мэдээж гишүүн болгон асуултаа асууж, хариулт өгөх ийм асуудалтай явж байгаа. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирсэн дүгнэлт байж байгаа, энд гишүүдэд хэвлэгдээд тараачихсан. Энэ дүгнэлттэйгээ холбогдуулаад үндсэн асуулт, хариулт явна. Бид эхнээсээ цэгцтэй Дэгийн тухай хуулийнхаа хүрээнд, яг хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбогдуулаад асуултаа асуугаад, хариултаа хариулаад явах нь зүйтэй гэж бодож байна.

Бидэнд энэ дахиж өргөн баригдсан төсөв дээр нэлээдгүй хариуцлагатай хандах, түүний урьдчилаад энэ төсвийн хүрээ, төсвийн төсөөлөлтэй холбоотой асуудал дээр энэ Тогтвортой байдлын зөвлөлөөс гарсан дүгнэлттэй холбогдуулаад асуугаад явах нь зөв байх гэж ингэж бодож байна. Гишүүдээс дахиж нэрээ өгье гэсэн санал гарч байна. Гишүүд тэгэх юм уу? Тэгвэл энэ ирсэн нэрийг цуцлаад, техникийн албаныхан энэ ирсэн нэрийг цуцлаадахъя. 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулахтай холбоотой төсөл өргөн баригч болон Байнгын хорооноос асуух асуулттай гишүүд нэрсээ өгье? Ялгаагүй юм биш үү. 14 гишүүн асуулт асуухаар нэр ирлээ. Ганмаа гишүүнийг нэмье. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** Төсвийн хүрээ дээрх тоонууд байна. 33,5 их наядын орлоготой, 33,5 их наядын зардалтай ийм төсөв байна. Төсвийн хүрээн дээр тавигджээ 25 онд. 33,5 их наядын орлогын, орлогыг харахаар эндээс 31,5 их наяд нь татварын орлогоор гэж байгаа буюу 95 хувь нь Монгол Улсын ирэх жилийн төсвийн орлогын 95 хувийг татварын орлогоор бүрдүүлэх нь. Тэгэхээр энэ үндсэндээ тийм асар их тийм улс орны хэмжээнд эдийн засгийн хэмжээнд татварын ачаалал ААН-үүдээс, иргэдээс авч байгаа татварын хэмжээ л ийм их байгааг харуулж байгаа юм.

Нөгөө талд нь татварын бус орлого гэдэгт юу байх ёстой вэ гэхээр энд чинь төрийн өмчит ААН, төрийн өмчит ААН-үүдийн ноогдол ашиг, эндээс гарах ёстой тэр хувьчлалын болоод олон нийтийнх болгосных энэ бусад орлогууд гэдэг зүйлүүд байх ёстой. Тэгэхээр эндээс асуулт нь энэ татварын ачааллыг төсвийн орлогод эзэлж байгаа 95 хувийг татвараар бүрдүүлнэ Монгол Улсын иргэн, ААН-

ээс татвараар бүрдүүлнэ гэж байгаа энэ өндөр татварын ачаалал дээр нэг тайлбар өгөөч.

Нөгөө талд нь татварын бус орлого бага байгаагийн нөгөө талд ер нь ирэх жилд ямарваа нэгэн төрийн өмчит ААН-үүдээс олох орлого нэмэгдүүлэх чиглэлд ажил хийгдэхгүй юу? Төрийн өмчит ААН-үүдийн хувьчлал гэдэг зүйл ирэх онд байхгүй юу? Төрийн өмчит ААН-үүдийг олон нийтийнх болгох гэдэг дээр ямар төсөв төлөвлөгөөг төсөөлөл дээрээ ер нь харж байгаа юм бэ? Энэ чиглэлд ерөөсөө ажил хийгдэхгүй. ТӨК-ууд энэ чигээрээ байна, улам том болно. Тэгэхдээ ноогдол ашиг өгдөггүй, улам ашиггүй ажиллана. Бусад ААН, иргэдээс 95 хувийг нь, бараг 100 хувийн төсвийн татварын орлогоор улсын төсөв цалинжина, улсын төсвийг санхүүжүүлнэ гэдэг ийм дүр төрх байна. Энэ дээр нэг тодорхой хариултуудыг эхлээд авмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсэг Лувсаннъямын Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Энэ татварын орлогын тооцоолол ТӨК дээрээ хийхгүйгээр төрийн, хувийн хэвшил дангаараа хийж байгаа зүйл биш л дээ. Энэ ТӨК-ууд Эрдэнэт улсын үйлдвэрийн газар бол нэлээн том татвар төлнө. Хамгийн том татварын орлого бүрдүүлж байгаа айл бол Эрдэнэс тавантолгой компани байгаа. Тэгээд энэ улсын өмчит, төрийн өмчит байгууллагууд чинь хамгийн том л татварыг бүрдүүлж байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээр эргэлзэх хэрэггүй. Татварын орлого яг ТӨК-удаасаа хамгийн өндөр бүрдүүлэлттэй байгаа. Зүгээр энэ дээр манай гишүүд эмзэглээд байгаа юм. Явал цаашдаа ТӨК-ийнхаа оролцоог багасгаад, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог томруулах тухай уг нь өнгөрсөн төсвийн хүрээний мэдэгдлийн, төсвийн хүрээгээ өнгөрсөн удаа ярилцахад энэ тухай тойрч ярьсан.

Тийм учраас тэр хүрээндээ бид улсын хөгжлийн төлөвлөгөөнийхөө үндсэн чиглэлд улсын үйлдвэрийн газруудын үр ашигтай байдлын тооцооллыг богино хугацаанд хийгээд, хамгийн ашигтай компаниудаа цаашаа илүү эрчимжүүлэх, зардлыг нь бууруулах, өгөөжийг нь нэмэгдүүлэх, дээр нь олон нийтийн оролцоо, олон нийтийн хяналтыг бий болгох гэдэг зүйлийг хийж байгаа. Нөгөө талдаа ашиггүй байгаа компаниудыг цаашдаа үйл ажиллагааг нь зогсоох, хувьчилна гэхээр хүмүүс буруу ойлгоод байдаг. Төрийн өмчийг хэн нэгэн хулгайгаар худалдаж авах гэж байгаа юм байна гэж. Үнэхээр ашиггүй газрыг хэн нэгэн хувийн өмчтэй компани аваад, тэрийг ашигтай ажиллуулна гэсэн зүйл байхгүй юм билээ. Тэгэхээр Засгийн газар дээр энэ төрийн өмчтэй компаниудынхаа үйл ажиллагааг эрчимжүүлэх, менежментийг сайжруулах ажил хийгдэж байгаа шүү Цогтгэрэл гишүүнээ.

Удахгүй энэ тухай танилцуулна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ч байгаа, жилийн хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэлд ч гэсэн энэ тухайд байгаа. Жишээлбэл Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай өнгөрсөн долоо хоногт би очиж танилцсан. Энэ хүрээнд юу харагдаж байна вэ гэхээр Эрдэнэт үйлдвэр хиймэл оюун ухаанаар худалдан авалтаа хийж эхэлж байгаа. 1 жил худалдан авалтыг хийх хиймэл оюун ухааныг хөгжүүлсэн, зардал гаргасан юм байна лээ. Энэ ажлыг зогсоомооргүй байгаа юм. Улам илүү эрчимжүүлэх үүргийг би өгсөн. Засгийн газар дэмжинэ гэдгээ илэрхийлсэн байгаа. Ер нь энэ ТӨК-удын худалдан авалтыг ил тод болгох, энийг хиймэл оюун ухаанаар хийх ажил цаашаагаа Монгол Улсын төсвийн худалдан авалтыг бүхэлд нь хиймэл оюун ухаан



руу шилжүүлэх шилжилтийг энэ 4 жилд бид хийж чадах юм байна лээ. Хамгийн гол нь эрмэлзэл, итгэл хэрэгтэй. Энэ хөгжүүлэлт өөрөө их богино хугацаанд даацтай явна гэдэгт эргэлзэхгүй байгаа.

Нөгөө талдаа Засгийн газраас гарсан шийдвэр энэ өгөөжийг нь сайжруулах чиглэлээр менежерүүдийг энэ ТӨК-уд дээрээ томилох ийм шийдвэр гарсан. Удахгүй ТӨК-удыг эрчимжүүлэх, өгөөжийг нь сайжруулах менежерүүд ч гэсэн томилогдоно. Энэний дараа бид аль компаниудаа олон нийтийн болгох вэ гэдэг зүйлийг хийж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайдын микрофоныг нэмж өгье.

**Л.Гантөмөр:** Эрдэнэт үйлдвэр бол өөрөө олон нийтийн болох, Хөрөнгийн бирж дээр гарах бэлтгэлээ бүрэн хийж байгаа юм байна лээ. Сүүлийн 4 жилийн хугацаанд олон улсын аудит оруулчихсан, дэлхийн хэмжээний аудитын компаниар аудитаа хийлгэдэг. Энэ нь юу вэ гэхээр бирж дээр гарах үндсэн бэлтгэлээ бүрэн хангаж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Харин энэ тооны ингээд өөрчлөлтийг нь харахаар төсвийн орлогод эзэлж байгаа татварын орлогын хэмжээ сүүлийн 4 жилд 5 хувиар нэмэгдчихээд байгаа байхгүй юу. Тэгэхээр 1 дүгээрт нь зөвхөн энэ бүгд чинь төрийн ч бай, хувийн ч бай ААН-үүдийн өрсөлдөх чадварт нөлөөлж байгаа. Татварын ачаалал, татварын бус орлого гэдэгт хамгийн том ноогдол ашиг орох ёстой. Гэтэл ноогдол ашгаас авч байгаа татварын төсөвт оруулж байгаа татварын хэмжээ жилээс жилд буураад 1 дүгээрт нь. 2 дугаарт нь дахиад яг эндээс чинь төрийн өмчит ААН-үүдийн талаар Засгийн газраас баримтлах бодлого олон зүйлүүд явж байгаа байх. Ирэх жилүүдэд ерөөсөө төрийн өмчит энэ ААН-үүдээ цөөлөхгүй нь. Цөөлөхдөө тодорхой хэмжээний орлого эндээс орохгүй нь гэдэг, лав 25 онд тэг гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө талд нь ТӨК-удыг, ААН-үүдийг менежмент, үр ашиг, олон, олон зүйлүүдийг шинэчилнэ гэдэг зорилт Засгийн газар тавиад байдаг. Энэ төсөв дээр ерөөсөө тэр тоо байхгүй байгаа байхгүй юу. Төсөв дээр тэнд ямарваа нэгэн тоо байхгүй. Тэндээс орлого олно.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр дарга, Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь бид энэ Их Хурлын индэр дээрээс айхтар, айхтар мэдэгдэл хийгээд байж болохгүй л дээ. ТӨК-удыг олон нийтийн болгох ажил явагдана. Яг өнөөдөр яагаад тоо орж ирэхгүй байгаа вэ гэхээр энэ менежментийг өөрчлөх тухайд гүн гүнзгий судалгаа хиймээр байгаа. Энийг санааны зоргоор зараад эхлэхээр өмч хувьчлал буюу идэж байна, ууж байна, шамшигдуулж байна гэдэг зүйл гарна. Үнэлгээнүүдийг нь бид эцэслэж байж орох юм. Түүнээс бид ингээд төсөөллөөр, таавраар тэр компанийг олон нийтийн болгоно, эндээс тэдэн төгрөг олно энэ тэр гэж тааварлахад эрт байна. Олон улсын байгууллагуудын судалгаа хийгдэж байгаа шүү гишүүдээ. Бид судалгаа хийгдээд гарсан тодорхой тоог л төсөвт тавина уу гэхээс биш баримжаагаар ирээдүйд нэг ийм орлого болж магадгүй гэдэг байдлаар төсөвт ерөөсөө орж ирэхгүй. Тийм учраас энэ ажил хийгдэж байгаа юм. Хийгдэхгүй юм байна гэж айхтар зарлаж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.



**С.Эрдэнэбат:** Төсвийн хүрээний ирэх энэ жилийн болон ирэх жилүүдийн мэдэгдлээс нэг зүйлийг асуумаар байна. Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ямархуу зарчим бодлогоор явах вэ? Жил болгон зөвхөн нэг инфляцаа хаах төдий байдлаар явах уу? Мөн дээрээс нь зөвхөн цалин хөлсөөрөө амьдарч байгаа хүмүүсээс гадна нэмэлт орлого бусад улс орон хөгжиж байгаа, хөгжингүй орнуудын хувьцааны ноогдол ашиг олгох чиглэлээр ямархуу зүйлүүд туссан бэ?

Энэ хувьчлалын асуудлыг ярьсан дээр нь ярьчихъя гэж бодож байгаа. Хувьчлалын асуудлыг түрүүн Гантөмөр дарга хэллээ. Маш сайн судалж нухацтай үзэхгүй бол энэ компаниуд төрийн өмчийн компаниуд чинь дандаа л нэг болж бүтэхээ байчихсан хүмүүс байдаг зүйл ерөөсөө биш. Ажил хөдөлмөрөө зориулаад, энэ улс орны чухал чиг үүргүүдийг аваад явж байгаа ААНБ-д ажиллаж байгаа олон мянган ажилчид байгаа. Ер нь энэ компанийн засаглалыг нь сайжруулахад зарим улс орнууд тэр дотоодод байгаад байдаг хулгай зэлгий, буруу зөрүү шамшигдуулсан юмыг шийдэхийн тулд ажилчид нь хувьцаа олгосон хүртэл тийм хөтөлбөр хэрэгжүүлж байсан юм байна лээ. Өөрөө өөрсдөө хянаг гэж. Хүн бол хэзээ ч өөрөө өөрөөсөө хулгай хийх юмыг бий болгож чаддаггүй. Тийм учраас энэ чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, нөгөө талаараа ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүс давхар өөрөө бий болгосон зүйлээ хувьцаа ноогдол гэдэг нэмэлт орлогуудтай бий болгох энэ чиглэлээр ямар ажлууд төлөвлөж байгаа вэ?

Сонгогч бид нараас 4 жилийн дараа асууна. 2024 онд байсан миний цалин бодитоор яаж өсөв, миний халаас дахь тэтгэвэр тэтгэмж яаж өсөв гэдэг зүйлийг л биднээс асуух байх 27 оны сүүл, 28 онд. Тийм учраас энэ чиглэлээрээ бид тодорхой энэ төсөв дээрээ, төсвийн бодлогууд дээрээ баримжаатай явахгүй жил болгон зөвхөн инфляцаа нөхөх хэмжээнд л явна гэх юм бол энэ чинь яг бодитоор нэмэгдэж байгаа гэсэн үг биш. Түрүү жилийн авч байсан цалин маань инфляцдаа идэгдэхгүй гэдэг байдлаар явна гэсэн үг. Тэгэхээр 4 жилийн дараа бодитоор хүмүүс биднээс асууна гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ асуултыг асууя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Лувсаньямын Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Эрдэнэбат гишүүнээ гол нь бид эдийн засгаа л босгох хэрэгтэй. Манайх гэдэг айл баян болж байж, хүмүүсийн орлого сайжирна. Энэ бол зарчим. Тэгээд Монгол Улс өнөөдөр ядуу байна гээд намайг хэлэхээр их муу үг хэллээ гээд намайг хараагаад байгаа юм. Бид үнэнээ хэлэх хэрэгтэй. Ядуу бол ядуугаа мэддэг байя гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ улс орныхоо эдийн засгийг босгож ирэх нь бид нарын хувьд амин чухал гээд Хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд яриад байгаа учир нь энэ юм. Улсын эдийн засаг босоод ирвэл хүмүүсийн цалин, тэтгэвэр тэтгэмж нэмэгдэнэ. Энэ бол тухайн улсын эдийн засгаас хамааралтай гэдгийг бүгдээрээ ойлгох хэрэгтэй.

Тийм учраас ойрын үед хэрэгжүүлэх томоохон төслүүдийг хэдүүлээ хамтдаа явуулна. Энэ явж байж Монголын эдийн засаг маш тогтвортой, айдас хүйдэсгүй болох юм. Энэ ажлын ард хэдүүлээ хамтдаа гаръя. Энэ өдрүүдэд бид баталгаатай орлого хүний амьдралд хүрдэг боллоо гэж зарлах өдрүүд ирэх юм гэдгийг хэлмээр байна. Ирэх жилийн хувьд цалин, тэтгэвэр тэтгэмжээ бид 6 хувь нэмэгдүүлж байгаа шүү дээ. Тэгээд түрүүн Нарантуяа-Нара гишүүн хэлсэн. Одоо бид нарын оруулж ирж байгаа хуулийн өөрчлөлтүүдийг янз бүрийн салбарын төлөөлөл болж

хамгаалахаар манай гишүүд зэхэж байгаа. Ер нь аль нэг салбарын төлөөлөл болохын төлөө явахаа манайхан болиорой. Ер нь хуулиар баахан зардал нэмчихсэн, хуулиар баахан халамж нэмчихсэн, хуулиар баахан мөнгө тараадаг болчихсон. Энэ хуулиудаа одоо бид буцаагаад цэгцэлье. Хэдүүлээ цэгцэлье.

Цэгцлэхгүй бол төсвийн урсгал зардал өдрөөс өдөрт нэмэгдэнэ. Тэр урсгал зардлыг дарга нар хэрэглэж байгаа юм шигээр ярьдаг ийм буруу ойлголт улам хавтгайрна. Тийм учраас энэ парламентын онцлог бол илүү зардал болгоныг хассан тэр хуулиудыг баталж өгөөсэй гэж Засгийн газар хүсэж байгаа. Та бүхэн ч энийг хүсэж байгаа. Тийм учраас та бүхэн бол төсвийг дахин боловсруулж, төсвийг алдагдалгүй болгох чиглэлийг Засгийн газарт өгсөн. Яг энэ чиглэлээр бид төслөө боловсруулсан гэдгийг хэлье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төсөөллийг бид ярьж байна. Тэгээд ер нь зүгээр яах вэ тодорхой хэмжээнд баримжаа багцаатай явах үүднээс эдгээр асуудлыг ярьж байгаа. Тэгэхдээ бид асуудлыг зайлшгүй хуульчлах ёстой юу? Ер нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн асуудлыг ч гэсэн дандаа багш, судлаачид гээд байдаг, заримдаа энэ гадаад, дотоод нөхцөл байдлуудыг нэг бодож, шийдвэр гаргах түвшний гэдэг юм уу, өмнө нь Сангийн сайд байсан энэ тэр хүмүүс орох бололцоо энэ тэрийг нь нээмээр юм шиг байгаа юм. Тэгээд хаана хаанаа шийдвэр гаргах юм дээр ойлголцохгүй бол нэг нь нэг ийм тоо яриад байдаг, нөгөөдөх нь тодорхой хэмжээний энэ төсөв гэдэг чинь нэг улс төрийн шийдвэр нэг ийм алхъя гэдэг нэг зориг байгаад байгаа шүү дээ. Энэ дээр нь ингээд буруу зөрүү мэдээ өгснөөс хойш олон зүйлүүд өрнөсөн. Энийг ер нь зүгээр цаашдаа бодъё гэж байгаа юм. Энэ удаад биш.

Тэгээд би яг Цогтгэрэл гишүүний асуудал дээр байгаа юм. Ер нь зүгээр татварын бус орлогыг болж өгвөл уг нь бага баймаар байна. Тэгэхдээ нэгэнт төрд байгаа ААН байгууллагууд байгаа учраас энэ нэмэгдэх ёстой. Энэний харин үр ашгийг нэмэгдүүлмээр байна. Тэгэхээр би Засгийн газраас энэ ТӨК-ийн засаглал, ил тод байдлыг шийдэхэд ямар реформууд хийх гэж байна гэдгийг олон нийтэд хэлээч. Энийг хувийн хэвшил харзнаад байгаа байхгүй юу. Аль хэсгээс ер нь Засгийн газар гэдэг юм уу, төр бизнесийн үйл ажиллагаанаас гарах гээд байна вэ, ямар бодлогыг бариад байна вэ гэдэг зүйлийг эртхэн хэлж байвал энэ уг нь хувийн хэвшлийн бизнесээ тэлэх тэр орон зайн дээр үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлэх юм.

Тэгээд зарим салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлдээ зарим хуулиудыг зайлшгүй өөрчлөх шаардлага байна. Ялангуяа Төр, хувийн хэвшлийн түншлэл. Энэ төсвийн хүрээний мэдэгдлээс бид зарлагаа багасгаж байгаа тохиолдолд хувийн хэвшлийг энэ бүтээн байгуулалт гэдэг юм уу тодорхой энэ үйл ажиллагаа дээр оролцох боломжийг нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар чөдөрлөчихсөн байгаагаа нээж өгмөөр байна. Уул уурхайн хуулиар чөдөрлөчихсөн байгаагаа нээж өгмөөр байна. Жишээ нь энэ газрын ховрыг ч юм уу явуулъя гээд тэгж байна. Нэг талдаа ингээд банк нь банкны үйл ажиллагаагаа хийчихсэн бол энэ ажил гарахгүй л дээ. Банк нь газрын ховор ухах гээд байгаа учраас нэг асуудал байна.

2 дугаарт ер нь газрын ховор ч гэдэг юм уу тодорхой энэ уул уурхайн салбаруудыг орон нутгийн дэмжлэгийг авахын тулд Амнатыг тодорхой хувийг нь ахиу хувийг нь тэнд үлдээх бодлогоосоо гадна, тухайн төсөл хэрэгжүүлэгч компанийн 25 хувийг эхлээд сумын иргэдэд, сумын иргэд нь эндээс авахгүй гэвэл аймгийн иргэдэд, тэгээд Монгол Улсын иргэд ч гэдэг юм уу нэлээн олон нийтийн компани болгох бодлогоор гаргаж ирж байж ингэж цаашдаа энэ уул уурхайн салбарыг төсөвт үзүүлэх нөлөөллийг ч гэсэн нэмэгдүүлмээр байна. Тэгээд энэ дээр жоохон ингээд хурдтай ажиллах бололцоо бодлого бий юү? Ер нь ТӨК-ийн засаглалын асуудал, энэ уул уурхайн салбар дээрх бодлогыг ер нь яаж хийх гээд байна вэ? Бид эдийн засгаа өсгөө гэвэл ерөөсөө энэ 2 дээр ярих гээд байна л даа.

Дээрээс нь төрийн чиг үүргийг мэргэжлийн холбоонд ч гэдэг юм уу, нөгөө чаддаг институт рүү нь шилжүүлэе гээд байдаг. Энийг олон жил ярьсан. Тэгээд нөгөө бусдаар гүйцэтгүүлэх дээр 1,9 их наяд аваад ирсэн чинь пүү паа бүгдийг нь хас гээд ерөөсөө буцаад ингээд төр бүгдийг нь хийе гэдэг рүүгээ л бид хэд явлаа л даа. Тэгээд бид хэд нэг юм ярилаа. Нөгөөдхөө хэрэгжүүлэх гээд төсөв оруулж ирэхээр ингээд попролт нь дэндээд, төрийг ярьж гоё ганган болдог. Тэгээд ерөөсөө энэнээсээ шалтгаалаад мега төслүүд хойшилж байх шиг байна. 28 онд орно гэсэн төслүүд ер нь амжих уу? Гантөмөр сайдаас яг энийг асууя. Нефтийн үйлдвэр орох уу, цэвэрлэх байгууламж орох уу? Эргээд энэ Эрдэнэбүрэнгийн УЦС ажил нь яаж явах юм бэ? Энэний өртөг ингээд л алдагдана. Өнөөдөр гадаадын зээл, тусламжийг ашиглах байдал 660 тэрбумаар танагдаж орж ирэх гэж байна шүү дээ. Тэгээд энэний өртөг өнөөдөр энэ хоосон улс төржилтөөс боллоо. Нефтийн үйлдвэрээ барьж чадахгүй бол 1 тэрбум долларыг жилд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Ер нь бид энэ нефтийн үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС энэ төрийн хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдэх тухайд парламент өөрөө шийдвэрээ гаргах хэрэгтэй юм байна лээ. Тэгэхгүй парламент ингээд 2 өнгөөр ярьдгаа болих ёстой. Нэг болохоор хас гэдэг, нэг болохоор нэм гэдэг. Тийм учраас нэгдсэн бодлогыг яаралтай та бүхэн гаргаач гэж хүсмээр байна. Мега төслүүдийн тухайд эргэлзээгүйгээр явна. Бид гаднын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, бас бус дотоод нөөцөө шавхаад энийгээ бол бид хийнэ. Гол нь бид энэ уул уурхайн салбартаа хэрхэн ажиллах вэ гэдэг хандлагаа их зөв болгох хэрэгтэй. Би таны саналыг дэмжиж байна. Газар газартаа уул уурхайг боомилдог байдлаас болоод Монголын эдийн засаг явахгүй байгаа. Тийм учраас бид хамгийн гол нь энэ хил холболтыг нэн тэргүүнд шийдье гээд байгаа нь өөрөө зах зээлээ бий болгож авъя л гэж байгаа юм. Баталгаатай зах зээлийг эзэлж авъя. Бидэнд Эрээнээс өөр үнэхээр бараа бүтээгдэхүүн тээвэрлэх хэмжээний терминал юмс алга.

Төрийн өмчийн компаниудын шинэчлэлтэй холбоотой асуудал Учрал сайд дээр нэлээн нухацтай хийгдэж байгаа. Төрийн өмчийн хороо гэж хуучин бидний яригддаг байсан газар бол яг Хэрэг эрхлэх газрын харьяанд байгаа. Тэнд олон улсын байгууллагууд болоод дотоодын аудитын компаниудад захиалга өгчихсөн. Эхний дүнгээ бол хүлээгээд авчихсан. Бид нарын олж хараагүй олон зүйлийг хэлж байна лээ. Явал ТӨК-ийн менежмент сайжрах вэ, явал ил тод болох вэ, явал авлига, хээл хахууль алга болох вэ гэдэг энэ зүйл дээр их олон талын зөвлөгөө

өгч байгаа. Энэ зөвлөгөөнүүдийг бид нэг бүрчлэн хэрэгжүүлэхийн төлөө ажиллах ийм бодолтой байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл шинэ тутам байгууллага гэдгийг манай гишүүд сайн ойлгоорой. Засгийн газар анх удаагаа нүүр тулж байгаа шүү. Өмнөх Засгийн газрууд бол ийм тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт энэ тэр байгаагүй шүү. Анх удаагаа бид нүүр тулж байгаа. Тийм учраас бид энэ байгууллагатайгаа ажиллаж сурмаар байгаа юм. Би бол Засгийн газар өөрөө энэ байгууллагадаа мэдээллээ бүрэн хангадаг, энэ байгууллагаас удирдамжаа хууль өргөн барих болохоороо биш бусад үед хөндлөнгийн энэ саналуудыг бид байнга авч явдаг ийм соёл руугаа бид цаашдаа явах ёстой байх. Тэр утгаараа хуулийг өнгөрсөн онд өөрчилж ийм байгууллага хараат бус байгууллага байгуулсан болов уу гэж би бодож байгаа юм. Тэгэхдээ анх удаагаа нүүр тулж байгаа болохоороо ингээд санаа бодол нь зөрдөг, мэдээллээ солилцож амждаггүй, дүгнэлтүүд нь ингээд өөр, өөр бодлогоор гарч ирдэг гэдэг ийм зүйл байгаа.

Нөгөө талдаа таны хэлдгээр Сангийн сайдаар ажиллаж байсан ч юм уу тийм ээ, яг энэ төсөв санхүүг яг дотроос нь орж гардаж байсан, магадгүй Монголын сүүлийн 30 жилийн төсвийг мэддэг хүмүүсээс энэ баг руу оруулах хэрэгтэй юм байна лээ. Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

**П.Сайнзориг:** Тэгээд ямар ч байсан энэ төрийн өмчийн реформ гэдэг юм уу уул уурхайн салбар дээр тодорхой бодлогын өөрчлөлтүүд гарна л гэж ойлголоо. Тэгээд бид хэд ч гэсэн нөгөө ядаж төр нь Ашигт малтмалын тухай хуулийн стратегийн салбар дахь компанийг эзэмшиж байгаа бол дотоодын биржээр 10 хувийн хувьцааг гаргана гэдгээ хэрэгжүүлчихмээр байна. Эрдэнэтээсээ эхлээд. Ер нь зүгээр 10 хувь, 5 хувь бол энэ бол зүгээр дүр эсгэсэн ийм зүйл шүү. Банкны реформ хийж байна гээд ТӨК-уд ч юм уу, банкнууд 5 хувийг гаргачхаад инээд хүрээд байгаа юм. Дор хаяж 25, 34-өөс доошгүй байж энэ үнэт цаасны зах зээлийг дэмжинэ. Тэгээд сая нэг асуудлууд яриад байна. Ирэх жилүүдэд энэ ажил олгогч бизнесийг дэмжих үүднээс энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг эргэж бодооч. Энэ өөрөө эргээд жижиг ажлын байруудыг байхгүй болгоод байдаг юм. Ядаж бид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг цагаар зарлаж сурмаар байна. Энэ хөдөлмөрийн байцаагчид нь ойлгохгүй учраас чи ингээд энэ ажилчиндаа байнгын ажлын байран дээр 660000-ыг өгсөнгүй гээд торгууль.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайд нэмж хариулья.

**Л.Гантөмөр:** Ер нь өнгөрсөн 30 жилийн төсвийг харахад төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ нийт төсөвт эзэлж байгаа жинг та нар харж болох юм байна лээ. Сүүлийн 2 жил 24, 25 онд бид тодорхой тооны ахиц амжилтыг гаргаж байгаа шүү гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

2 дугаарт Сайнзориг гишүүн гаргаад байгаа энэ сайн санаачилгуудаа парламент дээр Их Хурлын даргын захирамжаар 40, 50 ажлын хэсэг гарчихсан байгаа. Энэ ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлээд, ингээд парламент, засаг 2 тусдаа байгууллага юм шигээр та бүхэн битгий ойлгоорой. Засаг, парламент бол парламентын засаглалтай улсад парламент бодлогоо гаргадаг, Засгийн газар гаргасан бодлогыг хэрэгжүүлдэг шүү. Түүнээс биш Засгийн

газраасаа хууль нэхээд суугаад байдаг ийм зүйл ерөөсөө биш. Гаргасан бодлого энд хэлж байгаа 3 минутын үгээр хязгаарлагдахгүй. Бодлого бол Байнгын хорооны тогтоол, шийдвэр, хуулийн төсөл, санал.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууя.

**Г.Дамдинням:** Манайд заримдаа үүсчээд байгаа гажгуудын илрэл манай Тэргүүн Шадар сайдын амнаас гарч байх шиг байна. Парламент, Засгийн газар 2 нэг юм гэж харж, Засаг талаас Их хурал руу хандаж болохгүй. Энэ чинь 3 тусдаа байж байх ёстой хүчний 3 харилцаа нь явж байх ёстой, шүүх засаглал, гүйцэтгэх засаглал, Их Хурал гэж хууль тогтоох засаглал тусдаа л байх ёстой шүү дээ. Тэр тусдаа байр сууриараа л явах ёстой. Тэгээд яах вэ одоо бид алдагдалгүй төсөв гэж орилсоор байгаад тэгээд оруулаад ирлээ. Улсынхаа эдийн засгийг хязгаарласан юм оруулж ирж байгаа шүү дээ. Гайгүй байгаа дээрээ тэлээд авмаар байгаа байхгүй юу уг нь. Тэгээд Засгийг энэ юугаа оруулаад ирэх юм байх даа гэж бодсон. Нэг бага ч гэсэн улсынхаа эдийн засгийг тэлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийнхээ бизнесийг дэмжсэн ийм хөрөнгө оруулалтуудыг тавьсан төсөв оруулж ирэх байх гэж найдаж байсан, тэгээд байсангүй.

Төсвийн хүрээний мэдэгдэл энэ орж ирж байна. Тэгээд энэ улсын хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл 2 чинь тэгээд уялдах уу Засгийн газраа? Улсын хөгжлийнхөө төлөвлөгөөг та нар ийм алдагдалгүй төсвөөр хөгжил рүү тэмүүлсэн хөрөнгө оруулалтгүй төсвөөр биелүүлж чадах уу? Эдийн засгийн өсөлтийг 8 хувиар та нар гаргасан байна лээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энийг боломжгүй л гэж байгаа юм. Төсвийн зарлага багадаа байгаа юм чинь энэ доошоо явна шүү дээ. 25 оны төсөв өмнө нь орж ирж байхдаа 8 хувиар орж ирж байсан. Энэ бол доошоо явах байхгүй юу. Тэгэхээр та нар яах юм бэ, нэг том үзүүлэлт нь төсвийн зарлага шүү дээ Засгийн газрын зарлага. Тэгээд энийг та нар яаж тооцоод 8 хувь өснө гээд байгаа юм бэ? Хэт өөдрөг төсөөлөл юм биш үү?

Дараа нь орлогоо та нар ингээд 1 тонн нүүрсийг 129 ам.доллараар төсөөлж оруулж ирсэн байна, зэсийг 7,4 мянган ам.доллараар төсөөлж оруулж ирсэн байна. Эргэн тойрны улсуудын нөхцөл байдлыг харахаар бид хүнд хэцүү байдал руу ороод явчих вий дээ гэсэн ийм болгоомжлол байгаа. Орлого чинь хүрэх юм уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн зөвлөгөө бол орлого хүрэхгүй гэж байна, эрсдэл байгаа шүү л гэж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй холбоотой асуудал дээр энэ парламентын төсөв хэлэлцэх, төсвийг хэмжих, бодитой зөв төлөвлөх тал дээр маш хэрэгтэй зөвлөл шүү. Энийг бүүр байнгын ажиллагаатай болгох хэрэгтэй. Тэгж байгаад бид бүүр орон тооны болгоод гишүүдтэй болгосон юм байгаа юм. Ад үзээд байх ямар ч хэрэггүй. Энэ хүмүүсээ сайн сонсож, энэ судлаачдынхаа байр суурийг сайн харж байж хийж байхгүй бол болохгүй. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол харьцангуй сайн ажиллаад байгаа шүү. Саяын асуултууд байна.

Дээрээс нь энэ гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх тал дээр та маань ер нь ямар арга хэмжээ авах юм бэ? Үгүй ээ хэдүүлээ ингээд зардалгүй төсөвтэй болчихсон, хөрөнгө оруулалтаар л нөхнө шүү дээ. Тэгээд энэ 4 жил хуулиа өөрчлөөд бид нарт итгээд оруулж ирж байгаа хүмүүс байх ч юм уу, үгүй ч юм уу энэ дээр ер нь та ямар бодлого барьж байгаа юм бэ?



Төгсгөлд нь энэ Учрал сайд сүүлийн үед төрийн өмчийн компаниуд гээд их сүртэй яриад байгаа. Тэгээд өөрчилж чадах юм уу? Засгийн газар болгон баахан юм ярьдаг юм шүү дээ Учрал сайдаа. Сүртэй их гоё PR яваад байгаа даа, тэгээд хэзээ дуусгаж оруулж ирэх юм бэ та нар энийгээ? Баахан дарга нарын тавиулууд байгаа, баахан хулгай зэлгий байгаа, ухаж чадах уу? Би итгэхгүй л байгаа шүү. Энэ дээр нэг хариулчих.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Лувсаннъямын Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ярьж байгаа 2 юм хэлээд байна шүү дээ. Нэг болохоор тэл гээд, нэг болохоор Тогтвортой зөвлөлийн үгэнд ороод тана гээд Дамдинням гишүүнээ. Тэгээд таны санал яг аль нь юм бэ? Бид хамтдаа бүх бодлогоо гаргаж байгаа шүү дээ. Парламентаас тусдаа Засгийн бодлого гэж байхгүй шүү дээ. Бид нэгнийхээ үгэн дээр тоглоод юу болох юм бэ? Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг парламент баталсан шүү дээ. Жилийн төлөвлөгөөг парламент баталсан. Жилийн төлөвлөгөөг парламент баталсан, баталсан төлөвлөгөөнд эдийн засаг 8 хувь өснө гээд байж байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээ Засгийн газрын байр суурь юу юм бэ, тэрний байр суурь гэж нэхэхээс илүү парламентын байр суурь шүү. Ард түмэн парламентыг л сонгодог. Парламент Засгийн газраа сонгодог, Ерөнхий сайдаа томилдог. Томилсон Ерөнхий сайд Засгийн газраа бүрдүүлээд ажилладаг ийм л эрх зүй дотор бид явж байгаа шүү дээ. Тийм учраас хэдүүлээ цэцэн мэргэнээ шалгадаг газар бол парламент биш л дээ. Энэ бол бодлогын уралдаан. Бодлого гарах ёстой.

Мөрийн хөтөлбөр гарчихсан. Мөрийн хөтөлбөр дотор ТӨК-удын үр өгөөжийг нэмэгдүүлнэ, цөөлнө, олон нийтийнх болгоно гээд орчихсон. Ингээд парламентын баталсан хөтөлбөрийг бид ажил хэрэг болгох нь маш ойлгомжтой гэдгийг хэлье. 8 хувийн өсөлтийг бид хийнэ. Яагаад ийм итгэлтэй байгаа вэ гэхээр энэ жилийн импорт асар идэвхэжсэн. Энэ импорт дотор хамгийн том тоо 2,9 тэрбум долларын тоног, төхөөрөмж орж ирсэн. Машин механизм, унааны машин биш шүү. Таны сайн мэддэг уул уурхайн тоног, төхөөрөмж гэж ойлгоорой. Энэ хэмжээний хөрөнгө оруулалт орж ирнэ гэдэг бол энэ хэмжээний олборлолтын хүчин чадал нэмэгдэж байгаа гэсэн үг. Тэр утгаараа бид ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэхийн төлөө парламент ажиллана, юу Засгийн газар ажиллана.

Энэ дээр парламент ч гэсэн нэг дуутай байх хэрэгтэй. Нэг дарга нь цэргээ загнаж байгаа юм шиг байр суурьтай парламент ерөөсөө байж болохгүй. Парламент Засагтайгаа хамт бодлогоо гаргаж байж нэг үр дүнд хүрнэ. Энийг ард түмэн бид нараас хүсэж байгаа юм. Учрал сайд бол тэр төрийн өмчийн компаниудын шинэчлэлийн төлөвлөгөө дээр яс сууж байгаа шүү. Ажлынхаа ард гарна гэдэгт итгэлтэй байгаа. Бид нэг дарга нарын тавиул гээд компанийн захирлуудыг сольж чадахгүй, хольж чадахгүй ийм зүйл байхгүй. Их Хурлын гишүүд маань араас нь чаргууцалдахгүй байхад бид ёс зүйтэй, хариуцлагатай асуудлыг шийдэж чадна гэдэг эргэлзэхгүй байгаа юм. Хөрөнгө оруулалтын.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайдын микрофоныг нэмж өгье.

**Л.Гантөмөр:** Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг боловсруулж байгаа. Үзэл баримтлал нь гарчихсан. Энэ хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиа бид энэ ондоо багтаагаад өргөн барина. Их Хурал дээр



бага улс төржүүлээд, үнэхээр хөрөнгө оруулалтыг татаж чадах үндэстэн, татаж чадах улс болохын төлөө хэдүүлээ алхъя гэж хүсмээр байгаа юм. Тэгэхгүй ороод ирсний дараа дахиад яригддаг юм байдаг. Дотоодынх нь хаачихсан юм бэ гээд эхэлдэг. Тийм учраас бид ер нь 2 үзүүртэй явахаа багасгаад, гаднын хөрөнгө оруулалтыг татах чадалтай. Гадна талд Монгол руу хөрөнгө оруулахад бэлэн болчихсон байна, бэлэн болчихсон байна. Энэ бол 12 жилийн циклтэй юм байна. Яг энэ цикл нь ирсэн байна. Энэ циклийг бид бүрэн ашиглах хэрэгтэй. Ашиглахын тулд ухаан хэрэгтэй бид нарт, тэвчээр хэрэгтэй. Тэгж чадах юм бол бид гаднын Хөрөнгө оруулалтын хуулиа ондоо багтаагаад баталж чадах юм бол.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ням-Осорын Учрал сайд нэмж хариулах уу ТӨК-удын асуудлаар? Учрал сайд.

**Н.Учрал:** Энэ Төсвийн хуулийг дагалдуулаад Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд өөрчлөлт оруулж байгаа. Яг хамгийн сүүлийн Төрийн өмчийн хороонд ирүүлсэн тайлангаар 99 компани, тэгээд охин компаниудтайгаа нийлбэл 123. Тэндээс 43 компани алдагдалтай ажиллаж байна гэдэг ийм тоо гарсан. 3 жил дараалаад алдагдалтай ажиллаж байгаа 21 компани байгаа. Энэ төсөв дагуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар нэг эрх авч байгаа. Тэр юу вэ гэвэл 3 жил дараалаад санхүүгийн алдагдал хүлээсэн бол татан буулгах, өөрчлөх, зохион байгуулах хууль зүйн үндэслэлийг бий болгож байна. Энэ Төсвийн хууль дагалдаад батлагдсаны дараа энэ асуудал шууд шийдэгдээд өөрчлөн зохион байгуулах, 3 жил санхүүгийн алдагдалтай байсан бол татан буулгах арга хэмжээ авна.

2-т Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хуулиар нийт 12 төрлийн мэдээллийг ил тод болгох шаардлагыг энэ хуулиар хийж байгаа.

3-д олон улсын санхүүгийн аудитыг он гаргаад шууд оруулна. Хуулиар хийж байгаа. Тэр Төсвийн хууль батлагдсанаар.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гонгорын Дамдинням гишүүн тодруулж асууя.

**Г.Дамдинням:** Тэгэхээр Шадар сайдаа юу юм байгаа юм. Миний байр суурь туйлын тодорхой. Хөгжил дэвшил рүү тэмүүлсэн төсөв оруулж ирнэ гэсэн чинь байсангүй. Төсвийн хүрээний мэдэгдлийг харахад ирэх 3 жил хэдүүлээ тэгээд л яг л алдагдалгүй төсөв гэдгээрээ явах юм байна. Тэгэхээр хөрөнгө оруулалт, ажлыг чинь яаж явуулах юм бэ та нар? Мөнгө байхгүй, төсвөөрөө хийж чадахгүй. Төсвөөрөө хийх боломжийг чинь бүгдийг нь хаачихсан. Дийлэнх зардал нь урсгал зардал. Та нарын ажлыг бодож л дуугараад байна. Та нарын ажлыг бодож дуугараад байна. Хангалттай тавьж өгөөд уг нь араас чинь шахаад, эдийн засгаа тэлээд авмаар байгаа байхгүй юу. Харамсалтай нь тэгэхгүй байна. Тэгэхээр энэ дээрээ та нар нэг анхаараадах.

Тэгээд энэ Учрал сайд энэ яриад байгаа энэ Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн тухай хуулиа хурдан оруулж ир. Тэгээд энэ өөр эх үүсвэрээс энэ хөрөнгө оруулалтаа хийдэг, хөгжил дэвшлээ тэтгэдэг энэ ажил руугаа хэдүүлээ анхаарахгүй болохоо байлаа шүү гэж хэлье.

**Д.Амарбаясгалан:** Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

**Х.Ганхуяг:** Бид хөгжлийн төлөвлөгөөтэйгөө уялдуулаад төсөв баталж өгсөн. Тэгээд тэрийг хүчингүй болгосон. Хүчингүй болгосон шалтгаан нь яагаад вэ гэхээр дараа жил яг өнөөдөр Гантөмөр сайдын ярьж байгаа яриа бол дараа жил энэ Засгийн газрын гишүүн л хэлэх байсан юм. Их Хурал дээр байлгаж байгаад бид баталчихсан бол энэ төсвийн хариуцлагыг бид хүлээхгүй, энэ Их Хурал хүлээнэ гэдэг асуудал үүсэх байсан. Тийм учраас энэ төсвийг буцаасан байх шүү.

2 дугаарт энэ хэд хэдэн асуулт байна л даа. Энэ жилийн 7 сард таныг томилогдож байхад би нэг хэдэн тоо хэлж байсан. Манай эдийн засгийн өсөлт 7 хувьтай байсан, валютын нөөц 5 тэрбум доллартой танд хүлээлгэж өгсөн. Өнөөдөр валютын нөөц ер нь яг хэд байгаа вэ? 4,4 тэрбум дээр сая нийслэлийн гаргасан бондын 500 сая гээд 4,9 тэрбум гэсэн яриа сонсогдсон. Энэ үнэн эсэхийг нь би тодруулчихмаар байна.

2 дугаарт нэгдсэн төсвийн гүйцэтгэл 1 их наяд төгрөгөөр тасарчихсан явж байна, 1 их наяд төгрөгөөр. Ерөөсөө бид эдийн засгийн өсөлт, тэр валютын нөөцийг бол Уул уурхайн биржийн хуулиар ер нь бий болгож чадсан юм л даа. Тэгээд энэ асуудал маань ингээд өнөөдөр Казахстаны парламент манай энэ Уул уурхайн биржийн хуулийг хуулбарлаж батлах гээд байж байна. Тэгээд манай энэ нүүрсний уул уурхайн бүтээгдэхүүн энэ биржээрээ явж байгаа эсэхийг нь энийг тодруулчихмаар байна. Яагаад гэхээр манай энэ 68 сая тонн нүүрс борлуулсан гэсэн мөртөө яагаад энэ валютын нөөц буураад байгаа юм бэ? Бид чинь томоохон хэмжээний ямар ч төлбөр хийгээгүй, хийгээгүй. Мэдээж хэрэг тэр Шинхуагийн холболттой холбоотой тодорхой хэмжээний бартерын хэлцэл хийх юм шиг байгаа юм. Тэгэхээр цаашдаа энэ уул уурхайн биржийг ер нь яг энэ байдлаараа аниулах гээд байна уу эсвэл ингээд цааш нь үргэлжлүүлж явах гээд байна уу гэдэг асуулт байна.

Мөн энэ гадаад зээлтэй холбоотой асуудал дээр нэг асуудал байгаад байгаа юм. Бид нар зөвхөн Мянганы сорилтын сангийн төсөл болон цэвэрлэх байгууламжийн төсөл дээр ойролцоогоор 1 тэрбум долларын бид гадаадын зээл, тусламж авсан байгаа. Цэвэрлэх байгууламж дуусахгүй байхаар Мянганы сорилтын сангийн төсөл амжилттай болох эсэх нь эрсдэлтэй болчихсон байна шүү гэдэг мэдээлэл өгч байна. Мянганы сорилтын сангийн төсөл 2026 оны 3 сард бүрэн дуусах юм байна лээ. Тэрнээс хойш сунгагдахгүй, нэмж санхүүжилт гарахгүй, тэр оффис нь хаагдана. Тэрнээс өмнө цэвэрлэх байгууламж ашиглалтад орохгүй бол энэ 2 төсөл хоёулаа эрсдэлтэй болчихсон байна гэдгийг та бүхэнд хэлэх гэсэн юм. Энэ чинь 1 тэрбум доллар буюу 3,5 их наяд төгрөгийн асуудлыг би ярьж байгаа шүү. 3,5 их наяд төгрөг. Тэгэхээр энэ цэвэрлэх байгууламж болон энэ гадаад зээлийн ашиглалттай холбоотой асуудлыг тодруулмаар байна?

Дараагийн асуудал бид энэ төсөвтэй холбоотой тэр энэ Нийгмийн даатгалын сангийн, Нийгмийн халамжийн тухай хууль гээд төсвөөс гардаг зардлууд их байна. Цаашдаа улам нэмэгдэхээр байна. Тэгэхээр энэ төсөв тэлсэн энэ хуулиудаа түрүүн Гантөмөр сайд харин ярилаа. Тэрийгээ харин та бүхэн яг хийчихмээр байна. Дараа жилдээ багтаагаад бүгдийг нь сайхан цэвэрлэчихмээр байна. Нийгмийн даатгалын сан дээр энэ баахан юм орсон шүү ер нь. Тэр нөгөө малчны нийгмийн даатгалаас авхуулаад л, Малчны эрх зүйн байдлын хууль гээд л нэг удаа 38 тэрбум төлөөд, тэгээд дараа нь бид нарын нийгмийн даатгалын сангаас жилд хамгийн багадаа 700-аас 800 тэрбум төгрөг төсвөөс өгдөг болно.

Энэнээс чинь болоод бид нар манай энэ тэтгэврийн хөгшчүүлийн тэтгэвэр нэмэгддэггүй.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** 2024 он сонгуулийн жил гэдгээрээ онцлогтой. Сонгуулийн жилд юу олдог вэ гэхээр төсвийг асар их хэмжээгээр тэлдэг, зардал нэмэгддэг. Энэний үр дүнд эдийн засаг идэвхэждэг, халдаг. Халахаараа юу болдог вэ гэхээр импорт нэмэгддэг. Энийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Тийм учраас Монгол Улсын хэмжээнд хамгийн их нэмэгдсэн зүйл импорт байгаа юм. Импорт гэдэг нь валютын худалдан авалт, валютаар хийсэн худалдан авалт бол эрс нэмэгдсэн. Энэтэй холбоотой хүмүүс санаа зовоод байгаа юм. Зүгээр экспорт бас нэмэгдсэн шүү. Дагаад нэмэгдэж байгаа. Өнөөдрийн байдлаар 15 тэрбум долларт экспорт дөхсөн байгаа. Тийм учраас валютын нөөц хэвээрээ байгаа. Тэрэнд та бүхэн санаа зовоод хэрэггүй. Яг өнөөдрийн байдлаар 4 тэрбум, өнөөдөр юу байх вэ 11 сарын сүүлийн өдрийн байдлаар 4 тэрбум 960 сая ам.долларын валютын нөөцтэй байгаа. Том төлбөрүүд энэ зун хийсэн 7 сар, 8 сард. Ямар том төлбөр хийсэн бэ гэхээр Хятадын банктэй хийчихсэн байгаа свопын төлбөрийг төлсөн. Тийм учраас нөөц өөрөө буурч харагдсан шүү. Өнөөдөр төсвийн орлого тасалдах тухай ойлголт байхгүй. Энийг Сангийн сайд өөрөө та бүхэнд дэлгэрэнгүй мэдээлэл өгөөд явна гэдэгт эргэлзэхгүй байна.

Цэвэрлэх байгууламжтай холбоотой асуудал үнэ нэмэгдсэн. Асуудал шийдэх ёстой. Цаад хийж байгаа айл нь 35 сая билүү дээ америк доллароор үнэ нэмэгдсэн гэдэг ийм зүйл өгсөн. Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам хамтраад энэ асуудлыг шийднэ. Таны хэлдэг зөв, цэвэрлэх байгууламж бол цаг хугацаандаа орж байж бид тэр усны асуудлаа бүрэн шийдэх ёстой. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Би энэ Засгийн газраас л өргөн барьсан Төсвийн хууль байлгүй дээ. Энэний 18 дугаар хуудас дээр 2024 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр төсвийн гүйцэтгэл 902 тэрбум төгрөгөөр тасарсан гэж байна. Буурсан байна гэж байна, буурсан байна. Тэгэхээр энийгээ та нэг шалгачхаарай.

2 дугаарт энэ халамжаас хөдөлмөр лүү шилжинэ гээд байдаг. Тэгээд яг өнөөдрийн байдлаар манайх 47 төрлийн халамжийн, халамж байна. 47 төрөл. Төсөв тэлсэн хэчнээн хууль байгааг би хэлж мэдэхгүй байна. Энэ тоогоо алдсан. Тэгээд энэ дээр энэ онцгой анхаарал хандуулаад, ирэх жилдээ багтаагаад энэ асуудлуудыг бүгдийг нь сайхан цэвэрлэчихмээр байна Гантөмөр сайдаа. Тэгээд энэ халамжтай холбоотойгоор би энэ Энх-Амгалан сайдаас энэ дээр нэг тодорхой тайлбар авчихмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд хариулт өгье.

**Л.Энх-Амгалан:** Ганхуяг гишүүн их чухал асуудал ер нь байн, байн хөндөөд байгаа юм л даа. Ингээд бид яах вэ ерөнхийдөө халамжаас хөдөлмөрт гэдэг нэг ийм лоозон сүүлийн бараг 10 жил бараг энэ лоозон явлаа. Манай яаман дээр ч гэсэн тийм онигоо гарсан юм байна лээ. Нөгөө Халамжийн даргыг нь хөдөлмөр хариуцсан дарга тавьчихсан. Тэгээд халамжаас хөдөлмөрт шилжсэн бодлого хэрэгжлээ гэсэн тийм онигоо ч хүртэл гарсан юм байна лээ. Тэгэхээр бид

бодитойгоор ерөнхийдөө энэ Монгол Улсад зарж байгаа энэ халамжийн мөнгө 2,2 их наяд байгаад байгаа шүү дээ. Энэ 2,2 их наядын чинь 1,6 их наяд нь угаасаа хүүхдийн мөнгө байгаад байгаа юм. Хүүхдийн мөнгө. Цаана нь тэгээд 600 тэрбум байгаа. 600 тэрбумыг саяын Ганхуяг гишүүний хэлсэн 41, 2 төрлийн нийгмийн үйлчилгээний зардал гэж хэлэх юм даа. Дан бид ингээд халамж гэж хэлэхэд их хэцүү ийм байна лээ. Тэгээд бид маш нарийн судалгаанууд хийгдэж байгаа. Тэгээд бид Байнгын хороон дээрээ энэ судалгаануудынхаа юунуудыг юу яасан, энэ судалгааг танилцуулсан. Тэгээд энэ дээрээ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ дээрээ үндэслэж бид энэ Халамжийн хуулиа энэ намрын чуулганд багтааж ер нь өргөн барихаар ингээд ажиллаж байна. Ер нь цаашдаа бид энэ Халамжийн хууль гэж байх уу эсхүл Нийгмийн дэмжлэгийн хууль гэж байх уу гэдэг энэ яг тогтолцооны Ганхуяг гишүүний яг яриад байгаа энэ тогтолцооныхоо шинэчлэлийг нэг бодитой хийгээд авах нь зүйтэй шүү гэдэг дээр би үнэхээр санал нэг байгаа юм.

Энэ бол яг энэ парламентын үед бид энэ тэтгэврийн тогтолцооныхоо шинэчлэлийг хийж авах, энэ парламентын энэ Засгийн газрын хамтарсан үед бид энэ халамжийнхаа бодлого, тэр тусмаа хөдөлмөр эрхлэлтийнхээ бодлогыг хийж авч, энэ тогтолцооны шинэчлэл хийнэ гэдэгтэй бол би зайлшгүй байгаа. Тэгээд энэ дээр энэ намрын чуулган дээр бид энэ гол, гол хуулиудаа өргөн барина. Тэгээд ингээд энэтэй уялдуулж цаашаа бид 26 оны төсөв дээр нэлээн яг таны асууж байгаа энэ тэтгэврийн шинэчлэлийн асуудлууд, нийгмийн дэмжлэгийн хүрээнд цаашдаа яг зорилтот бүлгүүд рүүгээ хандсан яг ямар бодлогууд байх вэ гэдгээ тодорхойлсон ийм хууль, эрх зүйн орчинтой болно гэж бодож байна. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Өмнөх Засгийн газар дээр энэ гадаадын хөрөнгө оруулагч болон ер нь хөрөнгө оруулагч нартай холбоотой гомдлыг Засгийн газар сард 1-ээс 2 удаа авч хэлэлцдэг байсан юм. Манай Их Хурлын дарга мэдэж байгаа байх. Тэгээд яг тэр гомдлыг хэлэлцдэг тэр уламжлал нь байхгүй болчихсон гэж ойлгосон. Тэгээд бид Хөрөнгө оруулалтын хуулийг батлахаас гадна энд ороод ирчихсэн байгаа энэ хөрөнгө оруулагч нараа хэрхэн, яаж хамгаалах тал дээр нэг дорвитой ямар арга хэмжээ авах юм бэ? Сүүлийн тэр сошиалаар явж байгаа мэдээ харахаар тийм орны хөрөнгө оруулагчийг ингэж дээрэмдсэн гэнэ, тэр орны хөрөнгө оруулагчийг ингэж дээрэмдсэн гэнэ. Хууль зүйн яам нь ямар нэгэн үйл хөдлөл гаргадаггүй. Тэгээд энэ чинь нөгөө зөвхөн Хууль зүйн яам ч гэлтгүй нөгөө цэрэг, цагдаа, шүүх гээд л ингээд бүхий л байгууллага нь, сүүлдээ Улсын бүртгэлийн газар нь хүртэл оролцсон гэсэн ийм мэдээнүүд яваад байгаа. Энэ дээр нэг тайлбар авчихмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Лувсанямын Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тийм хөрөнгө оруулагчдын гомдлыг хүлээж авч хэлэлцэх асуудлыг манай яам хийж байгаа. Тэгэхдээ нэг зүйл байгаа. Шадар сайд, тийм ойрд хэлэлцсэнгүй л дээ. Бид чинь, та бүхэн мэдэж байгаа. Засаг байгуулагдсанаас хойш Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн

тодотгол, тэгээд дээр нь оны төлөвлөгөө, төсөв гээд. Бид нарын яг хүчээ зарцуулж байгаа ажил бол ирэх 4 жилийнхээ нэг ийм vision-г гаргах гээд л өнөөдрийг хүртэл Засаг парламенттайгаа нийлээд л явлаа шүү дээ. Тэгэхээр 1 тодорхой ажлууд хоцорч байгаа зүйл байна. Тэгэхдээ яг энэ гомдлууд дотор байгаа таны хэлж байгаа хамгийн том эзэлж байгаа жин нь бол шүүх дээр байна. Ерөөсөө энэ шүүхийн маргаан нь дуусдаггүй. Хөрөнгө оруулагчдын оруулагчид бол энэ дээр асар их хохирол амсдаг гэдэг зүйл ерөөсөө яг байдгаараа байна. Тийм учраас бид энэ гадаадын Хөрөнгө оруулалтын тухай хуулийг өргөн барихдаа тухайн үед хэрэгжиж байсан хууль өөрчлөгдсөн бол тухайн үеийнхээ хуулийг барьж явдаг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Засгийн газраас өргөн мэдүүлсэн 25 оны төсвийн төсөлтэй бид маш богино хугацаанд танилцлаа. Хавсралт 2 тооцооны задаргааг авъя гэсэн боловч авч чадсангүй. Тэгээд Монгол улсын 25 оны эдийн засгийн бодит өсөлт түрүүн Гантөмөр сайд маань гараад хэллээ. Бид эдийн засгаа тэлэх ийм зорилготой ажиллаж байгаа гээд. Тэгээд ер нь эдийн засгийн бодит өсөлтийг 8 хувьтай хэвээр үлдээсэн байна. ДНБ-ий нэрлэсэн дүнгээрээ 95 их наяд төгрөг бол бас өөрчлөгдөөгүй хэвээр хадгалагдаж орж ирсэн. Ингэхээр юу хэлж байна гэхээр 25 оны төсвийн орлого 400 тэрбум төгрөгөөр буурсан байгаа. Нэгдсэн төсвийн нийт зардал 2,3 их наяд төгрөгөөр танасан. Ингээд ААН-үүд болон нийт татварын татвар дээр харахад энэ бол гурван зуун бараг ерэн таван тэрбум төгрөгөөр үндсэндээ тэнд төсвийн тэнцвэржүүлсэн орлого мөн адилхан буурч орж ирж байгаа.

Тэгэхээр нэг юм ойлгогдохгүй байгаад байгаа юм нь болохоор нэгдсэн төсвийн нийт зардлын 2,3 их наяд төгрөгийн зардлын бууралтыг задлаад үзвэл урсгал зардал өөрөө 726 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардал 1,4 их наяд төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 127,6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Ингэхээр нөгөө улсын төсвөөс болон зээлийн ашиглалтын хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг 1,4 их наяд төгрөгөөр бууруулсан нь эдийн засгийн бодит өсөлтөд сөргөөр нөлөөлдөггүй юм уу? Энэ чинь орлого хумигдаж байна, ААН-ээс орж ирж байгаа татвар буурч орж ирж байгаа. Тэгсэн мөртөө эдийн засгийнхаа өсөлтийг болохоор хэвээр нь тавьчихсан, ДНБ-ийхээ дүн хэвээр ингээд орж ирж байгаа. Тэгээд нэг ойлгомжгүй юм нь болохоор энэ эдийн засгийн өсөлтөд энэ чинь сөргөөр нөлөөлдөггүй юм уу? Энэ зардлыг хэрвээ санхүүжүүлсэн байх юм бол эдийн засаг уг нь тэлэх байсан уу гэдгийг би Эдийн засгийн хөгжлийн яамны сайдаас асуух гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Жишээлбэл төсвийн зардлыг 2,3 их наядар бууруулснаар бид инфляцыг 0,3 хувиар бууруулж орж ирж байгаа. Нэг үгээр хэлбэл тийм хэмжээний мөнгө манай эдийн засаг буюу эдийн засгийн эргэлтэд тийм хэмжээний нөлөөтэй л гэж ойлгох хэрэгтэй. Тийм учраас эдийн засгийн өсөлтөд яг төсвийн 2,3 их наядын зардлын таналт шууд нөлөөлөх үү гэвэл үгүй. Бид нарт олон option байгаа. Гаднын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг явуулах, үйлдвэр технологийн паркуудын ажлыг урагшлуулах. Нэг үгээр хэлбэл Засгийн газар өөрийнхөө хийж чадах буюу Монголын баялаг



үйлдвэрлэгчидтэй хамтраад хамтдаа хөдөлж чадах юм бол энэ 8 хувийн өсөлт хангалттай хадгалагдана. Энд бол эргэлзэх хэрэггүй л гэж хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

**М.Мандхай:** Тэгэхээр дахиад аягүй маш ерөнхий хариулаад байна л даа. Яагаад гэхээр нийт эдийн засгийг эрчимжүүлэх, улсын төсвөөр санхүүжиж байгаа 38 төслийн 10 нь үндсэндээ хойшлуулагдаж байгаа юм байна гэж ойлгосон. Энэ нь өөрөө дандаа голцуу яг нөгөө орон нутаг, дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой замын төслүүд харагдаж байсан. Тэгэхээр нөгөө зам болон боомтын сэргэлт, тэгээд бүсчилсэн хөгжил дээр хийгдэхээр зорьж байсан зарим төслүүд нь өөрөө эрэмбэлэгдээд 25 онд яг эдийн засгийг тэлэх, эрчимжүүлэх төслүүд маань хойшлогдож байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дахиад асуухад эдийн засагт энэ тэлэлт чинь сөргөөр нөлөөлөхгүй гэж үү? Дахиад тодруулах гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Тодруулж хариулъя Гантөмөр сайд.

**Л.Гантөмөр:** Яг төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурч байгаа хэмжээгээр тухайн орон нутагт оруулж байгаа хөрөнгө оруулалт багасна. Тэр бол таны хэлж байгаа зөв. Ер нь энэ бүсчилсэн хөгжил буюу аялал жуулчлалаа дэмжих зорилгоор бид нарын хийх гэж байгаа энэ дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд саарах юм. Зүгээр нөхөөд бид юу ярьж байгаа вэ гэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг илүү идэвхжүүлбэ. Хуулийг нь илүү хялбар болгоё, боловсронгуй болгоё, ашиглаж болдог болгоё гээд. Сайнзориг гишүүн жишээлбэл Төсвийн байнгын хороон дээр ийм санал гаргаж байгаа юм. Тэгэхээр бид ч гэсэн адилхан тийм бодолтой байгаа. Өчигдөр Засгийн газрын хуралдаанаар төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрхэн орон нутагт хэрэгжүүлэх вэ гэдэг журмуудыг бид хэлэлцэж шийдсэн байгаа. Энэ журмын хүрээнд орон нутгууд хүртэл өөрийгөө дайчлах боломжийг нээж байгаа. Тэгэхээр шууд утгаараа эдийн засгийн өсөлтийн 8 хувьд нөлөөлөхгүй байх тухайд бид арга хэмжээ авна. Тийм учраас өсөлтөө бид 8 хувиа.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

**Э.Болормаа:** Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн төсвийн хэлэлцүүлгийн үеэр би нэг зүйлийг тодруулах шаардлагатай болов уу гэж харж байгаа. Ер нь олон улсын түвшинд манай Монгол Улс төсвийн хувьд сахилга баттай улс орны тоонд орно. Энэ маань юугаар харагдаж байна гэхээр Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед эдийн засаг бодитойгоор өссөн. Үүнээс гадна олон улсын хэмжээнд манай улсын зээлжих зэрэглэл өсөж байгаа. Энэ бол яг бодит факт. Нэг хүний, хувь хүний үзэл бодол биш гэж харж байгаа юм.

25 оны төсвийн хэлэлцүүлгийн үеэр төсвийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх гэдэг аргументыг цөөн гишүүдийн попролт нь алдагдалгүй төсөв гэдэг юм руу ингээд түлхээд оруулсан байгаа. Энийг энэ танхим дотор бүгдээрээ хүлээн зөвшөөрөөд, нөгөө хэд маань ч гэмшдэг нь гэмшээд сууж байх шиг байна. Харин 20, энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр 25, 26, 27 онуудад тус бүрд нь бүгдээрэнд нь алдагдалгүй төсөв гэж оруулж ирсэн байна. Энэ үр ашиггүй байдлаас болоод магадгүй 25 онд бол алдагдалгүй төсөв батлахыг дэмжиж байгаа. Харин 26, 27 онд яагаад ийм тооцоолол гаргасан юм бэ?



Би Дэлхийн банканд гүйцэтгэх захирлын ажлын албанд нь ажиллаж байсан л даа. Яг манайх шиг хөгжиж байгаа оронд ийм алдагдалгүй төсөв баталдаг улс байхгүй. Жишээлбэл АНУ гэхэд 23 онд -5 хувь гарчихсан байна. Франц, Япон бүгд -5 хувь. 20 он гэхэд манайхтай төстэй эдийн засгууд бүгд алдагдал нь -10 орчим хувь. Манайх хуулиараа харин сахилга баттай -2 хувиас хэтрүүлдэггүй нөхцөл байдалтай мөртөө яагаад бид 26, 27 онд мөн өөрсдийгөө боомилсон ийм төсвийн хүрээний мэдэгдлийг оруулж ирж байгаа юм бэ? 25 онд үр ашгаа нэмэгдүүлье, энэ ч утгаараа бүсээ чангалаад алдагдалгүй ийм тооцоолол оруулж ирж байгааг ойлгож байна, дэмжиж байна. Харин 26, 27 онд бид нийгмийн ийм үр ашигтай байа гэдгийг буруу ойлгосон энэ зүйлээ засъя. Одоо энэ хэтэрхий их попролтой, бүүр дараагийн 2 жилээ бүү оруулаасай гэж бодож байна. Тэгэхээр яагаад ийм тооцоолол оруулж ирсэн бэ гэдгийг асууя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь бодлого бол байн, байн алдагдаад байж болохгүй л дээ. Бид түрүүн оруулж ирэхдээ нэг зүйл хэлсэн шүү дээ. Дотоодоос дайчилж байгаа төсвийн зардлаа ДНБ-ий 2 хувийн ашигтайгаар цаашдаа 4 жил бариад явъя. Гаднын зээл, тусламжийг авахдаа бол 2 хувийн алдагдал хүлээж болох юм гээд оруулсан. Их Хурал үгүй гэсэн. Тэгэхээр Их Хурлын энэ байр суурь энэ жил үгүй, дараа жил окэй ийм байж болохгүй шүү дээ. Их Хурлын байр суурь бол байгаа бүрэн эрхийнхээ хугацаанд хадгалагдана. Тийм учраас бид 4 жил алдагдалгүй төсөв батална. Аль ч талаасаа. Нэг үгээр хэлбэл гадаадын зээл, тусламжаар бид ажил хэрэг хийхгүй гэдгийг бүгдээрээ ойлгож авах хэрэгтэй. Авсан зээлээ ирэх 4 жилийн хугацаанд харин хэрхэн ашиглах вэ гэдэг тухай л бодлого бодож эхэлнэ. Магадгүй парламент өөрөө шинэ бодлого зарлах юм бол тэр үед Засгийн газар парламентынхаа бодлогод нийцүүлж ажиллана. Бид парламентын засаглалтай улс гэдгээ хэзээ ч мартаж болохгүй гишүүдээ. Тэгээд парламент өөрөө шийдвэр гаргаад, төсөв буцаагаад байхад бид зөрөөд явах бидэнд тийм ёс суртахуун болоод хуулийн эрх байхгүй.

**Д.Амарбаясгалан:** Энхбатын Болормаа гишүүн тодруулж асууя.

**Э.Болормаа:** Энэ удаагийн 25 оны алдагдалгүй төсөв гэдэг байр суурийг энэ 4 жилд парламентын бүрэн эрхийн хугацаанд гэж би буруу битгий ойлгоосой гэж бодож байна. Магадгүй энэ дээр бид дэлгэрэнгүй ярилцах ёстой. Монгол Улс хөгжинө, өөрчлөгдөнө. Тэр болгондоо дагуулаад бид өөрчлөгдөж байх ёстой. Одоо алдагдалгүй төсөв жил болгон баталдаг манайх шиг 3, 4 жилээр ингэж баталдаг 3, 4-хөн улс байгаа. Норвег, Катар, Арабын Эмират гээд дандаа байгалийн баялаг маш өндөртэй, дэлхийд орлогоороо бүүр эхний 5, 10-д жагсаж байгаа ийм улс орнууд байгаа. Тэгэхээр бид энэ танхим дотор 25 оны төсөв дээр л хориг тавьж, хоригийг хүлээж авч, одоо дахин хэлэлцэж байгаа болохоос биш 26, 27 оны байр суурийг битгий үүнтэй уяасай гэж би зүгээр хувь парламентынхаа гишүүний хувьд тодруулж хэлье.

**Д.Амарбаясгалан:** Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Төсвийн хүрээний мэдэгдлийн энэ алдагдал дээр би Болормаа гишүүнтэй санал нэг байгаа. Тэгээд 1 асуулт байна. Бид ирэх 4 жилд алдагдалгүй төсөвтэй ингээд явлаа гэхэд хамтарсан Засгийн газар маань мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж бий юу? Бид амласан амлалтдаа хүрч

чадах уу, том төслүүдээ хэрэгжүүлж чадах уу нэг? Уг нь бид зардлыг хамгийн бага зардлаар аливаа ажлыг хийх биш, хамгийн оновчтой, үр ашигтай зардлаар л хийх ёстой. Тэгээд өнгөрсөн жилийн төсвийн өсөлтөөс энэ жилийн төсвийн өсөлт тэдэн их наядаар хэтэрлээ гэж харьцуулахдаа эхлээд ажлуудаа харьцуулмаар байгаа юм. Энэ төсвөөр өнгөрсөн хугацаанд юу хийж байсан юм, энэ жил энэ төсвөөр юу хийх гэж байгаа юм. Тэгээд энэ ажлаасаа хамаарч, хүрээнээсээ хамаарч төсөвт өртөг өөрчлөгдөх ёстой гэдэг ойлголтыг хаана хаана авч ажилламаар байгаа юм.

Сая яригдсан асуудлууд дээр Гантөмөр сайд ТӨК-удын хувьчлал, менежментийн асуудал дээр тодорхой хариултыг өглөө. Ер нь энэ ТӨК-удыг хувьчлах, олон нийтийн оролцоог хяналттай болгох, үр ашгийг нь нэмэгдүүлэх, цөөлөх, тоог цөөлөх гэдэг зарчмын байр суурь дээр би санал нэг байдаг. Гэхдээ өнөөдөр энийг хэрэгжүүлэх механизм бүрдсэн үү, үгүй юү гэдгийг бид харах хэрэгтэй. Хамгийн наад захын жишээ Эрдэнэт үйлдвэрийнхээ асуудлыг л бид харах хэрэгтэй. 49 хувиа аваачаад бид чинь худалдаад зарчихсан, тэрнийхээ асуудлыг өнөөдөр хүртэл шийдэж чадаагүй явж байгаа хүмүүс шүү дээ. Энэ 49 хувийг шийдээгүй байхад 10 хувийг олон нийтийн оролцоотой болгоно гэж хэзээ ч байхгүй. Өнөөдөр Эрдэнэт үйлдвэр үүнээс үүссэн алдагдсан боломжийнхоо өртгийг нөхөж чадаагүй явж байгаа. Өр, авлагаа дуусгаагүй л явж байгаа.

Тийм учраас энэ ашигтай байгаа 2 компани, үндсэндээ ноогдол ашгийн бараг 98 хувь нь 2-оос 3 компани л оруулж байгаа шүү дээ. Эрдэнэт Тавантолгой, Эрдэнэт үйлдвэр. Тэгэхээр энэ алдагдалтай байгаа компаниудынхаа асуудлыг яах юм гэдгийг түрүүлж шийдэж байж, дараа нь энэ асуудал хууль шүүхийн асуудалтай байгаа юмнуудаа цэгцэлж байж бид энэ дээр нэгдсэн ойлголттой байхгүй бол болохгүй байх гэж бодож байна. Тэгээд би танд талархаж байна. Эрдэнэт үйлдвэр дээр ажиллаад, хиймэл оюун ухааныг худалдан авах ажиллагаанд нэвтрүүлж байгаа энэ ажлыг Монгол Улсынхаа хэмжээнд ТӨК-удад хэрэгжүүлэх ёстой гэдэг санаачилгыг би бүрэн дэмжиж байгаа. Энэ ажлыг 2021 онд эхлүүлсэн юм байгаа юм. Анхны судалгаа, тооцоо хийх ажлын хэсэг 21 онд байгуулагдаад ажилласан. Манай энэ Эрдэнэт үйлдвэрийн уурхайчид, инженерүүд, энэ IT нар маш олон төсөл, хөтөлбөрүүдийг судалж үзэж, энийг өөрсдийн хүчээр хийж байгаа. Хөрөнгө оруулалт, санхүүжилт хэрэгтэй гэдэг дээр дэмжиж байгаад баярлаж байна. Энэ ажлыг анхнаас нь Учрал сайд Цахим, харилцаа холбооны яам байхдаа яамны сайд байхдаа их сайн дэмжсэн. Энийг бид цаашдаа нэвтрүүлээд явах ёстой. Эндээс бид тодорхой төсвийн зарлага хэмнэлтийг гаргана. Энийг бол би төсөвтэй холбоотой хэлэлцүүлэг дээр хэлье гэж бодож байгаа.

Таны ярьсан асуудал дээр би нэг зүйлийг сайн ойлгосонгүй. Магадгүй буруу ойлгосон байж магадгүй, уучлаарай сайдаа. Өгөөж сайжруулах менежерийг Засгийн газар бүх ТӨК-уддаа тавина гээд ярьчихлаа. Энэ уг нь өгөөж сайжруулах, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх гүйцэтгэх удирдлагын үүрэг байх гэж би ойлгож байна. Компаниуд үр ашиггүй, өгөөжгүй байвал гүйцэтгэх захирлын удирдлагын багтай асуудлыг ярина. Хэн нэгэн Засгийн газраас томилогдож очоод, үйлдвэрийн газрын үр ашиг, өгөөж нэмэгдэнэ гэж байхгүй л дээ. Бид чинь Төрийн хэмнэлтийн хуулиа бариад бүгдийг нь орлогчгүй болгочихсон шүү дээ. Тийм учраас би энд нэг зүйлийг та бүхнээсээ, эрхэм сайд, дарга нараас хүсмээр байна. Хэдий засаг хамтраад, улс төрийн бодлогын хувьд хамтраад явж байгаа ч гэлээ гэсэн мэргэжлийн салбар, мэргэжлийн хүмүүс ажиллаж байгаа салбараа бага улс төржүүлээрэй гэж хүсмээр байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Манай Их Хурлын гишүүд дахиад 2 үзүүртэй юм ярьж байгаа юм. ТӨК-удын бүтээмжийг нэмэгдүүл гэж шаардаж байгаа юм. Бид бүтээмж нэмэгдүүлэх менежер томилно гэхээр наадах чинь болохгүй, улс төржих гэж байна гэж байгаа юм. Тэгэхээр бид бүтээмж, хяналт 2-ыг хоёуланг нь хийхээр Засгийн газар шийдвэрээ гаргачихсан. ТӨК-уд дээрээ бид бүтээмжийн менежер томилно, хяналтын менежер томилно. Тэгэхээс өөр аргагүй. Ер нь Монгол Улс өнөөдөр хүртэл хэтэрхий улс төржиж, хүний нөөцөө 2 хуваасан. Аль ялсан нь бүгдийг нь эзэлж авдаг, нөгөө намынхаа гишүүн буюу дэмжигчдийг бүгдийг нь гадна талд орхидог. Энэ цөөхөн Монголчуудын хувьд хүний нөөц дээрээ хийсэн хамгийн том алдаа. Энэ алдааг та бүхэн цаашаагаа үргэлжлүүлэе гэсэн бодол тээгээд байх юм бол Монгол хөгжихгүй. Хамгийн чадалтай хүмүүсийг бид Монголын энэ хамгийн сайн компани, хамгийн сайн бизнес дээрээ ажиллуулж сурмаар байгаа юм.

Жишээлбэл ингээд 2 талтай 2 тайлбар өнөөдөр явмааргүй байна. Эрдэнэтийн 49 хувийг бид хэн нэгэнд зараагүй. Оросуудын эзэмшиж байсан 49 хувийг Монгол Улс худалдаж авсан. Авсан эзний тухай маргаан байгаа. Төр авна гэдэг шийдвэр гарчихсан энэ бол эцсийн шийдвэр. Энийг ажил хэрэг болгох тухай л асуудлыг та хөндөж байгаа гэж би ойлгож байна. Тийм учраас хэдүүлээ ингээд нэг урагшаа хараад явахгүй бол эргэж хулгаад байх юм бол бид урагшаа явахад их хүндэрнэ.

Нөгөө талаар эдийн засгийн өсөлт буюу Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг бид бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Би итгэлтэй байна. Бид нэг хүнд оногддог ДНБ-ийг 10 мянган долларт хүргэх зорилттой. Энэ зорилтыг биелүүлэхэд 70 хувь нь хувийн хэвшлийн хүчийг бүрэн дайчлах ёстой. Хувийн хэвшлээ бид дайчлахын тулд бизнесийн орчноо эрүүл саруул болгох хэрэгтэй. Тэнд гомдол санал байдаггүй байх ёстой. Тэднийг мөшгөж мөргөдөггүй байх хэрэгтэй. Энэ тухайд энэ бизнесийн орчин хэрхэн сайжруулах вэ гэдэг дээр асар том ажлуудыг хэдүүлээ ойрын үед хийнэ. Бидэнд хугацаа байгаа гэж бодож байна. Бид цагаан сар гэхэд ямар ч байсан Монголын бизнесийн орчин сэргэж байгаа тухай мэдээллүүдийг гаргадаг болно. Тэр тухай хуулиудыг ярьдаг болно. Тийм учраас ер нь энэ парламентын том зорилго хувийн хэвшлийн орон зайг нэмэгдүүлэх, эдийн засгийг эрчимжүүлэх, эдийн засгийн орчноо сайжруулах гэдэг дээр эргэлзэхгүй хөдөлнө гэж ингэж 25 оны хөгжлийн төлөвлөгөөнд ч байна. Энэ дээрээ хэдүүлээ хатуу алхъя.

Төсөв бүгдийг шийдэхгүй. Нөгөө талаар төсвөөр зарим зүйлийг шийдэх гэж оролдсон. Засгийн газар жишээлбэл 26, 27 оныг алдагдалгүй байхаар төсөөллийг оруулж байгаа болохоос биш төсвийн хүрээгээ 26 онд ямар байх вэ гэдгийг хэдүүлээ үлдэж байгаа бид оруулж ирэхэд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энэ тийм төрийн өмчийн компаниудын 1 дүгээрт үр ашгийг сайжруулах, 2 дугаарт ер нь төр шаардлагагүй аж ахуйн, бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй байх гэдэг нэг ийм 2 ойлголт зэрэг яваад болохгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ дотроо жишээлбэл хэд хэдэн томоохон төрийн өмчит үйлдвэрийн газрыг харахад дэргэдээ аж ахуйн үйлчилгээний ажил маш ихтэй. Амралтын газар, сувиллын газар, спорт заал. Тэгээд яг ийм зэргийн үйлчилгээг нь эхний ээлжид байхгүй болгох ажлыг хийх нь хамгийн зохимжтой болов уу гээд Засгийн газрын 2022 оны 342 дугаар тогтоол гарсан байдаг. Жишээ нь аймаг,

нийслэл, дүүрэг бүгд дэргэдээ амралтын газруудтай байх жишээний. Үсчин, гоо сайхнаас бараг бусдыг нь л ажиллуулж байх шиг байгаа юм. Тэгэхээр эхний ээлжид үе шаттайгаар энийг бууруулах дээр энэ гишүүдийн хэлж байгаа санааг 2 үе шаттай авч явахгүй бол ерөөсөө л төрийн өмчийн компаниудыг татан буулгах юм байна заримыг нь, зарим нь оршин тогтнох юм байна гээд ерөнхий байдлаар хандаад яваад байхаар үр дүн хангалттай хангалттай гарч өгөхгүй байгаа шүү. Энэ дээр давхар анхаарчих нь зүйтэй байх гэж бодож байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

**Д.Үүрийнтуяа:** Ер нь төсвийн тогтвортой бодлого бид нарт чухал л даа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа аль болох бага өөрчилж, энэ чинь төсвийн хувьд бид нарын Үндсэн хууль шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсөв дагаж өөрчлөөд л байвал бид тогтвортой бодлогоо удаан хадгалж чадахгүй л дээ. Тийм учраас бид энэ дараа дараагийнхаа жилийн төсвүүдийг хараач гэж байгаа юм алдагдлыг.

Тантай би санал нэгдэж байна, ТӨК-ийг улс төржүүлэхгүй байх ёстой гэдэгтэй санал нэгдэж байна. Улс төржүүлсэн гэдэг нөхцөл байдалтай бол өнгөрсөн 8 жилийн хугацаанд Эрдэнэт үйлдвэр харин улс төрөөс ангид явсан. Ангид явах боломжийг энэ үе үеийн Засгийн газар, парламент нь олгож явсан. Та судалгааг нь аваад үзчих хэрэгтэй. Энэ хугацаанд улс төрийн шалтгаанаар хэчнээн хүмүүс халагдаж, солигдсон байна гэдгийг нэг судлаад үзчих хэрэгтэй. 49 хувийн хувьд тийм ээ энийг тухайн үеийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

**Ж.Баярмаа:** Юуны өмнө баярлалаа. Ямар ч байсан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад, алдагдалгүй төсөв оруулж ирж байгаад. Гэхдээ яах вэ ерөнхийдөө нөгөө алдагдалтай байна уу, алдагдалгүй байна уу даа гол биш, энэ зардлаасаа үр ашиггүй зардлуудаа хасаач гэсэн ийм ер нь үндсэн зарчим байх ёстой буюу төсвийн үндсэн гол зарчим энэ байгаа юм. Тэгээд хэд хэдэн асуулт байна. Дахиад л хэт өөдрөг ийм төсөв, төсөөлөл байна гэж харж байна. Жишээлбэл дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 95 их наядад хүрнэ, 95,1 гэж ингэж тооцож байгаа юм. Гэтэл энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлтэд бодит өсөлт нэмэх нь инфляц гээд тэгэхээр бодит өсөлтөө бол ДНБ-ийхээ 8 хувь гэж үзээд, тэгээд инфляц 7,2 гэхээр 15,2 хувийн өсөлттэй байх юм биш үү 20 биш гэж үзэхээр энэ чинь дахиад зөрөө нь бараг 4,7 их наяд болж байгаа юм.

Тэгэхээр магадгүй бидний ДНБ-ий хэмжээ маань 95 их наяд биш 90 их наяд болбол яах вэ? Энэ зөрөө алдагдлыг юугаар нөхөх вэ гээд. Энэтэй холбоотой 129 доллароор тооцсон байна тэнцвэржүүлсэн үнийг нүүрсний. Гэтэл энэ олон улсын шинжээчид болохоор 35, манайх бол 10 доллароор бууруулж тооцоод байх шиг байгаа юм. Олон улсын байгууллагын шинжээчид 35 доллароор бууруулж тооцоод байгаа юм. Тэгэхээр энийг манайх яг юун дээр үндэслэж энэ 129 доллар гэж ингэж тооцож гаргасан юм бэ гэдэг 2 дахь асуулт байна.

Тэгээд түрүүний юутай уялдах юм бол энэ түрүүн Ганхуяг гишүүн хэлээд байна л даа. Энэ гүйцэтгэл бараг 1 их наядаар тасрах нь гээд. Тэгэхээр одоо ийм байдалтай байгаа юм чинь ийм өөдрөг төсөөлөл маань дахиад гүйцэтгэл дээрээ алдаа гаргаад нөгөө орлого нь тасрах юм бол яаж нөхөх тийм тооцоо хийсэн бэ?

Тооцоо судалгаа байгаа юу? Тогтворжуулалтын сангаас яах вэ авч болох байх. Гэхдээ тэр нь хүрэхгүй дутах энэ тэр асуудлууд гарвал яах вэ гэсэн ийм 2, 3 үндсэн асуулт байна. Баярлалаа, тэгээд тодруулъя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Энэ тооцоо судалгаанд аягүй эргэлзэцгээдэг юм байна. Тэгэхдээ нэг юмыг улс төрчид мэдээд авчих хэрэгтэй. Мэргэжлийн эдийн засагчид энэ тооцоог хийдэг юм шүү. Гантөмөр юм уу, Оюун-Эрдэнэ хийдэг тооцоо биш. Манай яаманд ажилладаг хүмүүс бол улс төрийн хүмүүс биш. Манай яаманд ажилладаг хүмүүс насаараа тоо бодчихсон хүмүүс. Энэ хүмүүсийн гаргаж ирсэн тоог бид улс төрийн аргаар гуйвуулдаг хүмүүс бас биш. Энэ хүмүүсийн гаргаж ирсэн тоог л бид та бүхэнд уламжилж байгаа. Төрийн бодлого болгож танилцуулж байгаа. Тийм учраас хэт өөдрөг ч юм уу эсхүл хэт доройгоор бид бодоогүй. Байгаа тоог байгаагаар нь л хэлж байгаа. 8 хувь өснө гэдгийг Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоолон бодож байгаа залуучууд өнгөрсөн жил хэлчихсэн байдаг юм л даа. Энийг одоо нэг ингээд зохиогоод, тэрийг унагах бодлогыг бид гаргаад, эсхүл хий хөөрөгдөөд байгаа зүйл биш.

Төсвийн зөвлөл, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн санал бол ирэх оны ДНБ 80-аас 101 их наяд байна энэ хооронд хэлбэлзэх юм байна л гэж байгаа. Эрсдэл байгаа шүү дээ. Зуд болбол эрсдэл ирнэ. Түлш тасарвал эрсдэл ирнэ. Монгол бол эрсдэлтэй улс шүү дээ. Энэ эрсдэлийг хааж явахын тулд түргэн шуурхай ажил хийх нь Засгийн газрын үүрэг. Өөр, өөр option-ыг харж суух нь Засгийн газрын үүрэг шүү. Тийм учраас та бүхэн ингээд улс төрийнхөн тооцоолол хийдэг юм шигээр ойлгож, бид бүхэнд энэ тооны тухайд эргэлзээтэйгээр Их Хурлын индэр дээрээс ярьдгаа цаашид ер нь бодолцоорой. Шаардлагатай бол яг тэр яамны мэргэжлийн залуучуудтай суугаад таныг хэрвээ эдийн засгийн тооцоолол байвал мэтгэлцдэг байх ёстой гэсэн ийм зүйл байна.

Гүйцэтгэл 1 их наядаар тасалсан гээд дахиад ийм цуурхал тарааж болохгүй. Гүйцэтгэл гэдэг чинь хийж байгаа ажил нь дутуу хийгдсэн гэсэн үг. Орлого, зарлагын тэнцэл 1,5 их наядын ашигтай гарсан 10 сард. Тэгэхээр бид орлоготой байгаа. Гүйцэтгэл гэдэг нь сонгууль болоод сонгуулийн жил бол тендерүүд хойшилдог, бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ ажил цалгарддаг. Тендерүүд хойшилсон гэсэн үг. Тэр утгаараа жишээлбэл огт эзэн шалгараагүй байгаа 102 тэрбум төгрөгийн ажлыг ирэх оны төсөв дээрээс бид хасаж байгаа шүү дээ. Нэгэнт эзэн шалгараагүй учраас, хийх хүн нь шалгараагүй учраас тэр тухай ярьж байгаа юм гүйцэтгэл гэдэг нь.

Гэтэл гүйцэтгэл гэхээр орлогын гүйцэтгэлийн тухай ярьж байгаа юм шигээр дахиад ингэж гуйвуулж айхтар тийм мэдэгдэл битгий хийгээрэй гэж хүсмээр байна. Энэ жил орлого давна. Гүйцэтгэлийг бид хүчээр хийж чадахгүй шүү дээ. Тэр хувийн компани, тэр тендер авсан хүмүүсийн ажлын байдал тэр зүйлийг бол.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энэ өнгөрсөн хугацаанд ер нь аливаа Засгийн газар төсөв оруулж ирэхдээ өөрсдийн потенциалыг жоохон нөөгөөд, парламент нь орж ирэхээр нэлээн шахаж ажилладаг байсан цаг хугацаа л даа. Зүгээр яах вэ манай гишүүд мэдээж аливаа асуудалд хашир хандаж байгааг ойлгож байна. Гэхдээ Засгийн газар жоохон зүтгээд өгье гэхээр үгүй ээ чи зүтгэж болохгүй гээд зарим



талаар хандаад байгаа нь их тийм сайн зүйл ч биш байхыг үгүйсгэхгүй. Магадгүй 2 жилийн дотор хүрчих замаа бид энэ байдлаас болоод 4 жил болгож удаашруулдаг, ард иргэдийн боломж хойшилдог, хойшлогддог энэ байдлыг хэдүүлээ их олон талаас нь харж хандах нь зүйтэй байх гэж бодож байгаа. Баярмаа гишүүн тодруулж асуух уу?

**Ж.Баярмаа:** Энэ олон улсын байгууллагууд чинь өөрөөр дүгнээд байгаа юм л даа. Тэгээд нөгөө гүйцэтгэлүүд нь өөр гараад жишээлбэл IMF 7 хувь манай өсөлтийг, Дэлхийн банк ADB 6 хувь гээд гаргаад байгаа юм л даа. Тэгээд гайхаад асуугаад байгаа байхгүй юу. Энэ ямар учиртай юм бол? Энэ олон улсын байгууллагууд нь ингээд тооцоолоод гаргаад байхад манайх арай өөрөөр гараад байх юм. Хэтэрхий өөдрөг байгаа юм биш үү гээд. Энэнээс гадна би зориуд нэг үг хэлье. Ингээд нэг гишүүд попорсон л гэх юм, будилуулсан л гэх юм, байнгын нэг тийм юм яриад байх юм. Гишүүд будилуулж дампууруулсан юм бол Ерөнхийлөгчийн хориг чинь буруу байсан юм биш үү? Яагаад Ерөнхийлөгчийн хоригийг алга ташаад авсан юм. Тэгээд үг болгондоо тэгээд байх юм энэ нэг хэдэн гишүүд попорсон байх, одоо гэмшээд сууж байна гэнэ үү. Хэрвээ тэгж байгаа бол энэ бууруулж орж ирсэн энэ төсвийн төслийг ч гэсэн дэмжихгүй байх ёстой юм биш үү одоо энэ хэлээд байгаа хүмүүсийн логикоор. Би тэгээд нэг юм уншаад өгчихье. Төсвийг алдагдалгүй.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд маань мэдээж энэ чуулганы танхимд өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Тэгэхээр бие биеийнхээ үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхэд аль, аль талдаа халдаж болохгүй. Нэгэнт ард түмнийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүд энэ олон ургалч үзэл бодлыг түгээх эрх нь ч байгаа, үүрэг нь ч байгаа. Зүгээр мэдээж ингээд олуулаа хэлэлцээд асуудлаа шийдвэрлэнэ. Олонхоороо шийдсэн асуудалд цөөнх болсон гишүүд маань хүндэтгэлтэй хандаж байх ёстой байх гэсэн ийм байр суурийг гишүүд хэлж байх шиг байгаа юм. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд хүргэе. Тэгээд ямар ч байсан Засгийн газар маань энэ Их Хурлын гишүүдийнхээ үгийг сонсоод, Ерөнхийлөгчийнхөө хоригийг хүлээж аваад энэ төсвөө алдагдалгүй оруулж ирж байгаад хувь гишүүний хувьд их талархалтай байгаа. Айл гэр ч гэсэн бид жилийнхээ төсвийг орлого, зарлагаа хардаг. Ямар ч байсан аж ахуйн нэгж ч гэсэн орлого зарлагаа хардаг. Хэрвээ алдагдалтай, өртэй байгаад байх юм бол дахиад бизнесийн байгууллагууд зээл авахгүй болдог. Айл өрхөд ч гэсэн амьдрахад хүнд хэцүү болдог. Тэгэхээр ерөнхийдөө энэ төсвийг алдагдалгүй оруулж ирж байна гэдэг энэ парламент 126 гишүүнтэй болсны хамгийн том илрэл, хамгийн сайн давуу тал гэж харж байгаа юм. Яагаад гэхээр урьд урьдын жилүүдэд дандаа алдагдалтай баталдаг. Тэгэхээр энэ удаа арай нэг өөр өнгө аяс орж ирж байна гэж харж байна 1 дүгээрт.

2 дугаарт гэвэл бид энэ төсвөө тэлчихсэн үү гэвэл тэлчихсэн шүү дээ. 2024 оны төсөв хэд байлаа 27 их наяд байсан, дараа нь 30 болгосон. Тэгээд ингээд 2025 оных чинь 33,4 гээд 10 хувь өсөөд ороод ирсэн. Тэгэхээр тэлсэн үү тэлсэн. Дээрээс нь ААН-үүд дээр очиж өгөөж нь очих ёстой төсвөө хэтэрхий танаад байвал очдоггүй л гээд байдаг. Яг үнэнийг хэлэхэд 10 хувиар ингээд тэлчихсэн байна 1-д.

2-т гэх юм бол энэ чинь нийт ДНБ-ий 35 хувь гэвэл 65 хувиа дэмжих талаар л яриад байгаа шүү дээ бас. Нөгөө 65 хувь буюу нөгөө ААН-ээ яаж дэмжих юм бэ? Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаа яаж татах юм бэ? Дотоодынхоо энэ

үйлдвэрлэгч ААН-ээ яаж дэмжих юм бэ? Ингэснээрээ мэдээж дараа жилийн энэ төсөв бол дахиад орлого нь нэмэгдээд явна гэж сайн талаас нь харж байгаа шүү.

Асуулт. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад тэнцвэржүүлсэн орлогыг 33 их наяд гэж харж байгаа. Нөгөө талдаа төсвийн суурь зарлагын дээд хэмжээг 30 их наядаар ингээд 30,2 их наядаар оруулж ирж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.6 дээр байгаа суурь тэнцэл 3,3 их наядаар ашигтай гарсан бол 6.6 дээрээ юу гэж заасан бэ гэхээр энэ Засгийн газрын үндсэн зээлийн төлбөрт зориулагдана гэсэн байгаа ашиг нь. Тэгэхээр яг энэ Засгийн газрын зээлийг нөгөө талд нь зээлийг нь харахаар яг энэ ингээд тусгагдаагүй байгаад байх юм. Энэ дээр тодорхой Жавхлан сайд байсан бол Сангийн сайд байсан бол асуух гэсэн, байхгүй байгаад байдаг. Энэ хуулийг яаж хэрэгжүүлсэн бэ? Энэ дээр нэг тодруулга авчихъя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Лувсанн्याмын Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Яг тэр тухайд бол төсвийн хэлэлцүүлгийн үеэр Жавхлан сайдаас тодруулаад асуучих нь зөв байх. Өр төлөгдөнө шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

**Г.Очирбат:** Харин энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай, хууль дээр 6.6 дээр хэрвээ ашигтай нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай буюу 3,1 их наядын ашигтай ингээд оруулаад ирж байгаа юм, ингэсэн бол 6.6-гаараа Засгийн газрын өрийг өрнөөс хасагдуулах ёстой. Тэгээд тэр тал дээрээ бичилт хийгдээгүй болохоор гайхаад 1 дүгээрт асуугаад байна.

2-т гэх юм бол ард иргэд энэ ярьж байгаа шүү дээ. Монгол Улсын нийт өр бол нэг хүнд бараг 35, 6 сая төгрөг болчихсон. Засгийн газрын өр бараг ингээд 10 орчим сая төгрөг хүрчихсэн. Тэгэхээр яг энэ хуулиа хэрэгжүүлээд нөгөө талаасаа тэр Засгийн газрын зээлээс хасагдуулах ёстой гэж бодож байгаа. Хэрвээ ингэж байж бид Засгийн газар чинь дахиад олон улсад их цэвэр харагдана. Төсөв нь их ил тод юм байна, олсон орлогоосоо мэдээж зээлээ төлдөг юм байна, эргээд буцаад харилцахад их төвөггүй болох юм болов уу гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр Жавхлан сайдаас бас дараа нь төсөвтэй холбоотой асуулт асууя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Хүн зээл авахдаа тодорхой хугацаатай авдаг, хүү тохирдог, өгч байгаа хүн бол тэр үед мөнгөө ашигтай байлгана гээд тооцоолоод өгчихсөн, түрүүлээд буцааж өгч болдоггүй юм. Яагаад гэвэл авсан хүнийхээ өмнө хариуцлагагүй хандаж байгаа хэрэг 1 дүгээрт. Тийм учраас бид энэ хөрөнгийг Засгийн нөөц хөрөнгөд бүртгээд авчихдаг. Бид хөрөнгөжөөд л байгаа, хөрөнгөжөөд л байгаа гэж ойлго. Энэ байгаа мөнгөө ирэх жил төлчхөөч гээд байна. Төлөхөөр доллар болчихдог юм. Доллар болохоор нөгөө валютын нөөц гэдэг асуудал чинь хөндөгдөнө. Тийм учраас бид төгрөгийн нөөцөө нэмэгдүүлэхийн зэрэгцээ энийгээ валютын нөөцөө улам нэмэгдүүлж яваад, төлбөрийг бол цаг тухайд нь төлөөд явах юм Очирбат гишүүнээ. Түүнээс биш одоо манайд мөнгө байгаа, байгаа гээд шууд бүгдийг нь төлбөр болгоод өгөхөөр тэр чинь доллар

болоод гараад явчихдаг. Гэтэл манай доллар нь хомс байхгүй юу даа. Тэгэхээр бид доллароо улам илүү.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

**Г.Очирбат:** Тэгээд бид чинь ингээд нөгөө хууль батлах дээд байгууллага парламент. Тэгээд энэ чинь батлагдсан хууль байгаад байдаг. Тэгээд хуулиа дагахгүй, тэгээд ингээд хадгалж байх ёстой юм гээд байгаад байдаг. Яагаад гэхээр валютын нөөц хомсдоод байна гэдэг шалтгаанаар. Тэгвэл энэ хууль батлах ер нь хэрэг байгаад байгаа юм уу? Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.6 бүгдээрээ Их Хурлын гишүүд нэг анхааралтай уншчихаарай.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд гүйцээж хариулья.

**Л.Гантөмөр:** Ер нь Засгийн газрын авч байгаа зээлийг Их Хурал баталж авдаг юм, хуулийн түвшинд л баталж байгаа ийм хугацаатай, ийм хүүтэй, ийм хугацаанд та нар буцаагаад төлнө гээд. Энэнийхээ дагуу төлбөр хийгдэнэ, төлөх ёстой зээлээ төлөхгүй байгаа юм шигээр ерөөсөө ойлгож болохгүй шүү Очирбат гишүүнээ. Таны ярьж байгаагаар бол төлөх ёстой төлбөрөө та нар төлөхгүй хойшлуулж байгаа юм байна гэж ингэж уншигдаж байна шүү. Бид төлбөрийг цаг тухайд нь төлнө, хүүг цаг тухайд нь төлнө энд та эргэлзэх хэрэггүй.

**Д.Амарбаясгалан:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

**Д.Ганмаа:** Сайн байцаана уу? 2 товчхон асуулт байна. Төсвийн зарлагаа бууруулаад алдагдалгүй болгоод оруулж ирж байгаа юм байна. Тэгээд энэ төрийн зардал буурсантай холбоотойгоор энэ эдийн засгийн өсөлт бусад макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд нь хэрхэн нөлөөлж байгаа вэ? Их богинохон хугацаанд, маш хурдан ажиллаж оруулж ирсэн учраас ийм тооцоо тооцооллоо хэр зэрэг үндэслэлтэйгээр гаргаж шийдсэн бол? Ер нь хийсэн үү гэдгийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт энэ алдагдалгүй төсөв баталсантай холбоотой эдийн засаг дахь төрийн оролцоо харьцангуй хумигдах гэж байгаа гэсэн хүлээлттэй байгаа. Нөгөө талд нь болохоор энэ хувийн хэвшлүүдийн орон зай илүү нээлттэй болох гэж байгаа, боломж гарч ирэх гэж байгаа гэж бүгд хүлээлттэй байгаа байх. Тэгэхээр яг хувийн хэвшлүүд яаж идэвхжих вэ? Мөн гол, гол энэ идэвхжих сувгууд нь юу вэ? Энийг Эдийн засгийн яамны талаас асууя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулья.

**Л.Гантөмөр:** Төсвийн зардал 2,3 их наядаар буурч байгаа юм. Тэгэхдээ энэ мөнгө ингээд нэг өдөр алга болчих мөнгө биш шүү дээ. Эсвэл зах руу нэг өдөр нийлүүлдэг бол мөнгө бас биш. Тийм учраас эдийн засгийн өсөлтөд шууд хамаарал байхгүй. Эдийн засгийн өсөлт 0,1-ээс +, -, 0,5 +, - энэ бол байх асуудал. Бид зорилтоо 8 хувь гээд тавьчихсан. Энийг бид шинээр зохиогоогүй. Энэ бол жилийн өмнө батлагдсан тоо гэдгийг дахин хэлмээр байна. Энийг хангахын тулд бид хувийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл дээр нь гаднын хөрөнгө оруулалт гээд эрх зүйн орчноо сайжруулах гээд энэ бүх зүйлээрээ нөхөөд явна Ганмаа гишүүнээ. Тэгэхээр энэ дээр тооцооллын алдаа 1 дүгээрт гарахгүй гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт хувийн хэвшил ер нь яагаад төсөв багасахаар хувийн хэвшил яагаад сайжирдаг вэ гэдэг асуултыг гишүүд асуугаад байгаа юм. Энэ бол юу вэ гэхээр төсвийн зардал буухаар нөгөө үндсэн макро эдийн засгийн үзүүлэлтүүд дотор одоо бид инфляцаа 7,5-аас 7,2 гээд оруулаад ирж байна шүү дээ. Үнийн өсөлт буурч байгаа юм. Мөнгөний нийлүүлэлт багаслаа гэсэн гэсэн үг. Энэ хэмжээгээр зээлийн гаралт нэмэгдэх юм байна гэдэг ийм л хүлээлт бий болно. Нэг үгээр хэлбэл Төв банкны бодлогын хүү буурах боломж энэ дээр гарах болов уу гэж харж байгаа юм. Тэгэхдээ бидний тооцоолж байгаагаар ирэх оны эхний 1 юм уу, 2 улиралд ийм боломж гарахгүй. Яагаад гэвэл манай импорт бол одоо тулчихсан байгаа, тулчихсан байгаа. Тийм учраас бид энэ импорт, экспортынхоо харьцааг хараад явж байхад юу харагдаж байгаа вэ гэвэл эхний 2 улиралд мөнгөний нийлүүлэлтийг хийхэд хүндрэх юм байна. Яагаад гэвэл зээлийн хэмжээ ч гэсэн энэ оны түвшинд хангалттай өндөр түвшинд гарчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энийг бүүр ингээд шарик юм шиг үлээгээд хагалчхаж ерөөсөө болохгүй. Тийм учраас энэ халалтыг харин бид яг ердийн түвшинд аваачихын тулд тэвчээртэй 2 улиралд явах ёстой гэдэг ийм зүйл харагдаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Даваагийн Цогтбаатар гишүүн, Ганмаа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж асууя.

**Д.Ганмаа:** Энэ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд нь нөлөөлөхгүй гэж хариуллаа гэж ойлголоо. Зөв үү 1 дүгээрт? 2 дугаарт тэр хувийн хэвшлүүдийн идэвхжих суваг ямар байдлаар идэвхэжнэ гэж харж байгаа вэ? Энэ дээрээ хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр харин би уг нь түрүүн тайлбарлалаа шүү дээ. Жишээлбэл хувийн хэвшил яаж идэвхжих вэ гэхээр нэг талаараа хувийн хэвшилд энэ худалдан авалт унана. Ялангуяа манай үйлчилгээний салбарууд энэ 2,1 их наяд чинь явж байгаад л манай үйлчилгээний салбарт очоод дуусдаг юм шүү дээ. Тэгэхээр үйлчилгээний салбар тэр консерв хийдэг, боорцог хийдэг, ундаа үйлдвэрлэдэг энэ хэсгийн худалдан авалт автоматаар 2,1 их наяд хасагдаж байна гэж ер нь бид ойлгочих хэрэгтэй 1 дүгээрт.

2 дугаарт хувийн хэвшил хүсээд байгаа зүйл нь хүү бууруулаач гэдэг асуудал хүсээд байгаа юм. Тэгэхээр бид бол энэ зардлаа бууруулснаар юу болох вэ гэхээр хүү буурах боломжийг олгож байгаа юм. Хүү хэзээ буурах вэ гэхээр Төв банкны бодлогын хүү буурч байж буурахаар байгаа юм. Гэхдээ Төв банкны бодлогын хүү бол эхний 2 улиралд буухааргүй байгаа шүү гэдгийг би хэлж байгаа юм. 3 дугаар улирлаас, магадгүй ирэх 4 дүгээр улирлаас бодлогын хүүгээ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Алдагдалгүй төсөв батлах чиглэлд санаачилгатай ажиллаад, тодорхой хэмжээний үр дүнд хүрээд, Засгийн газраас анхны алдагдалгүй төсвийг оруулж ирж байгаад талархалтай хүлээж авч байгаа. Тэгээд 8 сарын 30-ны байдлаар төсөв өргөн барьж байх үеийн дэлхийн нөхцөл байдал нэлээн өөрчлөгдөж байгаа. Жишээлбэл

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль болсон. Үүнтэй холбогдолтойгоор АНУ болон Хятад улсын худалдааны талаарх асуудлууд нэлээн өөрчлөлттэй орж ирэх байх. Тэгээд Хятад улсын худалдааны асуудал дээр өөрчлөлт ороод ирэхийн цагт манайтай холбоотой гарч байгаа эрдсийн бүтээгдэхүүний үнэд нэлээн өөрчлөлт орох байх. Тэгэхээр энэ дэлхийн нөхцөл байдлын өөрчлөлтүүд болон энэ эрдсийн үнийн өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүдийг ямархуу байдлаар тооцоолж байгаа вэ гэж асуулт байгаа.

**Д.Амарбаясгалан:** Лувсаннъямын Гантөмөр Тэргүүн Шадар сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Бид зүгээр Трампын ялалтыг шууд Хятадын эдийн засаг өсөхгүй юм байна гэдэг тухайд харахгүй байгаа шүү. Хятад, Америкийн эдийн засаг интеграцид орчихсон эдийн засаг. Тэр зах зээл аль, аль нь интеграцид орчихсон, аль, аль нь өөрийнхөө үнэт цаасыг нөгөөдөх нь хамгийн том эзэмшдэг. Ер нь Хятадыг муужрууллаа гээд Америк нэг сайжрах юм ерөөсөө байхгүй. Америкийг муужрууллаа гээд Хятад сайжрах юм ерөөсөө байхгүй. Тодорхой салбаруудын өрсөлдөөн л яригдах байх. Магадгүй өндөр технологи дээр хэн нь яах вэ? Жишээлбэл Хятад тодорхой үнэт металлуудыг Америк руу зарахаа болилоо гээд л 2 өдрийн өмнө мэдэгдсэн. Ингэснээр Америк дахиад л хохирно.

Жишээлбэл Америкийн үнэт цаасыг хамгийн их авчихсан байгаа нь Хятадын Засгийн газар шүү дээ Хятад. Тэгэхээр энэ холбоосноос илүүтэйгээр Хятад өөрөө дотоод хүчээ хэр дайчлах вэ гэдгийг хараад байгаа юм. Хятад бол бүс нутгуудын эдийн засгийн төлөвлөлтийг 4,9-өөс 5,2 хувь өсгөнө гэдэг ийм тодорхой төлөвлөлтийг хийчихсэн. Тэгээд яг энэ төлөвлөлтийнхөө дагуу явна. Энд бид эргэлзэхгүй байгаа. Гол нь тэр том зах зээл рүү бид хэрхэн нэвтрэх вэ гэдэг даалгавар байгаа юм. Нэвтэрч чадах юм бол тэнд унасан, боссоноос үл хамаараад бидний бүтээгдэхүүн зарагдана. Бид нэвтрээгүй байж, яаж нэвтрэх шийдлээ гаргаагүй, эцсийн нэвтрэлтээ хийгээгүй байж тэр зах зээлийн тухай төсөөлөөд байгаа нь жоохон өрөөсгөл юм билээ. Тийм учраас удахгүй энэ хил холболтын асуудлыг бид яалт ч үгүй шийдэх хэрэгтэй. Ингэж байж магадгүй тэр зах зээл манай зах зээл болно. Тэр зах зээл дээр бид бүтээгдэхүүнээ зардаг болно. Ингэснээр тогтвортой өсөлт бий болох юм гэдгийг ойлгох хэрэгтэй.

**Д.Амарбаясгалан:** Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

**Б.Заяабал:** Баярлалаа. Тэгэхээр энэ төсвийн энэ тогтвортой байдал Монгол айл өрхийн, Монгол Улсад бизнес эрхэлж байгаа энэ бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаагаа төлөвлөх, орлого, зарлагаа төлөвлөх хамгийн чухал зүйл. Тийм учраас төсөв тогтвортой байх ёстой гэдэг ийм бодлого явдаг. Энийг хуульчилсан бие даасан Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай. Энэ хууль дээр орсон нэг зөв заалт байгаа 7.5 дахь заалт. Энэний дагуу энэ төсвийн дунд хүрээний мэдэгдэл батлагдсанаас 3-аас, 3 сараас доошгүй хугацааны өмнө төсөв өргөн барихгүй, төсөвт өөрчлөлт оруулахгүй гэсэн ийм заалт маань 25 оны 1 сарын 1-нээс хэрэгжих юм байна. Хэрэгжих юм байна. Тэгэхээр энийг цааш цаашдаа бид анхаарч явах ёстой юм байна, ийм чухал заалт байгаа юм байна гэдгийг 1 дүгээрт би хэлэх гэсэн юм.

2 дугаарт нь энэ төсөв боловсруулах дээр бид энэ олон талын оролцоог хангаж өгсөн байгаа. Энэ жил ялангуяа сая Гантөмөр сайд хэлж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ жилээс эхлээд ингээд төсвийн боловсруулах



шатад орж ирж байгаа. Ялангуяа төсвийн хүрээний мэдэгдэл дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хуулийн дагуу үүргийнхээ дагуу оролцож явдаг. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэхгүй иргэд, олон нийтийн байгууллагуудын оролцоог хүртэл бид энэ Төсвийн хуулиараа оруулаад өгчихсөн байгаа. Цааш цаашдаа энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл шиг иргэд өөрсдөө ажилладаг ийм хэмжээнд чадавжаад цаашдаа төсвийн боловсруулалт сайжраад явна гэж ингэж харж байгаа.

Ер нь олон улсын жишгийг бид судлах ёстой байх гэж ингэж бодож байгаа. Төсвөө өөрөө боловсруулж оруулж ирээд, батлаад, буцаад өөрөө хэрэгжүүлээд явдаг энэ зарчим зөв үү, үгүй юу? Олон улсын ямар жишиг, сайн жишгүүд байна. Энийг бид судалж явах ёстой гэж бодож байгаа. Тийм учраас энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг бид оруулж ирсэн дүгнэлтийг бид анхаарч үзэх ёстой юм. Манайдаа л байдаг мундаг эдийн засагч энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд ороод ажиллаж байгаа юм байна лээ. Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр, зөвлөлийн дүгнэлтийг бид онцгой анхаарч ажиллах ёстой.

Энэ удаагийн энд орж ирж байгаа төсөв дээр дахиад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн дүгнэлтэд өгсөн хэд хэдэн хуулийн заалтууд хангагдаагүй байна гээд бас дүгнэлт дээр ороод ирчихсэн байна. 1.5-д байгаа тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>б</sup> дахь заалт хангагдаагүй байна. Нөгөө макро эдийн засгийн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол тэрний үндэслэл, шалтгааныг дурдаж, тайлбарыг төсвийн хүрээний мэдэгдэлтэй хамт өргөн барих ёстой гэж байгаа. Энэ тайлбар чинь хангагдаагүй байна. 1.6 дээр нь байгаа тэр 12.3-д байгаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд агуулагдах ёстой гол агуулагдах мэдээллүүд чинь тусгагдаагүй байна гээд ингээд ороод ирчихсэн байгаа.

Ерөнхийлөгчийн хоригийн үндсэн нэг заалт нь тийм шүү дээ. Энэ Үндсэн хууль дээр байгаа төрийн үйл ажиллагааны хуулийг мөрдөх зарчим, хуулийг дээдлэх зарчим чинь алдагдсан байна гэдэг ийм агуулгаар Ерөнхийлөгчийн маань хориг тавигдсан шүү дээ. Тэгэхээр энэ хуулийн заалтууд чинь дахиад ингээд тусгагдаагүй орж ирж байгаа дээр энэ дээр ямар хариулт байгаа юм бэ гэдэг ийм асуулт байгаа.

3 дугаарт нь энэ төсөв сая манай нэлээдгүй гишүүд ярьж байна. Орлогын, зарлагын тэнцэл гээд. Ингээд алдагдалгүй төсөв баталж орж ирж байгаа нь нэг талдаа мөнгөний бодлого талдаа нэлээдгүй орон зайг гаргаж өгч байгаа. Мөнгөний бодлого зөөлөн бодлого явах боломжийг үүсгэж байгаа боловч нөгөө талдаа Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжихэд аягүй хүндрэлтэй байдал руу оруулж байгаа нь үнэн. Бид хамтарсан мөрийн хөтөлбөрийг 590 орчим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ гээд заачихсан. Тэгэхээр мэдээж хамтарсан Засгийн газар байгуулагдсан учраас төсөв алдагдалгүй гэж байгаатай холбоотой бид мөрийн хөтөлбөрөө биелүүлж чадахгүй гэж хэлэхгүй байх. Энэ дээр ямар бодлого, ямар төлөвлөлт та төлөвлөж байна вэ гэсэн ийм асуултуудыг асууя. Дээрээс нь энэ олон улсад энэ төсвийг бид зайлшгүй ингээд зарлагаа бүрэн хангана гэдэг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулья.

**Л.Гантөмөр:** Ер нь бид өсөлтөө барьж явахын тулд төлөвлөлтөө их сайн хийх хэрэгтэй. Бид гарсан төлөвлөлтийг хэрхэн ажил хэрэг болгох вэ гэдэг маш тодорхой нарийвчилсан төлөвлөгөөнүүдийг гаргах учиртай. Жишээлбэл 14 мега төслийн хувьд бид төлөвлөлт хийгдсэн байна, нарийвчилсан төлөвлөгөө эцэслэгдэж гараагүй байна. Энийг ондоо багтаагаад бид нарийвчилсан төлөвлөгөөгөө гаргаад явах ёстой. Ингэж явахдаа бидний хамгийн чухал асуудал бол хувийн хэвшил буюу гаднын хөрөнгө оруулагчдыг хэрхэн татан оролцуулах вэ, тэр үүд хаалгыг хэрхэн томруулах вэ, нээх вэ, тэр хамтрах хамтралын хөрс суурийг хэрхэн сайн боловсруулах вэ гэдэг зүйл хамгийн чухал байна. Тийм учраас энэ ондоо багтаагаад хэдүүлээ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиа баталчих нь зөв. Тэрний хэлэлцүүлгийг улс төржихгүйгээр тал талаасаа ажлын хэсгүүд маш сайн ажиллаад, ингээд энийг маш ойрын хугацаанд баталж, энэ нь өөрөө гадна талдаа зөв суурь болж зарлагдана.

Энэ зарлагдсан хүрээнд өнөөдөр яг 14 мега төсөлд хөрөнгө оруулагчид хангалттай байна. Тэнцвэрийн асуудал байна бодит байдал дээр. Нэг улсаас хэт хамааралтай хөрөнгө оруулалттай байхгүй байх, олон талт хөрөнгө оруулалтыг бий болгох, энэ тэнцвэрийн асуудал байгаа учраас бид энэ сууриа зөв болгочихвол магадгүй олон талт хөрөнгийн хөрөнгө оруулалтын орчноо бүрдүүлж чадах юм бол бид энэ томоохон төслүүдийг явуулна.

Нөгөө талдаа энэ төслүүд өөрөө яагаад онцлоод байгаа юм бэ гэхээр дандаа улс төртэй юм байна лээ. Тэр улс төрийг хэдүүлээ давмаар байгаа юм. Парламент энэ хамтарсан Засгийн газрын хамгийн том даалгавар улс төржилтөөс болоод яваагүй зарим нь 10 жил, зарим нь 20 жил гацчихсан байгаа ажлуудыг бид хөдөлгөө гэдэг энэ улс төрийн ойлголцол нь өөрөө энэ 14 төслийг онцолж байгаа онцлог юм байгаа юм. Нөгөө талаар гадаадын бодлого энд орж ирдэг. Тэр гаднын бодлогыг давахын тулд бид талцалгүйгээр энэ ажлуудын ард гарах гэдэг ийм зүйл байна. Тийм учраас бид ганцхан төсөвт дулдуйдалгүйгээр нэгэнт парламент шийдвэрээ гаргачихсан. Тийм учраас бид олон option харж, олон эх үүсвэр харж цаашаагаа нөгөө эх үүсвэрүүдийнхээ орчныг харин яаралтай сайжруулах чиглэлээр ажиллах нь зөв байх гэж бодож байна. Тэр дунд хугацааны Жавхлан сайдаа, Энхбаяр сайд, дунд хугацааны бодлогын баримт бичгийн тухай та нэг хариулчих уу. Та 2 буу халаад, Заяабал гишүүний асуултыг сонсоогүй юу.

**Д.Амарбаясгалан:** Батжаргалын Заяабал гишүүн тодруулж асууя.

**Б.Заяабал:** Би сая асуултдаа хариулт бүрэн авч чадсангүй л дээ. Тэгээд уг нь асуулт, хариулт сонсоод үргэлжлүүлж асууя гэж бодож байсан. Түүн дээрээ нэмэлт хариулт надад өгөөрэй. Өөрөөр хэлбэл хуулиар Тогтвортой байдлын тухай хуулийг хангаж энэ төсвийн тогтвортой байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл орж ирээгүй байна гэдэг ийм зүйл асуусан. Түүн дээр тодорхой хариулт өгөөрэй.

Ер нь бид энэ орлого биелэхгүй бол яах вэ гэдэг ийм асуудал үүсэхээр зэрэг мэдээж хүссэн, хүсээгүй алдагдал руу орно. Төсвийн алдагдал руу орно. Тэгэхээр бид энэ алдагдлаа бууруулахын тулд Засгийн газар өөрийнхөө зарлагыг хянах үүднээс энэ Засгийн газрын үйл ажиллагаа дээр бид дахин энэ инженерчлэл хийх, дахиж эргэж харах ийм зайлшгүй шаардлага байгаа юм болов уу гэж ингэж харж байгаа. Сая энэ Трампын, Трамп ялсантай холбоотойгоор Засгийн газрынхаа бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг ярьж байна. Тэндээ энэ үр ашгийн яамыг

байгуулахтай холбоотой асуудал ярьж байгаа. Тэр яамыг толгойлж ажиллах хүмүүс нь тодорхой саналуудыг энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Заяабал гишүүний асуултад хариулъя. Гантөмөр гишүүнээ сайдаа юу биз дээ 25 оны төсвийн хүрээ, 26, 27 оны төсвийн хүрээний төсөөлөл гээд энэ мэдэгдэл бүтнээрээ ороод ирчихсэн байгаа шүү дээ. Жишээ нь тэнцвэржүүлсэн тэнцэл тэг, тэг гээд ороод ирчихсэн байж байгаа. Энэ чинь дандаа яг 26, 27 оны төсөөлөл гээд 3 жилийнхээрээ бүтнээрээ ороод ирчихсэн. Ингээд өнөөдөр хүрээгээ яриад сууж байгаа 1-д.

2-т хэрвээ орлого дээр эрсдэл үүсээд, төлөвлөлтөд өөрчлөлт орох юм бол бид Төсвийн хуулиараа суурь хуулиараа тодотгол хийх нөхцөл үүсээд, тодотгол хийгээд зардлуудаа танаад, хөрөнгө оруулалтуудаа мөн бууруулаад ингээд явдаг байгаа. Тэгэхдээ энд ийм юм байгаа шүү Заяабал гишүүнээ. Тогтворжуулалтын сан бид нэг үеэ бодвол овоо хуримтлалтай болж ирж байгаа. Энэ жил 1,8 байгаа одоо байгаа нь.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Минут нэмж өгье.

**Б.Жавхлан:** Энэ 24 оных дээр бид 600-гаад тэрбум төгрөгийн нэмэлт орлого олно Тогтворжуулалтын сан руу. Ингээд нийлээд 2,4 их наяд төгрөгийн ирээдүйд хэрвээ тогтворжуулсан орлого буураад, алдагдал үүсэхээр бол энэ сангаар нөхөх бас бидэнд боломж байгаа. Өөрөөр хэлбэл орлого дутвал эхлээд энэ рүүгээ орно, 2,4 их наядаас илүү орлого таслалдах юм бол бид зарлага руугаа орно, хөрөнгө оруулалт руугаа ороод явдаг, тодотгол хийгээд явдаг ийм л зарчмаар явна. Тийм. Харин загварчлал, хөгжлийн бодлогын загварчлал, орлогын загварчлал, хөрөнгө оруулалтаас ДНБ-ий өсөлтөд нөлөөлөх энэ загварчлалууд дээрээ бид өөрчлөлт хийх юм бол байлгүй яах вэ.

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Батбаатар:** Хориг хүлээж авсан, аваагүй, талархаж байна, талархахгүй байна гэдэг яриад байгаа зүйл ч нэг их тийм зөв биш юм шиг байгаа юм. 2024 онд энэ Засгийн газар байгуулагдсанаас хойш бид 4 дэх, 5 дахь удаагаа ингээд төсөвтэй холбоотой хэлэлцүүлэг явж байна Улсын Их Хурлын чуулганаар. Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэсэн нэртэй гэрээ дээр үндэслэсэн Засгийн газар ажиллаж байгаа. Анх Засгийн газар байгуулагдах, Засгийн газрын сайд нар томилогдох үед, тэрний дараа орж ирсэн Төсвийн тодотголын үед та нарын нөгөө мөрийн хөтөлбөр хааччихав гэхэд хариулт нь ирээгүй. Засгийн газрын сайдууд томилж байгаа суурь үндэслэл чинь юу юм бэ, тэр Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэдэг гэрээнийхээ хувийг өгчхөөч гэхэд өгөөгүй.

Тэгэхээр юун дээр үндэслэж Засгийн газар буюу Их Хурлын 118 гишүүн шийдвэр гаргаад байна вэ гэдэг нь их эргэлзээтэй болчхож байгаа юм. Үндэслэж байгаа суурь үндэс, зарчим, гэрээ юун дээр суурилж байгааг нь мэдэхгүй байгаа учраас та бүхнийг ойлгохоо байчхаж байгаа юм. Зориг гэдэг бол олон дотор, олонх дотор нуугдаж байхыг зориг гэж хэлэхгүй. Цөөнх дотор ил гараад зогсож байхыг илүү зориг гэнэ. 3 нам ард түмэнд амласан мөрийн хөтөлбөрөөсөө ухарлаа гэдгээ энэ дахиж орж ирж байгаа төсвөөрөө дахиад нотолж байгаа шүү дээ. 3 намын

мөрийн хөтөлбөр дээр ДНБ-д эзлэх төсвийн зохистой хэмжээ 25 хувь дотор багтана гэж 3-ланд нь байж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл энэ 26, 27 онд 33 хувьтай байхаар л тавьж байгаа шүү дээ. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх хэмжээгээр тэр 25 хувьтай төсвийнх нь зардал нь орж ирэх тухай огт ойлголт алга. Дараа нь энэ 3 нам гурвуулаа иргэд, сонгогчдод амласан мөрийн хөтөлбөрөөс ухарч байна гэдгээ өнөөдөр нотолж, энэ төсвөө батлах гээд сууж байна гэдгийг дахин сануулмаар байгаа юм.

Мөн тэр Засгийн газар ашиг олдог биш, иргэд нь ашиг олдог, Засгийн газар татвараа авч, тэрийгээ хэрэгтэй зүйлд нь зардаг, хяналттай зөв захиран зарцуулдаг энэ чиглэл рүүгээ явах хэрэгтэй. 120 гаруй ААН байна гэж байна, 40 гаруй нь ашигтай, бусад нь ашиггүй ажилладаг, алдагдал үйлдвэрлэдэг гэж байна. Энэ ашигтай ажилладаг улсын үйлдвэрийн газрууд ч гэсэн энэ ашгийн зах зээлээсээ гарах хэрэгтэй шүү дээ. Иргэд, сонгогчид нь, иргэд нь ашиг олж, Засгийн газар нь татвараа авдаг энэ суурь зарчим руугаа шилжихгүйгээр ашиггүйг нь татан буулгана, ашигтайг нь бид улам төгөлдөржүүлнэ, илүү их ашиг олно, иргэдтэйгээ ашгаар өрсөлдөнө гэдэг ийм бодлоготой явж байж болохгүй.

Тэгэхээр Иргэний зориг ногоон намын мөрийн хөтөлбөрт Хятадын ардын банкт байгуулсан своп хэлцлийг эдийн засаг, улс төрийн аргаар тэглэнэ гэдэг ийм зүйл, заалт орсон байсан. Сая 7, 8 сард энэ своп хэлцэл тал хувиараа буурсан. Монголбанкны Ерөнхийлөгч энд мэдээлэл хийхэд Мөнгөний бодлого ярихад хэлж байсан. Тэргүүн Шадар сайд хэллээ. Бид нарын мөрийн хөтөлбөрөөс зарим нэг заалт Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон. Энэ бол тодорхой хугацааны дараа буурна. Тийм болохоор 118-ыг бүрдүүлж байгаа намууд 24 оны сонгуульд орсон мөрийн хөтөлбөрөөсөө ухарч байна гэдгээ нотолж байна гэдэг дээрээ хэлмээр байгаа юм. Үгүй ээ бид өөрчлөх гэж байгаа юм уу, үгүй юм уу гээд.

**Д.Амарбаясгалан:** Жадамбын Энхбаяр сайд асуулт асууя. Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

**Б.Батбаатар:** Үгүй ээ энэ хариулахгүй байхаар хариулж өгөөч гэдэг тодруулгаа эхлээд хэлчихье. 3 намын дарга юм уу, нэг бол тэр бүлгийн дарга нар нь байгаа шүү дээ энд. Мөрийн хөтөлбөртөө бүгдээрээ 25 хувь дотор барина, 23 хувьд, 20 хувьд барина гээд орж ирсэн шүү дээ. Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэдэг нэртэй тэр гэрээгээ өгчих гэхээр өгөхгүй нуугаад байгаа шүү дээ. Засгийн газар сайд нар томилогдох байгуулагдах чинь улс орны асуудал шүү дээ. Хувь хүмүүсийн хоорондох гэрээний, наймааны асуудал биш шүү дээ. Дараа нь олон дотор нуугдаад энэ 3, бид 3 хамт байсан учраас мөрийн хөтөлбөрөө хийгээгүй гэдэг зүйлээ өнөөдөр хариулаад өгөөч л гэж байгаа шүү дээ. Нэг бол тэр 25 хувьдаа барих юм уу? Төсвийн төсөөлөл дээр 27 онд 33 хувь гэж байгаа шүү дээ. Энэ чинь 25 дээрээ очихгүй юм уу?

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулья.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр бид юу гэдэг юм намын дарга нарын нэг бол улс төрийн мэтгэлцээн энд яваагүй. Энд яг парламент өөрөө ирэх оны төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг ярьж байгаа. Яг ингээд талцахаараа улс төржөөд нэг ийм юм яриад байдаг учраас бид улс төржихгүйгээр хөгжлийн төлөө зориг гаргаж байгаа юм. Муу хэлэгдэх, тэр яллагдах тэр эр зоригийг бид гаргая гэж байгаа юм. Хамгийн гол зүйл ДНБ-ий нэг хүнд оногддог хэмжээг 10 мянган долларт хүргэнэ.

Тэгэхийн тулд улс төржилтийг хойшоо тавина. Энэ үгэндээ байгаа. Бидэнд дахиад хэлэхэд бууж өгдөггүй зориг байгаа. Бид бууж өгөхгүй. Тийм учраас бидний ажлыг тэртээ тэрэнгүй 4 жилийн дараа ард түмэн дүгнэнэ. Тэр үед бид харин нэг хүнд оногддог ДНБ-ээ 10 мянган долларт хүргээгүй байвал Батбаатар дарга бид нарын амыг асуух хэрэгтэй. Тийм учраас энэ Монгол орны эрх ашиг 1 дүгээрт юм гэж ингэж хамтарсан Засгийн газрын гэрээ хийсэн. Тэр тийм, танаас нуугаад байх юм байхгүй. Нээлттэй. Тэр гэрээ дээр үндэслэсэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг бид Их Хуралд өргөн барьсан. Тэр бол нээлттэй. Энд намуудын мөрийн хөтөлбөрийн 70-аас 80 хувь нь бүрэн шингэсэн. Энийг бид ажил хэрэг болгоно, энэ дээр эргэлзэх зүйл алга байна.

**Д.Амарбаясгалан:** Жадамбын Энхбаяр сайд асуулт байхгүй байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

**Б.Жаргалан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид анх удаа улсын төсвөө баталчхаад, тэгээд хүчингүй болгоод, дахиж хэлэлцээд явж байна. Төсвийн хүрээний мэдэгдлээсээ авхуулаад. Тэгээд тухайн үед болохоор би нэг асуулт асууж байсан юм. Энэ орон нутгийн төсвүүд яах вэ гэсэн чинь тухай бүр нь тодотгоод явна гэсэн хариулт явж байсан. Гэтэл сая төсөв бүхэлдээ хүчингүй болсон гэж ойлгож байгаа. Түүнтэй холбоотойгоор Сангийн яамнаас орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд руу бичиг явсан гэж ойлгож байгаа.

Гэтэл уг өчигдөр Нийслэлийн ИТХ төсвөө баталчихсан гэсэн мэдээлэл яваад байгаа юм. Тэгээд би тэрийг гайхаад байна л даа. Тэгэхээр яах вэ энэ яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой биш боловчиг энэ цаг үеийн нухацтай асуудал учраас дурдахыг хүссэн юм. Яагаад ийм улсын нэгдсэн төсөв батлагдаагүй, төсөв ч үгүй сууж байхад Нийслэлийн ИТХ төсөв хэлэлцээд, баталчхаж байгаа юм бэ? Юун дээр үндэслэж баталж байгаа юм бэ? Энэ дээр Сангийн яам хариулт өгөх үү?

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр таны хэлж байгаа зөв л дөө. Бид орон нутгууд руу албан бичиг хүргүүлсэн байгаа. Төсвөө дахин боловсруулж өргөн барьж байгаатай холбогдуулаад. Тэгэхээр өөрөө удирдах ёсны орон нутгийн байгууллагууд бид төсвөө баталчихсан одоо яах вэ гэсэн янз бүрийн тийм тодорхойгүй, ойлгомжгүй байдал бидэнд огт хариулт ирээгүй байгаа. Нийслэлээс ч тийм юм ирээгүй байгаа. Нямбаатар даргатай би холбогдсон л доо. Тэгээд ямар ч байсан, ер нь хуралдаад хэлэлцэх нь бол хэлэлцсэн юм шиг байна. Батлаад, цохиод, тэгээд бид нар луу хүргүүлэх хэмжээнд очоогүй байгаа юм байна гэж ойлгосон. Бид нарт ямар нэг албан ёсны хариу ирээгүй байгаа. Тэгээд тэнд ямар нэг зөрчилдөх асуудал бид байхгүй байна л гэж ойлгож байгаа. Цохиогүй байгаа юм шиг байна лээ.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай, намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй тус бүр 2 хүртэл гишүүн дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж болно. Тэгэхээр нийт 6 гишүүн үг хэлнэ гэсэн үг. Гишүүд нэрээ өгөхийг хүсье. Ирсэн ирцийн дарааллаар нэр таслагдана. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр дээр урьж байна.



**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр Гантөмөр сайд хэлж байна л даа бид маш зоригтой, бид нарт маш их зориг байна гээд. Та, танай 3 нам Хөгжлийн төлөөх зориг гэж нэрлэсэн энэ Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийг ингэж нэрлэхээд хамгийн зориггүй үйлдлээр үйлдлийг гаргаж байгаа чинь та бүхний энэ эмэгтэй сайдынхаа хөтөлбөрийг 100 хувь хасаад, хүүхдүүдийн хөтөлбөрийг 100 хувь хасаад орж ирснээр чинь та нарыг ямар зоригтой байгааг чинь илэрхийлж байгаа юм яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд одоо нэг зүйл байна. Ингэж бууруулсан, танасан, тэгээд дээрээс нь цааш цаашдын хөтөлбөрт тийм ээ, жишээлбэл энэ ДНБ тэгж, ингэж буурах хандлагатай байна гэсэн энэ юмнуудаа дараа нь та бүхэн та нар өөрсдөө тана гэж байгаад ингэсэн шүү дээ, одоо яая гэх вэ дээ гээд сууж байх юм биш биз дээ. Миний бодлоор та нар үнэхээр зоригтой байсан юм бол, үнэхээр л зоригтой байсан юм бол энэ тэлсэн төсвөө бүхэлд нь хамгаалаад, бид чадна та нар хар гээд өчнөөн олон гаргалгааг нь гаргаж ирээд, Улсын Их Хурлын гишүүд төдийгүй иргэд, олон нийтдээ ч гэсэн энэ маш зөв ойлгуулаад, бүх хөтөлбөрөө яагаад энийг хэрэгжүүлэх ёстой юм, яагаад энийг хийх болсон юм гээд бүх үндэслэл, шаардлага энэ хуулиа, хуультайгаа холбоод та бүхэнд танилцуулах байсан. Тэр ажлуудаа хийж чадаагүй байж одоо яагаад өөрсдийгөө зоригтой гэж яриад байгаа юм.

Би маш эсэргүүцэж байна. Та ингээд харахад хар л даа 50-аас 100 хувь бууруулах хөтөлбөрт нь тэр чигтээ ганц эмэгтэй сайдынх нь, эмэгтэй сайдынх нь хөтөлбөрүүд ороод ирчихсэн. Та нарын зориг чинь эмэгтэйчүүд, хүүхдэд л гарч байна. Тийм учраас би энэ хөтөлбөрийг чинь бол дэмжихгүй байгаа шүү.

**Д.Амарбаясгалан:** Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэллээ. Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэлье, 1 дүгээр индэр дээр урьж байна.

**Д.Ганмаа:** Санал байгаа юм. Хувийн хэвшлийг дэмжих, татварын хөнгөлөлтийг дэмжсэн хуулийн заалтууд орж ирсэн гэж хариулсан. Тэгэхээр эдгээр бодит амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд дагалдах процесс, журам, стандартуудыг нь маш тодорхой болгомоор байна. Илүү нарийн зохицуулмаар байна. Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр иймээс Засгийн газарт эдгээр хуулийн зохицуулалттай холбогдох дүрэм журам, батлан хэрэгжүүлэх хугацааг нь яг зааж оруулж ирье гэсэн саналтай байна. Тэгэхгүй бол хууль нь батлагдчихдаг, хүлээлт үүсчихдэг, процедур нь тодорхой биш, журмууд нь дагалдаж гардаггүй, иймээс болоод нэг л сайхан лоозон, аягүй гоё үгтэй бид үлдчихдэг. Энэнээс болж тэгээд хувийн хэвшлүүдийг ер нь хараад байхад бид нараас хөнгөлөлт, татвар энэ тэр гэхээсээ илүүтэйгээр процедур, журам энэ нь маш тодорхой, маш ойлголттой байхыг хүсдэг гэж би бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэллээ. Жудагийн Баярмаа гишүүн үг хэлнэ, 2 дугаар индэр дээр урьж байна. Баярмаа гишүүнийг үг хэлсний дараа санал хураалт явагдахаар байгаа, гишүүдийг танхимд цугларахыг урья.

**Ж.Баярмаа:** Ямар ч байсан төсөв алдагдалгүй орж ирж байна. ДНБ-д эзлэх төсвийн зардал 37 орчим хувь байснаа 35 болж буураад ойролцоогоор 2,5 хувиар буурч байгаа нь өөрөө төдий чинээ эдийн засаг дахь хувийн хэвшлийн орон зай нэмэгдэж байна гэсэн үг буюу энэ нь асар их ач холбогдолтой зүйл болж байна.

Дээрээс нь нөгөө бид суурь зарлага, суурь тэнцэл гээд холбоотой нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдээ бараг эргэж харах хэрэгтэй байх. Хязгаар заагаа дахиж нэг харахгүй бол нөгөө манайх чинь ерөөсөө уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай улс. Тэр улс, тэр бүтээгдэхүүний үнийн бус бүтээгдэхүүнтэй холбоотойгоор хязгаар тогтоосон тэр заалтаа бид аваад хаячихсан байгаа. Тэрийгээ ер нь ирээдүйд буцааж оруулж ирж байж сая энэ зах хязгаарууд чинь зөв болох байх.

Тэгээд эхний ээлжид энэ төсвийг алдагдалгүй баталснаар гарах эерэг нөлөөг энэ Засгийн газар өөрөө энд бичсэнийг нь би уншъя. Инфляцын дарамт буурна, төлбөрийн тэнцэл сайжирна, макро бодлогын орон зай нэмэгдэнэ, зээлжих зэрэглэлд эергээр нөлөөлнө гээд Засгийн газар өөрөө энэ алдагдалгүй баталсан төсвөө ингэж сайшааж, дүгнэсэн шүү. Тэгэхээр энэ дээр нэг энэ асуудлыг анх өрдөж эхлүүлсэн гишүүдийг ад үзээд попорлоо, ингэлээ тэглээ, будилуулаад байна гэх юм ямар ч хэрэг байхгүй болсныг чинь энэ Засгийн газрын дүгнэлт нь өөрөө нотолж байна шүү гэдгийг бүүр зориуд хэлье. Сав л хийвэл попорсон, будилуулсан гээд нэг хэдэн гишүүдийг ад үзээд байх юм. Гэтэл Засгийн газар чинь өөрөө аягүй баярлаад ингээд дүгнэчихсэн байна шүү дээ эерэг талуудыг нь. Тийм. Засгийн газар нь өөрөө баярлаад дүгнэчихсэн байхад тэр логикоор эсэргүүцэж байгаа, будилуулсан гэж үзэж байгаа хүмүүс энэ алдагдалгүй төсвийг дэмжихгүй байна гэж ойлгож байна.

Дээрээс нь энэ бол бид нарын мөнгө биш, Их Хурлын гишүүдийн мөнгө огт биш. Энэ чинь татвар төлөгчдийн ёстой нөгөө үсээ зулгааж, хуйхаа маажиж байж олж байгаа мөнгө шүү дээ. Нийтийн төсөв. Улсын төсөв ч гэж байхгүй. Олон нийтээс татсан мөнгөө хэрхэн буцаагаад олон нийтэд нь хуваарилах тухай асуудал. Тэгэхээр энэ дээрт бол энэ түрүүн гишүүдийн ам дээр гарсан шүү дээ. ААН, айл өрх хүртэл нэмэхтэй гарахын төлөө явдаг биз дээ. Тэгж байж тэр байгууллага, тэр ААН чинь ашигтай ажиллаж байж, хуримтлал үүсэж байж эргээд тэр хуримтлал нь хөрөнгө оруулалт болж тухайн айл байна уу, ААН-д эергээр нөлөөлдөг. Улс ч гэсэн яг л адилхан шүү дээ.

Гэхдээ мэдээж айл жишээлбэл ААН зээл аваад үр ашигтай хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тэр зээл нь магадгүй алдагдал болж орж ирэхийг үгүйсгэхгүй. Гагцхүү тэр алдагдлаар бий болж байгаа мөнгөн дүнгээс юу гарах ёстой вэ гэвэл үр дүн гарах ёстой. Тэр алдагдал нь хэд байхаас хамаараад тухайн айл өрх байна уу зээлээр авсан мөнгөний үр дүн нэмэх болж орж ирэх ёстой шүү дээ. Яг тэрэнтэй л агаар нэг шүү дээ улс. Тэгэхээр алдагдалгүй баталсан учир ингээд амар сайхандаа жаргаж байгаа гэсэн үг биш. Дахиад цаана нь үр ашиггүй зардал байвал хасах хэрэгтэй. Жишээлбэл тавилга 100 хувь хасаад болсон байна шүү дээ, 100 хувь хассан. Гадаад зардлыг 50 хувь хассан, болохгүй юм байхгүй л байгаа байхгүй юу.

Тэгэхээр дахиад ч үр ашиггүй зардал байгаа байх. Тэрийг бол дахиж хасахын төлөө явна. Үр ашигтай юм байх юм бол нэмж бас болно. Гагцхүү үр ашиг дээр тооцоогоо хийх ёстой гэдгийг би дахин хэлмээр байгаа юм. Тэгэхээр энэ, энийг дахин сайн уншаарай манай гишүүд. Төсвийг алдагдалгүй батлахын үр ашгийг энд бичсэн байна шүү Засгийн газар өөрөө.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 66 гишүүн буюу 62,3 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

16.27 цаг

***Дөрөв. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ. Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гадаадад айлчлалтай, түр эзгүй байгаа тул хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Гантөмөр:** Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор нийт ард иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор анхны 3 намын хамтарсан Засгийн газар байгуулагдаж, Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолоор Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэрээнд суурилсан, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан билээ. Ирэх 2025 он нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бүсчилсэн хөгжлийн цогц реформыг хэрэгжүүлж, шинэ 30 жилийн хөгжлийн эхлэлийг тавих эхний жил учир Засгийн газраас хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, эдийн засгийн суурийг тэлэх томоохон зорилт бүхий Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 8 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьж байна.

Төсвийн төсөлд урсгал зардлыг бууруулахад дараах зарчим баримталлаа. 1 дүгээрт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, Учрал сайдаа, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн шүүхийн байгууллагууд болон ХЭҮК зэрэг байгууллагуудын урсгал зардлыг тус тус бууруулаагүй болно.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь бууруулна. А.Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулна. Б.Соёлын эрхийн бичиг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон Эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна. В.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр, шатахууны зардал төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл, худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулна. Г.Дээр дурдсан 50-аас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээлийн ашиглалтыг төлөвлөхөд дараах зарчмыг баримталсан байна. 1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан, ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн 512 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулаагүй буюу 2 их наяд 80,7 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа.

2.Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж, хойшлуулна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлж эхлүүлэхээр батлагдан ирэх онд үргэлжлэн хэрэгжих боловч 2024 оны 12 дугаар сарын 2-ны байдлаар гэрээ байгуулаагүй 32 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих 117,8 тэрбум төгрөгийг хойшлуулна.

2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүдийн хүрээнд 38 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг дахин эрэмбэлж, бүс нутагт нэн тэргүүний, богино хугацаанд хэрэгжих боломжтой, дараа онуудад төсөвт ачаалал бага үүсгэх төслүүдийг 2025 онд хэрэгжүүлэхээр 29 төсөл, арга хэмжээнд 497 тэрбум төгрөгийг тусгалаа.

3.Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног, төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулна. 1 дүгээрт зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 8 төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 62,1 тэрбум төгрөгөөр буурууллаа. 2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх, иргэдийг төрийн үйл ажиллагаагаар хэвийн хангахад шаардлагатай тоног, төхөөрөмж болон шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн салбарын барилгуудын тоног, төхөөрөмжийн зардлыг 2025 оны төсвийн төсөлд анх төлөвлөж өргөн барьсан хэмжээнээс 20 хувь бууруулсан.

4.Хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулна. Үндэсний хиймэл дагуулын төсөл хэлэлцээрийн шатад байгаатай холбогдуулан 2025 онд зээлийн ашиглалт 211,6 тэрбум төгрөг, зарим төслүүдийн санхүүжилтийг 300 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж нийтдээ 511,6 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтын төсвийг, ашиглалтыг төсвийн төсөлд буурууллаа. Мөн тус зээлийн ашиглалттай холбоотой Монголын талын санхүүжилтийг бууруулах зарчмыг баримталлаа

5.Хавдар судлалын үндэсний төв, 2.хөрөнгө оруулалтыг нэмж тусгана. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Хавдар судлалын үндэсний төв 2 барилга төсөл, арга хэмжээ тусгагдсан боловч газрын асуудлыг бүрэн шийдвэрлэгдээгүйгээс тендер шалгаруулалт зарлаагүй, хасагдсан байдаг. Төслийн газрын асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд хавдрын эрт илрүүлэг, оношилгоог сайжруулах, хавдрын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой нийгмийн үр ашигтай учир төслийн төсөвт өртөг 10 тэрбум, санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр төсвийн төсөлд тусгалаа. Мөн Хавдар судлалын үндэсний төвийн одоогийн барилга нь 1981 онд баригдсан бөгөөд урсгал засвар зайлшгүй хийж, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор их засвар шинэчлэлтэд 5,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2,9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд шинээр тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Үүнд гаалийн орлого 174 тэрбум, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого 25 тэрбум, Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 112,3 тэрбум, ХХОАТ-ын орлого 21,1 тэрбум, ААНОАТ-ын орлого 50,3 тэрбум, бусад орлого 12 тэрбум төгрөгөөр тус тус буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35,2 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35,2 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцлийн ДНБ-ий 3,3 хувийн ашигтай болохоор төлөвлөгдлөө.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,



Ирэх 2025 оны төсөв алдагдалгүй болсноор импорт буурч, гадаад худалдааны тэнцэл сайжирч, инфляцын дарамт саарч, мөнгөний бодлогын орон зайг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй ч гэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудын хөрөнгө оруулалтууд хумигдаж, Засгийн газрын ирэх 4 жилд дэвшүүлж байгаа хөгжлийн зорилтуудад хүрэх боломжийг хойшлуулж болзошгүй байна. Иймд Засгийн газраас урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд эхлүүлж, уул уурхайн бус салбарын өсөлтийг дэмжих замаар макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөлөөтэй салбаруудын бодлогын реформыг эрчимжүүлнэ. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжих томоохон төслүүдийг урагшлуулж, төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах, зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар эдийн засгийг тэлэх бодлогыг баримтална.

Бүсүүдийн төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг нэмэгдүүлнэ, бүрдүүлнэ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөв нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн ба хөгжлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн үр дүнд эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэх зорилтыг хангах болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүллээ. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайдад баярлалаа. Төсвийн төслийн талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Загджав:** Та бүхэнд энэ өдрийн мэнд өргөн дэвшүүлье. Монгол Улсын дарга, Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн, аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын

20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн, хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьсан байна.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурт нийцэж байгаа эсэх талаар дараах аудитын дүгнэлтийг өгч байна. Үүнд,

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 онд ДНБ-ий 41,9 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцааны түвшинд байна.

2.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нийт зарлагын хэмжээг 33 их наяд 470 тэрбум төгрөгөөр, ДНБ бүтээгдэхүүний 35,2 хувь байхаар, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг анх удаа алдагдалгүй төлөвлөсөн нь төсвийн төлөвлөлтөд ахицтай үзүүлэлт болсон байна. Төсвийг алдагдалгүй байлгах зорилгоор төсвийн төслийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2 их наяд 301,9 тэрбум төгрөгөөр, нийт орлого ба тусламжийн дүнг 394,8 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, дахин өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ий 2-оос дээш хувийн ашигтай байх, нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн тусгай шалгуур, шаардлагуудыг тус тус хангасан байна.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй.

1.Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж, нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай. 2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна. 3.Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцох, төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зарлагыг хумьж, зарим хэрэгжих, хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр үйл ажиллагааг нь зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцааг бууруулсан нь сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна. 5.Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна. 6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн, болох тухай, санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Мөн Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд, Монгол Улсын Засгийн газарт дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чанарыг дээшлүүлж, төсвийн сахилга батыг ханган ажиллах. Төсвийн төслийг төрийн мөнгөний бодлогод нийцүүлэх, төсвийн зарлагын тэлэлтээс нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг үр дагаврыг үнэлж, бууруулах арга хэмжээ авах. Төсвийн боломжит эх үүсвэр, бүх төрлийн ашигт малтмалд ноогдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны татварыг бүрэн төвлөрүүлэх. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бүсүүдэд улсын хэмжээнд нэршлээр, байршил тодорхойгүй тусгагдсан арга хэмжээний задаргааг тусгайлан хэлэлцүүлж, батлуулах. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн, нийцүүлэх.

Сангийн яаманд, Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх, төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ноогдол ашгийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, тоног төхөөрөмж, их засвар болон техник, эдийн засгийн үзүүлэлтийг төлөвлөх, эрэмбэлэх аргачлал, зохицуулалтыг тодорхой болгох.

Эдийн засаг, хөгжлийн яаманд, ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцож, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу бүх шатын төсөв захирагчид аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, анхаарч ажиллах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Н.Энхбаяр:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг эрье. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлал, холбогдох танилцуулгыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хүлээн аваад, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1.5.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1 дэх заалтын дагуу дүгнэлтээ гаргалаа.

Дүгнэлтийг өнөөдөр Улсын Их Хуралд албан ёсоор албан бичгээр хүргүүлсэн. Парламентын веб сайт дээр тавигдсан байгаа учраас би та бүхэнд хураангуйлан танилцуулъя гэж бодож байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дараах дүгнэлтийг гаргахдаа Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл, түүнд тусгагдсан үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх, 7.3-д заасан төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 6.2.1, 6.2.2, 6.3.3, 6.4.1, 27 дугаар зүйл, 32.2-т заасны дагуу боловсруулагдсан эсэхэд анхаарсан.

Монгол Улсын Засгийн газраас энэ удаад өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд нэгдсэн төсвийн зарлагын дүн нь 33 их наяд 469,9 тэрбум төгрөг байхаар тусгагдсан нь 2025 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн барьж, өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан нийт төсвийн зарлагаас 2,3 их наяд төгрөгөөр бууруулан тооцсон байна. Үүний дотор урсгал төсвийн зарлагыг 726 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1 их наяд 448,3 тэрбум төгрөгөөр бууруулж, төсвийн нийт тэнцлийг алдагдалгүй байхаар төлөвлөжээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн дүгнэлтэд тусгагдсан төсвийн зарлага хэт хурдтай өсөн нэмэгдэж байгаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг хангалтгүй байгаа талаар дурдсан дүгнэлтүүд, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс 2025 оны төсвийн тухай хуульд тавьсан хоригт тусгагдсан үндэслэлүүдийг харгалзан үзээд, төсвийн үрэлгэн оновчгүй зардлыг бууруулах, төсвийн тэнцлийг сайжруулах зарим алхам хийгдсэн, 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төсвийн үр ашиггүй зарлагыг бууруулах арга хэмжээ авах талаар тодорхой заалтуудыг тусгасан зэрэг нь макро эдийн засгийн болон төсвийн тогтвортой байдлыг хангахад анхаарсан зөв зүйтэй эхлэл болжээ гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс үзэж байна.

Ингээд тус төсөлд тусгагдсан тодорхой зардлын зүйлийн талаар товчхон дүгнэлтийг танилцуулъя. Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар. Төсвийн орлогыг анх удаа бууруулан тодорхой тооцоолол үндэслэлийг гаргасан нь эерэг үр дүн юм. Өмнө нь төлөвлөгдсөн төсвийн орлогыг тодорхой хэмжээгээр бууруулсан нь эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, болзошгүй эрсдэлийг бууруулахад эерэг нөлөөлөх өөрчлөлт болжээ гэж үзэж байна.

Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийн тухайд, Монгол Улсын төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүнд урсгал зардал дийлэнх хувийг эзэлсээр байна. Төсвийн урсгал зарлага 2018 онд 7,3 их наяд төгрөг байсан бол 2024 оны

хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 26 их наяд 34,6 тэрбум төгрөг, 25 оны өргөн бариад байгаа төсвийн төсөлд 25 их наяд 308,6 тэрбум төгрөг байхаар тусгагдсан байна. Нөгөө талаар урсгал зардлыг байнга өсгөж байгаа нэг зардал бол цалин хөлсний зардал буюу бөгөөд 2009 онд Монгол Улсын 100 хүнд ноогдох төрийн албан хаагчийн тоо 4.4 байсан бол 2015 онд 5.7, 2023 онд 6.4 болж өссөн байна. Төрийн албаны тогтолцоонд институтийн болон бүтээмжийн томоохон шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарч буй бөгөөд боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллага, онцгой байдал, батлан хамгаалахаас бусад салбарт төрийн албан хаагчдын тоог царцаах, цаашид аажмаар төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал гэж үзэж байна.

Урсгал зардлыг бууруулахдаа тавилга, эд хогшил, сургалт, уралдаан тэмцээн, соёлын эрхийн бичиг зэрэг зардлыг 100 хувь, гадаад, дотоод албан томилолт, бичиг хэргийн зардлыг 50 хувь, байр ашиглалт, хангамж, бараа материал, бараа үйлчилгээний зардал гэх мэтийг 10 хувиар бууруулах бодлого баримталж, үүнийг хэрэгжүүлэхдээ хуулийн өөрчлөлтүүдийг хамт оруулан өргөн мэдүүлж байгааг дэмжиж байна.

3 дугаарт хөрөнгө оруулалт, их засварын зардлын талаар, хөрөнгө оруулалтын удирдлага, төлөвлөлтийн системийг сайжруулах шаардлагатай байна гэж үзэж байна. Улсын хөрөнгө оруулалтын удирдлагыг хэрэгжүүлэхэд цогц бөгөөд нэгдмэл арга барилыг баримтлах, улсын хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн багцыг үр ашигтай, оновчтой болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг түлхүү хэрэглэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулахад төлөвлөлтөөс эхлээд тайлагнах, хэрэгжүүлэх бүхий л үе шатыг ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах шаардлагатай. Төсвийн хөрөнгийн ба урсгал зардал хоорондын хамаарлын тооцож, улсын төсвийг төлөвлөдөг байх шаардлагатай. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө тухайн хөрөнгө оруулалтын объект хэрэгжсэний дараах төсөвт үзүүлэх ачаалал өөрөөр хэлбэл төсвийн хөрөнгийн зардал болон урсгал зардал хоорондын уялдааг сайтар ханган тооцож байх шаардлагатай гэж үзэж байна.

Төсвийн төлөвлөлтийг илүү оновчтой төлөвлөж байх, төсвийн үрэлгэн зардлыг бууруулах, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг сайжруулах үйл ажиллагаа нь нэг дор, нэг удаа хийгдэх арга хэмжээ биш, харин гүйцэтгэх засаглал, төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчдын зүгээс тасралтгүй хийгдэж байх ёстой жилээс жилд улам бүр сайжруулж, шинэ шатанд гаргаж байх ёстой бодлогын зорилт, тасралтгүй үйл явц юм гэж үзэж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих үйл явцтай хамт улсын төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг цаашид илүү сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Сангийн яаманд хуулийн төслийг боловсруулах ажил хийгдэж байгааг бид сонссон. Энэ асуудалд бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ихээхэн талархалтай хандаж байна. Өнгөрсөн жилүүдэд жил бүрийн төсвийн төслийг хэлэлцэн батлах явцдаа Улсын Их Хурлаас батлан гаргасан удаа дараагийн тогтоолуудад төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, төсвийн бодлого, төлөвлөлтийг сайжруулах талаар Монгол Улсын Засгийн газарт удаа дараа үүрэг даалгавар өгч ирсэн байдаг. Эдгээр тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хурлын зүгээс эргэн шаардах,



холбогдох хууль, тогтоомжуудад заасны дагуу гүйцэтгэлийн явцыг тогтмол хянан шалгаж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд зөвхөн батлагдсан, батлагдан гарах төсвийн үзүүлэлтүүд нь шаардлага хангасан байхаас гадна Улсын Их Хурлаас батлагдан гарах Монгол Улсын 2025 оны төсвийн хуулийг хэрэгжүүлэх явцад төсвийн зарцуулалтын үр өгөөжийг сайжруулах, төсвийн хөрөнгийн үрэлгэн зарцуулалтаас зайлсхийх, төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчдын төсвийн зарцуулалттай холбоотой гарч байгаа алдаа дутагдлыг тухай бүрд нь шуурхай илрүүлэн засварлаж байх, тэдний үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж байх нь төсвийн тогтвортой байдлыг хангах, улмаар нийт эдийн засгийн эрүүл саруул байдалд нэн чухал ач холбогдолтой гэдгийг онцолж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуульд заасан бүрэн эрх, үүргийн дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнтэй хамт өргөн барьсан дагалдах хуулиудыг хэлэлцэн батлах явцдаа Улсын Их Хурлын гишүүд та бүхний гаргах шийдвэр нь оновчтой, мэргэн байхыг хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Лхагвадоржийн Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Цэвээнсүрэнгийн Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Барсүрэнгийн Баасандорж Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Дэмбэрэлдашийн Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Дугарын Сүнжид Монгол Улсын ХЭҮК-ын дарга, Гаваасүрэнгийн Азжаргал АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар, Дарьхүүгийн Баянбилэг Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Батсуурийн Даваадалай Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх, Заяатын Лхагвадорж Шадар сайдын ажлын албаны дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Одонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Сүрэнжавын

Гансэлэм Улсын Ерөнхий аудиторын Ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга, Лувсандагвын Мөнхцацрал Үндэсний Аудитын газрын Стратеги, төлөвлөлтийн газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Юрагийн Энхтуяа Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Доржсүрэнгийн Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга, Вандансүрэнгийн Жавзан Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга, Намдагийн Ганбаатарын Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Бямбасүрэнгийн Лхагва Үндэсний статистикийн хорооны ерөнхий менежер бөгөөд Тамгын газрын дарга, Идэшийн Батхүү Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны ТНБД, Адъяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Хөхөөгийн Отгонжаргал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Санхүүгийн хэлтсийн дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн хэлтсийн хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.17-д улсын төсвийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж заасны дагуу илтгэл, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Нийт 44 гишүүн, 44 гишүүнээр тасаллаа. Ирсэн ирцийн дарааллаар эрэмбэлье. Нарантуяа-Нара гишүүн төхөөрөмждөө бүртгүүлээрэй, суудлын чинь дугаар гараад байна. 4 дэх гишүүн Гомбын Ганбаатар гишүүн бүртгэлээ хийлгээрэй төхөөрөмжийн, хурууныхаа хээг уншуулъя. Энэ дэлгэц дээр нөгөө нэр гарахгүй, зөвхөн суудлын дугаар харагдаад байгаа юм уншуулахгүй болохоор. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна. Нарантуяа-Нара гишүүний асуултаас өмнө 44 гишүүн асуулт асуух учраас өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг сунгаж хуралдъя. Татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна. Өнөөдрийн хуралдааныг сунгалаа. Сунгаж хуралдахаар боллоо. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

**М.Нарантуяа-Нара:** 1 дүгээрт энэ үнэхээр энэ утаа, утааны асуудал үнэхээр хэрээс хэтэрсэн аргагүй олон жил болсон доо, одоо бараг 20 гаруй жил дээр явж байна. Тэгээд ард иргэдийн хамгийн 1 дүгээр бухимдал утаа байна. Тэгээд ер нь өнгөрсөн хугацаанд энэ утааг арилгах ажилд хэчнээн их наядыг зарцуулсан боловч одоогоороо арилахгүй байна. Би анхдугаар чуулган эхлэх үеэс л энэ түлшний чанарын талаар ярьж эхэлсэн. Одоогоороо энэ түлшний чанарын шалгалтын хариу гарч ирээгүй ийм байдалтай байж байгаа. Тэгээд энэ Засгийн газар энэ онд 25 онд энэ утааг арилгахтай холбоотой хэдэн төгрөгийн зардал энэ төсөвтөө тусгасан байгаа юм бэ? Энэ төсөв, тусгасан төсөв чинь 25 он гэхэд энэ

Монголын ард иргэдийг утаагүй болгох юм уу, үгүй юм уу гэдгийг хариулт авмаар байна.

Дээрээс нь Эрүүл мэндийн яамны сайдаа энэ эмнэлгүүд чинь ерөөсөө очер юмаа дийлэхгүй болчихлоо. Ерөөсөө энэ сошиал дээр ерөөсөө тэр чигээрээ эмнэлэгт очерлоод, коридороор нь зулж байгаа дүүргүүдийн эмнэлгүүдийн чинь асуудал хөвөрч байна. Тэгээд та болохоор энэ ЭМЯ-наас төсөв нь болохоороо дүүргийн эмнэлэгт өгөөд байдаг, зохион байгуулалт удирдлагыг юунаас НЭМГ-аас томилдог гээд байдаг. Тэгээд энэ зөрөөтэй энэ зарчим алдагдсан энэ байдлаа та өөрөө зохицуулах юм уу? Энэ ер нь өвчлөлийн эд оргил үе ирж байгаа. Тэгээд энэ асуудлаар хүмүүс яагаад тан руу хандахгүй байгаа юм бэ? Та хариуцах ёстой биз дээ? Салбар хариуцсан сайд нь мөн биз дээ?

Эх, нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн даргыг та яагаад сольсон юм бэ? Ажлаа маш сайн хийгээд, маш том ажлын ард гараад, одоо дараагийн, дараа дараагийн ажлуудаа хийх гээд ингээд төлөвлөж байсан. Тэгээд энэ удаад нэг энэ жил 25 оны төсөв дээр 24 тэрбум орж ирсэн байсан шүү дээ. Энэ удирдлага солиод байгаа чинь юутай холбоотой юм бэ? Хувийн ашиг сонирхол байгаа юм уу эсхүл өөрсдийн хүнээр ингээд эх нялхсыг гэхэд энэ удирдлагаа дагасан багийг, удирдлагын нийт ажилтны халаа солио болно гээд Эх, нялхас дүүрэн хэл ам болж байна. Өвчтөнөө дийлэхгүй, ажлаа дийлэхгүй, ачаалал ихтэй, цалин багатай нөхцөлд ажиллаж байгаа эмч чинь удирдлагатайгаа нийцэхгүй гэсэн асуудлаар ажил хаяад эхэлбэл та энэ өвчлөлийн энэ оргил үеийн ачаалал хариуцлагыг өөрөө үүрэх юм байгаа биз дээ?

Дээрээс нь энэ Боловсролын яамны сайдаас асуумаар байна. Энэ Боловсролын яамны энэ төсөв хөрөнгө оруулалтын энэ барилга, их засварын ажил дээр чинь маш олон энэ харилцан адилгүй дүнгүүд байгаад байгаа. Яг ижилхэн аймагт, яг ижилхэн хүүхдийн тоотой суудалтай сургуулиуд хамгийн багадаа 1, 2, 3, 4 тэрбумын зөрөөтэй үнийн дүнтэй орж ирж байгаа. Энэ бүх дүнгүүд, энэ хүмүүс сургууль, цэцэрлэг гэхээр маш чих зөөлөн байдаг учраас энийг нэг их олж харахгүй байх шиг байна. Анзаарахгүй байх шиг байна. Гэтэл дотроо энэ чинь маш олон тэрбумын зөрөөтэй ийм юунууд орж ирж байна шүү. Та энэ дээр ирээдүйд энэ асуудал үүсвэл хариуцлага хүлээх үү? Яагаад ийм үнийн зөрөөтэй байгаа юм бэ?

Соёлын яаманд залуучуудын асуудлыг хариуцуулчихсан. Залуучуудын асуудлыг 16-аас 18 насны залуучуудын нийгмийн судалгааг үндэслээд, шалтгаанд суурилсан судалгаанд, статистик судалгаанд үндэслэсэн ийм хөтөлбөр хэрэгжсэнийг нь хуулийг нь хүчингүй болгож байгаад энэ асуудлыг цуцлах гэж байх шиг байна. Тэгээд энэ 16-аас 18 насны хүүхдүүдийн бодлогод ямар бодлого баримтлах юм бэ энэ засаг төр? Тэрийг холбогдох хүн нь хариулаад өгөөрэй.

**Д.Амарбаясгалан:** Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан сайд хариулъя.

**Т.Мөнхсайхан:** Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Энэ гэхдээ төсөвтэй, хэлэлцэж байгаа асуудалтай ер нь нэг их холбоогүй л зүйл юм.../үг тасрав/

**Д.Амарбаясгалан:** Гишүүд суудалдаа сууя.

**Т.Мөнхсайхан:** Гэхдээ асуусан учраас хариулъя. Гадуур томуу, томуу төст өвчний дэгдэлт үнэхээр их байна. Энэ дээр бид сэргийлэх арга хэмжээнүүдийг маш эрчимтэй авч хийсэн. Энэ жил бид өмнөх жилүүдэд байгаагүйгээр энэ томуунаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтуудыг эрт хугацаанд хийж хэрэгжүүлсний хүчинд өнөөдөр өдий зэрэгтэй байна. Ард иргэдийн хариуцлага, эрүүл мэндийн боловсрол их тааруу байна. Өнөөдөр бид томууг туссаных нь дараа эмчилдэг эмнэлгийн асуудал ярих биш, томуугаа тусгахгүй байхын тулд халдвар хамгааллын дэглэм, маскаа яаж зүүх вэ, агаар сэлгэлтээ яаж хийх вэ гэдэг энэ бодлого дээрээ бид түлхүү анхаарсан. Тийм учраас өнөөдөр ор хүрэхгүй хэмжээндээ, өнөөдөр хэвтэж чадахгүй хэмжээндээ оччихоогүй байна өнөөдрийн байдлаар. Бид Улаанбаатарын хэмжээнд 1300 орыг томууд бэлтгэсэн. Яг өнөөдрийн байдлаар хэвтэн эмчлүүлж байгаа 1250 хүүхэд байна. Цаашдаа ч энэ байдал нэмэгдэж хүндрэх эрсдэл байна. Энэтэй холбоотой бүх талын бодлого арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүний нэг нь таны хэлээд байгаа саяын тэр ЭХЭМҮТ-ийн удирдлагыг сольсон гэдэг асуудал. ЭХЭМҮТ бол үндэсний хэмжээнд.../үг тасрав/

**Д.Амарбаясгалан:** Отгонбаяр, Баярбаатар, Жавхлан, Идэрбат гадаа гарч байна инээлдье.

**Т.Мөнхсайхан:** Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах ёстой ийм байгууллага. Үндэсний хэмжээнд хүүхдийн эмч, хүүхдийн сувилагч, хүүхдийн мэс заслын эмч нарыг хэрхэн яаж бэлдэх вэ гэдэг бодлого тодорхойлох ёстой ийм үндэсний төв. Зөвхөн эмнэлгийн хэмжээнд өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаа явуулж ирсэн учраас өнөөдөр хүний нөөцийн бодлого нь тийм тодорхойгүй. Цаашдаа энэ дэлгэсэн орууд дээр хэн очиж ажиллах нь тодорхойгүй ийм нөхцөл байдлууд үүсээд байгаа учраас бид яалт ч үгүй туршлагатай, мэдлэг боловсрол сайтай ийм хүнийг сольж томилохоос өөр аргагүй байдалд хүрсэн.

Гэхдээ энэ нь ЭХЭМҮТ-ийн дарга бол түр орлон гүйцэтгэгч байсан. Ингээд дотооддоо ажиллаж байсан ЭХЭМҮТ-д ажлаа хийж байгаа олон жил ажиллаж байгаа энэ туршлагатай эмчийг нь тавьсан ийм асуудал. Энэ бол бас томуугийн бэлтгэл ажил, цаашдаа бид нөхцөл байдал хүндрэхээс сэргийлэх дорвитой арга хэмжээ авах бодлогын ажлуудын нэг.

Таны хэлж яриад байгаа тэр олон эмнэлгүүд гээд байгаагийн нэг нь ХӨСҮТ-ийн дарга. ХӨСҮТ энэ томууны халдварт өвчний дэгдэлтийн үед маш чухал үүрэг оролцоотой ажиллах ёстой байгууллага. Гэтэл ерөнхий захирал нь хавсран гүйцэтгэгч байсан юм. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь ерөнхий захирлынхаа ажлыг хавсран гүйцэтгэж байсан. Тийм учраас эмчилгээ эрхэлсэн орлогчийг нь ажлыг нь хийлгэж, ерөнхий захирлаар нь түр орлон гүйцэтгэгчийг тавьсан.

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Наранбаяр хариулт өгье.

**П.Наранбаяр:** Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Тэгэхээрээ энэ сургууль, цэцэрлэгийн барилгын энэ төсөв, норм дүрэм Барилгын хөгжлийн төвийн магадлал гарч байж хийлгэгддэг. Энэ хүрээндээ бол Төсвийн хуульд тусаад явдаг. Ижил төрлийн хүчин чадалтай сургууль, цэцэрлэгийн төсөвт ийм өртгийн зөрөө гарах тохиолдол байдаг. Энэ газрын байршил, дэд бүтцийн хол,

ойр, газар хөдлөлийн бүс, гадна шугам сүлжээ нь төсөвт орсон, ороогүй гэх мэтээсээ шалтгаалдаг ийм тал бий. Зөвхөн хуулийн хүрээнд бүх зүйлийг бид хийж явдаг. Энэнээсээ хэтэрсэн юм хийхгүй, энэнээс дутуу юм хийхгүй. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Байгаль орчны яамнаас хэн байна вэ, хотоос хэн байна вэ? Энэ агаарын бохирдолтой холбоотой асуудлаар өнөөдөр гишүүд маш олон асуулт асууна шүү. Холбогдох алба, албаны хүмүүс, энэ хотын Засаг дарга, Байгаль орчны сайд гадаадад томилолттой байгаа. ТНБД, холбогдох албаны хүмүүсийг одоо дуудаж ирүүлье. Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

**Б.Жавхлан:** Нарантуяа-Нара гишүүний асуултад нэмж хариулъя. Төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалтыг харах юм яг шууд утаа гэхчхэн утааны эсрэг, утаа бууруулна гэхчхэн зардал байхгүй юм шиг харагдах байх. Гэхдээ энэ утаатай тэмцэхийн тулд бид маш том цогц асуудал энэ чинь шийдэх ёстой. Нийслэл дээр ялангуяа энэ газар чөлөөлөлтөөс эхлээд, орон сууцжуулах, энэ түгжрэлийг бууруулах, дэд төвүүд, дагуул хотууд гээд маш том сүүлийн 2 жил үргэлжилж явж байгаа энэ арга, хэмжээнүүд бүгд ирэх онд нэлээн өргөжсөн хэлбэрээр тэлээд ингээд үргэлжилнэ. Ялангуяа нийслэл дээр нэлээн их ачааллуудаа авч байгаа. Түрүүний таны яг нарийвчилж асуусан түлштэй холбоотой түлшний үйлдвэр бол нийслэл рүү шилжсэн. Нийслэл өөрсдөө хариуцаад явъя гэж байгаа. Нийслэлээс хүмүүс байвал энийг хариулаад өгөөрэй.

Харин түрүүний миний хэлсэн түгжрэлийг бууруулах, орон сууцжуулах асуудлууд бол сая бид өнгөрсөн тодотголоос эхлээд л нийслэл дээр бонд гаргах, бондоор энэ газар чөлөөлөлтийг санхүүжүүлэх болон.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

**Б.Пүрэвдорж:** Энэ төсвийн хоригтой холбоотой дахиж төсөв боловсруулж оруулж ирж байна. Тэгэхээр 38 төсөл арга хэмжээг нь 6-г нь хасаад ТЭЗҮ-гүй учраас 32 нь орж ирж байгаа юм байна. Тэгэхээр үүнийгээ эдийн засгийг солонгоруулах, дэд бүтцийг сайжруулах, эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх энэ ажлуудыг хийсний үр дүнд ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлт нэлээн сайжирна гэж харж байгаа юм.

Гэхдээ ирэх жил яг тэр Засгийн газрын хэлснээр 8 хувийн өсөлт гарахгүй шүү. Яг ОУВС 6 хувь гэж байгаа. Дэлхийн банк, АХБ 7 хувь гэж байгаа. Та нар л өөрсдөө 8 хувь гээд байгаа болохоос биш яг энэ өсөлт чинь яг гарах уу гэдэг дээр чинь асуудал байгаа шүү гэдгийг хэлье. Энэ дээр ирэх жилийн төсөв дээр нэг анхаарах ёстой зүйл бол гадаад өрийн хэмжээ нэлээн нэмэгдэхээр тийм хандлага байна шүү. Өөрөөр хэлбэл та нар 300 тэрбумаар дотоод зээл авах боломжийг гаргаж өгч байгаа. Дээрээс нь 1,5 их наядаар гадаад зээлийн зээлийг нэмэгдүүлэхээр оруулж ирж байгаа. Тэгээд ер нь Засгийн газрын өрийн баталгааны дээд хэмжээг 3,5 их наядаар тавьсан байгаа. Ингээд ирэх жил наадах нөгөө нүүрс, зэс чинь үнэ нь өсөхгүй, экспорт нь хэмжээ нь нэмэгдэхгүй бол та нар тэгээд гадаадаас баахан өр авах ийм нөхцөл байдал руу очих юм байна шүү гэж харагдаж байгаа.

Тэгээд урсгал зардлаа нэлээн танаад ороод ирж. Тэгэхдээ урсгал зардлаас чинь ялангуяа төрийн албан хаагчдын чинь тоо үндэслэлгүй өссөн. Энд жишээ нь



наадам, сонгуулиас хойш гэхэд л 6 мянгаар өсчихсөн байна гэж байна шүү дээ. Тэгээд би та нарт нэг жишээ хэлье. 2014 онд намайг Гадаадын харьяатын дарга байхад Ховд аймагт нийтдээ 7-хон хүн ажиллаад, 1 нь дарга, 6 хүн нь, 1 хүн нь 1000 виз буюу 6000 виз олгодог байсан. Гэтэл 16 онд 23 болоод, 17 онд 27 болгоод, өнөөдөр 27 хүний орон тоотой ажиллаж байна. Тэр хүмүүс жилдээ 10-хан виз олгоод, тэгсэн мөртөө 27-уулаа ажиллаж байна шүү дээ. Улсын төсөвт 2014 онд, үгүй ээ Ховд аймгийн төсөвт 600 сая төгрөг оруулдаг байсан тэр нөхдүүд өнөөдөр тэр төсөвт 300-хан виз олгож байгаа юм чинь ямар өөдтэй юм орох вэ дээ. Ийм нөхцөлтэй байж байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр энэ төрийн албан хаагчид чинь үр дүнгүй төрийн албан хаагчид тэгээд компьютерын ард сууж байдаг. Тэгээд нөгөө сонгуулиар хэн нэгэн дарга нарын албанд явдаг, сонгуульд явдаг, тэгээд тэнд очиж төрийн алба бөглөдөг ийм нөхдүүдтэй байна. Тийм учраас энэ ирэх жил дотроо энэ төрийн албан хаагчдыг багасгах, цомхотгох, ажлын байрных нь тодорхойлолтыг бүрэн хийх энэ ажлуудыг хийж байж тэгээд энэ хэмнэлтээ сайн хангахгүй болохгүй юм байна шүү гэдгийг Учрал сайд анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Энэ юуны Боловсролын сайдаас асууя. Боловсролын сайд дээр урсгал зардал яг хэд байгаа юм бэ? Энэ чинь улсын төсөв дээр яг төлөвлөгөөний дагуу орж ирэх ёстой. Урсгал зардал хэд байгаа юм бэ? Ямар, ямар ангиллаар зарцуулах юм бэ? Бусдаар гүйцэтгүүлэх ажил чинь хэд байгаа юм бэ, хэдэн төгрөгийн зардалтай байгаа юм бэ, тэрийгээ яаж зарцуулах гэж байгаа юм бэ? Яг тэр нөгөө яг тэр төлөвлөгөөнийхөө дагуу надад хэлээд, хариулаадах. Жишээ нь энэ жил гэхэд таны урд талын сайд чинь багш нарын нэг арга хэмжээг Их хурлыг зохион байгуулахад 1 аравны хэдэн тэрбум билээ зардал гаргасан байна лээ шүү дээ. Ийм замбараагүй. Тэгээд ерөөсөө хурал хийгээд байдаг, хурал хийгээд л байдаг энэ хажуу талд гэхэд 200 гаруй хурал энэ Их танхимд боллоо шүү дээ энэ өнгөрсөн хугацаанд. Тэгээд ерөөсөө тэр зардлууд чинь ерөөсөө хасагдахгүй ороод ирчихсэн ингээд зардал нь хэвээрээ явж байгаа байхгүй юу. Тийм учраас яг энэ жилийн, ирэх жилийн төлөвлөгөөнийхөө дагуу яг тэр бусдаар гүйцэтгэх ажил, гүйцэтгүүлэх ажил чинь ийм, ийм зардал гарна гэдгийг яг дүнгээр нь хэлээдэх. Яагаад гэвэл тэр улсын төсөвт чинь зүгээр нэг дурын тоо авч тавьдаггүй, төлөвлөгөөний дагуу тавигдах ёстой. Тэр тоог хэлээдэх. 2 дугаарт нь тэр урсгал.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан. Боловсролын сайд Наранбаяр, Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Асуултад хариулъя. Нийт урсгал зардалд 3,9 их наяд байгаа. Үүнд цалин нь 2,3 их наяд ингээд яваад өгдөг, бусдаар гүйцэтгүүлэх гээд энэ ажлууд энэ нь болохоороо зэрэг сургуулийн харуул хамгаалалт, үйлчилгээ эд гэсэн ийм зардлууд хүртэл орчихсон ийм байгаа. Би танд энэ нарийн юунуудаа хараад хэлээдэхье одоохон. Тэгээд энэ задаргаа нь юун дээрээ байгаа, байгаа төсөв дээрээ. Тэгэхээр зэрэг дотроо энэ дээр урсгал зардал дотор бараа, үйлчилгээний зардал, тэгээд норматив зардал, хангамж, бараа материалын зардлууд, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд эд нар гээд байж байгаа.

Тэгээд та мэдэж байгаа энэ сүүлийн жилүүдэд энэ 3 ээлжийг багасгахын тулд, мөн цэцэрлэгийн хангамжийг нэмэгдүүлэхийн тулд түрээсийн энэ зардлууд

нь нэмэгдэж байгаа. Ийм зардлууд байдаг юм. Тэгээд урсгал зардал дээрээ бид энэ багаж техник, тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, урсгал зардал гээд ингээд ийм зардлууд ороод явдаг. Юуны хувьд бол 217 тэрбум төгрөг нь бусдаар гүйцэтгүүлэх зардал байгаа. Энэ дээр хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ байгаа. Норматив зардлын гол нь хүүхдийн хоолны зардлууд, дотуур байрны болоод, 1-ээс 5 дугаар ангийн хүүхдийн үдийн хоолны ийм зардлууд ороод явж байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Пүрэвдорж гишүүний ярьж байгаа тэр ДНБ дээр эрсдэл учирна гэдэг дээр би санал нийлж байна. 38 шинэ төслөөс 10 юм байгаа юм шүү, 10 төсөл хойшилж байна гэж хэлж болно. Бид энэ зорилтоосоо бол ухрахгүй. 10 төслийн 8, 9 нь зам юм байгаа юм. Зам, тээврийн салбарын. Гэхдээ төсөв дээрээс хөрөнгө оруулалт хийх бүтээн байгуулах ажлаа л бид хойшлуулж байгаа. Гэхдээ энэ орон зайн дээр төр, хувийн хэвшлийн түншлэл бусад өөр хөрөнгө оруулалтуудын ямар боломжууд байна, value exchange бид Баялаг солилцооны шинэ хуулийн орчин бүрдүүлэх, гадаад Хөрөнгө оруулалтынхаа хуулийг яаралтай нэлээн либералчилж баталж өгөх, Төсвийн хуулиудаа баталснаар хувийн хэвшлээ яаж дэмжих вэ энэ орон зайн дээр хувийн хэвшлийг яаж тэр бизнес хийх боломжуудыг нь тэлж өгөх вэ. Төр бүх юмыг нь гүйцэтгээд байлгүйгээр аль болох бизнесийн орчныг нь сайжруулж, бизнес хийх боломжийг нь тавьж өгч, хувийн хэвшилдээ нэлээд эдийн засагт оролцоог нь дэмжье гэсэн ийм бодлогын.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

**Б.Пүрэвдорж:** 3,9 их наядын урсгал зардалтай юм байна Боловсролын яам. Тэгээд 2, дээрээс нь 217 гэхэд 0,2 их наяд, тэгээд ингээд нийтдээ 4,1 их наядын урсгал зардал болон бусдаар гүйцэтгүүлээд ажилтай. Тэгээд тэрний дөнгөж цалин нь 2,3 байгаа юм, тал нь ингээд бусад зардал болоод ерөөсөө данхайсан ийм төрийг л ингээд тэжээдэг ийм зүйл болчихоод байгаа юм. Тэгэхдээ нэг зүйлийг анхааруулахад бүх сайд дотор ийм бусдаар гүйцэтгүүлэх болон урсгал зардал чинь замбараагүй болчихсон ийм юмнууд байгаа. Тэгээд та нар ингээд яг оны эцэс гэхэд баахан гэмт хэрэгт холбогдох, баахан юман дээр гарын үсэг зурсан байвуузай. Тэгээд манайхаас манай энэ Хууль зүйн сайд маш анхаарч ажиллана гэж хэлж байгаа шүү.

**Д.Амарбаясгалан:** Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

**Б.Найдалаа:** Төсвийг эргэж хараад ингээд танасанд бол, танасан явдлыг дэмжиж байгаа. Гэхдээ 2 зүйл ойлгомжгүй байна, үнэхээр ойлгомжгүй байна. Эхнийх нь алдагдалгүй төсөв гээд энд танилцуулж байгаа, дүгнэлт хийж байгаа байгууллага болгон, институт болгон, сайд болгон ярьж байна. Сонсоход гоё юм шиг боловч энэ өөрөө ингээд яг улс төрийн хувьд болон цаашдаа ийм жишиг тогтоод явах юм уу? Төсвийн бодлогын, миний ойлгож байгаагаар төсвийн бодлогын гол агуулга нь алдагдал, тэрийгээ юунд зарцуулахаас л хамаардаг зүйл биз дээ. Тэгээд тэрийгээ хэрвээ ингээд үр ашиг, төсвийн үр ашиг гэж ярина уу гэхээс биш алдагдалтай, алдагдалгүйгээр нь шүүдэг болчих юм бол энэ буруу жишиг болно гэж бодож байна.

Тэгээд цаашдаа нөгөө орлогоо ч гэсэн буруу төсөвлөх, буруу тавих, хөөрөгдөж тавих ийм буруу жишиг гарчихна. Иргэдээс, нийгмээс алдагдалгүй л байвал сайн гэсэн нэг ийм буруу ойлголт гараад байна. Энийг ядах нь Сангийн яам маань, Засгийн газар маань өөрийнхөө танилцуулга дээр ашиглахгүй байж болохгүй юу? Эсвэл арай өөр өнцгөөр хандахгүй бол ийм жишиг тогтчих юм бол цаашдаа төсвийн бодлогынхоо юуг хумьчих юм биш үү? Түүнээс төсөв алдагдалтай, алдалгүйдээ сайн, муу биш, үр ашигтай байх тухай л яримаар байгаа байхгүй юу. Тэгээд энийг хариулах байх.

2 дахь нь төсвийг ийм том дүнгээр 2 аравны их наядаар хасчхаад, таначхаад байхад танилцуулга дээр нөгөө зорилт, үр дүн хэвээрээ гэж байна лээ. ДНБ-ий өсөлт 8 хувь, инфляцын хүлээлт 7,2 хувь гээд хэвээрээ байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм том дүнгээр төсвийг таначхаад байхад бид нарын энэ хүлээгдэж байгаа үр дүн, ажлын үр дүн хэвээрээ байна гэж байгаа нь ойлгомжгүй байгаад байгаа юм. Тэгээд 2 сарын өмнө ярьж байсан яг төсвийн тэр анхны танилцуулга дээр хийж байсан зүйлс, төсөвлөсөн зүйлс, төлөвлөсөн зүйлс төсвийг ийм том дүнгээр таначхаад байхад хэвээрээ байгааг нь гайхаж байгаа юм. Энэ дээр хариулт өгөх болов уу гэж бодож байгаа. Тэгээд яг энэ 2-оос гадна өөр яг энэ төсөв танаснаар ямар нийгэм, эдийн засагт ямар нөлөөлөл үзүүлэх юм бол? Энэ талаар ямар нэгэн тооцоо байгаа юу? Энийг жоохон тодруулж өгөөч. Ийм асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Найдалаа гишүүний асуултад хариулъя. Таны саяын асуултауд ялангуяа тэр макро агрегатуудын талаар түрүүн төсвийн хүрээ ярьж байхад Гантөмөр сайд нэлээн дэлгэрэнгүй, ойлгомжтой хариултууд өгсөн. Би нэмж төсөвтэй холбоотой хэсэг дээр нь хариулт өгье. Алдагдалтай төсөв, алдагдалгүй төсөв гэдэг дээр та их зөв ярьж байна. Засгийн газар бол ашгийн төлөө институт биш, хөгжлийн төлөө институт. Алдагдалтай байх нь эдийн засгийнхаа бодит өсөлтийг дэмжээд, зөрөө нь эерэг байх юм тэр амжилт байдаг. Ирэх жилийн төсөв маань анх өргөн баригдаж орж ирэхдээ хөгжлийн төлөөх энэ зорилтуудыгаа нийцсэн, тэрийгээ дэмжсэн, тэрийгээ бүрэн санхүүжүүлэх, түүгээрээ дамжаад баялаг бүтээгч хувийн хэвшлээ дэмжих ийм төсөв байлаа. Ингээд ямар ч байсан алдагдалгүй төсөв батлах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэл авч, хууль хүчингүй болж, шинээр боловсруулах ийм бидэнд сорилт гарч ирлээ. Ингээд ямар ч байсан энэ удаа төсөв алдагдалгүй байхаар орлого, зарлагаа төлөвлөө.

Төсвийн хүрээг та анзаарсан байх. 25 он алдагдалгүй, 26, 27 оны төсөөлөл дээр мөн алдагдалгүй байгаа, маш ойлгомжтой байгаа. Тэгэхээр энэ форматаараа цаашаа бид зорьж ажиллана. Дараагийн том сорилт бол байгаа энэ төсөв дотроо илүү их үр ашигтай, бүтээмжээ нэмэгдүүлэх л ийм зорилт тавьж орж ирж байгаа. Тэгэхээр төсөв танагдсан хэмжээгээр бид эдийн засгийнхаа өсөлтийг яаж идэвхжүүлэх вэ, хувийн хэвшлийг яаж дэмжих вэ, гаднын хөрөнгө оруулалтуудыг яаж дэмжих вэ, одоо байгаа нэгэнт суурилагдсан дэд бүтцээ яаж нэмэгдүүлэх вэ, энэ жил ялангуяа уул уурхайн салбарт дэд бүтцүүд их сайн суурилагдсан шинээр. Ирэх жил энэ үр дүн гарах байх гэж бид харж байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас ч мөн ингэж харж байгаа.

Дээрээс нь уурхай ялангуяа Тавантолгой дээр бид шинэ ам нээнэ гэж байгаа. Орано гэх мэт гаднын хөрөнгө оруулалтуудыгаа л дэмжих, хөрөнгө оруулалтуудын цоо шинэ орчныг бий болгох, value exchange буюу баялаг

солилцооны энэ дэлхий нийтэд либералчилж өргөн ашиглагдаж байгаа энэ олон хувилбарууд дээрээ бид ажиллая гэдэг шинэ сорилт, шинэ зорилт тавьж байгаа. Тэрнээс биш хөгжлийн зорилтуудаасаа бид огтхон ч ухарч болохгүй. Төсөв танагдлаа ингэлээ гээд ингээд гоншигноод гээд зорилтоосоо ухраад байх юм байхгүй.

Гэхдээ сөрөг дарамтууд, ачааллууд ирнэ. ДНБ буурах дарамт ирнэ. 1 хүнд ноогдох үндэсний орлого 2028 онд 10 мянган доллар хүрнэ гэж байсан бол энэ цаг хугацааны хувьд хойшлох эрсдэл гарна. Эдийн засгийн идэвхжилт буурах ийм эрсдэлүүд зөндөө гарна. Гэхдээ энийг ингэж тоочилгүйгээр эдийн засгийн идэвхжилийг өөр ямар байдлаар бид улам илүү их идэвхжүүлэх вэ, энэ бүгд дээр Засгийн газар хичээж ажиллана. Мөн Улсын Их Хурал дээр ч тэр эрх зүйн орчнуудыг илүү их либералчлах тал дээр хамтарч ажиллана гэдэгт найдаж байна.

**Д.Амарбаясгалан:** Бадрахын Найдалаа гишүүн тодруулж асууя.

**Б.Найдалаа:** Асуулт, хариултыг ойлголоо. Зүгээр энэ дээр одоо бол асуулт биш, тодотгоод санал хэлэх гэсэн юм. Хэрвээ ийм нөгөө төсвийг том дүнгээр өөрчлөөд ажилд нь нөлөөлөхгүй байсан юм бол эндээс бид ямар дүгнэлт хийж болох вэ гэхээр яг төсөв боловсруулж байгаа, төслүүдээ эрэмбэлж байгаа энэ процесс дээр, энэ чадавх дээр асуудал байна Засгийн газарт болон Сангийн яаманд яг энэ дээр заавал нэг ийм дутагдал байна гэж би бодож байна.

2 сарын өмнө ярьж байсан зүйл ажил нь хэвээрээ, төсөв нь шал өөр болчихсон явж байгаа. Тэгсэн хэр нь бүх юм хэвээрээ гэхээр энэ бол ямар нэгэн байдлаар энэ хандлага нь ингээд, танаж байгаа хандлага нь зөв боловч яг төсөв хянаж байгаа, боловсруулж байгаа түүн дээр асуудал байна. Цаашдаа анхаарч ажиллах ёстой юм байна гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Найдалаа гишүүний саяын зүйлтэй 100 хувь санал нийлэхгүй байна. Бид төлөвлөгөөгөө баталсан, 4 жилийн мөрийн хөтөлбөрөө баталсан. Энд хүрэх зорилгоо санхүүжүүлэх ийм төсөв өргөн барьсан байгаа. Та танагдсан зүйлүүдийг харж байгаа байх 2,3 их наяд, 800 тэрбум хөрөнгө оруулалт, 700 тэрбум төгрөг нь зээлийн ашиглалт, 700 тэрбум төгрөгийн урсгал зардал. Та тэр зээлийн ашиглалт гэдгийг хараарай. Энэ дотор нефть боловсруулах үйлдвэр байна, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжууд байна. Эдгээрийг ирэх жил санхүүжүүлэх дүн нь багасаж байгаа. Бид өөрөөр энийгээ бид алдагдалгүй баланс барих ямар ч боломж байхгүй. Өөрөөр хэлбэл бид 26 оноос нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулж аваад, жилд тэрбум доллар хэмнэдэг тэр үйлдвэрээ ашиглаж эхлэх хугацаанд эрсдэл орно, хугацаанд эрсдэл орно. Танана гэдэг, нэмэх амархан, танах маш хэцүү байдаг. Энэ удаа нэлээн тийм механик таналтууд хийгдлээ. Цаашдаа энэ танасан хэрээр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж 1 минут өгье Найдалаа гишүүнд. Бадрахын Найдалаа гишүүн тодруулж асууна.

**Б.Найдалаа:** Би тодруулчихъя. Энэ жоохон буруу ойлгочихсон байж магадгүй. Санаа нь энэ байгаа байхгүй юу Жавхлан сайдаа. Хэрвээ энэ төсөв ингээд зөв, би энэ танагдсанд ингээд хавтгайруулж танасанд дурамжхан байгаа

юм. Яг үнэндээ ийм богино хугацаанд буруу байхгүй юу. Харин зүгээр Засгийн газраас яамаар санагдаж байгаа вэ гэхээр нэг бол яг саяынхаа танасан нь гоё, хориг тавьсан нь гоё байлаа гэж хэлэлгүйгээр хамгаалаад цаашаа нэг мөсөн явахгүй бол энэ чинь өөрөө ингээд зөрчилтэй байгаад байгаа байхгүй юу. 2 сарын өмнө ярьж байсан зарим гишүүд ингээд бодлогыг ингээд бодлогыг нь дэмжээд дэмжсэн, гэтэл эргээд таначхаад танасан нь гоё байна гэхээр чинь ингээд ийм зөрчилтэй болчхож байгаа байхгүй юу. Ялангуяа гишүүдийн хувьд дунд нь ингээд яг яагаад байгаа юм болчхож байгаа юм. Тэгэхээр нэг бол бодлогоо хамгаалаад, төсвөө хамгаалаад, ингээд гараад явахгүй бол тийм байсан юм байна, биш байсан байна, биш нь ч гоё, тийм нь ч гоё болчхоод байгаа юм. Тэгээд энийг анхаараарай гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Оройн мэнд. Аудитын дүгнэлт дээр тус дүгнэлт нь 14 заалттай юм байна дүгнэлт нь. Тэгээд 1 дүгээр зүйл дээр нь анх удаагаа алдагдалгүй төсөв төлөвлөсөн төсвийн төлөвлөлтөд ахиц бий болголоо гэж. Яг 1 сарын өмнө шахуу юм даа 11 сарын 18-нд би Сангийн сайдаас энэ нэг Засгийн газрын өр шир өндөр байна, энэ нүүрс уул уурхайн бүтээгдэхүүн жаахан үнэтэй, ер нь яваандаа уруудаж байгаа үед нэг төсвөө алдагдалгүй баталчхаж болохгүй юм уу гээд тэгсэн чинь та бол битгий улс төрж бай гэж байсныг санаж байна.

Тэгээд аудитын дүгнэлт гараад ирэхээр, бас Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавихаар та их таатай хүлээж авдаг юм шиг байна лээ. Яах вэ ер нь тэгэхдээ бид ийм шүү дээ, яг хөрс дээрээ бууж байна шүү дээ. Дээрээс нь улс төрийнхөө сонгуулийн золиосыг төлж байна. Энэ 2,4 их наядаар багасгаж байгаа чинь та нар ингээд доторх бүх юмаа харвал улс төрийн сонгуулийн өмнө цалин, тэтгэвэр, тэтгэмж 1,4 их наяд, Шинэ хоршоо 516 тэрбум, хууль дагаад хууль, шүүхийн байгууллагад ямар ч их хайртай юм 371 тэрбум төгрөгийн төлбөр 71 тэрбум, тэгээд энэ бүгд чинь нийлээд 2,4 их наяд байхгүй юу. Яг үнэндээ 2,4 их наядаар л багасгаж байна шүү дээ.

Өнөөдөр ингээд өчнөөн ажил болж, хэчнээн сар хэлэлцэж, хэлэлцэж байгаад бид нарын байгаа байдал ийм байна. Тэгээд яах вэ энэ удаадаа яах вэ бид урсгал зардал, хөрөнгө оруулалт, гадаад зээлийн ашиглалтаасаа ингээд нэг удаадаа 2,4 их наядыг ингээд хасчхаж болж байна л даа. Түрүүн Пүрэвдорж гишүүн хэлж байгаа байна лээ. Яг 16 оноос хойш 48 мянган төрийн албан хаагч нэмэгдсэн байна шүү дээ. 25 оны төсвийн төсөөлөл дээр чинь 4173 төрийн албан хаагчид, мэдээж үүнд жилээс жилд орж ирж байгаа эмнэлэг, сургууль, цэцэрлэг гээд төрийн үйлчилгээний албан хаагчдыг би оруулахгүй байна л даа. Гэхдээ ер нь ингээд том дүнгээрээ хэдүүлээ том зургаар харах болоогүй юм уу? Энэ данхар төрийнхөө бүтцийг хасаад, оновчтой, үр дүнтэй ийм юм руу явахгүй бол эцсийн эцэст урсгал зардал, хөрөнгө оруулалт хоёроо хасаад яваад байх юм бол нэг иймэрхүү амь аргацааснаар яваад байх юм үргэлж ингээд данхайгаад л яваад байна. Үүнтэй холбоотой энэ тал дээр Засгийн газар ямар байр суурь баримталж байгаа юм бэ гэдгийг хууль санаачлагч, оруулж ирж байгаа Сангийн яам болоод Эдийн засгийн хөгжлийн яамнаас асууж байна.

2 дахь асуудал нь энэ Төрийн ордон чинь яг үнэндээ event hall болчихлоо шүү дээ. Өглөө ирэх болгонд л баахан улсууд энэ зааланд, үгүй ээ үнэн шүү дээ. Баахан хурал, цуглаан, чуулган хийж байх юм. Өнгөрсөн хугацаанд ер нь яг



хэчнээн тэрбум төгрөгийг иймэрхүү арга хэмжээнд зарцуулчихсан юм бэ? Энэ сургалт, семинар, өөр юу гэдэг юм, нээрээ үнэндээ энэ чинь утгагүй болж байгаа байхгүй юу. Тэгээд тэр орж ирж байгаа машин тэрэг нь бодвол арай болдоггүй байх л даа. Ер нь энэ Төрийн ордон чинь Улсын Их Хурлын гишүүд нь машинаа тавих юугүй болчихоод байна шүү дээ. Үүнтэй холбоотой асуудалд холбогдох хүмүүс нь хариулаад өгөөсэй гэж хүсэх байна.

3 дахь асуудал нь говийн бүсийн тойргоос сонгогдсон гишүүний хувьд манай Өмнөговь аймгаас нэг хүсэлт ирсэн байна. Өмнөговь аймаг 1,7 их наядыг улсын төсөвт төвлөрүүлж байна. Өмнөговь, Дорноговь, Дархан, Орхон гээд хэдхэн аймаг байдаг юм л даа. Тэгээд хэд хоногийн өмнө Цогтцэций сумд сургуулийнх нь дээвэр золтой хүүхэд дараад алчихсангүй. Уг нь 19 онд энэ Өмнөговь аймгийн Засаг даргаас ирсэн бичиг нь байж байна. Тэгээд нэг ийм юман дээр ингээд, ийм их мөнгө төсөвт төвлөрүүлдэг аймаг байж, 10 тэрбум гуйгаад Улсын Их Хурлын гишүүн нь яриад байж байх нь инээдтэй юм л даа. 960 хүүхдийн сургуулийнх нь 19.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гомбын Ганбаатар гишүүнд нэмж 1 минут өгье.

**Г.Ганбаатар:** Өмнөговь аймгийн Засаг даргаас ирсэн бичиг дээр тус суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 960 хүүхдийн сургуулийн барилгыг 2019 онд эхлүүлсэн юм байна. Тэр Грийн Ресурс гэдэг компани гэрээ байгуулаад 21 оноос хойш ерөөсөө барилгынхаа ажлыг хийгээгүй юм байна. Мэдээж магадлан орсоор байгаад анх бол төсөв 6 орчим, 6 тэрбум гаруй төгрөг байж байгаад нөгөө магадлан хийгээд 9,8 болсон юм байна л даа. Тэгээд Өмнөговь аймгийн Цогтцэций сум хамгийн их төсөвт мөнгө төвлөрүүлдэг мөртөө өнөөдөр Улсын Их Хурлын чуулган дээр 10 тэрбумын асуудал ингээд бид нарт Их Хурлын тус тойргоос сонгогдсон гишүүддээ хандчихаад байж байна л даа. Иймэрхүү зүйл дээр орон нутгийн биеэ даасан байдлыг хангах, уг нь бид чинь нөгөө төвлөрлийг сааруулна гээд яриад явсан. Тэгээд өнөөдөр байгаа байдал нь ийм байна. Ядаж үнээг нь сааж байгаа юм бол тугалд нь сүү үлдээ л дээ гэдэг ийм зүйлийг хэлмээр байна. Тэгээд энэ 3 дээр хариултаа авчихъя.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Та өмнө нь өмнөх хэлэлцүүлэг дээр тэр орлого тал дээр нэлээн ярьж байсныг санах юм, буруу санаагүй бол. Энэ удаа дахин боловсруулсан төсөв дээр орлого талд өөрчлөлт ороогүй. Өөрөөр хэлбэл ирэх онд орох ёстой байсан, ялангуяа уул уурхайгаас орох ёстой байсан энэ орлого хэвээрээ төлөвлөж байгаа. Өөрөөр хэлбэл энэ зорилтдоо хүрнэ гэж байгаа. Тийм буураагүй.

Event hall гэж байна. Тэрийг Улсын Их Хурлын Тамгын газраас ярина биз дээ. Хувь хүний бодлоор энэ Төрийн ордон чинь зөвхөн дарга нарын ордон биш байх. Олон нийт энэ дээр ашиглаад, олон нийт энийгээ орж ирж үзээд, энэ сайхан том зааландаа болж байгаа арга хэмжээнүүдийг бүгдийг дэмжээд, нээлттэй байх тусмаа улам зүгээр байх гэж би ингэж боддог шүү.

Манай говийн бүсийн аймгууд тэр дундаа ялангуяа манай Өмнөговь аймгаас мэдээж орлого төвлөрүүлэлт дээр сүүлийн жилүүдэд маш сайн нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл ер нь уул уурхайд маш ээлтэй ийм нутаг. Тэр хэрээр урсгал

зардлууд нь нэмэгдэж байгаа. Сүүлийн жилүүдэд хамгийн өндөр урсгал зардалтай, суурь зардал нь ийм өндөр аймаг болж байгаа. Мөн Амнатаас буцаад хуваарилах энэ тооцооллуудын хувьд ч тэр илүү их ээлтэй байх тусмаа илүү хуваарилдаг энэ бодлого руугаа аажмаар шилжиж байгаа. Тэгэхдээ Өмнөговь аймаг ер нь чамгүй өндөр, бусад аймгуудтай бүүр харьцуулшгүй өндөр орлого төвлөрөлт маш сайн болж байгаа. Тийм учраас цаашдаа энийг илүү их аймагт нь үлдээж, хуваарилах, заавал төсвөөр дамжуулж хуваарилахгүйгээр суурь бүтээн байгуулалтын, ялангуяа бүтээн байгуулалтын зардлууд дээр нь нэмэх тал дээр арга хэмжээ авахаар бид тооцоолж байгаа. Ер нь яах вэ одоо бол амнатийн 10 хувь, Орон нутгийн хөгжлийн сан гээд энийг 30 хүртэл хувиар нэмэх боломж юу байна гээд энэ дээр ажиллаж байгаа. Мөн өөр бусад аймгууд ч энэ асуудлыг хөндөж байгаа. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Золжаргал:** Түрүүчийн нөгөө буцаагддаг төсөв дээр татварын орлого ойролцоогоор 32 их наяд гээд байсан. Тэгээд тэр нь өмнөх жилээсээ 20 орчим хувиар өсчихсөн дүн байгаад байгаа юм. Сая хасагддаг дээр 0,5 их наяд хасагдсан байгаа. Тэр нь зардал хасчихаар тэр зардалтай холбоотой хилээр орж ирэх бараа, бүтээгдэхүүн НӨАТ ингээд юмнууд гээд 500 тэрбум, 540 тэрбум. Тэгэхээр асуулт нь ийм байна. ААН-үүдийн тоо Х тайлан өгдөг нь олшроод, хаагдаж байгаа нь их байгаад байдаг. Татварын орлого хаанаас нэмэгдээд байна гэдэг. 20 хувийн өсөлтийн эх үүсвэр нь юу вэ гэдэг талаар асуумаар байна. Энэ татварын орлого чинь яг энэ хүлээлтээрээ гарахгүйгээр дараа нь хэцүү, төсөвт хэцүү юм болох вий дээ гэж.

2 дахь асуулт болохоор эдийн засгийн өсөлт 8 хувиар тооцсон байгаа шүү дээ. Түрүүн яриад байна лээ. Валютын сан болохоор 6 хувь гээд, 6, 7 гээд янз бүрийн тоонууд байгаа. Бодит байдал дээрээ жишээ нь 6 хувь болчихвол нөгөө төсвийн тооцоолол дээр мэдээж өөрчлөлт орох болчих байх. Тэгэхээр 1 хувиар эдийн засгийн тэлэлт 1 хувиар, 1 функт буурахад төсвийн алдагдал хэдэн төгрөг болох бол, ийм хувилбар тооцоо байгаа юу? Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** 19 оноос хойш өөрөөр хэлбэл Татварын багц хуульд өөрчлөлт орсноос хойш татварын хувь хэмжээ огт өөрчлөгдөөгүй байгаа. Тийм учраас энэ нэмэлт орлогууд бол манай экспортын үйл ажиллагаа нэмэгдсэн. Ер нь эдийн засгийн идэвхжил өөрөө суурь ингээд тэлээд ирэхээр энэ татвар хураалтад ч нэмэгдэж, орлого бүрдүүлэлтэд огцом ийм нөлөөлөл үзүүлж байна гэсэн үг. 25 оны хувьд 17 хувиар өсөж байгаа, өмнөх жилүүдийн өсөлтийн дунджаас арай жоохон бага байгаа. Ингэж төлөвлөсөн байгаа.

Сүүлийн 2 жил 22, 23 онуудад бид төсвийг алдагдалтай баталж төлөвлөж байсан боловч гүйцэтгэл дараалан нэмэх гарсан. Дараалан нэмэх гарсан. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид орлого бүрдүүлэлт дээр, өөрөөр хэлбэл нөгөө тэнцвэржүүлсэн орлого, өөрөөр хэлбэл уул уурхайн савлалтаа цэвэрлэж байгаад хамгийн багаар, эрсдэлгүйгээр тооцдог орлогын түвшин байна. Бид тооцоолол дээр алдаагүй байна гэсэн үг. Сүүлийн 2 жил давж орлого биелсэн, алдагдалгүй гарсан Монгол Улсын төсөв. Энэ жилийн 24 оны хувьд ч тэр, тодотгол хийсний дараа ч гэсэн мөн бид яг төлөвлөснөөрөө гарах шинжтэй байна, хүлээлттэй байна.

Одоо 1 сарын хугацаанд элдэв том юм болчихгүй бол. Ирэх жилийн хувьд мөн энэ тооцоолол дээрээ байх болов уу гэж ингэж бид хүлээлттэй байгаа. Ялангуяа манай гол, гол экспортын, ялангуяа биет хэмжээний хувьд дэд бүтэц, нэвтрэн өнгөрүүлэх чадвар, цаад талын эрэлт буурахааргүй байна. Харин ч нэмэгдэхээр байгаа. Тийм учраас орлого тал дээр эрсдэл бага байна гэж харж байгаа. Тэр, ингээд зардал буурснаас болоод шууд нөлөөлдөг орлогууд буурна. Тэгэхдээ юу нь 540 бол буурсан шүү, энэ талдаа нөгөө бид цалингийн нэмэгдэл дээр яах вэ гээд эргэлзэж байсан. Одоо бол цалингийн нэмэгдлээ 6 хувиа тооцоод оруулж ирж байгаа учраас түүн дээр буцаад орлого нэмэгдээд, хасагдах орлого буураад, 394 тэрбум болсон байгаа.

Эдийн засгийн өсөлтийн хувьд түрүүн Эдийн засгийн хөгжлийн сайд хэд, хэд тайлбарласан даа. Төсөв хумигдахаар ДНБ-ий өсөлт буурах дарамт нэмэгдэнэ. Зөрөөд энийг харин юугаар орлох вэ л гэдэг бид нарын дараагийн том сорилт болж ирж байгаа. Хувийн хэвшлээ л дэмжье, гаднын хөрөнгө оруулалтуудыг дэмжье. Төсвийн үлдсэн 1 төгрөг болгоныг илүү их үр бүтээмжтэй болгоё гэдэг дээрээ л ажиллах. Товчхондоо ийм зорилт тавьж байна гэсэн үг. Тийм биз дээ Гантөмөр сайдаа.

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

**О.Цогтгэрэл:** Улсын төсөв гэдэг өөрөө татвар хураагаад, буцаагаад зарцуулах төдий зүйл биш. Энийг дагаад салбар, салбар бүрийн энэ бодлогын өөрчлөлт шинэчлэлт, ирэх жил ер нь юунд анхаарах вэ, юу өөрчлөгдөх вэ гэдэг бодлогын баримт бичиг гэж ойлгодог. Тэгэхээр яг бусад зүйлээс эдийн засгийн нөхцөл байдлыг аваад үзэхээр ер нь хэчнээн хүн ажил хийж байна, хэчнээн хүн нь ажилгүй байна, ажил хийж байгаа нь ямар цалин мөнгө авч байна, яг энэ бодит орлого, нөхцөл байдлууд юу вэ гэдэг өөрөө эдийн засгийн хамгийн суурь асуудлууд байх. Яг өнөөдөр манай Монгол Улсын эдийн засагт болж байгаа үйл явцыг харахаар баахан ажилгүйдэл их байна гэдэг. Залуучууд ажлын байр байхгүй гэдэг. Нөгөө талд нь ААН-үүд нь ажилтан олдохгүй байна гэдэг. Энэ 2 зүйл нь хоорондоо огтлолцдоггүй, баахан ажилгүй залуучууд гэдэг, ажилтангүй компани 2. Энэ 2 яагаад огтлолцохгүй байна вэ гэдэг өөрөө яг өнөө цагт бидний тулгамдчихсан суурь асуудлуудын нэг байх гэж.

Тэгээд ирэх жилээс баахан том, том төслүүд гэж байдаг. Нөгөө их чадвартай, мэдлэгтэй боловсон хүчнүүд нь хаанаа байгаа юм. Сүүлдээ тэгээд гадаадаас ажиллах хүчний квотыг чөлөөтэй болгоё гэдэг аргагүй шийдвэрүүд гарч, гарахаар болж байх шиг байна. Тэгэхээр яг эндээс би Боловсролын сайдаас нэг зүйл тодруулж асуух гээд байгаа юм. Тэр ажилтангүй компани, ажилгүй залуучууд хоёрын хооронд гарч байгаа энэ зай, энэ бодлогын дутмагшлын асуудал чинь явсаар, явсаар байгаад манай боловсролын тогтолцооны алдаа энэ дээр, бодит байдал энэ дээр харагдаж байгаа байх гэж. Энийг чинь хооронд нь тэр боловсрол гэдэг зүйл холбож байдаг байх. Техник, технологи гэдэг зүйл энийг холбож байдаг ёстой байх. Гэтэл яг боловсрол, тэр тусмаа дээд боловсролын тогтолцоог харахаар үнэхээр яг одоо бол нөхцөл байдал сэтгэл өвдөм.

Сэтгэл өвдөм гэдэг нь явсаар, явсаар байгаад хамгийн сүүлд эрчим хүчний салбарт либералчлал чөлөөлөлт гэдэг зүйлийг ярьж байна. Хамгийн энэ хөгжил дэвшлийн үзүүрт нь явж байх ёстой боловсролын салбар энэ улсын их, дээд сургууль гэдэг нь яг одоо төрөөс үнэ тогтоодог салбар болоод хувирсан, сургалтын

төлбөрийг нь ТУЗ нэртэй төрийн албан хаагчаар дамжуулаад төрөөс тогтоодог. Тэгээд тэнд өрсөлдөөнгүй газар, өрсөлдөөнгүй, нээлттэй үнэгүй тэр газарт чанаргүй бүтээгдэхүүн тэндээс гардаг. Тэр гарсан чанаргүй бараа, бүтээгдэхүүн чанаргүй боловсон хүчин нь энэ эдийн засгийн үндсэн суурь дутмагшил энэ асуудлын үндэс болоод хувирчихсан. Тэгэхээр ирэх жилийн энэ үйл ажиллагаа энэ төсөв дээр байгаа Боловсролын сайдын дээд боловсрол гэсэн би энэ хуудсыг харж байна л даа 4, 5 шалгуур үзүүлэлт бүхий зорилтот түвшин гээд байна. Энэ дээр ямарваа нэгэн тийм бодитой энэ эдийн засгийн нөхцөл байдал руу харсан тоо алга. Тэгэхээр та энэ ер нь энэ улсын төсөв ирэх жил, тэр тусмаа боловсролын салбарт, тэр тусмаа дээд боловсролын салбарт, тусмаа энэ чанартай ажлын байр бий болгох, энэ ажилтангүй компани, ажилгүй залуучуудыг холбохдоо ямар бодлогын өөрчлөлт, шинэчлэлт боловсролын салбараас, Боловсролын сайдын зүгээс барьж байгаа вэ? Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч.

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ туйлын чухал асуудал. Өнөөдөр 64 их сургуульд төрийн өмчийн сургуулиуд дээр яг энэ төлөөлөн удирдах зөвлөл нь өөрсдөө энэ оюутныхаа төлбөр мөнгийг тогтоож байгаа. Хөдөлмөрийн зах зээл бэлтгэгдэж байгаа боловсон хүчин 2 ингээд нийлэмжгүй байна гээд 40 мянган ажлын байр байгаад байхад 80 мянган хүн ажилгүй байгаад байна гэсэн ийм тоон мэдээг дурдсан байна лээ. Тэгэхээр энэ дээр бид энэ мэргэжлийн боловсрол, ерөөсөө энэ өнөөдөр 40-өөд мянган хүн мэргэжлийн боловсрол дээр сурч байгаа 44 мянган хүн. Энэ мэргэжлийн боловсролоо дэмжиж явах нь их чухал байгаад байгаа юм. Ахлах сургуулиудыг төрөлжүүлж эхлэх нь их чухал байгаад байгаа юм. Ингэж сонголттой болгохгүй бол бүгд ингээд их, дээд сургууль руу явдаг, тэгээд яг мэргэшсэн мэргэжлээрээ өөрөө ингээд ажиллаж чаддаггүй энэ нөхцөл байдал үргэлжлэхүйц ийм байгаад байгаа.

Тийм учраас их, дээд сургуулиудын, их сургуулиудыг бид энэ техникийн зохицуулалтаар яг энэ мэргэжлийг нь өөрсдөөр нь энэ зах зээлтэй нь уялдуулах ийм ажил явж байгаа. Дээд сургуулиуд нь бол их сургууль болж өөрсдийнхөө техникийн зохицуулалтаар явах энэ шалгуур үзүүлэлтээ хангахгүй тохиолдолд эдгээр сургуулиуд коллеж болж ингэж явах гэсэн ийм ажлууд явагдаж байна. Эрэмбэ чансааг тогтоох ажил явагдаад өнөөдөр Боловсролын үнэлгээний төвөөр дамжуулаад олон нийтэд зарлаж байна. Олон их, дээд сургуулиудын чанарын асуудлыг өнөөдөр энэ нууц биш шүү дээ, БНХАУ-д өнөөдөр Монголын ялангуяа магистр, докторантын энэ сургалтын гэрчилгээг нь хүчинтэй гээд тооцоход хэцүү гэсэн юм зарласан шүү дээ олон нийтэд. Энэ дээр Филиппин улс байсан, Энэтхэгээс байсан, Монголоос байсан. Ингээд ярилцаад үзэхэд энэ ер нь чанарын асуудлыг аль, аль нь хөндөөд байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бид энэ их сургуулиудыг судалгааны их сургууль болгож хөгжүүлэх, судалгааныхаа их сургуулийг инновацын их сургууль болгож хөгжүүлэх энэ бодлого руугаа л явах юм байгаа юм. Тэгээд энэ жилээс оюутнуудын босго оноог нэмж эхэлж байгаа. Бид энэ сургуулиудтайгаа ярилцаад, босго оноог энэ жилдээ 10 оноогоор өсгөж оруулж ирж байгаа. Тэгэхээр босго оноог нэмж, чанартай оюутан хүлээж авдаг, чанартай сургалт явдаг энэ их, дээд сургуулийн орчин, их сургуулийн орчин бидэнд хэрэгтэй. Ийм бодлогын хувьд бид ингэж

чанартай боловсон хүчнээ бэлдэнэ гэсэн, ийм бэлдэнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Золжаргал гишүүнээ түрүүн миний минут хүрсэнгүй, ийм байгаа юм. 22 онд өмнөх жилээсээ татварын орлого 37 хувиар, 23 онд өмнөх жилээсээ 32 хувиар, 24 онд өмнөх жилээсээ 25 хувиар, 25 онд өмнөх жилээсээ 19 хувиар нэмэгдсэн байгаа юм. 21, 22 оных чинь нөгөө 20, 21 оны эдийн засаг 5 хувь уначихсан байсан суурин дээрээс харахаар өсөлт нь ийм өндөр харагдаж байгаа юм. Ингээд өсөлт хэвийн, эдийн засаг тогтворжоод ирэхээр өмнөх жилтэйгээ харьцуулсан орлогын өсөлтүүд буурч ирнэ. Хэмжээний хувьд маш сайн нэмэгдэж байгаа. 23 онд 167 их наяд, 24 онд 188 их наяд, 25 онд 218 их наядын татвар ноогдуулах орлого ААН-үүдээс ингэж орохоор байгаа юм. Тэгэхээр энэ маань өөрөө татварын хэмжээтэй холбоотой биш, ер нь далд байсан эдийн засгууд маань ингэж ил болж байна, бүртгэл сайжирч байна. Дээрээс нь эдийн засгийн идэвхжилийг сэргээх энэ бодлогууд үр дүнгээ өгч байна л гэж үзнэ. Энэтэй шууд холбоотой.

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя.

**О.Цогтгэрэл:** Наранбаяр сайдаас би тодорхой асуулт асуугаад байна л даа. Бид нэг ийм захиргааны аргаар тэрийг итгэмжлээд, шалгалт шүүлэг аваад, босго оноог нааш, цааш болгоод, тэгээд наад салбараас чинь тийм чанартай бүтээгдэхүүн гарахгүй гэдэг нь, хамгийн супер арга зам гэдэг нь биш гэдэг нь харагдчихаад байна л даа. Гол нь наад салбар чинь өөрөө чөлөөт үнэтэй, нээлттэй өрсөлдөөнтэй энэ арга механизм руу орж байж наад чанартай боловсон хүчин, чанартай бүтээгдэхүүний асуудал чинь шийдэгдэх юм биш үү? Наад улсын сургуулиудыг нь засаглалын хувьд баахан төрийн түшмэлүүд очиж суучхаад, тэгээд үнийг нь тогтоогоод байдаг, төлбөрийг нь тогтоогоод байдаг, чөлөөт өрсөлдөөнийг нь боомилдог. Үнэ тогтчихоор баахан 10 хүүхдийн ажиллах орчин нь сурах орчин дээр 100 хүүхэд аваад сургадаг, чанаргүй бүтээгдэхүүн гардаг энэ тогтолцооныхоо өөрчлөлтийг та хийхгүй юм уу гэж би асуугаад байна л даа. Мэдэхгүй тэгээд одоо.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн сайд нэмж хариулъя.

**П.Наранбаяр:** Энэ асуултад хариулъя Цогтгэрэл гишүүний. Тэгэхээр зөв, зөв. Тэр чөлөөт өрсөлдөөнийг дэмжих асуудал байгаа. Дээд боловсролын хууль шинэчлэн найруулагдаад гараад, энэ хуулиараа удирдах зөвлөл нь 15 хүний бүрэлдэхүүнтэй, үүнээс 8 нь юу байж байгаа, үүсгэн байгуулагч буюу төрийн төлөөлөл. Бусад нь багш нарын төлөөлөл, тэр бусад аж ахуйн нэгж, оюутны төлөөлөл гээд ингээд явж байгаа. Тэгэхээр цаашдаа энэ сургуулиудын чөлөөт өрсөлдөөнийг бид дэмжинэ. Энэ сургуулиуд өөрсдөө өрсөлдөж байж, мөн ялгарч байж энэ чинь улам сайжирна гэж харж байгаа. Тэгэхээр зэрэг таны энийг бид, таны энэ санаа, хэлээд байгааг бүрэн хүлээн зөвшөөрнө. Цаанаа ийм хуультай. Яг ингээд төр өөрөө очоод бүх юмыг шийдээд байгаа биш, харин ч илүү ямар нэгэн томилгоонд нь төр оролцдоггүй болсон, мөн энэ шууд удирдлагад нь шууд Боловсролын яам оролцдоггүй болсон шүү.



**Д.Амарбаясгалан:** Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

**Ж.Алдаржавхлан:** Баярлалаа. Би асуултаа асуучихъя, байж байгаарай манайхан. 2025 оны шинэчлэн боловсруулсан төслийг хүлээж авлаа. 3-хан асуулт байна. 1 дүгээрт энэ 25 оны төсөв дээр сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр шинэ сургууль, цэцэрлэг бараг байхгүй юм байна гэж би харсан. Тэгэхээр энэ бодлого хэдэн он хүртэл үргэлжлэх вэ? Би яах вэ нөгөө тойргоос сонгогдсон гишүүний хувьд юу гэж асуух гээд байна вэ гэхээр манай Хан-Уул дүүрэг жишээ нь 5 жилийн өмнө 187 мянган хүнтэй байсан одоо 300 мянга болчихсон. Хүүхдийн тоо байнга өсөж байна. 60 хүүхэдтэй ангитай сургуулиуд маш ихээр нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ хүмүүсийг, энэ хүүхдүүдийг хаанаас санхүүжүүлж сургууль, цэцэрлэгийг нь барьж өгөх вэ? Ирэх 25 онд лав улсын төсөв дээр лав байхгүй юм байна. Энийг хаанаас барьж өгөх вэ гэдэг арга замыг нь хэлж өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт нь хөрөнгө оруулалтын чиглэлтэй, хөрөнгө оруулалтыг олон жил тасалж тавьж байна. Жишээ нь Хан-Уул дүүргийн 15 дугаар сургуулийг ирэх жил 3 тэрбум төгрөгөөр тавьсан байна лээ, цаана нь дахиад 7 үлдсэн байна лээ. Энийг нь хэдэн он хүртэл гэж хувааж тавих вэ? Тэр олон жил хуваахаар чинь тэр барилгын компанидаа хүртэл хэцүү шүү дээ. Тэгэхээр хөрөнгө оруулалтынхаа бодлогыг арай өөрчлөх үү, үгүй юу? Энэ дээр нэг хариулт хийж өгөөч гэж.

3-д нь Учрал сайдаас нэг ийм асуулт байх юм. Энэ сая сүүлийн үед энэ сошиалаар энэ хиймэл дагуулыг хасуулчихлаа, ёстой бараг луйвар хийх гэж байхад нь би хасуулчихлаа гэсэн тийм постууд хаа сайгүй л явж байна. Нэг сэтгүүлч ч явуулж байх шиг. Яг үнэхээр тийм бараг луйвар хийх гэж байхад нь хасуулсан юм уу, үнэхээр тийм юм болсон юм уу гэдэг зүйлийг нэг албан ёсны тайлбар хийж өгөөч. Би бүр гайхаад байгаа юм.

Дараачийнх нь энд нэг сонин зардал байх юм Учрал сайдаа, Жавхлан сайдаа. Би энэ 8 жил орчим нийслэлийн төсвийг би батлалцах гээд сууж байхдаа огт хараагүй нэг ийм ангилал тууж явна. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх гээд 6 тэрбум төгрөг явж байна. Тэгэхээр энэ чинь яадаг юм бэ зөвхөн тэр дээгүүр байгаа төрийн албан хаагчдыг мэргэшүүлдэг зардал уу? Би лав орон нутгийн төсөв баталж байхад ийм зардал огт харж байгаагүй. Тэгээд энийг нэг хариулж өгөөч гэж хүсэж байна. Бусдаар гүйцэтгүүлэх дээр байж байна лээ. Тэрийг харж, танай хариуцсан улсууд нь хариулж өгөх байх гэсэн юм. Эхлээд хариултаа авчихъя.

**Д.Амарбаясгалан:** ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэ 14 мега төсөл бол улсын төсөвт ачаалал өгөөд байх ийм төслүүд огт биш л дээ. Тэгэхээр энэ төсөв батлагдлаа ч гэсэн мэдээж энэ хувийн хэвшлийн, гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих, сайжруулах, гаднын зээл, тусламжаар хэрэгжүүлэх чиглэлийн ийм төслүүд. Тэгэхээр энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн энэ 14 мега төсөлд орсон энэ үндэсний хиймэл дагуулын төсөл 2 улсын Засгийн газрын хооронд өнгөрсөн хугацаанд яригдаад, хэлэлцээрийн түвшинд байгаа ийм төсөл. Тэгэхээр нөгөө байхгүй мөнгийг байхгүй болголоо гэлтэй биш, энэ чинь нөгөө улсын төсвөөс ямар нэгэн санхүүжилт гаргаад, тэрийг нь энэ сая өргөн барьсан төсөв дээр хасаад ороод ирчихсэн юм шиг тийм буруу ойлголт байгаад байх шиг байна. Угаасаа энэ яриад байгаа энэ том тоотой төсөв улсын төсөвт ямар нэгэн

ачаалал үүсгээд, эцэслээд шийдэгдсэн зүйл ерөөсөө байгаагүй шүү дээ. Тэр байхгүй мөнгийг байхгүй болгоно гэж угаасаа байхгүй.

Тэгэхээр мэдээж улсын төсөв дээр урт хугацааны зээлийг 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр авсан тохиолдолд зардал талдаа бүртгэгдээд, жил болгон нөгөө ашиглалтынх нь зардал нь тавигдаад явдаг. Тэгэхээр Их Хурлаар зээлийн хэлэлцээрийг оруулаад, соёрхож батлаад, хэрвээ энэ зээл авагдвал 15-аас 20 жилийн хугацаанд энэ зээл 2 Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн дагуу жилд хэд төлөгдөх юм, тэрүүгээрээ ашиглалтад бүртгэгдээд ингээд явах нь. Энэ хүрээндээ энэ төсөв дээр зээлийн багтаамж буюу ирэх жилүүдэд 15-аас 20 жил хэрэгжих энэ зээлийг авна. Тэгээд энэ хэрвээ Их Хурал баталбал жил болгон ашиглалтыг нь тооцно гэдэг зорилгоор зардал талдаа бичиж явсан болохоос улсын төсөв дээр тавигдаад эсвэл тэр нь хасагдаад байгаа юм ерөөсөө байхгүй.

Тийм учраас энэ хиймэл дагуул хаслаа, нэмлээ гэдэг ойлголт энд огт байхгүй шүү. Яагаад гэхээр, яах вэ дараа жилийн хугацаанд ямар нэгэн байдлаар зээл авагдсан эцсийн шийдвэр ч гараагүй, дээрээс нь энэ зээлийн багтаамж талаасаа авчаж байгаа учраас дараа жил энэ тэр бол ямар нэгэн зээлийн ашиглалт тооцох, зардал тооцох ийм огт шаардлагагүй болж байна л гэсэн үг. Тэгэхээр 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр л үргэлжилж байсан ажил шүү. Тэрнээс улсын төсөвт ачаалаад байгаа зүйл огт байхгүй гэдгийг та бүхнийг ойлгоосой гэж бодож байна. Тэгээд байхгүйг байхгүй болго гээд бухимдаад байсан хүмүүст хэлэхэд угаасаа л улсын төсөвт ачаалал өгөөд, хаана ч байгаа юм тэр санхүүжилт шийдэгдсэн зүйл байхгүй шүү дээ. Тэгэхээр түүнийг аваад бараг утаанд зарцуул гээд зарим нь тэгээд байх шиг байна. Тэр санхүүжилт нь шийдэгдээгүй, тэр мөнгө төгрөг улсын төсөвт угаасаа байхгүй. Ирэх жил дахиж ийм зээлийн ашиглалт энэ тэр ч бүртгэгдэхгүй. Тэгэхээр ингээд хасагдаж байна гэсэн үг зээлийн багтаамжаас.

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Ер нь Хан-Уул дүүрэг маш их нягтаршилтай болж байгаа. Сүүлийн жилүүдэд хүн ам нь нэмэгдэж байгаа. Өнөөдөр төрийн өмчийн 24 сургууль тус дүүрэг Хан-Уул дүүрэгт нийтдээ 47731 хүүхэд сурч байгаа юм. Тэгэхээр сургууль, цэцэрлэг бол энэ дүүрэгт маш их шаардлагатай байгаа. Энэ жил 25 он гэхэд бид 96 сургууль, цэцэрлэгийг ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа. Үүнээс нийслэлд 30, орон нутагт 66 гэсэн ийм тоо бий. Юуны хувьд бол таны хэлдэг үнэн. Энэ юуны асуудлаар Хан-Уул дүүрэгт ялангуяа бид шинээр барилга барих боломжгүй нөхцөлд түрээслээд худалдан авах ийм гэрээнүүдийг хийх ийм бодлого барьж байгаа. Тэгээд өнөөдөр Хан-Уул дүүрэгт 9 сургуулийн байр түрээсэлж байгаа. 15, 34, 59, 75, 115, 130.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд гүйцээж хариулъя.

**П.Наранбаяр:** 130, 32, 52, 156 гэсэн сургуулиудыг бид түрээсэлж ингэж ажиллуулж байгаа, хэвийн үйл ажиллагааг нь хангаж. Ер нь тэр он дамнуулдаг асуудал бол үнэн. Он дамнуулдаг үнэхээрийн бүүр ингээд ковидын үеэр ч гэсэн энэ бүүр ингээд гаараад явчихсан юмнууд байгаа. Тэгэхээр санхүүжилтийнхээ хуулиар хуулиар 3 хувааж ийм төсөв олгогддог. Тэгэхээрээ 3 жилээс хэтэрч

болохгүй юм байгаа юм, болохгүй юм байгаа юм. Тийм учраас энэ жилийн төсөвт өмнө жилүүдээс он дамнасан төслүүдээ дуусга гэсэн ийм байдлаар энэ төсөв хуваарилалтыг хийж ингээд явж байгаа.

Мөн таны санаачлаад байгаа орон сууцны хотхон барьж байгаа тохиолдолд заавал сургууль, цэцэрлэг байгуулдаг энэ хуулийн шинэчлэл хийе гэсэн энэ санаачилгыг Боловсролын яамны зүгээс бид дэмжинэ, дэмжиж ажиллана. Энэ маш туйлын чухал байгаа. Та энийг өөрөө сайн мэдэж байгаа. Та бид 2 ч гэсэн энэ тал дээр санал солилцож байсан. Энэ стандарт барьж ингэж явуулахгүй бол энэ боловсролын хүртээмж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жуковын Алдаржавхлан сайд тодруулж асууя. Наранбаяр сайд хариулахдаа нийт Улаанбаатар хотын хэмжээний сургуулийн ачаалал дунджаар хэдэн хувьтай байдаг юм тэрийг нэг. Алдаржавхлан сайд, гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Нэг чухал юм асуусан шүү дээ. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх гээд ийм сонин зардал тууж явна, 6 тэрбум төгрөг бай явж байна. Би өмнө нь ийм юм хэзээ ч харж байгаагүй. Энэ орон нутагт ажиллаж байхдаа. Энэ яадаг мэргэшдэг хүмүүс юм бэ? Зөвхөн яам, тамгын газарт ажилладаг, дээгүүр ажилладаг хүмүүсийг мэргэшүүлдэг зардал юм уу? Энийг нэг хариулж өгөөч гэж.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Энэ манай ЗГХЭГ Учрал сайдын багц дээр байдаг зардал юм байгаа юм. Энэ нөгөө төрийн албан хаагчийн мэргэшүүлэх зардал нь Удирдлагын академид олгодог санхүүжилт байхгүй юу. Удирдлагын хөгжлийн академи чинь Хэрэг эрхлэхийн сайдын багц дотор байдаг юм. Тэгэхээр Удирдлагын академи нь энэ зардлаар үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг. Үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг, тэгээд төрийн бүх шатын албан хаагчдад богино, дунд, урт хугацааны сургалт, мэргэшүүлэх эдгээр үйл ажиллагаагаа санхүүждэг гэсэн үг. Тэгэхээр төрийн бүх албан хаагчдаа сургах зардал гэж ойлгож болно. Байгууллагын зардал.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

**С.Эрдэнэбат:** Цалингийнхаа асуудлыг ярина. Дотоодын бүтээгдэхүүнд эзлэх цалингийн хувь хэмжээ ерөнхийдөө баялгийг шударгаар хувилсан улс орнуудад ард иргэдийнх нь цалин хөлс орлогын хэмжээ 50-аас 60 хувь байдаг. Манай улсад 20 хавьцаа, 30 руу дөхөж байгаа. Тэгэхээр энэ томоохон эдийн засгийн төсөл хөтөлбөрүүдийн үр өгөөж маань хэчнээн иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна вэ гэдэг энэ нөлөөллийн үнэлгээг нь хийж байж бид эдийн засгаа өсгөх гэдэг ийм зүйлийг яримаар байгаа юм. Тухайлбал 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5 мянган доллароос дээшээ гарсан. Энэний нөгөө тал нь дагаад нэг тоог хүмүүс хардаг дэлхий нийтээрээ. 1 цагт ноогдох хөдөлмөрийн хөлс нь нэмэгдсэн үү, нэгж ААН байгууллагуудын орлого яаж нэмэгдсэн бэ гэдэг дээр нь хардаг юм.

Тийм учраас энэ төсвийн бодлогынхоо хувьд төсөв тодорхой хэмжээгээр тэлж байгаа, нэмэгдэж байгаа. Экспортыг дэмжих, импортыг орлох энэ томоохон

төслүүдээ, хөтөлбөрийг бол дэмжихийг бол, явуулахыг дэмжиж байгаа. Дээрээс нь төсөв дээр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж гээд нийгмийн эмзэг хэсгийнхээ нэмэгдлийн асуудлыг хэвээр нь орж ирж байгаад талархаж байгаа. Гэхдээ боломж байвал цаашаа бид нэмээд явах ийм шаардлага байна гэдгийг хэлмээр байна. Тухайлбал боловсрол, эрүүл мэндийн салбараас энэ жилийн төсөв дээр нэг айхтар юм хасаад байх хэрэггүй байгаа. Би бол эрүүл мэндээс хасаагүй, боловсролоос хассан байна гэдэг ийм мэдээллийг авсан. Жилд 40 мянган хүүхэд шинээр нэмэгдэж байгаа юм байна лээ. 40 мянган хүний зөвхөн багшийг нь бодоод үзэхээр энэ чинь мянга гаруй багшаас авхуулаад олон хүмүүс нэмэгдэнэ. Тэгээд энийг нөгөө нэг төрийн албан хаагчийн тоо өслөө гээд нэг өрөөсгөл байдлаар ингээд яриад байхаар энэ тоогоо харж байж бид ярихгүй бол яг аль хэсэгтээ нэмэгдээд байгаа вэ гэдэг дээрээ нэг ойлголттой болчихвол зүгээр байна. Цаашдаа дахин, дахин ярихгүйгээр 2-т.

3 дугаарт энэ орон сууцжуулах дээр нэлээн иргэд хүлээлт байна. Ирэх жилүүд дээр 1м<sup>2</sup>-ыг нь хэдэн төгрөгөөр, хэчнээн айл орон сууцыг моргейжийн зээл болон бусад зүйл энэ төсөв дээр тавигдсан бэ? Нөгөө төсвөөс нь хасагдсан уу, үгүй юу гэдгийг би тодруулж асуумаар байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал гээд байдаг. Төр маань өөрөө 0,5 гээд, хувийн хэвشلүүд 1,5-ыг гаргах ёстой гээд хуульчилчихсан. Саяхан нэг түрүү жил өвөл газ дэлбэрээд нэг компани зардлаа хэмнэх гэж байна гээд аюулгүй ачаа тээвэрлэхдээ 2 хүн байх ёстой. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагаандаа зардлаа хэмнэж байна гэдэг нэрийдлийн дор бүтэн байшин, хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон ийм асуудал гардаг. Тэгэхээр сая харахад хөдөлмөрийн аюулгүй байдлын зардлыг яг хэдэн төгрөг тавьчихсан байгаа юм бэ? Хуулиараа нийт зардлынхаа 0,5 байх ёстой.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмье гээд шийдвэрүүд нь гаргачихсан. Эзэд нь, үйлдвэрчин нь, Засгийн газар нь хоорондоо ярилцаад шийдчихсэн. Тэгээд Их Хурал болохоор үгүй ээ болохгүй, энэ чинь ААН байгууллагууд дампуурчихна, болохгүй, бүтэхгүй гээд ингээд тэгж ярих эрх байхгүй. Хуулиараа бол Үндэсний хороо нь тогтоочихсон. Тэгээд төсөв дээр 40 орчим тэрбум төгрөг нэмж орж ирэх юм байна. Үүнийх нь 20 гаруй тэрбум нь эрүүл мэндийн, 1 хүүхдийгээ бид чинь 1300, 13 мянган төгрөг сард эрүүл мэндийг нь эмчил гэж даатгалд өгч байгаа. 13 мянган төгрөгөөр яг үнэндээ нэг эмч авч хүрэхгүй шүү дээ. Тэгээд эрүүл мэндийн салбар бол энэ Эх, нялхсаар дүүрэн хүүхдүүд, хүндрэлтэй байгаа, төсөв хүрэхгүй, алдагдалтай байгаа гээд төсөв хоорондоо хүртэл гүйчих ийм боломж бололцоо байгаа юм. Тэгэхээр энэ Сангийн сайд маань би өдөр хэлсэн. Тэгээд та бүгд маань, Засгийн газар маань энэ тал дээр анхаараад шийдээч гэдгийг хэлмээр байна.

Амьжиргааны баталгаажих доод түвшин 454 мянган төгрөг байгаа. Ядаж ажил хийж байгаа хүн шүү дээ. Тэтгэврээсээ доор цалинтай, тэгээд өөрөөсөө гадна ядаж 1 хүүхдээ тэжээх хэмжээний цалин өгч байж энэ чинь баталгаат цалин гэдэг нэртэй байхгүй юу олон улсын нэршил. Үүнээс доош байж болохгүй гэсэн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын сан маань өөрөө тусдаа Төсвийн хуультай шүү Эрдэнэбат гишүүнээ. Улсын төсвийн хууль, ЭМД-ын сангийн тухай хууль, төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хууль гээд тусдаа төсвүүдийн. Тэгэхээр аль болох энэ сангийн төсвүүдийг бид ерөөсөө огт оролдоогүй. Тэртээ тэргүй энэ нөлөөллөөс болоод орлогууд нь буурч байгаа юм. Алдагдлууд нь нэмэгдэж байгаа гэсэн үг. Тэгэхдээ зардал талаас нь ерөөсөө огт бууруулаагүй. Харин эрүүл мэндийн ч бай, боловсролын ч бай яг яамны үйл ажиллагаатай холбоотой зардлууд тодорхой хэмжээнд хасагдана. Өөрөөр хэлбэл яг үндсэн үйл ажиллагаатай нь холбоотой эрүүл мэндийн салбарын тэр ЭМД-ын сангаас санхүүждэг тэр тусламж, үйлчилгээний зардлууд ерөөсөө огт хасагдахгүй.

Боловсролын салбар дээр ч тэр, түрүүн Наранбаяр сайд маш тодорхой хэллээ. Яг энэ салбарт ажиллаж байгаа багш, ажилтан, мөн хүүхдүүд дээр очиж байгаа хоолны мөнгө гэх мэтчилэн нэгж яг орлого болж очдог эдгээр зүйлүүд огт хасагдахгүй. Мөн л үйл ажиллагаатай холбоотой яг тийм администрэйшн тийм зардлууд нь тодорхой хэмжээнд хасагдаж байгаа гэдгийг хэлье.

Моргейж бол төсвөөс санхүүждэггүй гэдгийг хэлье. Хамгаалал, аюулгүй, ХАБ-ын зардлыг манайхнаас нэг тоо хэлээдхээрэй. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй асуудлыг бид жил болгон анхаараад явдаг. Энэ жил аягүй ойрхон 2 нэмэгдчихлээ. Өргөн барих үед 660 байсан, одоо энэ чинь 792 болоод нэлээн том дүнгээр нэмэгдчихлээ. Тэгээд уг нь 2 жил тутам 1 удаа нэмэгдэж байх ёстой. Гэтэл 1 жилийн дотор 2 удаа нэмэгдчихлээ. Тэгээд мэдээж төсвийн ачаалал ирнэ. Энд 40 тэрбум бол бага мөнгө биш шүү Эрдэнэбат гишүүнээ. Тийм. Дээрээс нь тэгээд таныг ингээд ярихаар хүмүүс ингэж ойлгоод байна. Төрийн албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэг хэсэг нь авдаг юм байна, тэр нь нэмнэ гээд Эрдэнэбат гишүүн тэгээд байхад төсвөөс ерөөсөө нэмэхгүй байгаа юм байна гэсэн ойлголт аваад байна. Энэ чинь огт тийм биш шүү дээ. Та тэрийг нэг өөрийнхөө амаар нэг хэлээд өгөөрэй.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авдаг нэг ч төрийн албан хаагч байхгүй болсон. Доод хэмжээ сая орчим болсон байгаа. Тийм учраас энэ бол төрийн албан хаагчидтай шууд холбоотой асуудал биш гэдгийг хэлье. Мэдээж цаашдаа энэ тал дээрээ мэдээж хүссэн, хүсээгүй энэ төсөв дээр ингээд тусгагдаад явна. Цаг хугацааны хувьд харин хэзээ вэ гэдгийг тал, тал, олон талаас нь харах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

**С.Эрдэнэбат:** Төрийн албан хаагч гэж ойлгож болохгүй. Төрөөс цалин хөлсний бодлогод оролцох ганц арга нь дэлхийд бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээрээ дамжуулж оролцдог юм. Би, та бүгд энэ google-с ороод ажилд авна гэдэг зар оруулаад бүгдээрээ хар даа. Угаагч, зөөгч гээд 1 сая 500, хамгийн багадаа 1 сая 200 гээд ингээд, зарим нь тогооч гэхэд 2,5 саяас эхлээд ингээд явчихсан байж байна. Тэгээд бид зүгээр хэлбэрдэх гэж ийм авдаггүй юм чинь ингээд бага хэвээрээ байж байг гэдэг байдлаар бодож болохгүй юм 1.

2 дугаарт төр өөрөө хүүхдийн ЭМД, ахмадын ЭМД, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бид даана гэсэн. Тэгэхдээ даах мөнгө нь өөрөө энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уячихсан учраас энэ өөрөө давхар, давхар тэр нэг салбаруудаа



дэмжээд, энэ үнэ инфляцынхаа үнэтэй ойролцоо эм, тариа чинь жил болгон өсөж байгаа. Үүнтэй холбоотой нэмээч гээд байгаа юм. Яг бодит байдал дээр бид 600 мянган төгрөгөөр цалин өгч чадахгүй байж гадаадаас ажилчид авчирна, ажилтан олдохгүй байна энэ тэр гээд ийм юм ярих чинь өөрөө маш.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Түрүүний асуултад гүйцээж хариулъя өмнөх дээр нь, сүүлийнх дээр Эрдэнэболд гишүүн санал хэлчих шиг боллоо гэж харлаа. Тэр орон нутгийн 3 хувийн ипотекийн зээл чинь зөвхөн төрийн албан хаагч нарт зориулсан зээл биш байгаа шүү. Түрүүн та тэгээд хэлчхэв үү, би буруу сонсов уу. Энэ бол орон нутаг руу, орон нутгаас Улаанбаатар луу яваад байгаа энэ л нүүдлийг тэнд, орон нутагт нь барих ийм бодлого юм байгаа юм. Тэрнээс зөвхөн төрийн албан хаагч биш шүү. Энэ бол жигд хүртээмжтэй иргэдэд ч олгогдоод явж байгаа ийм зүйл. Үүний татаас 63 тэрбум төгрөг огт хасагдаагүй тавьсан байна. Хөдөлмөр хамгааллын зардал 25 оны төсвийн төсөлд байгууллагууд дээр нь нэгдсэн төсвийн хэмжээнд 328 тэрбум. Үүнээс Онцгой байдлын байгууллагын 25 оны жилийн төсөв нь, уучлаарай нийт төсвийн хэмжээнд 3,5 тэрбум төгрөг, тийм 3,5 тэрбум төгрөг байгаа юм байна.

**Д.Амарбаясгалан:** Сандагийн Бямбацогт сайд асуулт асууя. Больсон. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Тэгээд би 4 асуулт байгаа юм. Ер нь тэгээд яах вэ алдагдалгүй гэдэг тал руугаа төсөв батлагдах юм шиг байна. Уг нь үр ашигтай төсөв гэдэг энэ томъёолол концепцоо ойлголцоод явсан бол уг нь зүгээр байлаа. Тэгээд өнөөдөр нийт төсвийн маань 70 хувийг урсгал зардал буюу тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгө, цалин хөлс л байдаг. 30-хан хувийн орон зайн дээр нь бусад дараа дараагийн цалингаа нэмэх, экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүнийг хийх тэр суурь дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд бол хийх гэж байна. Тэгээд сүүлдээ гүйцэхгүй байх. Би тэгээд их л харамсалтай байна. Попрон хуйлруулах урлаг гэж байдаг юм байна. Энийг зарим хүмүүс гаргууд сайхан эзэмшсэн юм шиг байна.

Тэгээд үр дүнг нь хэдүүлээ хожим нь 3, 4 жилийн дараа ярина л даа. Тэгээд төсөв гэдэг бол нэг компанийн төсөв баталж байгаа зүйл биш байхгүй юу. Энэ чинь өөрөө хүний эрхийг хангах бодлогын бичиг баримт. Энэ нийгэмд үүсээд байгаа суурь асуудлыг шийдэх бодлогын бичиг баримт. Хувийн хэвшлийг дэмжих бодлогын бичиг баримт байдаг байхгүй юу. Түүнээс биш энэ компанитай ялгаагүй шүү дээ ашиг, алдагдалгүй байх ёстой гээд юм яриад байдаг. Тэгээд нэг ардын баатар царайлаад, эцсийн дүндээ 3, 4 жилийн дараа, хэдэн жилийн дараа энэ тэтгэвэр тэтгэмжийг чинь нэмэх орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх суурь дэд бүтэцгүй л байж байгаа. Улам энд байгаа дэд бүтэц дээр чинь авлига нь цэцэглэж байна, утаа униар нь манарч байна шүү дээ. Ийм л зүйл рүү орлоо. Тэгээд харамсалтай байна.

Тэгээд би төрийн албан хаагчдаасаа уучлалт гуйж байгаад нэг санал гаргана гэдгээ хэлмээр байна. Энэ мега төслүүдийг буюу хөрөнгө нь шийдэгдчихсэн гадаадын зээл, тусламжаар шийдэгдчихсэн нефть боловсруулах үйлдвэр, цэвэрлэх байгууламж, Солонго 1, 2 хороолол, эргээд энэ Эрдэнэбүрэнгийн УЦС-ын ажлыг шуурхай явуулахын тулд энэ гадаадын зээл, тусламжийн ашиглалтаас хасагдаж байгаа 660 тэрбумыг аль болохоор бага

тануулъя гэж бодлого байна. Тэгээд бид хэд энэ Солонгост эдийн засаг нь муудахад ард иргэдээрээ алтаа тушаагаад зогсож байсан гэдэг шиг би энэ төрийн албан хаагчдынхаа 1 сарын 1-нээс 6 хувиар цалин нэмэх эх үүсвэрээсээ 7 сарын 1 болгоод санал гаргая гэж бодож байгаа.

Тэгээд энэ гарсан зардлыг нь гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг ашиглах энэ мега төслүүдээ явуулах бодлого руу оруулъя. Тэгээд төрийн албан хаагчид намайг зүхвэл зүхэг. Би адилхан төрийн албан хаагч байсан, та нар дундаас гарч ирсэн. Тэгэхдээ бүгд энэ улс эх орныхоо төлөө нэг удаа энэ уриалгыг хүлээгээд аваад, тэвчээртэй хандчихаасай. 7 сарын 1-ний өдрөөс нь энэ цалин хөлсийг нэмье. Энэнээсээ хэмнэсэн 200 орчим тэрбум төгрөгийг нь бид энэ том мега төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлд нь оруулъя гэж би уриалмаар байгаа юм. Энийг дэмжинэ байх гэж бодож байна.

Дээрээс нь энэ нефтийн үйлдвэр баригдах хугацаа хойшлох тусам жил болгонд 1 тэрбум долларыг бид гадагшаа алдаж байгаа шүү. Энийг ингээд бодолцмоор байгаа юм.

Дээрээс нь боловсролын салбарт хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгт 100 тэрбум төгрөгийн хувьсах зардал өгч байгаа. 38,5 сургууль, үлдэгдэл цэцэрлэг дээр байгаа. Би цэцэрлэг дээр юм ярихгүй. Энэ том, том компаниуд дэргэдээ дандаа эмнэлэг, сургуультай татвараас зугтах маягтай байгаад байгаа. Бүгдийг нь ТББ байгуулчихсан. Энэ 38,5 тэрбум төгрөгийн хувьсах зардлыг ерөнхийдөө больё. Энд хүүхдийн эрх зөрчих, хүний эрх зөрчих, Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхал биш шүү. Энийгээ харин хэдүүлээ хэмнээд, 3 ээлжийн сургууль үүсчхээд байгаа, тэр дотуур байрны хүрэлцээ сайжруулах асуудлыг нь шийдээд өгчихье. Энийг Боловсролын сайд би дэмжинэ гэж бодож байна. Хэдүүлээ ингээд ээж, ааваас нь ч мөнгө авдаг, улсаас ч мөнгө авдаг, энэ боловсролын системийг бүүр бизнес болгочоод байгаа хүмүүсээ одоо больё. Тэгээд энийгээ хэдүүлээ жирийн хүүхдүүдээ боловсролын тэгш байдлыг арилгах энэ зүйлдээ зарцуулмаар байна.

2 дугаарт Жавхлан сайд шүүхийн төсөв дээр ямархуу өөрчлөлт орсон бэ? Уг нь Цогтбаатар нарын, 2 Цогтбаатар гишүүнтэй би нэг санал гаргаад оруулсан юм. Тэгээд хасагдаад ороод ирж байгаа юу?

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Тэр шүүхтэй холбоотой зардлууд хөндөгдөөгүй. Хэдхэн хоногийн өмнө Улсын Их Хурал дээр Хууль зүйн байнгын хороон дээрээс саналууд нь гараад, Улсын Их Хурал дээр олонхоороо дэмжээд явсан. Хэдхэн хоногийн өмнө энэ шийдэгдсэн асуудал. Тэгээд энийг хасаж барьж хөдлөөгүй, хуучнаараа орж ирж байгаа. Хөндөгдөхгүй байх тусмаа л нөгөө хөндөөд байгаа зардлууд дээр ачааллууд улам нэмэгдээд байгаа. Гэхдээ энэ институтийн хувьд хууль дээр нь орчихсон ийм заалтууд. Өөрөөр хэлбэл салбарын хууль дээр нь бүр Засгийн газар ч энийг төлөвлөхгүй, Улсын Их Хурал, Байнгын хороон дээр энийг төлөвлөөд, шууд Засгийн газарт хүргүүлээд төсөвт суулгуулах ёстой гэхихсэн ийм хуулийн заалттай юм. Их олон жил, олон ч юу байх вэ сүүлийн намайг ажил авснаас хойш байнга энэ асуудал яригддаг. Бид Төсвийн хуулиа барина, тэнд болохоор салбарын хуулиа барина гээд байнга маргалдаад ингээд нэг маргаантай яваад байдаг юм. Тэгээд энэ удаа мөн Улсын Их Хурал дээр нэмж тусгагдсан тэр дүнгээрээ явж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Энэ төсөвт 38 тэрбум байгаа. Тэгээд энэ нь болохоороо нөгөө төрийн ачааллыг үүрэлцээд 47, 8 мянган хүүхдийг сургаж байгаа сургууль. Тэгээд цэцэрлэгийнх тусдаа өгч байгаа. Тэгэхээр энэ дээр яах вэ Сайнзориг гишүүний асуултад хариулахад 10 саяас дээш төлбөртэй сургуульд хувьсах зардал огт олгохгүй байгаа. Ерөөсөө огт олгохгүй байгаа. Тэгээд шаталбараар нь ингээд хувьсах зардлынх нь олголтыг бууруулаад, бууруулаад, ингээд мөнгө нь ингээд мөнгөн дүн нь ихсэх тусам олгож байгаа хувьсах зардал нь буурдаг. Энэ Боловсролын ерөнхий хуульд байдаг заалт юм. Өмчийн хэлбэр харгалзахгүй өгнө гээд. Гэхдээ Засгийн газар өөрөө тогтоол гаргаад, энэ хувьсах зардлын олгох эсэх юугаа бол тэр тогтоолоор явж байгаа. Тэр мөнгөн дүнг нь би танд сая хэллээ. Боловсрол өөрөө тэргүүлэх салбарын хувьд ийшээгээ хөрөнгө оруулалтыг татах, тэгээд хувийн хэвшлийнхэн, ресторан баар гэхгүйгээр энэ боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

**П.Сайнзориг:** Боловсролыг төрөөс үнэгүй олгох ёстой гэдэг Үндсэн хуулийн зарчимтай. Ээж, ааваас нь ч авна, төрөөс авна гэдэг бол энэ зарчмыг аль нэг талдаа гажуудуулж байгаа. Тийм учраас Улаанбаатар хотод байрлаж байгаа энэ төлбөртэй сургуулиудад ерөөсөө хувьсах зардал олгохгүй. Харин бусад аймгуудад, хотуудад ийм сургууль баривал олгоё. Ийм бодлогын өөрчлөлтийг хийе хэдүүлээ 1 дүгээрт.

Тэгээд ер нь олон төсөл, хөтөлбөрүүд ерөнхийдөө хасагдаж байна. Би зүгээр энэ дээр нэг сүүлийн л юм хэлчихье. Тэрэлжийн зам гээд ганцхан хүнтэй холбосоор байгаад хаслаа. Аялал жуулчлалын гол зам дээрээ автобус дүүрэн жуулчин онхолдсоны дараа бүгдээрээ амаа барина. Аялал жуулчлалыг дэмжих биш энэ ганц уул уурхайн талаар мөнгө, уул уурхайн дараа мөнгө олъё гэдэг салбараасаа хэдүүлээ ингээд нэгхэн хүнтэй холбож байгаад хасчих жишээний. Би энэ Засгийн газар дээр 44 хороо энэ тэр байгаа. Энийг буулгахыг нь буулгая, хуультайгаас бусдыг нь. Тэгээд энэ бүтээмжгүй Бүтээмжийн хороо, Хурдасгуур энэ тэр гээд юу хурдлуулаад байгаа юм бэ, одоо татан буулга. Яамдаас илүү орон тоотой, яамдаас илүү цалин авдаг. Яамнууд луу зүгээр бичиг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Хороод ажиллаж байгаа. Эндээс байнгын ажиллагаатай ч хороод байна, байнгын бус ч байна, бүтэцтэй ч байгаа, бүтэцгүй ч байгаа. Тэгээд гишүүд энэ дээр нэлээн наана, цаана шүүмжлэлтэй хандаж байгаа. Тэгээд Засгийн газар дээр хариуцдаг сайд нартаа уламжилъя. Бас сонсож байгаа байх ер нь.

**Д.Амарбаясгалан:** Сайнзориг гишүүн Дэгийн хуулиа сайн уншчихсан байна, тодруулъя гэж байна, дахиж нэг байгаа.

**П.Сайнзориг:** Тэгээд би ингэмээр байна, гадаа амьсгалмаар байна гээд жагсаал болж байгаа юм байна. Энийг дэмжих суурь юм бол дэд бүтцээ л бүрдүүлэх. Орон сууцжуулах бодлогыг дэмжихийн тулд цэвэрлэх байгууламжаа

барих, нефтийн үйлдвэрээ барих. Тэгэхээр би төрийн албан хаагчдыгаа нэг учир явдлыг ойлгоод 7 сарын 1-нээс цалингийн нэмэгдлээ авъя гэдгийг уриалмаар байна. Энэнээс хэмнэсэн зардлыг хэдүүлээ мега төсөлдөө өгчихье.

2 дугаарт хамгийн сүүлийн нэг санал байна. Ер нь энэ бяслагийн үйлдвэр гээд байгаа юм. Уг нь жишээ нь Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын онцлогийг судлаад өгчихмөөр байгаа юм. Тэр өвс ургамал нь юу юм бэ. Тэгвэл нөгөө газарзүйн заалтаараа бяслагаа үнэд оруулдаг болохоос биш ингэж май бяслаг барья гээд үйлдвэр дээр нь мөнгө тавиад ингэж хувийн хэвшлээ дэмждэггүй юм. Энэ Швейцар бяслагууд чинь яагаад үнэд ороод байгаа вэ гэхээрээ энэ уулын нугд бол цагаан-уул цэцгийг идсэн учраас ийм Швейцар бяслаг үнэтэй байх ёстой гэж газар зүйн заалтаараа үнэд ордог байхгүй юу. Ийм зүйлүүдийг нь төр хийж өгдөг болохоос энэ дээр мөнгө тавих ёстой байхгүй юу. Түүнээс биш бяслагийн үйлдвэр барь гээд өгдөг хэдэн дарга.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд Тэрэлжийн зам жишээлбэл хувийн хэвшил 100 хувь хөрөнгө оруулалт хийгээд, сонирхоод хийчих тийм боломж бололцоог нь энэ гишүүдийн хэлж байгаачлан нээх боломж байхгүй юу? Заавал бүх л хөрөнгө оруулалтыг төр төсвийн мөнгөөр гэж харахаас илүүтэйгээр эргэлт өндөртэй хувийн хэвшил сонирхвол сонирхож болохоор иймэрхүү зүйлүүдийг та энэ дээр нэг тодруулаад хариулчаач.

**Б.Жавхлан:** Ганц Налайх-Тэрэлжийн зам биш. Жишээ нь Дархан-Алтанбулагийн зам ер нь хангалттай урсгалтай, хангалттай трафиктай. Тэгэхдээ яах вэ 2 жилийн өмнө бид зарласан юм, 2 жил дараалж зарласан юм. Жишээ нь Дархан-Алтанбулаг дээр. Тариф нөгөө эргэлтийнх нь энэ график нь ингээд гологдоод, тухайн үед эдийн засгийн тогтворжилт, өсөлт ч өнөөдрийнх шиг байсангүй. Зүгээр цаашдаа энэ дээр ийм боломжууд төр, хувийн хэвшлийн түншлэлээр явах ийм боломжууд гарах байх. Тийм учраас энэ удаа зураг төсөв нь бэлэн, тэгээд хойшлуулж байгаа замууд бүгдээрээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр явах боломжтой. Бид бүгдээрээ энэ рүү нэг ямар ч байсан үзээд алдана.

**Д.Амарбаясгалан:** Тэгээд шаардлагатай тохиолдолд Засгийн газраас төсөл санаачлаад Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, чиглэл аваад Тэрэлжийн зам, Дархан-Алтанбулаг чиглэлийн эдийн засгийн эргэлт сайтай, хувийн хэвшил сонирхож хөрөнгө оруулалт хийх боломжтой ийм төслүүдийг оруулж ирэх боломжтой шүү. Тэр дээрээ анхаарч ажиллаарай гэж хэлье. Ринчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

**Р.Батболд:** Оройн мэнд гишүүдээ. Товчхон хоёрхон зүйл асуучихъя. Энэ хүчингүй болдог төсвийн хэлэлцүүлгийн үеэр угаасаа асуугаад л байсан энэ нэг төсвийн тэнцлээ алдагдалгүй болгочхож болохгүй юм уу гэсэн. Ер нь дандаа хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулиудын дагуу орсон зардлууд байгаа, хасчихаар болохгүй байгаа гэсэн тайлбартай байгаад байсан. Тэгээд Ерөнхийлөгч хориг тавьчихаар буцаагаад хасаад оруулаад ирлээ. Тэгэхээр ирэх жил ер нь хэчнээн хуулиар олгогдох ёстой байсан энэ төсөв зардал хасагдчихав гэдэг нэг асуултыг нь Сангийн сайдаас асууя.

2 дугаарт нь ер нь энэ тоон мэдээлэл байхгүй учраас асуух юм ингээд бараг дуусчих гээд байна. Би энэ Их Хурлын даргаас нэг юм асуумаар байгаа юм. Энэ

Их хурлын гишүүдийн тэнцвэртэй, тэгш мэдээлэл авах боломж ерөөсөө хангагдахгүй байна.

Энэ бүлэгтэй гишүүд сүүлийн 4 хоног энэ төсөв яриад, бүлгийн хурал нь хийгдээд л явдаг, Засгийн газар нь мэдээллээ хийгээд л явдаг. Ингээд одоо хаанаас юугаа хасчихсан юм, ямар юмаа танаад оруулаад ирж байгаа юм, үүнийгээ бүгдээрээ мэдээд байдаг. Энэ бүлэггүй гишүүд нь үүнийгээ ерөөсөө мэдэж байгаа юм байхгүй. Тэгээд өглөө энэ номоо өгчихдөг. Одоо бид бодвол 3 хоногийн дотор үүнийгээ хуучин төсөвтэйгөө харьцуулж үзээд, хаанаас, юу хассанаа олж аваад, тэгээд ярих ёстой юм шиг байна. Энэ хооронд нөгөө төсөв батлагдчихна. Тэгэхээр энэ тэнцвэртэй мэдээлэл яаж өгөх юм бэ? Үүнийг та нэг анхаарч. Ямар ажил хийх юм бэ энэ тал дээр?

**Д.Амарбаясгалан:** Эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Хэдэн хуулиар, ямар төсөв тавигдаад байна вэ, ямар нь өнөөдөр хасагдаж орж ирж байна вэ гэж байна.

**Б.Жавхлан:** Батболд гишүүний асуултад хариулъя. Гишүүдэд ирэх жилийн урсгал зардал нэмэгдсэн 3.5 их наяд нь одоо хүчин төгөлдөр ажиллаж байгаа 26 хууль тогтоомжийн нөлөөлөл байна гэдгийг хүргүүлсэн байгаа. Мөн одоо хэдийгээр хууль тогтоомжтой боловч орж амжаагүй ингээд орох гээд хүлээгдэж байгаа 4.5 их наядын ийм зардал хүлээгдэж байна гэдгийг танилцуулсан байгаа. Энэ удаа хасагдаж байгаа зардлууд болон бусад хэмнэж байгаа зардлуудтай холбоотой салбар салбарын 7 хууль дээр байгаа заалт, мөн Хэмнэлтийн хууль дээр мөн 7 заалт нэмж орж, нийтдээ 250 гаруй тэрбум төгрөгийн зардал бууруулах боломж нээгдэж байгаа гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын тухай хуулиар сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан улс төрийн нам 10 буюу түүнээс дээш суудал авсан тохиолдолд намын бүлэгтэй байх ийм хуультай. Ингээд мэдээж одоо бүлэгтэй байгаа намууд бүлгээр дамжуулж гишүүдээ мэдээлэлжүүлэх, байр сууриа, бодлогоо тодорхойлох, илэрхийлэх тэр нөхцөл хангагдаад явж байгаа. Харин Улсын Их Хуралд суудалтай мөртөө бүлэггүй намууд яах вэ гэдэг асуудал өнгөрсөн хугацаанд яригдсан.

Үүнийг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл журамдаа өөрчлөлт оруулаад парламентад бүлэггүй нам, эвслийн дарга, удирдлагуудыг Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүнээр орж ажиллах боломжийг энэ парламентын түүхэнд анх удаагаа нээсэн. Энэ тэр нам, эвсэл өөрсдийн дотоод зохион байгуулалтын хүрээнд гишүүдээ мэдээлэлжүүлж байх, гишүүдийнхээ санал бодлыг нэгтгэж, санал бодлыг нь сонсож, байр сууриа илэрхийлж байх боломжийг олгоод өгчихсэн байгаа. Мэдээж 126 гишүүн 126-лаа Даргын дэргэдэх зөвлөлд орж сууж, мэдээлэл авна гэвэл боломжгүй. Энэ бол цаг хугацаатай, тодорхой дүрэм журмаар зохион байгуулагддаг. Бид 2025 оны төсөв хүчингүй болсонтой холбогдуулж, Ерөнхийлөгчийн хориг тавьсантай холбогдуулж яаралтай горимоор нэг удаагийн дэгээр үүнийг хэлэлцэхээр болсон.

Ингээд өчигдөр Засгийн газар хууль албан ёсоор хүчин төгөлдөр болсонтой холбогдуулж, 18 цагт хуулийн төсөл өргөн барьсан. Улсын Их Хурлын Тамгын газраас 18 цаг 30 минутад бүх Улсын Их Хурлын гишүүний цахим хаягаар дамжуулж, өргөн барьсан төслийн мэдээллийг бүрэн хүргэсэн. Урьд шөнө 3 цаг 30



минутад Тамгын газар бүх материалыг хувилаад, бүх гишүүдийн хайрцагт хүргэж өгсөн байгаа. Мэдээж бид асуудал болгон дээр ингэж шуурхай ажиллах боломж байдаггүй. Цаг хугацаа, нөхцөл байдалтай уялдуулсан ажлын зохион байгуулалтыг бүх талаас анхаарч ажиллаж байгаа. Цаашдаа ч энэ гишүүдийг ижил мэдээллээр хангах тал дээр илүү анхаарч ажиллах шаардлагатай гэдгийг Тамгын газарт хэлье. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асууна. Батболд гишүүн тодруулж асууя. Ринчиндоржийн Батболд гишүүн.

**Р.Батболд:** Тодруулж асуухгүй, зүгээр саналаа хэлчихье. Ер нь бол яах вэ ямар, ямар хуулийн заалтаар ирэх жил тэр өгөх ёстой төсөв мөнгө нь хасагдчихаад байгаа юм бэ гэдгийг ер нь Сангийн яам эртхэн зарлачихсан нь дээр байх. Тэгэхгүй бол ирэх жил бөөн асуудал болоод л, мөнгө нь байхгүй гэхээр Их Хурал хасчихсан ч юм шиг, Засгийн газар хасчихсан ч юм шиг ийм нэг хачин юм руу явчих вий гэж бодоод байгаа юм. Тэгэхээр үүнийгээ нэг эртхэн зарлаад, энэ төсөв мөнгө чинь байхгүй шүү гээд эртхэн хэлчхэж байсан нь дээр байх.

Зүгээр нөгөө мэдээллийн тухайд бол яах вэ Шадар сайдын саяын танилцуулга эсхүл Сангийн сайдын танилцуулгыг ядаж нөгөө энэ рүү хайрцаг руу хийчихсэн байсан бол нэг жоохон ойлголттой орж ирэх байлаа тэгээд. Ямар ч тийм тоон мэдээлэлгүй л ороод ирлээ.

**Д.Амарбаясгалан:** Шадар сайд, Сангийн сайд нар чинь энэ том товхимлыг чинь товчилж танилцуулж байгаа. Тэгэхээр Их Хуралд тэрийг бол урьдчилж өгдөггүй шүү дээ. Өөрсдөө яг танилцуулах цагтаа үүнийгээ танилцуулаад явчхаж байгаа. Энэ Сангийн сайд энэ Батболд гишүүний хэлж байгаа энэ санал их чухал юм байна. Нийт 56 орчим хуулиар төсөв зохицуулаад байгаа байдлыг ер нь засаж залруулах дээр Улсын Их Хурал, Засгийн газар идэвхтэй сайхан хамтарч ажиллах хэрэгтэй.

Нөгөө талаас гишүүдэд би анхааруулж, анхааруулж ч юу байх вэ, энэ ойлгуулж хэлэхийг хүсээд байгаа нэг зүйл нь өнөөдөр хууль нь өөрчлөгдөөгүй байгаа, хуулиар заачихсан төсвийг байхгүй болгох чиглэл дээр санал гаргах ямар ч үр дүнгүй зүйл байдаг гэдгийг гишүүд маань их сайн анхаарч ажилламаар байгаа юм. Халамж хас л гээд байдаг, халамжийг хасах санаачилгыг өргөн барьж, хуульдаа өөрчлөлт оруулаагүй байгаа үед Сангийн яам, Засгийн газар тэрийг хуулийн дагуу тусгаж орж ирэхээс өөр аргагүй байдаг гэдгийг бид их тийм эергээр ойлгож авах ёстой юм байгаа юм. Мэдээж танхимд үгээ хэлэх үзэл бодлоо илэрхийлэх гишүүдийн эрх. Гэхдээ бид яг бодит байдалтай нийцэж, нийгэм, олон нийтэд бодитой мэдээлэл хүргэж байх үүднээс аль, аль талдаа ийм хариуцлагатай хандах ёстой шүү гэдгийг бас хэлье. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

**Б.Пунсалмаа:** Сайн байцгаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийг бүхэлд нь алдагдалгүй болгож байгаад талархаж байна. Төсвийн алдагдал гэдэг тэр чигээрээ зээл, өглөг болж ирдэг. Тэгээд Засгийн газрын өр, өрийг төлөхийн тулд татварыг нэмэгдүүлэх, татварын хатуу бодлого баримтлах ийм шаардлага бий болдог. Гэхдээ энэ удаа бид төсвийг алдагдалгүй баталж байгаа гэдэг утгаараа энэ татварыг бууруулах ямар бодлого энэ жил хэрэгжүүлэх вэ 1 дүгээр асуудал?

2 дугаар асуулт нь 126 гишүүнтэй парламент хамгийн түрүүнд бид Төсвийн тогтвортой байдлын тухай баталсан. Энэ Тогтвортой байдлын тухай 6.1.3 дээр урсгал зардал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувьтай тэнцэнэ гэж оруулж ирсэн. Гэтэл дотоодын нийт бүтээгдэхүүн гэдэг манайх шиг уул уурхайн эдийн засагтай улс орон бол гэнэт өсөж магадгүй эсвэл буурч магадгүй. Тэр болгонд бид энэ төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмж энэ болгоныгоо шууд өсгөөд, шууд бууруулах боломж бол байхгүй. Тэгэхээр энэ ерөөсөө 6.1.3 гэдэг заалт бол дотоодын нийт бүтээгдэхүүнээ дагаж өсдөг гэдэг утгаараа энэ тун тохиромжгүй заалт болжээ. Үүнийг бид засаж залруулаад, тогтмол урсгал зардалд байгаа энэ цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг инфляц, дээрээс нь 5, 10 хувийн тогтмол өсөлттэй байхаар цаашид ингэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм боломж, бололцоо байна уу?

Яагаад гэхээр ирэх жил дахиад энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдэг шиг дахиад 1.9 их наяд төгрөгийн зардал төсөв дотор орж ирж суучаад, үүнийгээ бид ингээд яаж шийдэхээ мэдэхгүй ингээд маш олон мэтгэлцээн цаг хугацаа авч магадгүй учраас бид нар энэ Төсвийн тогтвортой байдлын 6.1.3-аа ер нь өөрчлөх тал дээр дахиж бодвол ер нь ямар вэ гэсэн ийм асуултыг хүргүүлж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Би хариулчих уу? Энэ нөгөө Булгантуяа гишүүнээр ахлуулчихсан нөгөө ажлын хэсэг чинь их том ажлын хэсэг байгуулагдсан шүү дээ, 25 гишүүн оролцсон байгаа. Энэ ажлын хэсэг бол 1 дүгээрт энэ төсөв хэлэлцэхтэй холбоотой 7, 8 хуулийн хоорондын нийцлийг бүрэн хангах, дараа жилийн өдийд төсөв хэлэлцэж байх үед ямар нэгэн байдлаар ийм зөрчил, хууль хоорондын зөрчил үүсээд, нөхцөл байдлыг хүндрүүлээд байхгүй тал дээр анхаарч ажиллахаар байгаа. Уг нь энэ цаг үе дээр нэлээн идэвхтэй ажиллаж байх ёстой. Харамсалтай нь төсөв дахин хэлэлцэж байгаа учраас бид энэ ажлын хэсгийг идэвхтэй ажиллуулж одоохондоо чадахгүй байгаа.

Хоёр дахь нь энэ ажлын хэсгийн том үүрэг бол Засгийн газартай хамтраад, энэ 56 орчим хуулиар төсөв Төсвийн хуулиас гадуур зохицуулаад байгаа байдлыг эмхэлж цэгцлэх дээр анхаарах ёстой. Үүнийг ганц Улсын Их Хурлын эсхүл ганц Засгийн газрын ажил гэж орхихгүйгээр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Аудитын ерөнхий газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, холбогдох бүх байгууллага оролцоод, бүгдээрээ нэг ажил хэрэгчээр энэ асуудлыг шийдэж авъя гэж байгаа юм. Түүнээс Засгийн газрын ажил гээд бид орхиж болохгүй. Улсын Их Хурал дангаараа хий гээд Засгийн газар оролцохгүй байж болохгүй. Энэ үүсээд байгаа нөхцөл дахиж үүсдэггүй байхад л бүгдээрээ анхааръя. Энэ 126 гишүүнтэй парламентын чинь нэг том давуу тал асуудлыг маш олон талаас нь харж ярьж чадаж байгаа. Ингэж ярихад нь хуулийн ямар нэгэн зөрчил саад үүсдэггүй байх тэр нөхцөлийг бүрдүүлэхэд энэ парламентын мэргэжлийн байдал шууд хамаарна гэж байгаа юм.

Тийм учраас парламент Хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтын ажиллагааг эхлүүлсэн. Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны ажлын алба шиг ажилладаг байх тэр нөхцөл рүү бид шилжиж байгаа. Тэгэхээр ерөөсөө Монголд байгаа хуульчдын бүх потенциалыг бид энэ өөрчлөлт, шинэчлэлтэд зориулж ажиллах боломжтой болсон гэдгийг хэлэхийг хүсэж байна. Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

**Б.Жавхлан:** Пунсалмаа гишүүний асуултад хариулна. Татвар асуусан тийм ээ. Татвараар хувийн хэвшлээ яаж дэмжих гэж байна вэ гээд. Өмнөх хэлэлцүүлгийн үед бид бас мэдээллүүдээ өгсөн. 3 суурь асуудал татвараар хувийн хэвшлийг дэмжье гэж байгаа. Үүнийг л Засгийн газраас оруулж ирсэн байгаа дээр нь бушуухан Их Хурал батлаад өгнө байх гэсэн ийм хүлээлттэй байгаа шүү. Энэ дээр ерөөсөө боловсруулах чиглэлийн үйлдвэр. Одоо бид ингээд хэрвээ төсөв дээрээсээ төсвийн бодлогоо хумих ийм чиглэл барьж байгаа бол одоо дандаа л ерөөсөө хувийн хэвшлээ л дэмжих ёстой. Хөрөнгө оруулалтыг л дэмжих ёстой. Яг энэ бодлого руу чиглэсэн ийм 3 төрлийн татварын бодлого байгаа шүү. Боловсруулах шатын үйлдвэр, тэгээд эцсийн бүтээгдэхүүн ч гаргаж болно, анхан шатын боловсруулалт ч хийж болно, боловсруулах шатаа ахиулж байж ч болно. Тэгэх юм бол технологийн тоног, төхөөрөмжийг нь гаалиар орж ирэхэд нь гаалийнх нь татварыг нь бүрэн чөлөөлчхөж байгаа юм. Хүрч ирээд угсрагдаад, үйл ажиллагаагаа явуулаад, бүтээгдэхүүнээ гаргаад эхлэхээр эхний 5 жилд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Ингээд үйлдвэрээ яваад эхлэхээр 5 жил орлогынх нь албан татварыг 90 хувь хөнгөлнө гэж байгаа юм, 90 хувь шүү. Тэгээд нийгмийн чиглэлийн суурь бүтцүүдтэй холбоотой эсвэл ногоон байгууламж гээд ийм зардлууд дээр тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалтууд хийх юм нийт борлуулалтын орлогынх нь 1 хувь хүртэл нь татварын орлогоос татварт ногдох орлогоос нь чөлөөлнө гэж ийм 3 төрлийн юм байгаа шүү. Яах вэ өмнөх хэлэлцүүлгийн үед бид дутуу ойлгуулсан юм байлгүй дээ. Үүнийг заавал яаман дээр Сангийн яаман дээр үүнийг шийддэг, татварын байцаагч шийддэг биш үүнийг Улсын Их Хурал дээр, Засгийн газар төслүүдийг нь оруулж ир гээд яагаад байна. Тийм ойлголт байж болохгүй шүү. Бид хувийн хэвшлийг дэмжсэн бол дэмжсэн шиг дэмжээд, илүү ил тод, ойлгомжтой байх хэрэгтэй. Чи одоо чөлөөлүүлэх ийм үйлдвэр барих гэж байгаа бол тэрийгээ Их Хурал дээр авчирч танилцуул гэхээр чинь ямар аж ахуйн нэгж төслөө бариад энд ирж далан булчирхайгаа тоочоод, энэ голд сууж байх вэ дээ.

Тийм учраас тэнд нэг сумын татварын байцаагч, хил дээр байгаа гаалийн байцаагч хийчихдэг ажлуудыг энэ дээр харин ч чөлөөтэй үүнийг нь аягүй, хуулийг нь аягүй тодорхой болгоод батлаад өгөх хэрэгтэй. Бид арай жоохон дундын ойлгомжтой хувилбар оруулж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Монголын хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо мэргэжил арга зүйн маш том зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллах болсон гэдгийг би сая бас хэлсэн байгаа. Манай энэ Улсын Их Хурлын гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд энэ мэргэжлийн төрийн бус байгууллагуудтайгаа нягт сайхан хамтарч ажиллах ёстой шүү гэдгийг тодруулж хэлье. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням асуулт асууна.

**Г.Дамдинням:** Бид нар ингээд 2025 оныхоо төсвийг туйлширсаар байгаад л ямар ч улс орны ирээдүйд хөгжил дэвшилд хэрэггүй л ийм төсөв рүү л яваад орчихсон доо. Анх орж ирсэн төсөв нь уг нь жижиг сажиг тэр алдаануудыг нь засчихсан бол эдийн засгаа томруулах, ажлын байруудыг нэмэгдүүлэх, хөгжлийг хурдасгах нэг аятайхан юмнууд байсан юм шүү дээ уг нь. Нөгөө тийш нь шууд 180 градус эргүүлж татаад л, алдагдалгүй төсөв гэж зүтгэсээр байгаад ингээд, яг

үнэнийг хэлэхэд Засгийн газраас ажил шаардахад, хөрөнгө оруулалтын ажлуудын үр дүнг нэхэхэд их хүнд байдал руу л явуулчихлаа л даа. Тэгээд одоо яалт ч үгүй нэг ороод ирсэн төсөл дээр нэг хэдэн юм асууя даа.

1 дүгээрт энэ утаа, түгжрэл гэж энэ Улаанбаатар хотын томоохон асуудлууд байна. Энэ Улаанбаатар хотын томоохон асуудлуудыг шийдэхийн тулд Улаанбаатар хотод томоохон хэмжээний хөрөнгө оруулалтууд хийгээд л байвал хөдөө орон нутаг, зах хязгаар нутгаас ийшээгээ нүүж ирээд л суурьшаад л байна. Орон нутагт ерөөсөө хөрөнгө оруулалт сүүлийн үед их харам болоод байна шүү. Дарханд хөрөнгө оруулалт хиймээр байна, Төв аймагт хөрөнгө оруулалт хиймээр байна, Сэлэнгэ аймагт хөрөнгө оруулалт хиймээр байна. Эргэн тойрны энэ аймгуудад хийж байж, төвлөрлийг бууруулж байж, тэнд хүн сургуультай, цэцэрлэгтэй, замтай, эмнэлэгтэй, дулааны эх үүсвэртэй байж, амьдрах таатай орчин нь бүрдэж байж тийшээ хүмүүс явна.

Харамсалтай нь хөдөө орон нутгийн хөрөнгө оруулалтуудыг нээрээ үнэхээр танах юм нээрээ. 2022 онд биднийг энд сууж байхад орон нутагт нэг удаа та нар тэвчээдхээч гээд 470 тэрбум төгрөгийг нийтийн тээврийг сайжруулна, хотын түгжрэл 30 хувь буурна гээд авсан. Ногоон автобус болоод дууссан. 2024 оны төсөв дээр 500 тэрбум төгрөгийн бонд босгоод, Нийслэлийн эрчим хүчийг сайжруулна гээд Бөөрөлжүүтийн цахилгаан станцад аваачаад хийчихсэн, станц нь шатчихсан, цахилгаанаа нийлүүлээгүй. 2025 оны төсөв дээр орон нутгуудад юу ч байхгүй. Дарханд баригдаж байгаа Залуус хорооллын дулааны холболтын хөрөнгө оруулалтыг би тусгах гээд чадахгүй байна шүү дээ. Мянган айл Улаанбаатараас тийшээ нүүж очих байхгүй юу мянган айл. Мянган хүнээр Улаанбаатарын хүн цөөрнө. Энэ орон нутгийг хөгжүүлэх энэ төлөвлөгөө бид нарт хийгдсэнгүй. Тэгэхээр энэ дээрээ Засгийн газар ямар гаргалгаа гаргах юм бэ 1 дүгээрт?

Хоёрдугаарт, энэ орж ирж байгаа алдагдалгүй мундаг төсвөөрөө хэдэн ажлын байр бий болгох юм бэ Гантөмөр сайдаа? Хэдэн ажлын байр өмнө нь та нар төлөвлөж байсан нь одоо хэдэн ажлын байр болж бууж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

Гуравдугаарт, энэ Энх-Амгалан сайдаас асууя. Чингис хаан банканд танай Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангаас 95.3 тэрбум, Капитал банканд 65.9 тэрбум, тэгээд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгой, Цахилгаан холбоо гээд ТӨК-удын мөнгө ороод гацчихсан. Үүнийг та прокурорт өгсөн байна лээ. Сайн. Үр дүн хэзээ гарах вэ? Хүмүүсийн өөрсдийнхөө ирээдүйд зориулж хийсэн энэ мөнгөнүүд байхгүй болсон шүү. Үүнийг хэдүүлээ бас ярих ёстой, энэ юу болж байна вэ?

Эцэст нь энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам нүүгээд байна. Энэ ажилчдынх нь хэдэн хувь нь ажлаасаа гарчихсан байна гээч олон хүн ажлаасаа гарчихсан байгаа шүү дээ хөөрхий амьтан. Байнгын наашаа, цаашаа явна. Одоо сайд, дарга нар нь тэндээ гэр оронтой, бизнестэй сайхан байдаг л юм байгаа биз. Дагуулаад энэ Хөдөө аж ахуйн корпорац гэдэг байгууллагыг авч явах гээд, тэгээд тэрний газар, үл хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаагаар зарна гээд ойр тойрны хүмүүс нь авна гэсэн яриа сонсогдоод байх юм. Арай тийм юм байхгүй биз дээ? Байхгүй биз дээ? Төрийн юм төр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Ажлын байр дээр яг тодорхой хэлэх гэхээр ер нь яах вэ эрсдэл бол гарч байгаа юм. Тэрийг одоо бодитой шүү дээ ойлгомжтой. Эдийн засгийн идэвхжил буурахаар энэ чинь ийм эрсдэл үүснэ. Буцаад харин үүнийгээ бид яаж нөхөх вэ гэж байгаа юм. Өмнөх танилцуулга дээр бол хэлэлцүүлгийн үед бид маш ойлгомжтой хэлж байсан. Эдгээр дэд бүтцүүдийг нэмснээр ирэх жил лав ямар ч байсан хувийн хэвшил дээр бол 35-аас 40 мянган, энэ чинь зөвхөн төсөвт харагдаж байгаа хөрөнгө оруулалтуудаас гадна маш олон ажлын байрыг дэмжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд явж байгаа. Ялангуяа гадаадын зээл, тусламжаар. Энэ бүгдийг оруулах юм бол 35-аас 40 мянган ажлын байр шинээр гарах нь гэдэг ийм тооцооллуудыг хийж байсан.

Одоо энэ дээр бол жишээ нь зам маань ирэх жилүүдэд ингээд бид 4 мянган км-ээр хатуу хучилттай зам нэмэгдэнэ гэж байсан бол ирэх жилийнх дээр ингээд ямар ч байсан төсвөөс хийх нь бол ингээд тодорхой хэмжээнд багасчихна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр яг хэд нь амжилттай байхыг бас урьдчилж хэлэхэд хүнд. Тэгэхээр энэ бүхний үзүүр дээр энэ чинь дандаа л хувийн сектор, үйлдвэр барина, байшин барина, ажлын байр нэмэгдүүлэх л ийм зорилтууд юм байгаа юм. Энэ дээр тодорхой хэмжээний буурах эрсдэл гарна. Тэгээд үүнийг яаж нөхөх вэ, яаж зорьсон хэмжээндээ хадгалах вэ, очих вэ гэдэг дээр Засгийн газар хичээж ажиллана. Түрүүн Их Хурлын дарга бас хэллээ. Одоо төсөв дээр эрсдэл учруулж байгаа, зардал нэмж байгаа нийгмийн чиглэлийн ялангуяа эдгээр зардлуудыг бууруулах, цаашид нэмэхгүй байх ингэснээр төсвийн бусад нөгөө хөрөнгө оруулалтуудын орон зайгаа суллаж өгч, хувийн хэвшлээ дэмжсэнээр энэ ажлын байр, эдийн засгийн идэвхжилээ хадгалах ийм зорилт тавьж ажиллана даа.

**Д.Амарбаясгалан:** Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Ганцхан минутад багтаахад хэцүү юм. Асуултууд нь их том асуудал хөндсөн асуултад гишүүн нь 3 минут асуучхаад, сайд нар нь ганц минут хариулаад явахаар бодитой хариулт өгч бол чадахгүй болчихоод байна. Тэгэхээр Дамдинням гишүүний хөндөж байгаа асуудалтай би санал нэг байгаа. Өнгөрсөн хугацаанд нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банкнууд дээр байршуулж, алдагдал хүлээх ийм бодитой эрсдэл нүүрлэсэн гэдэг бол үнэн. Өнөөдөр Капитал банк бол дампуурлаа зарласан. Энэ дээр бол 63 тэрбум төгрөгийн асуудал байна. Чингис хаан банк дампуураагүй банк. Өнөөдөр Монголбанкнаас Чингис хаан банкны дампуурлын зарлаагүй. Тийм учраас дампуураагүй банктай бол бид асуудал шийдэх ийм бололцоонууд бол байгаа гэж харж байгаа.

Тэгээд энэ хүрээнд бид нар Үндэсний зөвлөлөөс шийдвэр гаргаад, анх удаа гомдол гаргаж, прокурорт гомдол гаргаж, ингээд прокурор, АТГ дээр хэрэг нээгээд, энэ асуудлууд нь явагдаж байгаа. Энэ дээр би тодорхой үр дүн гарах болов уу гэж бодож байна. Тэгээд 2025 оны төсөв дээр өөрийн багц дээрээ зохицуулалт хийж, 300 сая төгрөгөөр нэлээн хуульчид, өмгөөлөгчдийг авах энэ зардлуудыг зохицуулах ийм саналуудыг гаргаад ингээд явж байгаа. Тэгээд Их Хурал бас баталж өгнө үү, баталж өгөх байх гэж найдаж байна 1-д.



Хоёрт Булгантуяа сайд, сайд байхдаа байхдаа Нийгмийн даатгалын энэ багц хуулийг их сайн хууль батлуулсан. Энд бид талархах ёстой. Энэ хуулийн зохицуулалтаар Үндэсний зөвлөлд зөвлөдөг мэргэжлийн ийм зөвлөлийн хороог байгуулах ийм эрх зүйн зохицуулалттай болсон. Ганцхан мэргэжлийн хорооноос гадна Олон нийтийн хяналтын зөвлөлийг байгуулах ийм зөвлөлтэй ийм зохицуулалттай болсон. Энэ хүрээндээ бид саяхан олон нийт дээр нэлээн нээлттэй сонгон шалгаруулалт хийж, яг Үндэсний зөвлөлд зөвлөдөг энэ 9 хүнтэй мэргэжлийн хороо активаар ч хөрөнгийн мэргэжилтэн, хөрөнгийн үнэлгээний мэргэжилтнүүдээр бүрэлдэхүүнтэй ийм мэргэжлийн хороог сонгон шалгаруулалтаар бид нар бий болгосон байгаа.

Ингээд 7 хүнтэй хяналтын хороог бид бий болгосон. Ингээд энэ хүрээнд бол ямар ч байсан тэтгэврийн даатгалын, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгүүдийг цаашдаа байршуулж өгөөж хүртэхэд бол ямар хэлбэрээр хийх вэ гэдэг дээр бол мэргэжлийн туслалцаа дэмжлэгүүд авдаг ийм энэ мэргэжлийн хороодын юун дээр дүгнэлт дээр үндэслэж, энэ хөрөнгийн менежментүүд хийдэг ийм тодорхой бодитой ийм шинэлэг алхмууд бий болж байгаа гэдгийг би онцолж хэлье гэж бодож байна. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Гонгорын Дамдинням гишүүн тодруулж асууя.

**Г.Дамдинням:** Тэгэхээр тэр Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангаас бол банкнуудын зохист үйл ажиллагааны харьцаа алдагдчихсан байхад хэдэн арван тэрбумаар нь төрийн мөнгө байршуулж байсан гэмт хэргийн шинжтэй юмнууд байдаг юм байна лээ шүү Энх-Амгалан сайдаа. Үүний араас та хатуу яваарай. Олон мянган хүний эрүүл мэндийн, тэтгэврийн асуудал яригдана шүү дээ энд тийм ээ. Тэгээд энэ дээр хамтарч ажиллана.

Хөдөө аж ахуйн яамны энэ нүүлттэй холбоотой энэ хүмүүсийн томилолт, энэ ахуй амьдрал ер нь юу болж байгаа вэ? Үндсэн бүрэлдэхүүн хэдэн хувь солигдсон бэ?

Хоёрдугаарт, энэ Хөдөө аж ахуйн корпорацын үл хөдлөх хөрөнгө, газартай холбоотой энэ яам нүүсэнтэй холбоотой чөлөөлөгдөж байгаа энэ байруудыг ер нь яаж ашиглахаар төр шийдэж байгаа вэ? Ямар бодлого барьж байгаа вэ? Энд нэг хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу, Улсын Их Хурлын шийдвэр гарсны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Дархан-Уул аймагт шилжин байрлаад, үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар нийт бүрэлдэхүүний 70 орчим хувь Дархан хотод очиж үйл ажиллагаагаа явуулж байна.

2 асуудал. 1 дүгээрт тэнд шилжин очиж байгаа ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудал буюу орон сууцын асуудлыг шийдэх тухай. Энэ дээр Засгийн газраар асуудал оруулж хэлэлцүүлээд, төсөвт дарамт болохгүйгээр Хүнс, хөдөө аж ахуйн яам, түүний харьяа байгууллагад байгаа ашиглалтгүй байгаа хөрөнгийг Төрийн өмчийн хороогоор дуудлага худалдааг нээлттэй зохион байгуулах замаар

хуримтлуулсан эх үүсвэрээс орон сууцын асуудлыг шийд гэдэг ийм шийдвэр Засгийн газраас гарсан. Үүний хэрэгжилтийг хангахаар Төрийн өмчийн хороонд хүсэлтээ тавьсан. Зохион байгуулалтыг Төрийн өмчийн хороо дуудлага худалдааг хийх.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайдын микрофоныг нэмж өгье, гүйцээж хариулъя.

**Б.Энхбаяр:** Дуудлага худалдаанаас бий болсон эх үүсвэрээр нийгмийн асуудлыг шийдэхээр хүлээж байгаа.

Хоёрдугаарт, Монголбанктэй зөвшилцөж шилжин суурьшиж байгаа төрийн албан хаагчдад зориулсан моргейжийн эх үүсвэрийг, мөн хувийн орон сууцтай болох хүсэлтэй албан хаагчид моргейжийн эх үүсвэрийг гарч өгөхөөр шийдвэрлэсэн. Энэ төрийн өмчийн хөрөнгийг зарж борлуулсан хөрөнгөөр зөвхөн төрийн өмчийн 100 хувийн албан тушаалын орон сууц авч, албан хаагчдыг орон сууцаар хангах гэсэн ийм үүрэг өгөгдсөн. Ийм 2 хувилбартайгаар орон сууц, нийгмийн асуудал шийдэгдэж байгаа. Тэрнээс.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

**С.Зулпхар:** Их Хурлын дарга, Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн оройн мэнд мэндийг эрье. 4 асуулт байна. Эхний асуулт нь Гантөмөр сайдаас асууж байгаа юм. Бид улсын төсвөө бол 2.3 их наядаар танаад орж ирэх ийм төсөлтэй танилцаж байна. Тэртээ тэргүй ингэж танана гэдэг нь тодорхой байсан. Гэхдээ энэтэй уялдсан байдлаар арваад арга хэмжээг бол бас мэдээж хэрэг хасаж байна. Энэ бол зүй ёсны байх. Тэгэхээр яах вэ миний гол асуулт улсын хөгжлийн төлөвлөгөө дээр ямар нэгэн өөрчлөлт орох уу эсхүл ямар нэгэн зохицуулалт хийгдэх үү гэдэг нэг ийм асуулт байна. Нэгэнтээ энэ ирэх жилийн төсөв дээр өөрчлөлт ороод, арга хэмжээнүүд дээр өөрчлөлт орсон учраас үүнийг тодруулж байна.

2, 3 дахь асуултыг би Жавхлан сайдаас асуух гэсэн юм. Жавхлан сайдаа тэр яах вэ бид дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ өсөлтийг 8 хувь байхаар их сайн өөдрөгөөр төсөөлсөн байна. Оюу толгойгоос зэсийн баяжмал бол илүү гарна, хөдөө аж ахуйн салбар сэргэнэ гээд иймэрхүү нааштай үр дүнгүүдийг та бүхэнд тооцсон байна л даа. Гэхдээ төсвийн хөрөнгө оруулалтыг дагаад хийгдэж байсан, түүнтэй уялдсан төсөөлөлд төсөөлж байсан, тооцоолж байсан эдийн засгийн өсөлтийн нөлөөлөл байгаа шүү дээ. Үүнийгээ тооцсон юм болов уу? Хэт ийм өөдрөг тавьчихдаг, тэгээд дараа нь бид чинь ийм болохгүй бол ахиад л үүнийг чинь хариуг нь өгөх хэрэг гарах байх. Тэгэхээр энэ хэр зөв тооцоолол байсан бэ гээд нэг ийм хариулт авъя.

3 дахь асуулт энэ төсөв бол өөрөө бодлого. Гэхдээ их чухал бодлогын ийм хувилбарууд орж ирж байна. Бид төсөв хэлэлцэж байх үедээ сайн зүйлийг, тэрнээс гадна бидний хүсэж байсан зүйлийг болж байгаа бол, болох гэж байгаа бол болох гэж байгаагаар нь ярих ёстой байх. Нэн ялангуяа сая бол та хэллээ шүү дээ. Тэр татвартай холбоотой хөнгөлөлтүүд, чөлөөлөлтүүд явж байна. Үүнийг бол бид угаасаа сайшааж байгаа. Хувийн хэвшлийг дэмжсэн бодлого байна уу л гэж бид байнга асуудаг шүү дээ. ОУБ-тай уулзсан ч тэр, яг бидэнтэй адилхан гаднын улсуудын парламентын гишүүдтэй уулзсан ч тэр ерөөсөө та хэд бол хувийн

хэвшлээ дэмжихгүй бол танай эдийн засаг бол нэг их тийм урагшаа олигтой явахгүй гэдгийг бүгд хэлж байгаа. Бид үүнийг угаасаа мэдэж байгаа.

Сүүлийн 30 гаруй жилийн бидний эдийн засгийн хичээл бол яг энэ дээр л байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ их сайн зүйлүүд орж ирж байна. Гэхдээ мэдээж хэрэг саяын тэр хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зарим нэг жишээ нь захиргааны процесстой холбоотой хүндрэлүүд байдаг. Үүнийг шийдэх зүйлийг та сая их тайлбарлаж байгаад цаг нь дуусаад, дутуу орхичихлоо. Үүнийг та ахиад нэг яриад өгөөч гэж байгаа юм. Бид үүнийг бол. Цаашдаа энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэх явцад захиргааны арга хэмжээгээ зохицуулалтаа яаж хийх юм бэ гэдгийг.

Өөрөөр хэлбэл та их тодорхой зүйл яриад байна шүү дээ. Орон нутагт нь эрхийг нь шилжүүлээд, тэндээс бид тэр энэ асуудлыг зохицуулаад явчихна гээд ингээд ярьж байгаа зүйл дээр. Үүнийг ер нь тодорхой ярьж байсан нь дээр байх. Тэгээд үүнийг олон нийтэд болон хувийн хэвшилд бид үүнийг мэдээж зөв гэж ойлгосны үндсэн дээр үүнийг та тайлбарлаач гэж байгаа юм.

4 дэх зүйл би Наранбаяр сайдаас асуумаар байна. Ер нь бид сая бол хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг ярьж байна. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт, нийлүүлэлт алдагдчихсан ийм хүндрэлтэй нөхцөл бол байгаа. Энэ бол өнгөрсөн бараг 10 гаруй жилийн асуудал. Хүн ам зүйн өөрчлөлттэй холбоотой янз янзын л хүчин зүйлүүд байгаа л даа. Тэгэхдээ энэ дээр жишээ нь бидний заримдаа ад үзээд янз янзаар шүүмжлээд байдаг сантай холбоотой зүйл байгаа юм. Тэгэхээр энэ сангууд дээр бол боломжийн мөнгө тавьж орж иржээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан өнгөрсөн жил 84 тэрбум байсан бол энэ удаа 46 тэрбумаар нэмэгдүүлээд оруулаад ирсэн байна. Энх-Амгалан сайд бол энэ саналыг бол маш сайн авч явсан байна. Байнгын хороон дээр ярьж байсан юм. Гэтэл нөгөө талдаа бол бидний сайн мэдэх Мэргэжлийн болон техникийн боловсролыг дэмжих сан байгаа юм. Энэ дээр 196 тэрбум байсан юм өнгөрсөн жил, энэ жил 213 болгоод, сая бол бас жоохон таначхаж. Тэгэхээр Наранбаяр сайдаа энэ хэр хангалттай вэ? Бид чинь мэргэжлийн болон техникийн боловсролоороо дамжуулаад энэ хөдөлмөрийн зах зээлийг зохицуулна, цаашдаа ажиллах хүчнийг нийлүүлнэ гэж ярьж байгаа шүү дээ. Энэ дээр та ямар бодолтой байна вэ гэсэн асуулт байна. Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Боловсролын сайд Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Зулпхар гишүүний асуултад хариулъя. Энэ та бол яг харсан байна. Энэ Мэргэжлийн боловсролыг дэмжих сан гэдэг нь ер нь бол энэ чинь нөгөө нэг яг мэргэжлийн боловсролоороо сурсан хүүхдүүдэд тэтгэлэг олгодог шүү дээ, яг төгсөхөд нь олгодог ийм тэтгэлгүүд байгаа. 3 жил сурчихсан хүүхэд 6 сая төгрөгийн тэтгэлгээ аваад, тэгээд яг мэргэжлээрээ ажиллаад ингээд явдаг. Тэгэхээр энэ жил бол бид энэ юунаас бол нэмж оруулж ирээд, тэгээд нэмснээсээ жоохон хасагдчихсан ийм байгаа юм. Тэгэхээр энэ удаагийн энэ юугаар бид бол нэмж оруулж ирсэн. Эндээс хасагдсан гэдэг утгаараа үйл ажиллагаа, хэвийн үйл ажиллагааг бол ноднин жилийнхээ хэмжээнд бол аваад явж чадна, аваад явж чадна.

Мөн сая бас Засгийн газраас тогтоол гаргуулаад, энэ 16 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаа. Энэ зэрэг юмнуудаа ингээд он дотроо хийгээд ингээд аваад явах

боломж бий. Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаа бид дэмжиж явж энэ 44 мянган хүүхэд сурч байгаа. Төрийн болоод хувийн өмчийн нийлсэн энэ коллежууд байна. Эд нарыгаа ингээд хэвийн үйл ажиллагааг нь хангаад явах юм. Тэгэхээр түрүүнд яриад байгаа энэ бид энэ олон, олон Боловсролын зээлийн сангаас ч гэсэн хасалтууд орж ирж байгаа. Тэгэхдээ тэр нь нөгөө өнөөдөр үзүүлж байгаа үйлчилгээ өөрөө нэмэгдээд байгаатай холбоотойгоор тэр нэмэгдэл хэсэг нь хасагдсан ийм байгаа. Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Зулпхар гишүүн. Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Зулпхар гишүүний асуултад хариулъя. Яг тийм шүү. Жишээ нь тэр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт энд Улаанбаатар хотын захиргааны төв байгууллагууд дээр яамнууд дээр шийдэх юм ердөөсөө байхгүй. Маш ойлгомжтой ийм татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, гааль дээр ч тэр, аж ахуйн нэгжүүд дээрээ ч тэр. Тэрийг ерөөсөө сумын татварын байцаагч тэндээ л шийднэ. Маш ойлгомжтой одоо яг оруулж ирснээр ингээд шийдвэр гаргаад батлаад явуулчих юм бол. Тухайн бүсчилсэн, бүсчилсэн бүс нутгийн тэргүүлэх чиглэлийн салбар нь юу байна яг тэр чиглэлдээ тохирсон тэнд үйлдвэр баригдвал тэгээд аж ахуйн нэгжийн орлого албан татварын 90 хувь нь 5 жил хөнгөлөгдөнө.

Тэр гаалийн хөнгөлөлт, чөлөөлөлт бол бүүр маш ойлгомжтой. Ерөөсөө хил дээр гаалийн байцаагч шийднэ. Тэнд болохгүй хэдэн салбарууд байна тийм ээ, тэр архи, тамхи татвар, зэр зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис энэ үйлдвэрүүдээс биш л бол бусад бүх салбаруудын тоног, төхөөрөмжийг 100 хувь гаалийн татвараас шүү, НӨАТ биш, гаалийн татвараас бүрэн чөлөөлье гэдэг. Энэ бол аж ахуй нэгжүүд дээр бол маш том.../минут дуусав/

**Булгантуяа:** Эдийн засгийн өсөлттэй холбоотой Гантөмөр сайд хариулах уу? Тэгье.

**Л.Гантөмөр:** Эрхэм гишүүний асуултад хариулъя. Ер нь бол хөгжлийн жилийн төлөвлөгөөндөө нийцүүлж, улсын төсвийг өргөн барьж байгаа шүү. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс бол биелэлт бүрэн хангагдана гэдэгт бид нар итгэлтэй байгаа. Энэ нарийвчилсан төлөвлөлтүүдээ гаргаад, ажилдаа орчихсон явж байгаа гэдгийг хэлмээр байна. Түрүүн Их Хурлын дарга хэлж байсан. Тэр Тэрэлжийн зам гэх мэтчилэн зарим нэг улсын төсвөөр санхүүжүүлэх гэж байсан дэд бүтцийн ажлуудаа бид төр, хувийн хэвшлийн төсөл болгож, ажил хэрэг болгохыг зорино.

**Х.Булгантуяа:** Зулпхар гишүүн нэмж тодруулъя.

**С.Зулпхар:** Би тодруулахаас гадна нэг санал хэлчихье. Хэн Наранбаяр сайдаа та бол аягүй чухал салбарт ялангуяа тэр нөгөө хөдөлмөр эрхлэлттэй холбоотой маш чухал ажил хариуцаж байгаа юм. Энэ өөрөө та ч гэсэн энэ чиглэлээр туршлагатай хүн. Тэгэхээр саяын тэр Мэргэжлийн болон техникийн боловсролыг дэмжих сантай холбоотой зүйл дээр янз янзын шүүмжлэл явдаг. Энэ шүүмжлэлийг бол ерөөсөө бид наанатай, цаанатай хүлээж авдаг л даа. Гэхдээ энэ сангийн мөнгийг бол нэмж л байх ёстой. Энэ сан дангаараа бол биш шүү дээ, тэтгэлэг бол биш. Тухайн сургуулиудын чадавхыг бэхжүүлэх, сургалтын жишээ нь нөхцөлийг сайжруулахтай холбоотой арга хэмжээ бол байх ёстой шүү дээ. Тэгж

байж бид чинь орчин үеийн нөхцөл байдалд таарсан ажиллах хүчнээ бэлдэх үүднээс энэ дээр анхаараач гэж байгаа юм.

Би Энх-Амгалан сайдыг маш сайн байна гэж хэлмээр байна. Яагаад гэвэл энэ хэлээд байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулаад түр сургалтууд явагддаг. Тэр түр сургалтууд чинь богино хугацаанд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг жишээ нь хангах гол арга хэрэгсэл байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол 46-г нэмж чадсан байна. Би бол үүнийг үнэхээрийн сайшааж байна. Мэдээж хэрэг 10-аад.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Санал хэллээ. Энхбаярын Батшугар гишүүн.

**Ж.Батшугар:** Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Энэ улсын төсвийн зарцуулалт болон үр ашиг, бүтээмжийн талаар нэг бас эргэж харах зүйтэй болов уу гэж бодож байна. Ялангуяа жишээлбэл ийм зүйл байгаа юм. Энэ урсгал зардал 24 их наяд, үүнээс эрүүл мэнд, боловсрол, тэтгэвэр, хүүхдийн мөнгө, батлан хамгаалах салбарыг нь хасвал энэ нь 11.8 их наяд болоод байгаа юм. Энэ нь нийт төсвийн болон дотоодын нийт бүтээгдэхүүний 12.4 хувь болж байна л даа. Тэгэхэд бид нарыг харьцуулдаг Казахстан улсын нийт төсөв нь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 15.6 хувь байж байгаа юм.

Нэг ёсондоо бид урсгал зардалдаа дэндүү их мөнгө үрээд, үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын зардалдаа хийж чадахгүй байна. Манай хөрөнгө оруулалтын зардал ердөө л 9 хувь байгаа юм л даа нийт төсвийн. Тэгэхэд хөгжиж байгаа улс орнууд болон emerging market гэж ярьдаг. Эд нарынх 20 хувьтай байдаг. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр бид энэ том зургаараа нийт төрийн албаны Засгийн газрын болон бусад салбаруудынхаа бүтээмжийг нь харах ёстой, үр дүнг нь харах ёстой гэж би бодож байна л даа. Тэгээд үүн дээр Засгийн газар ямар ирэх жил болон дараа дараагийн жилдээ ямар төлөвлөгөө байгаа вэ? Яаж төрийн албаны бүтээмжээ сайжруулах тийм зорилго тавьчихсан байгаа вэ? Ямар төлөвлөгөө байгааг асууя.

Хоёрт нь Хөгжлийн банк гэж том институт байгаа. Тэгэхээр Хөгжлийн банкны одоо байгаа чанаргүй зээлийн тодорхой хэмжээгээр restructuring хийгээд, үүгээрээ дамжуулаад хөрөнгө оруулагчаа татах бололцоо байна л даа. Энэ нь манай мега төслүүдийг санхүүжүүлэх, дээрээс нэмээд бусад одоо хөгжлийн түүчээ болох том, том төслүүдээ санхүүжүүлэх бүрэн бололцоотой. Хөгжлийн банкны үндсэн зорилго нь ийм учиртай байгуулагдсан. Тэгэхээр яах вэ blended finance байдаг юм уу, янз янзын аргачлалууд байна гэх мэтчилэн зүйлүүд хийх төлөвлөгөө байна уу, бололцоо байна уу гэж асууя?

Засгийн газрын баталгаа 5.8 их наяд хүрсэн байна. Энэ жил 1.9 их наяд байгаа. Тэгэхээр энэ 3 их наядын нэмэгдэл нь яг юутай холбоотой вэ гэж асууя.

Дотоодын бонд гаргах уу? Энэ манай капитал маркет болон нөгөө хөрөнгийн зах зээлд маш их хэмжээний дэмжлэг бол бенчмарк болдог. Тэгэхээр Засгийн газар тодорхой хэмжээгээр дотоодын бонд гаргаад, үүгээрээ дамжуулаад бусад хөрөнгө гаргах гэж байгаа, бонд босгох гэж байгаа аж ахуйн нэгжүүдээ дэмжих үү гэж асууя. Солонгосын эксим банк болон Хятадын эксим банкны зээлийн ашиглалт нь хэдэн хувьтай байгаа юм бэ? Миний санаж байгаагаар Солонгосын эксим банкнаас 700-гийн эрх сая долларын эрх байгаа гэж санаж байна.



Бусад хөрш орнуудын худалдааны хэлэлцээр хийгдэж байна гэж төсвийн танилцуулга дээр тавьсан байна, бичсэн байна. Тэгэхээр ямар, ямар улс оронтой ямархуу хэлэлцээр хийгдэх вэ? Үүнтэй холбоотойгоор ямар бараа, бүтээгдэхүүн илүү хөнгөвчилсөн байдлаар худалдаа хийх бололцоотой вэ гэж асууя. Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Үүнтэй холбоотой Сангийн сайд Болдын Жавхлан.

**Б.Жавхлан:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Холимог санхүүжилт хийх боломжууд байлгахын төлөө ажиллана даа. Нэгэнт бид төсөв дээрээсээ ингээд нэлээн тоормос татчихаж байгаа учраас энэ том төлөвлөчихсөн байгаа хөрөнгө оруулалтуудыгаа тэгээд л хамтарсан, ямар л хөрөнгө оруулалт байж болох нь вэ value exchange гэж бид сүүлийн үед их ярьдаг боллоо. Энэ хамгийн эвтэйхэн орчуулга нь энэ баялгийн солилцоо л байгаа юм даа. Ялангуяа Арабын орнууд үүнийг маш амжилттай хэрэгжүүлсэн. Баялаг нь байгаад байдаг, тэгсэн мөртөө төсвөөрөө оруулж ирээд хөрөнгө оруулалт хийхээр төсвийн өсөлтдөө хязгаарлагдчихаад байж байдаг. Бидэнд маш их баялаг байгаад байна. Тийм учраас үүнийгээ эргэлтэд оруулах тал дээр эрх зүйн орчиндоо нэлээн либералчлах зүйлүүд бол байгаа. Тийм учраас таны ярьж байгаа энэ боломжуудын төлөө бүгдээрээ ажиллана. Бүгдээрээ ажиллана гэдэг нь Засгийн газар ч тэр, Улсын Их Хурал дээр эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр та хэд маань тусалж дэмжиж ажиллаарай гэж хүсье.

Баталгааны тал дээр бид юмыг яаж мэдэх вэ гэж энэ боломжит энэ нөөцүүдээ тоонуудаа авч орж байна. Хэрвээ энэ 14 мега төслүүд дээр Засгийн газрын баталгаа гаргах шаардлагатай бол төсөл нэг бүрээр дахиад эргээд Их Хурал дээр орж ирнэ. Ийм хэлбэрээр явна. Дотоодын бонд, жишээ нь дагасан хуулиуд дээр 4 их наядын Засгийн газрын үнэт цаас гэж байгаа. Тэрний бол 1 тэрбум доллар хүртэлх нь дахин санхүүжилтийн, дахин санхүүжилтийн боломж ирэх жил гарчих вий, бид чинь зээлжих зэрэглэлээ сайжруулчихлаа. Тийм учраас хугацаагаа хойшлуулаад, хүүг нь буулгах ийм боломжууд гарч ирж болзошгүй байгаа. Тэгэхдээ 2025 онд бол хугацаа нь тулчихсан бонд байхгүй. Бид амжилттай энэ дээр refinance хийчихсэн байгаа учраас.

Гэхдээ боломж гарч магадгүй. Бид нарын хувьд өртгөө бууруулах боломж гарч магадгүй. Зөрөө нь 500, 300 тэрбум орчим нь дотоодын бондод бид нөөцөлж байгаа. Гэхдээ дотоодын манай Төрийн сангийн төлбөрийн чадвар ирэх жил эрс сайжрахаар байгаа. Нөгөө суурь тэнцэл маань 2 хувь гэж байсан. Ингээд алдагдалгүй болчихоор тэр суурь тэнцэл маань бүр 3.3 хувийн ашигтай болоод ирэхээр манай Төрийн санд бол маш эерэг нөлөө үзүүлнэ. Тэгэхээр Төрийн сан дээр зөрөө нөхөх ч юм уу, шаардлагатай тийм эх үүсвэр гарах тийм юу бол гарах шаардлага бол гарахгүй. Гэхдээ яг таны ярьж байгаачлан нөгөө бенчмарк тогтоох зорилгоор бол бага хэмжээнийхээр бол бид гаргахаар платформ бэлдсэн байгаа. Тэгээд тэрийг хэлье. Удахгүй он гармагц эхний бонд дотоодын зах дээр гарна. Тэгээд Солонгосын Эксим банкны эрх ашиглалт ямар байгаа, манай Сонор дарга мэдээлэл өгөх үү? Энд байна даа.

**Х.Булгантуяа:** Жавхлан сайд нэмж хариулъя. Жавхлан сайдын микрофон.

**Б.Жавхлан:** Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эксим банкны зээл 4 аравны, 4.5 их наяд төгрөг. Үүнээс ашиглагдаагүй үлдэгдэл нь 3 их наяд төгрөг байна гэсэн үг, 9 төсөл дээр явж байгаа.

**Х.Булгантуяа:** Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ төрийн албаны шинэчлэл хийх гарцаагүй болчихсон. Яагаад гэвэл бид цомхон хүнтэй, сайн цалинтай байхгүй бол болохгүй. Ийм бага цалингаар цаашаагаа төрийн албыг ийм нүсэр бүтцээр авч явна гэх юм бол барахгүй юм байна лээ. Тэгэхээр Засгийн газар дээр хөгжлийн төлөвлөгөө дээр, хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэл дээр байгаа шүү дээ. Ирэх онд бид төрийн албаны бүтцийн шинэчлэл хийнэ, менежментийн шинэчлэл хийнэ гэж. Юу гэсэн үг вэ гэхээр давхардсан бүтцүүдийг бол арилгана, өгөөжгүй бүтцүүдийг арилгана. Тийм учраас ирэх оны харин энэ Засгийн газрын боловсруулсан төслийг Их Хуралтайгаа бид яаж хамтарч боловсруулж, төрийн бодлого болгох вэ гэдэг дээрээ анхаарч байгаа. Үүнийг Их Хурлын гишүүд маань эрс дэмжиж өгөхийг бид чин сэтгэлээсээ хүсэж байгаа.

Хоёрдугаарт, Хөгжлийн банкаа хэдүүлээ босгож ирнэ. Хөгжлийн банк Монголын хөгжилд бол онцгой.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Гантөмөр сайдад нэмж микрофон өгье.

**Л.Гантөмөр:** Батхүү дарга тэр худалдааны хэлэлцээрүүдийн мэдээллийг өгөөдхөөч. Ер нь Бүгд Найрамдах Солонгос улс, Евро-Азийн худалдааны байгууллага хоёртой хэлэлцээр эхлээд 2 жил явж байгаа. 2 жил явж байгаа. Хэлэлцээр эцсийн шат руугаа орчихсон. Удахгүй бид хэлэлцээр хийнэ. Евро-Азийн худалдааны байгууллагатай бид түр хэлэлцээр хийж байгаа. Бүгд Найрамдах Солонгос улстай чөлөөт худалдааны хэлэлцээр хийж байгаа. Үүнийг Батхүү дарга нэг хариулаадах, 21.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийн 21 номерын микрофон.

**И.Батхүү:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Бүгд Найрамдах Солонгос улстай Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахаар хэлэлцээ хийгээд, ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд 2 жилийн хугацаанд бол 4 удаагийн хэлэлцээний үе шатыг амжилттайгаар зохион байгуулсан. Хэлэлцээр маань өөрөө 14 бүлэгтэй, 346 зүйлтэй, 19 хавсралттай ийм том өргөн цар хүрээтэй хэлэлцээр байгаа. 2 улсын хооронд стратегийн түншлэлийн харилцаа тогтоосонтой холбоотой эдийн засгийн хамтын ажиллагааг өндөр түвшинд гаргах гол зорилгын дагуу хийгдэж байгаа.

Энэ хэлэлцээрийн хүрээнд гарах гол асуудлуудыг бол хамгийн чухал бүлгүүд бол татварын хөнгөлөлт эдлэх барааны жагсаалтаа айлын талтай тохирно. Хамгаалах үйлчилгээ, хөрөнгө оруулалтын салбарын жагсаалтаа бас тохирох ажлууд хийгдэж байгаа юм. Барааны гарал үүслийн тусгай дүрмийг тохирно. Монгол Улсаас гаргах боломжтой бараа, бүтээгдэхүүнийг ямар дүрмээр Солонгосын зах зээлд гаргах вэ гэдэг дээр бараа, бүтээгдэхүүн бүрээр тохирох ажил хийгдэж байгаа юм. Эдийн засгийн хамтын.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийн микрофоныг нэмж өгье.

**И.Батхүү:** Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх салбаруудыг айлын талтай тохирч байгаа. Техникийн саад тотгорыг бууруулах ажлыг ярилцаж байгаа. Ер нь бол худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийг тэлж, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх ажлыг энэ хэлэлцээрийн дагуу хийгдэхээр ажиллаж байгаа. Хэлэлцээр маань нөгөө ерөнхийдөө Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөөд 170 орчим хүний бүрэлдэхүүнтэй том ажлын хэсэг 14 бүлэгт хуваагдаад ажиллаж байгаа. Мөн түрүүн дурдсан ЕАЭЗХ-ны 5 улстай нийт 375 төрлийн 603 барааг Монгол Улсаас ямар нэгэн импортын татвар төлөхгүйгээр, квотгүйгээр Оросын Холбооны Улс бусад тэр гишүүн орнууд руу гаргах чөлөөт худалдааны түр хэлэлцээрийг хийгээд, эцсийн шатдаа орсон байгаа. Энэ хэлэлцээрийн ач холбогдол нь бол мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс шир гэх мэтчилэн Монгол Улсын хөдөө аж ахуй, үйлчилгээний салбараас гаргах боломжтой бараа, бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдэх юм. Тухайлбал, Оросын Холбооны Улс бусад Евро.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Батшугар гишүүн нэмж тодруулж асуух уу? Хассуурийн Ганхуяг гишүүн. Ганхуяг гишүүн байхгүй байна. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн. Мөнхтулга гишүүн байхгүй байна. Мөнхтулга гишүүн байна. Уучлаарай.

**П.Мөнхтулга:** Засгийн газрын тэргүүлэх 14 чиглэлийн мега төсөл, Гашуунсухайт, Ганцмод, Тавантолгойн станц, Эрдэнэбүрэн, Эгийн гол, сэргээгдэх эрчим хүч, Орхон-Онги, Эрээн цав, Монгол Францын хамтарсан ураны төсөл, нүүрс хими, кокс хими, зэс боловсруулах, гангийн цогцолборыг ашиглалтад оруулах, газрын тос, алт цэвэршүүлэх, үндэсний хиймэл дагуул гээд. Ингээд энэ 14 дотор 1 ч хөдөө аж ахуйн төсөл байхгүй байгаа юм. Тэгээд бид чинь хөдөлмөрийн зах зээлийн 21 хувь нь хөдөө аж ахуйн салбартаа ажилладаг. Тэгээд эндээсээ дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 10 хувийг гаргадаг. Энэ болохоор хөдөлмөрийн зах зээлийнх нь 21 хувь нь тэнд ажиллаад байгаа мөртөө 10-хан хувь гэдэг бол аягүй үр ашиггүй тоо байгаад байгаа байхгүй юу. Тэгээд ямар ч байсан эдийн засгаа солонгоруулна гээд л жил жилийн Засгийн газар ярьж байсан. Сая сонгуулиар ч гэсэн хөдөө аж ахуйн салбараа дэмжинэ. Ялангуяа орон нутаг дэвшиж байсан гишүүд бол энэ малын дайвар бүтээгдэхүүн, арьс, ширийг газар хаяад байна, хог дээр хаяад байна бид сонгогдвол ёстой очоод л арьс, ширний үйлдвэр бариад л, боловсруулаад л ёстой будаа болгоод өгнө л гэсэн. Тэгээд энэ Засгийн газрын хөтөлбөр дээр ч алга, орж ирж байгаа төсөв дээр ч яг тодорхой юм байхгүй байна л даа.

Тэгэхээр би яг зүйл, заалттай маш тодорхой юм асуух гээд байгаа юм Хөдөө аж ахуйн сайдаас. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 3.3.4.6 дээр хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг жилийн 4 улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах иж бүрэн механикжсан агуулахыг, агуулахын нэгдсэн цогцолборыг байгуулна гэж. Энэ хэзээ, хаана, хэдэн онд байгуулагдах юм бэ? 3.3.4.15 дээр малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулна гэж. Энэ хаана, ямар төсөл байгаа вэ? Дарханы арьс, ширний үйлдвэр цогцолбор ярьж байгаа. Түүн дээр зөвхөн цэвэрлэх байгууламжийн төсөвт тавигдсан. Хөрөнгө оруулалт хийх хувийн хэвшлүүд нь төрөөс хийгдэх бусад бүтээн байгуулалтуудаа хүлээж байгаа юм байна лээ. Тэгээд түүн дээр Төсвийн тухай хуулиараа бид чинь төсөв тавиад 3 жилийн дараа л түүнийхээ үр шимийг бүтнээр нь хүлээж авна шүү дээ. Улсын

комисс ажиллах байх. Тэгэхээр энэ 3 жилд лав, одоо энэ төсөв дээр орж ирээгүй юм чинь 27 оныг дуустал, 28 он хүртэл бол Дарханы арьс, ширний цогцолбор бол ашиглалтад орохгүй юм байна гэж ойлголоо. 3.3.4.24 дээр арьс, ширний үйлдвэрийн бүсүүдэд дундын хаягдал ус цэвэрлэх байгууламж байгуулна гээд. Тэгэхээр энэ бүсүүдэд гэдэг нь аль, аль бүсүүдэд, хаана, хаана яг тогтчихсон судалгаа байгаа юм уу?

Тэгээд хамгийн сүүлд нь базаад 4 дэх асуулт. Ингээд би мөрийн хөтөлбөрийн 3 юм асуулаа. 4 дэх асуулт нь яг хэдэн оноос манай малчид арьс, ширээ хог дээр хаяхаа болих вэ? Яг энд л хариулаад өгчих.

**Х.Булгантуяа:** Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ж.Энхбаяр.

**Ж.Энхбаяр:** Нийтдээ хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 4 том бодлогын ийм хөтөлбөр хэрэгжинэ. Цагаан алт гээд үндэсний хөтөлбөр нийт 101.9 тэрбум төгрөгийн санхүүжилт 2025 онд байгаа. Үүгээр бол хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд болох арьс шир, ноос ноолуурынхаа боловсруулалтын түвшнийг дээшлүүлнэ. Хаана дээшлүүлэх юм бэ одоо байгаа суурилагдсан хүчин чадлуудаа сайжруулна. Мөн Дарханы арьс, ширний парк буюу Хөнгөн үйлдвэрийн парк, Эмээлтийн арьс, ширний парк буюу Хөнгөн үйлдвэрийн парк, Хөдөө аж ахуйн арьс, ширний парк буюу Хөнгөн үйлдвэрийн парк гэсэн 3 бүс дээр гол ажлууд явагдана. Нэг онцлог байгаа. Төсвийн мөнгөөр аливаа ямар нэгэн байгууламжид бизнест хөрөнгө оруулалт хийхгүй. Энэ 101.9 тэрбум төгрөг маань өөрөө 500 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээл болж, Цагаан алт хөтөлбөр хэрэгжүүлэх хувийн аж ахуйн нэгжид эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл болж очно.

Хэзээ арьс, шир үнэ цэнтэй болох вэ гэж. Энэ малаа эрүүлжүүлэхээс шалтгаална. Монгол Улсын нийт байгаа энэ 70 орчим сая малыг бид 3 жил системтэйгээр иж бүрэн вакцинжуулж, энэ хачиг хувалз болон бусад төрлийн халдварт өвчнөөс хамгаалах том цогц ажлыг төсвөөр дамжуулж хийх ёстой. Мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэдэг Үндсэн хуулийн гол зарчим яг энэ дээр л хэрэгждэг. Малын эрүүл мэндийн асуудал, мал эмнэлгийн бодлого төрийн төсөв дээр байдаг. Энэ төсөв ний нуугүй хэлэхэд чамлалттай буюу нэн шаардлагатай 100 төгрөгийн 20 төгрөгийг л зарцуулж чадаж байгаа. Иймд бүх нийтээр нь эрүүлжүүлэх процедур бүрэн хангагдаж чадахгүй. Гол, гол өвчин гарч байсан голомт газраа хянах, голомтыг давхар тойруулж хяналтын вакцинжуулалт хийх маягаар л нэлээн тактикийн хөдөлгөөнтэй ийм маягаар энэ эрүүлжүүлэх, вакцинжуулах бодлого явж байгаа.

Нөгөө талаар арьс, ширний энэ салбарын зах зээлийн төлөв таагүй байгаа. Харьцангуй технологийн шинэ нано болон бусад материалуудыг хүн их хөнгөхөн хувцас хэрэглэдэг болчихоод, уламжлалт ноос, арьс, шир ийм хүнд хувцас хэрэглэх ийм хэрэглээ ер нь дэлхий нийтээрээ эрс багасчхаад. Нөгөө талаас мал эрүүлжүүлэх буюу тэр хачиг хувалзын асуудал жоохон хүндрэлтэй байгаа болохоор арьсны чанар буюу олон улсад өрсөлдөх чадвараа нэлээн алдаад, ингээд зах зээлийн эрэлт нь унаад байгаа нь тэр. Манайхаас хамгийн сайн явж байгаа нь бол ноолуур, мах бол зах зээлд их эрэлт сайтай, байнгын экспортын өндөр өсөлттэй явж байгаа. Арьс, ширний салбар жоохон дутаад байгаа. Боловсруулах үйлдвэрүүд дутуу байна, цэвэрлэх байгууламжууд хүндрэлтэй байна. Иймд энэ Цагаан алт хөтөлбөрөөр энэ ноос, ноолуурын зэрэгцээ арьс, ширээ босгож ирье гэдэг том зорилт хийнэ. Энэ.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Дахиад төр юм хийж өгөх ажлаас илүү төр тэр бизнес хийж байгаа аж ахуйн нэгжүүдэд урт хугацааны бодлогын хөнгөлөлттэй зээлүүдийг нийлүүлэлтийг л нэмж байгаа. Бас нэг бодлогын өөрчлөлт, хуучин сайд шийдээд компанид мөнгө хуваарилдаг байсан асуудал байхгүй. Их Хурал бодлого орууллаа, баталлаа бол эх үүсвэр арилжааны банканд шилжээд, арилжааны банк энэ гарсан тэр бодлогын хүрээнд, Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд, Атрын 4 дүгээр аяны хүрээнд, энэ Хүнсний хувьсгал бодлогын хүрээнд, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд судлагдсан аж ахуйн нэгж, байгууллага, хоршоонд зээл олгож байгаа. Тэгэхээр тэр бүх эрсдэл, хариуцлагыг арилжааны банкнууд хүлээж байгаа. Энэ нь илүү үр дүнтэй гэдэг нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бодлогоор тодорхой болсон.

Ер нь сүүлийн 30 жил байгаагүй эх үүсвэр шийдэгдсэн. 3 орчим их наяд төгрөгийн зээл энэ хөдөө аж ахуй, газар тариалан, арьс шир, ноос ноолуур, хоршоо гэсэн энэ гол 4.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Мөнхтулга гишүүн нэмж тодруулъя.

**П.Мөнхтулга:** Тэгээд нөгөө асуугаад байгаа нь тийм ээ төр бол үйлдвэр барихгүй. Гэхдээ үйлдвэр барих нөхцөл бололцоо буюу дэд бүтцээр нь хангах ёстой. Энэ байгууллагууд маань зээл авчхаад, авсан зээлээрээ дэд бүтэц барих юм бол энэ төсөл хэзээ ч явахгүй шүү дээ. Тэгэхээр хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг нь бүрдүүлэхийн тулд дэд бүтцийг нь хийгээд өгчихсөн газар хувийн хэвшлүүд бол уралдаад хөрөнгө оруулалт хийнэ. Тэгэхээр миний асуугаад байгаа юм төсөв дээр дэд бүтцүүд нь их ховор байна. Зөвхөн цэвэрлэх байгууламж ганц Дархан дээр. Тэгсэн мөртөө мөрийн хөтөлбөр дээр нэлээн олон юм хийчихсэн. Үүнийг цаг бага байгаа учраас хоёулаа Байнгын хороон дээрээ яриад явъя.

Одоо маш тодорхой юм, түрүүн та маш их зөв өнцөг хөндлөө. Тэр синтетик материалаар энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн арьс, ширийг орлуулаад байгаа. Тэгээд энэтэй бид уралдахгүй бол хөдөлмөрийн зах зээлийн 21 хувь чинь буюу малчид маань ерөөсөө өдрөөс өдөрт нүүдэл зогсохгүй. Ажиллаад, ажиллаад.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Яг үйлдвэрлэл явуулах цөөхөн үйлдвэрлэлийн дэд бүтэц яг одоо Дархан хотод л байна. Үйлдвэрлэлийн уур, цэвэрлэх байгууламж, ус татуурга, дулаан энэ байгаа нөөц. Улаанбаатар хотод байхгүй, бусад 20 аймагт байхгүй. Ганц байгаа дулаан, цахилгааны станц бүхий Дархан-Уул аймагт байгаа тэр нөөц дээр тулгуурлаж, 2 хүнсний үйлдвэрийн парк, хөнгөн үйлдвэрийн парк гэсэн томьёолол явж байгаа. Төсөв дээр эх үүсвэрүүд тавигдаад ингээд ирэх жил дэд бүтэц, дэд бүтэц дотроо цэвэрлэх байгууламж, зам холбоо, тэгээд цэвэр, бохир, дулаан гээд энэ бүгдийг л татна. Тэгээд үүнийгээ хийж дуусгачхаад бид хувийн хэвшил болон гадаадын хөрөнгө оруулалтыг урина. Газар нь шийдэгдсэн, 25 га бүхий нэг газар байгаа, 180 га бүхий нэг газар байгаа. Ингээд дэд бүтцийг нь шийдээд өгнө. Дотоод хөрөнгө оруулалтыг бол хувийн хэвшил хийхээр. Үүнээс



цааш бол төр бол оролцоо байхгүй. Тэгээд энэ Цагаан алт буюу энэ бусад зээлийн бодлогоороо энэ төсөл хийвэл ийм хөнгөлөлттэй.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Мөнхтулга гишүүн дахиж 1 минут тодруулъя.

**П.Мөнхтулга:** Тэгээд түрүүн минут хүрсэнгүй. Дэлхий даяар синтетик материалаар орлуулж байгаа ч гэсэн бид одоо энэ цөөхөн бага хугацаанд бушуухан үйлдвэрээ бариад яарахгүй бол манай малчид үнэхээр нүүдлийн мал аж ахуй эрхлээд нэмэргүй болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр дэлхийн зах зээл маань арай ч ингэж хумигдаагүй байгаа дээр бид нарт нэг жоохон хугацаа байгаа. Тэгээд энэ хугацаандаа амжихын тулд төр маань эхлээд нөгөө хувийн хэвشلүүдэд дэд бүтцүүдийг нь бариад өгчихгүй бол хөрөнгө оруулалт нь хийгдэхгүй явсаар байж байгаад, сүүлдээ энэ хот руу явах урсгал зогсохгүй. Малчдын амьжиргааг дэмжихгүй бол. Тийм болохоор хэдүүлээ яарах ёстой. Тэгээд энэ яарахын тулд бид дэд бүтцүүдийг нь төрөөсөө хурдан хийгээд өгье. Олон жил хөдөө аж ахуйн орон болно л гээд байгаа. Тэргүүлэх чиглэл дээр хөдөө аж ахуйн төсөл алга байна. Тэгэхээр үүнийг хэдүүлээ мөрийн хөтөлбөрт багтсан энэ 3 чухал заалт байна. Энэ заалтынхаа хүрээнд дараа дараагийн төсвүүд дээр анхаараад, хөрөнгө оруулалтыг нь 28 ондоо дуусгаад, хувийн хэвшил.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Бараг санал хэлчихлээ дээ. Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Үнэхээр яарах хэрэгтэй. Ковид бол бидэнд хатуу сургамж өгсөн. Ямар ч үнээр хамаагүй эх орондоо 19 нэр төрлийн барааг тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэдэг байхгүй бол болохгүй гэдэг нь тодорхой болсон. Хөдөө аж ахуй дээрээ суурилсан энэ боловсруулах салбарын үйлдвэрүүдээ яаралтай босгохгүй бол дайн дажин, гамшиг, өвчний үед дотоод үйлдвэрлэл үндсэндээ байхгүй. Эрчим хүчний хэдэн үйлдвэрээс өөр юмгүй болчихдог юм байна лээ. Энэ бол бид нарт өгсөн том сургамж.

Нөгөө талаар хөдөөгийн хөгжил гэдэг маань хөдөө хүн ажиллах, амьдрах, хөрөнгө оруулах, бизнес орлоготой байх бололцоог л хангаж өгөхгүй бол төвлөрөл саарахгүй. Тэгэхээр төвийн бүсэд гол найдлага тавьж, тэр байгаа дэд бүтэц дээр яаралтай хөрөнгө оруулалтыг, бодлогын, татварын орчныг бүрдүүлж байж энэ төвлөрлийг сааруулахад том ахиц гаргана гэж үзэж байгаа юм. Иймд төвийн бүсийг хөдөө аж ахуйг эрчимжүүлэн, төрөлжүүлэн хөгжүүлэх аж үйлдвэрлэлийн бүс гэж зарлаж байгаа юм. Үүнийг хэрэгжүүл гэж Их Хурлын шийдвэр гараад, Хүнс, хөдөө аж ахуйн яамыг үүрэг өгөөд, Дархан хот руу шилжүүлэн ажиллуулж байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан бодлого тодорхой болсон, тодорхой эх үүсвэр тавигдсан.

**Х.Булгантуяа:** Отгоншарын Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Ингээд 2025 оны төсвөө ингээд хоёр дахь удаагаа бүгдээрээ хэлэлцэж байна. Нэлээн улс төржилт боллоо. Тэгээд үр дүнд нь бид 2.3 их наяд төгрөгийн зарлагаа хаслаа гээд сууж байна л даа. Гэхдээ энэ удаагийн энэ төсвийн өөрчлөлт зөвхөн энэ удаагийн төсөв биш шүү. Үүний үр дүн, үр нөлөө, үр дагавар нь дараагийн 3, 4, 5 жилдээ мэдрэгдэхүйц хэмжээний өөрчлөлтийг бид өнөөдөр яриад сууж байна л даа. 2.3 их наяд төгрөгийн урсгал зардал, зардал хасаж байна. Гэхдээ үүний 63 хувь нь хөрөнгө оруулалтын зардлаа хасаж байгаа шүү дээ. 2/3 нь хассан зардлын 2/3 нь

хөрөнгө оруулалтын зардлаа хасаж байгаа юм. Урсгал зардал ерөөсөө 31 хувь л хасагдаж байгаа юм.

Тэгэхээр нэг зүйлийг бид маш сайн ойлгох хэрэгтэй. Буцаад нөгөө газрын тос боловсруулах үйлдвэр маань 27 онд ашиглалтад орсон орно гэж тооцоолж байсан, энэ нь хойшилно. 28 юм уу, 29 юм уу. Улаанбаатар хотын нөгөө саарал ус боловсруулах үйлдвэр маань цаашаагаа ингээд хойшлох нь байна. Тэгэхээр үүний үр дагавар өнөөдөр бид ингэж хэт улс төржөөд, энэ ийм байдалд орж байгаа үүний үр дагавар дараагийн 5 жилдээ бид нарт 3.5 саяулаа мэдэгдэнэ шүү дээ. Тэгэхээр үүнийгээ бүгдээрээ өнөөдөр нэгэнт ярилцаж байгаа том зургаар нь харах хэрэгтэй. Дүгнэлтээ хийх хэрэгтэй гэж бодож байгаа.

Монгол Улс юу ойлгомжтой гэх юм бол бид дандаа мега төсөл дээр эдийн засаг маань явж ирсэн. Ганцхан жишээ хэлье. 2009 онд Оюу толгойн гэрээ зурагдсанаараа гуравхан жилийн дотор Оюу толгой гэсэн мега төсөл урагшилснаараа 4-хөн жилийн дотор нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 1500-аас 4000 болж 2.7 дахин тэлсэн байдаг. Тэрнээс хойш 2012-оос дахиад дараагийн 10 жилдээ 22 онд хүртэл бид яг нэг хүнд ногдох дотоодын бүтээгдэхүүн 4000 дээрээ очоод гацчихсан. Тэгэхээр үүнийг зарим орнуудад бол ...trap буюу ингээд нэг хавханд орчхож байгаа юм бид. 10 жил бид хавханд орж ирсэн. Яагаад гэх юм бол буцаад бид мега төслөө явуулж чадаагүй байхгүй юу. Ганцхан санхүүжилтээ олсон газрын тос боловсруулах үйлдвэрийнхээ мега төслийг өнөөдөр бид дахиад л хойшлуулчихаад сууж байгаа шүү дээ. Тэгэхээр эдийн засгийн өсөлт 8 хувь гэж ярьдаг бол өнөөдөр яг үнэнийг хэлэхэд бодитоор хэлэхэд хэнийг хуурч байгаа юм бэ, 8 хувь байхгүй шүү дээ. 8 хувиа өнөөдөр бид хасчихаад сууж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хавхнаас гарахын тулд бид төсвийн бодлого дээрээ ч гэсэн яг 8 сарын 27-нд баталсан нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан чинь буцаад дахиад үсрэнгүй дараагийн энэ түвшинд очиход энэ мега төслүүдийг явуулахад зайлшгүй гарах өөрчлөлтүүдээ бид хийж явсан. Тэгэхээр өнөөдөр яг энэ 2.3 их наядыг хассанаар яг үүний үр дагавар юу болох вэ гэхээрээ буцаад нөгөө мега төслүүдийг урагшлуулж байсан гэсэн тэр урагшаа 2 алхсан маань буцаад арагшаагаа дахиад л яг 2 алхсан л яг үр дагавар харагдаад байна л даа.

Тэгэхээр өнөөдрийн бид нарын энэ 2 дахиа баталж байгаа 2025 оны төсөв бол дараагийн 5 жилдээ яригдах байх гэж бодож байна. Дараагийн 5 жилдээ эндээс болоод яг ийм юм болсон гээд. Өнөөдөр бид 26, 27 оны төсвийн төсөөлөл дээрээ хүртэл алдагдалгүй төсвөөр гээд явчихлаа шүү дээ. Тэгэхээр энэ концептын маш том өөрчлөлт бид зөвхөн 2025 оны яг энэ улс төржилтөөсөө болоод энэ цаашаагаа дахиад олон жил мэдрэгдэхээр болчихлоо. Тэгэхээр үүнийг би эндээс Шадар сайдаас болон Жавхлан сайдаас асуумаар байгаа юм. Дараагийн 4 жилийг энэ үр нөлөөг та нар яг юу гэж харж байгаа юм бол? Ямар дүгнэлт эндээс хийж байгаа вэ? Зөвхөн энэ жилийн төсвөөс гадна энэ цаашаа ямар үр дагавар гаргана гэж та бүхэн тооцоолж харж байгаа вэ? Дараа нь.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Б.Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Яах аргагүй бидэнд тийм дараагийн шинэ сорилт гарч ирж байгаа, шинэ даалгавар гарч ирж байгаа байхгүй юу. Гишүүд ер нь жигд бүгд ийм асуулт асууж байна. Төсөв чинь байхгүй болчихоод байхад дотоодын бүтээгдэхүүн чинь яагаад буурахгүй байгаа юм бэ гээд. Тэгэхээр тэр орон зайг бид юугаар нөхөх вэ гэдэг дээр дараагийн бодлогын сорилт ирж байна гэж бодох хэрэгтэй. Тэгэхдээ бид энэ төсөв дээрээ бодлогын шилжилт хийнэ гээд хөгжлийнхөө зорилтоосоо ухарч болохгүй. Сорилт ирж байгаа. Гэхдээ ухарч болохгүй. Энэ дээр төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн илүү их идэвхтэй оролцоо, гадаадын хөрөнгө оруулалт, дээрээс би дахин, дахин л хэлээд байна. Бид байгалийн баялагтай улс. Тэгэхдээ энэ байгалийн баялгийг зөвхөн заавал төсөвт татвараар оруулж ирээд, тэгээд төсвөөсөө хөрөнгө оруулалт хийх гэхээр төсвийнхөө өсөлтийнхөө хязгаартаа баригдчихаад өөрсдийгөө хүлчихсэн ийм дүрэмтэй яваад байх юм бол нөгөө хөгжлийн том зорилтууд дээрээ бид яагаад ч авч чадахгүй.

Тэгэхээр өөр холимог эх үүсвэр, холимог өөр боломжууд дээрээ эрх зүйн боломжуудаа нээж өгөх ёстой. Энэ байгалийн баялгийг заавал төсвийн дүрмээр төсөвт оруулж ирэхгүйгээр яаж бүх нийтийн баялаг болгож, бүтээн байгуулалт болгож, таны хэлж байгаа тэр дэд бүтцүүдийг нэмж суурилуулах вэ гэдэг дээрээ л бид дараагийн шинэчлэлээ хийх ёстой байх. Энэ дээр Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль, Гадаад худалдааны тухай хууль, value exchange баялгийн солилцоо гэж очуулбал их зүгээр санагдаад байгаа. Энэ Арабын орнуудын маш том туршлага байна. Эд нарыг яаж хийсэн тэр туршлагыг нь судлаад эрх зүйн орчныг нь маш хурдан хэдүүлээ авчиръя энд нутагшуулъя. Ингээд бүх боломжуудаа эргэлтэд оруулаад, ингээд төсвөөр хийдэг байсан эдийн засгийн өсөлт, төсвөөр хийдэг байсан дотоодын нийт бүтээгдэхүүнийг бид арай өөр хэлбэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн идэвхтэй оролцоог дэмжсэнээр, гадаадын хөрөнгө оруулалтын оролцоог дэмжсэнээр үүнийгээ нөхье гэдэг ийм бодлого руу шилжинэ.

Тийм учраас манай Эдийн засгийн хөгжлийн яамнаас ч тооцоолол гаргасан. Хэдүүлээ дотоодын нийт бүтээгдэхүүний хүрэх гэж байгаа зорилгоосоо ухрахгүй. Бидэнд өөр байгалийн баялаг, өөр олон нөөц боломжууд байгаа. Энэ рүүгээ бүгдээрээ дараагийн том зорилтоо тавьж, илүү их чармайж, оролцъё гэж бодож байгаа.

**Х.Булгантуяа:** Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд Гантөмөр сайдын микрофон.

**Л.Гантөмөр:** Бид 2025 оны төсөв өргөн барихад хөөсөрлөө, томорлоо, Монгол дампуурлаа гээд айхтар том мэдэгдлүүд гарсан. Одоо 2.3 их наядаар бууруулахаар эдийн засаг жижгэрлээ, багаслаа гээд бас их айхтар том мэдэгдлүүд гарах гээд байна. Тийм зүйл байхгүй. Ер нь бол хөгжлийг хөгжил гэдэг бол бодлогодоо л байна. Харин нэг зүйлийг хэдүүлээ одоо яс хийнэ. Нэг зүйлийг. Тэр төрийн албыг хэдүүлээ цомхотгоно. Энэ дээр парламент нэг дуутай байна шүү. Салбарын хамгаалагчид төрөхгүй шүү. Энэ дээрээ хэдүүлээ нэг энэ төсвийг батлахдаа нэг зүйлийг ойлголцчихмоор байна. Давхар алба, давхар бүтцүүдийг алга хийнэ. Үүнийгээ хэдүүлээ ойлгочихмоор байна. Дээр нь төрийн өмчит компаниуд дээр нэлээн том цомхотгол, нэлээн сайн бүтээмжийн менежмент рүү одоо хэдүүлээ.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Батнайрамдал гишүүн нэмж тодруулъя.

**О.Батнайрамдал:** Тэгэхээр яах вэ магадгүй давуу тал нь ч гэх юм уу эд нар ялангуяа Засгийн газрын хувьд бол яг үнэнийг хэлэхэд хайрцгаас гарч сэтгэхээс өөр аргагүй л болж байна л даа. Тэгэхээр магадгүй бид урьд өмнө нь хийж үзээгүй зүйлээ хийх ёстой болж таарах байх. Гаргаагүй шийдвэрүүдийг бид гаргах ёстой болох байх. Нөгөө талаасаа урьд нь ч би хэлж байсан. Төсөв тэлэхийн хэрээр яг тэр хэмжээгээр нь төрийн өмчит компаниуд дээрээ бид яг 3 их наядаар хэрвээ тэлсэн бол 3 их наядаар бууруулах ч юм уу яг л тийм нөгөө талдаа балансжуулах хатуу ч гэсэн, шорвог ч гэсэн тэр шийдвэрүүдийг гаргахаас өөр гарцгүй ийм байдал руу орж байна л даа. Яах вэ тэрийг хийж чадвал давуу тал, хийж чадахгүй бол сул тал. Тэгэхээр юм л болохоор мега төслүүдээ хасдаг яг энэ байдал ондоо хэлбэрээр л 10 жил, 20 жил явж ирсэн. Тэгэхээр мега төслөө ер нь хасмааргүй л байгаа юм л даа.

**Х.Булгантуяа:** Санал хэллээ. Батнайрамдал гишүүн. Төсөвт тэлээд, тэгсэн мөртөө мега төслүүд олигтой явж өгөхгүй байна. Зардлыг нь таналаа энэ бол буруу юм гэдэг саналыг хэлэх шиг боллоо. Гантөмөр Шадар сайд.

**Л.Гантөмөр:** Ер нь одоо бид нарын өргөн барьсан төсөв батлагдах юм ирэх жил төрийн санд 1.5 их наяд төгрөг үлдэнэ гэдгийг та хэд ойлгож байгаа. Улс маань мөнгөтэй болж байгаа юм. Түүнээс нэг айхтар ингээд хөрөнгө оруулалт эрс буурлаа энэ тэр гээд хэдүүлээ их том дүгнэлт ерөөсөө хийж болохгүй шүү. 8 их наядын хөрөнгө оруулалт гэдэг та бүхэнд би нэг зүйлийг хүсмээр байгаа юм. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд жилд гаргасан хөрөнгө хөрөнгө оруулалтад зарсан мөнгөний хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувь байсан бэ гэдгийг харчих юм бол 2024 он, 2025 он онцгой өндөр он жилүүд эхэлж байгаа шүү. Дараа жил бидэнд дахиад 3 их наядын зай гараад ирнэ. Бид төсвөөр хангалттай ажил хийж чадна. Бүр ихийг хийх гэж байсан алхмаас нэг алхам ухарч байгаа. Дахиад бид урагшаа 2 алхана, хойшоо 1 алхаж байгаа бол урагшаа 2 алхана.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

**Б.Түвшин:** Өнөөдрийн энэ төсөв дээр яах вэ сайн, муу 2 тал байна. Сайн тал нь төсөв алдагдалгүй орж ирж байна. Цаашдаа ч ер нь ингээд төсвөө алдагдалгүй явбал улсын өр хэмжээ, тэгээд үүнтэй холбогдуулаад бүтээмжийн асуудал, зардлын асуудлуудаа танах ёстой, хасах ёстой, танах ёстой гэдэг ийм ойлгоцууд яригдаад явж байгаа нь нэг талаасаа сайн цаашдаа ер нь үүнийг барьж явбал их зүгээр юм байгаа юм.

Хоёрдугаарт, хөрөнгийн зардал нь 64 хувь, урсгал зардал нь 33 хувиар хасагдчихлаа. Уг нь энэ хоёрын байр солигдчихсон бол уг нь нэлээн баярлах байсан юм. Яагаад урсгал зардлыг хасуулах гээд байгаа вэ гэж. Урсгал зардал өөрөө хамгийн бага бүтээмж авчирдаг. Маш оновчтой Засгийн газрын хөтөлбөрөөс бусад нь бол ихэвчлэн цалин, хангамж хэрэгслүүд болчихдог учраас байр савны зардал болдог учраас нийгэмд үзүүлэх нөлөө нь маш бага байдаг. Тийм учраас ийм хэмжээгээр зардал тэлэх юм бол эдийн засаг өсөж байна гэдэг чинь худлаа механик тоо байхгүй юу. Харин эсрэгээрээ тэр хөрөнгө оруулалтын зардал нь хэр олон хүнд үйлчилж байгаагаасаа хамаараад магадгүй тэр мега төслүүд нь явах юм бол эдийн засгийн импакт нь илүү эерэг сайн нөлөөтэй.

Тэгээд энэ бүсчилсэн хөгжлийн гэж оруулж ирсэн. Энэ нь бол арай хэд хэдэн илүү аймгуудыг оруулж байгаа учраас илүү нөлөөтэй. Тэгээд түүнээс доошоо нөгөө муу хэлүүлээд байгаа аймаг, сумын тэр хөрөнгө оруулалтууд чинь ямартай ч байсан ингээд эдийн засгийн нөлөө үзүүлдэг цаад талын импакт нь том. Тийм учраас эдийн засаг өөрөө голдирол руугаа зөв оръё гэх юм бол урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал нь ядаж 60, 40, 50, 50 хавьцаа байж бид ер нь өнөөдөр энэ төсвөө зөв голдирол руу оруулах юм байгаа юм л даа. Өнөөдөр ингээд төсөв ярих болгонд хамгийн чухал салбар болох эрүүл мэнд, боловсрол 2 л дандаа хөрөнгө оруулалт байхгүй, эмнэлгийн хүрэлцээ байхгүй, хүртээмж байхгүй, цалин багатай, сургууль, цэцэрлэг хүрэлцээгүй гэж ярьдаг. Тэгэхээр энэ нэг талаасаа энэ төсвийг хувааж, булаацалдаж зардаг энэ бид нарын энэ арга барилуудад байгаа юм.

Ер нь ихэнх орнууд ялангуяа боловсрол, эрүүл мэндийг дээрээс доош нь буюу төсвийн орлогынхоо эсхүл дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ тэдэн хувийг шууд тавина гээд ингээд төлөвлөчихдөг. Энэ нь өөрөө 3-аас 5 жилийн төлөвлөгөө болоод боловсрол, эрүүл мэндийн салбар бол тухайн төсөвтөө багтаагаад тогтвортойгоор жигд үйл ажиллагаа явуулах боломж нь хангагддаг. Цаашдаа энэ байдал руу ялангуяа энэ 2 салбарыг шилжүүлэхгүй бол уралдаанд муу боловсрол, эрүүл мэнд 2 чинь ингээд хоцрогдоод, дээрээс нөгөө ач холбогдолтой гэсэн төслүүд нь явсаар байгаад үр дүн муутай болох ийм хандлагатай байна. Тэгэхээр өнөөдрийн энэ төсвийн зардлын төсвийн таналт дээр алдагдалтай байж байгаа нь сайн хэдий боловч яг үнэндээ бид нисдэг морийг нь алаад ир гэсэн чинь нисдэггүй морийг нь алаад ирчихсэн юм шиг ийм юм боллоо гэж бол би хувьдаа дүгнэж байна.

Ганцхан асуулт байгаад байгаа. Энийг Төрийн аудитынхнаас нэг асууя гэж бодоод байгаа юм. Төрийн аудитын дүгнэлтийн тэр 15 дээр нэг юм байгаад байгаа юм л даа. 15 дугаар дээр нь төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилийн аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэсэн байж байгаа. Би ойлгохдоо аудит хийх байгууллагуудыг хуулиараа төрийн аудит хийдэг. Тэгээд төрийн аудит нь сонгон шалгаруулалт хийгээд явдаг гэсэн. Одоо Засгийн газар нь өөрийнхөө харьяа байгууллагуудад, өөрийнхөө салбар нэгжүүдэд аудит хийлгэдэг болох гэж байгаа юм уу? Энэ хуульд нийцэж байгаа юм уу? Энэ яг юу гэсэн үг юм бэ? Энэ хэрвээ ингээд явах юм бол Засгийн газар нь өөрсдөө аж ахуйн нэгжүүддээ өөрийнхөө төрийн өмчит шууд удирдлагад байдаг аж ахуйн нэгжүүдийн аудитыг сонгох юм байна гэж ойлгож байгаа.

**Х.Булгантуяа:** Гантөмөр сайд хариулах уу.

**Л.Гантөмөр:** Түвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь бид намраас хойш төсвийн тухай ярьж байгаа. Тэгээд бид анх төсөв өргөн барихдаа нэг зүйлийг хэлсэн. Ер нь бол энэ төсвийн урсгал зардлыг бууруулах тал дээр ажиллах цаг хугацаа, боломж, реформ хийх тийм цаг хугацаа бол Засгийн газарт байгаагүй шүү. Үүнийг та бүхэн цөмөөрөө мэдэж байгаа гэдэгт бол найдаж байна. Намраас хойш Их Хурлын гишүүд маань төсвөө бүтэн уншсан. Тал талаас нь харсан. Ялангуяа Түвшин гишүүн шиг ийм аудитор хүн өдийд хэн нь хэдэн төгрөг хаана зарцуулж байгааг нэг бүрчлэн харсан байгаа гэдэгт бол итгэж байна.



Тэгэхээр одоо би бол ажил хэрэгч санал тавимаар байна. Нисдэг бор морио олоод ир. Яг үнэхээр энэ төсвийн урсгал зардал дотроос нэрлээд малчны тэтгэвэр хасъя, мэдэхгүй байна би, яг энэ, энийг хасъя гээд санал гаргаад Их Хурлаараа дэмжүүлээдэх. Засгийн газар хүлээж авахад бэлэн шүү. Бид чадлаараа хасаад ороод ирлээ. Тэгэхээр бид бол алдагдалгүй төсөв өргөн барилаа. Одоо та бүхэн бүүр ашигтай гаргаад өг. Би бол уриалмаар байна. Их Хурлын гишүүд бид судлаагүй гэдэг үг байхгүй. Одоо бол 3 сар уншчихсан, бүгд харчихсан, мэдэж байгаа. Тэгэхдээ нийт төдөн хувь энэ тэр гэж худлаа тоглож болохгүй. Одоо бол яг ажил хэрэгчээр цагдаагийн зардлыг төдөн хувь, батлан хамгаалахын зардлыг төдөн хувь бүү мэд. Санал гаргаад дэмжүүлээдэх тэгэх үү? Одоо бол ажил хэрэгч явъя.

**Х.Булгантуяа:** Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Түвшин гишүүний асуултад нэмж хариулъя. Бараг л адилхан юм хэлэх гэж байна л даа. Урсгал зардлуудыг хөндөж болохооргүй зүйлүүд байна гэдгийг нь би ялгаад та бүхэнд танилцуулсан. Хүүхдийн мөнгө, Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгө, Нийгмийн даатгалын сангийн мөнгө, цалингийн фонд 7 их наяд, гадаад зээлийн хүүгийн төлбөр нөгөө талдаа дефолтын заалттай байдаг эд нар маань нийлээд 17 их наяд. Нөгөө 26 их наядынх чинь 17 нь эдгээр зардлууд байдаг. Өөрөөр хэлбэл хувийн хэвшил хийх боломжгүй ийшээгээ хөрөнгө оруулалт хийх боломжгүй. Төр заавал үйлчилгээ үзүүлж, үүгээр бүрэн санхүүжүүлж байх ёстой ийм үйл ажиллагаанууд. Цаана нь хөндөж болно гэж байгаа тэр зардал дотор маань 10 их наяд дотор чинь 4 их наяд нь жишээ нь боловсролын зардал байж байна. Боловсролын зардлыг мөн л бусад салбаруудтай адилхан 10 хувиар танаж болохгүй. Зөвхөн үйл ажиллагаатай холбоотой, яамны үйл ажиллагаатай.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Ийм зардлууд байгаа юм. Тийм учраас бид цаашдаа энэ яг төр өөрөө тусгаар тогтносон улс байгаа бол эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ энэ бүх юмаа бид цаашаагаа төр өөрөө аваад явна. Жил бүр зардал нэмэгдэнэ, жил бүр хүн амын статистик өсөлтөөр нэмэгдэнэ. Тийм учраас тэр 60, 40 гэдэг юм уу буцаад эргүүлээд хөрөнгө оруулалт дээрээ нэмээд хэрэв болдог бол амар болон амархан шийддэг бол тэгчих, тэгчих гэдэг шиг сайхан юм оновчтой зүйл байхгүй. Тэр шилжилтийг хийх ер нь маш их хугацаа хэрэгтэй дээ, маш их хугацаа хэрэгтэй. Жишээ нь хүүхдийн мөнгө 1.6 их наяд. Бид жил болгон 300 мегаваттын цахилгаан станцыг хүүхдийн мөнгөндөө зарцуулаад л байгаа жил болгон. Жил болгон бараг мянган км-ийн замыг тийш нь хийгээд байгаа. Одоо болдог ингээд танаад хасаад хөрөнгө оруулалтуудаа, дэд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Аудит нэмж хариулъя, 1 дүгээр индэр дээрээс.

**Я.Самбууням:** Түвшин гишүүний асуултад хариулъя. Ерөнхий аудиторын орлогч Самбууням байна. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөөллийн дүгнэлт өгөхдөө 15 дугаар зүйл дээр нь сая гишүүний тавьсан дүгнэлтийг хэлсэн байгаа. Төрийн аудитын тухай хуульд болон Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг төрийн аудитын

байгууллага хийж гүйцэтгэх ийм цаглавар болон хуулийн бүрэн эрхийг нь нээж өгсөн байгаа.

Гэтэл энэ 2025 оны төсвийн төсөлд өгсөн дагалдах хуулийн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газраас тогтооно гээд ингээд төрийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**Я.Самбууням:** Аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуультай зөрчилдсөн ийм хуулийн томъёоллыг оруулж ирсэн байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ хууль нь бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн байгаа. Баярлалаа.

**П.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал.

**Н.Учрал:** Үндэсний аудитын байгууллага ТӨК-удад аудит хийж байгаа. Тэгээд 42 компани нь алдагдалтай ажилладаг гээд ингээд тайлан гаргачихсан. Зүгээр ийм хоосон тайлан болчихоод байна шүү дээ. Авч хэрэгжүүлэх ямар нэгэн арга хэмжээ байхгүй. Тэгэхээр энэ төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компаниуд дээр олон улсын аудит оруулах хэрэгтэй. Зөвхөн Үндэсний аудитын байгууллага хийнэ гээд ингээд суугаад байж болохгүй юм байна л гэж үзээд байгаа юм. Тийм учраас шаардлагатай компаниуд дээр олон улсын аудит оруулъя. Тэгээд аль, аль компаниуд дээр оруулахаа листийг нь гаргаж байгаад шийдвэрлээд явъя. Ингээд хөндлөнгийн аудит оруулж байж асуудлаа нээлттэйгээр ярья.

Тэрнээс зөвхөн Үндэсний аудитын байгууллага энэ дээр аудит хийгээд, тодорхой үр дүнд хүрэх хэрэгтэй байна шүү дээ бид чинь. Тийм учраас олон улсын аудит оруулъя гэж ийм хуулийн зохицуулалт байгаа. Тэгэхдээ энэ бол алба шаардлага бол биш, болно гээд нээж өгсөн.

**Д.Амарбаясгалан:** Банзрагчийн Түвшин гишүүн тодруулж асууя.

**Б.Түвшин:** Энэ үзэл баримтлалтай санал нийлэхгүй байна л даа. Засгийн газар аудит хийлгэх захиалгаа ямархуу хэмжээний байгууллагуудаар ч юм уу, олон улсын аудитаар хийлгүүлье гэдэг захиалгаа төрийн аудитын байгууллага руу өгөөд, тэгээд төрийн аудит нь сонгон шалгаруулаад явахгүй бол Засгийн газар өөрөө өөрийнхөө агентлаг, газар, нэгжүүдэд аудит захиалдаг болчих юм бол нөгөө Их Хурлын дэргэд төрийн аудит байх, тэгээд Их Хурал нь өөрөө нөгөө аудит хийж байх дээр хуулийн зарчим алдагдчих гээд байна гэж би бол хувьдаа бодож байна. Тийм учраас энэ хэсэг дээр захиалгаа өгөх эрх нь бол байгаа байх. Хуулийн өөрчлөлт оруулж бол болохгүй байх гэсэн ийм бодолтой байна.

**Д.Амарбаясгалан:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

**Н.Учрал:** Захиалга өгөх эрхийг нь нээж өгөөд, тэгээд Үндэсний аудитын байгууллага цаашдаа олон улсын зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар хийлгэх энэ нэг боломжийг нь нээж өгөх ёстой юм шиг байгаа юм. Түүнээс биш яг нөгөө хуулиар нээгдээгүй учраас зөвхөн үндэсний аудитын байгууллага л үүнийг хийнэ гэчихээр чинь ялангуяа манай энэ уул уурхайн төрийн өмчит компаниуд дээр ийм олон улсад зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар ер нь хөндлөнгийн аудит хийлгэвэл зөв юм билээ. Тийм учраас Түвшин гишүүний энэ саналаар ажлын хэсэг дээр энэ хууль дээр нь оруулаад явж болох байх. Гэхдээ ер нь гол санаа нь бол юу вэ гэхээр аудитын байгууллага захиалах гээд байгаагаасаа илүүтэйгээр нөгөө алдагдалтай ажиллаж байгаа, эсвэл жил болгон алдагдал нь буурахгүй байгаа, эсвэл зарлага хэт өндөртэй байгаа компаниуд дээр ч гэдэг юм уу листийг нь гаргаж байгаад, Засгийн газраар эдгээр компаниуд дээр олон улсын аудит оруулъя гэдэг энэ захиалгыг Үндэсний аудитын байгууллагад өгдөг. Энэ боломжийг нээж өгөөч гэж хүсэж байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Аудитын байгууллагаас нэмж хариулт өгье. Наранчимэг тэргүүлэх аудитор, ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

**Ц.Наранчимэг:** Түвшин гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Энэ төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт дагалдаж орж ирж байгаа үзэл баримтлал дээр байгаа асуудал бол 1 дүгээрт төрийн өмчит энэ компаниудын үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниар аудит хийлгэнэ гэж байгаа юм. Тэр үйл ажиллагаанд аудит хийлгэнэ гэдэг маань гүйцэтгэлийн аудит хийнэ гэсэн үг. Өнөөдөр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аудит, аудитууд маань баталгаажуулах буюу санхүүгийн тайлангийн аудит хийдэг, зөвлөх үйлчилгээний аудитыг хийж болно. Энэ хэрвээ өөрсдөө зөвшөөрвөл.

Энэ дээр хэд хэдэн эрсдэл байгааг аудитын байгууллага харж байгаа юм. Нэгдүгээрт, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлд санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн нийцлийн аудитыг хараат бусаар хэрэгжүүлэх Улсын Их Хурлаас хэрэгжүүлэх Үндсэн хуульд заагдсан энэ аудит бол төрийн аудит өөрөө хийнэ. Хоёрдугаарт, санхүүгийн тайлангийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя, ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

**Ц.Наранчимэг:** Санхүүгийн тайлангийн аудитыг аудитын хуулийн этгээдээр хийлгэж болно гэсэн ийм хуулийн зохицуулалттай. Гуравдугаарт, байгаа эрсдэл нь юу байна вэ гэхээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдүүд маань маш өндөр төлбөртэй аудитыг хийж гүйцэтгэдэг. Тэгэхээр энэ төлбөрийн асуудал өнөөдрийн энэ төсөвт туссан уу гэдэг зэрэг ийм эрсдэлүүд байгаад байгаа. Төрийн аудитын байгууллагаас энэ ТӨК-удын засаглал менежментэд маш олон аудитыг хийсэн. Тэр тайлан дотор нэлээдгүй ашиглаж болох, хэрэглэж болох ийм асуудлуудыг хөндөж тавьсан зөвлөмж юмнуудаа өгсөн. Өчигдөр Төсвийн байнгын хороогоор 2025 онд аудит хийх сэдэв батлагдсан. Энэ сэдэвт төрийн өмчит компаниудтай холбоотой 3 төрлийн аудитын гүйцэтгэлийн аудит хийх сэдэв батлагдсан байгаа юм. Тэгэхээр бид юу гэж харж байна вэ гэхээр төрийн байгууллагуудын ажлын уялдаа, төсөв хэмнэх бодлого яавал бид зөв.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Олон гишүүдийн асуулт, саналуудтай дийлэнх асуулт, саналууд маань давхцаж байна. Тийм учраас би давхцуулалгүйгээр 2, 3 зүйлийг илэрхийлье гэж бодоод байна. Төсвөө дахин өргөн барьж хэлэлцэх тийм шинэ нөхцөл байдал үүссэн. Энэ нөхцөл байдал үүсэхдээ бид тодорхой зардлуудыг хөндөж болохгүй. Бусад зардлуудаа хөндөөд, төсвөө алдагдалгүйгээр боловсруулаад оруулаад ирээч гэдэг санал ер нь гишүүдээс ихэнхээс нь гарчихсан. Засгийн газар энэ шаардлагыг нь хангаад оруулаад ирлээ. Одоо бид сайн, муугийн тухай яриад хэрэггүй. Энэ дахиж хэлэлцэж байгаа нь зарим хэсэг нь сайн гээд л, зарим нэг нь улс орныхоо ирээдүйн хөгжлийг боомилчихсон маш муу зүйл болж байгаа тухай яриад байх юм.

Би бол тэгж харахгүй байна. Аливаа сорилтууд бол дандаа шинэ боломжуудыг бий болгож байдаг. Бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлаад, мега төслүүдийг урагшлуулах, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар урагшлах том хөтөлбөр зорилт бидэнд байгаа. Төсвийнх нь нөхцөл байдал ийм шинэ нөхцөл байдлыг бий болгочихлоо. Энэ хоёрыгоо уялдуулаад шинэ нөхцөл байдал, шинэ арга барил бид илүүтэй эрэлхийлж ажиллах тухай асуудал гарч ирж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Түншлэлийн, шууд хөрөнгө оруулалтын, төсвийн бүтэц юмнуудаа зөв болгох, төрийн зардлыг бууруулах чиглэл дээр ахиухан ажиллах тухай том ажлын эхлэл эндээс үүсэж байна гэж харж байгаа шүү дээ.

Яг нарийндаа бол энэ чинь хасагдаж байгаа зардал 2.3 их наяд. Үүний 0.8 нь хөрөнгө оруулалтаасаа, 0.7 нь зээл, тусламжийнхаа үйл ажиллагааны зардалтай холбоотой асуудлаасаа, 0.8 нь урсгал зардлаасаа хасагдаж байгаа. Тэгээд тэр гадаадын зээл, тусламжийн үйлчилгээтэй холбоотой зардлын бууралт чинь дан ганц бүгдийг нь хасчхаагүй шүү дээ бид 2,4 билүү их наядаас ийм юм хасагдаж байгаа. Эрэмбэ дараагаа зөв тогтоох тухай асуудал яригдана гэж ойлгож байгаа шүү дээ. Хамгийн түрүүн үр өгөөж өгөх тэр зээл, тусламжуудаа түрүүлж ашиглах энэ арга барил руугаа чиглэж явах ёстой гэж ойлгогдож байгаа шүү дээ.

Тийм учраас үүнийг сайн, муугийн тухай биш ямартай ч энэ төр өөр дээрээ, нуруун дээрээ аваад, эдийн засагт үзүүлээд байгаа тэр том данхайсан бүтэц юмнуудаа бууруулахад нэлээн том зүйл боллоо. Дээр нь энэ хувийн хэвшлийг баялаг бүтээгчдийг дэмждэг тэр эрх зүйн орчин, орон зай энэ бүх юмаа шинэ нөхцөлд харах ийм бололцоо боломжийг үүгээр бий болгож байна. Энэ нь энэний эхлэл боллоо гэж ингэж хараад байна. Тийм учраас сайн, муугийн тухай биш үүнийг зөв талаас нь ашиглах тал дээр хэдүүлээ илүү шуурхай анхаарч ажиллая.

Дээр нь Улсын Их Хурлаас байгуулагдах ажлын хэсэг нэлээн няхуур. Ёстой 7 хэмжиж, 1 огтолдог зарчмаараа ажиллаж, тэр нь мэргэжлийн Байнгын хороондоо санал, дүгнэлтээ оруулж ирж, мэргэжлийн Байнгын хороо нь Их Хуралдаа асуудлаа оруулж ирж маш богино хугацаанд шуурхай төсвөө батлах асуудал Их Хурлын өмнө үүрэг болж байна. Тийм учраас би Их Хурлын гишүүдийгээ энэ тал руугаа илүү анхаарлаа хандуулж, богино хугацаанд илүү нухацтай, илүү ажил хэрэгч сайн ажиллах ийм шаардлага бидэнд үүсэж байна гэж ингэж харж байна. Тийм учраас энэ 2025 оны төсөв, төсөв дагасан хуулиудыг нэлээн нухацтай хандаж, шуурхай батлах тал дээр хэдүүлээ хүч чармайлт гаргаж ажиллацгаая гэж зориуд хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Батжаргал гишүүн үг хэллээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

**Ө.Шижир:** Оройн мэнд. Бид нар сая 2024 оны 8 сарын 30-нд өргөн барьсан төслийг дахиад Засгийн газар жоохон өөрчлөөд оруулж ирж байна. Тэгээд өөрчлөлт оруулж ирэхдээ 2.4 их наядын 800 тэрбум нь хөрөнгө оруулалтын зардлаас хасчхаж байгаа юм. Тэгээд хөрөнгө оруулалтын зардлаас хасчихаар нөгөө анх өргөн барьсан төсөв, одоо барьсан төсөв хоёр чинь хоёулаа дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 8 хувь гээд тооцчихсон. Дотоодын нийт бүтцийн өсөлт нь өөрчлөгдөөгүй. Тэгэхээр энэ өөрөө хэр бодитой юм бэ гэдэг нэг асуулт байна.

Хэрвээ 8 хувьдаа хүрэхгүй бол нөгөө 2028 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 10 мянга хүргэнэ гэсэн нөгөө Засгийн газрын мөрийн хөтөлбөр байгаа. Тэр мөрийн хөтөлбөрт маань 10 мянган доллар хүргэхэд энэ өсөлт, энэ сааралт нь өөрөө хэр нөлөөлөх вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Тэгээд өмнөх төсөв дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар 25 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарсан. Ажлын хэсэг бол би хангалттай сайн ажилласан гэж бодохгүй байгаа. Ажлын хэсгийн гишүүд нь гарч хэвлэлд өөр юм ярьдаг, хуралдаа ирдэггүй, ажлын хэсэгтээ хойрго ханддаг. Тийм учраас Засгийн газрын анх өргөн барьсан төсөв бараг өөрчлөлтгүйгээр Их Хурлаар орчихсон. Тэгээд түүнээс болж ингээд маш ойлгомжгүй байдлууд үүссэн. Ажлын хэсгийн хурал дээр юу болсон бэ гэхээр Монгол Ардын намын ажлын хэсэгт орсон гишүүд манай намын бүлэг дээр 2025 оны төсвийг өөрчлөлтгүйгээр оруулахаар улс төрийн шийдвэр гарсан гэж хэлээд, хамгаалаад ийм асуудал үүсчихсэн. Тэгэхээр энэ дээр ямар байр суурьтай байх юм бэ гээд?

Дараа нь Б.Жавхлан сайд өнөөдөр асуулт, хариулт дээрээ зураг төсөлгүй, магадлангүй төслүүдийг бүгдийг нь хойшлуулж байгаа гэж үг өдөр хэлнэ лээ. Гэтэл 2020 он, 2024 оны 8 сарын 30-нд өргөн барьсан төсөв дээр 18 төсөл байсан. Үүнээс 6-г нь хассан, 12 нь дахиад ороод ирсэн. Тэгээд энэ 12 нь ямар учиртай болоод хасагдахгүй байгаа юм бэ гэдэг нэг асуулт байна.

Мөн 2025 оны сая өргөн барьсан төсөл дээр 8 сарын 31-нд байгаагүй цоо шинэ 11 төсөл хөтөлбөр байна. Энэ 11 төсөл хөтөлбөр харахаар нийгмийн шинжтэй барилга байгууламжууд байна л даа. Гэхдээ би энэ сэдвийг дахиад хэлэх гэж байгаа юм. Жишээ нь Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар гээд нийт төсөвт өртөг нь 5.7 их тэрбум, одоо 25 онд санхүүжих нь 2.8 тэрбум байгаа юм. Бид нар ингээд эмнэлгийн засвараа нэг жил хийж дуусгаж болдоггүй юм уу? Тэгэхгүй бол хавдрын эмнэлгээр үйлчлүүлж байгаа тэр иргэд чинь ингээд 2 жил засварын байдалтай эмнэлээр үйлчлүүлэх нь байна шүү дээ. Тэгэхээр иймэрхүү эмнэлэг, сургууль ийм нийгмийн шинж чанартай төслүүдийнхээ их засваруудыг бид нар нэг жилдээ хийж дуусгадаг, тэрийгээ ингэдэг болохгүй бол дараа жил яах вэ гэхээр үлдсэн 3 тэрбум дээр нь төсөвт өртөг өөрчлөгдөнө гээд дахиад ороод ирнэ. Одоо үлдсэн 3 нь магадгүй 3.5 ч юм уу, 4 болоод ороод ирнэ. Одоо хамгийн багадаа 18-аас, хамгийн ихдээ 670 хувь өссөн төслүүд байгаад байна шүү дээ. 20 хувь өслөө гэхэд бид нарын урсгал зардал дээр дахиад л нэмэгдээд ороод ирнэ.



Тэгэхээр бид нар хөрөнгө оруулалт хийх зардлууд чинь ингээд багасаад байгаа. Жавхлан сайд зовлон яриад байна шүү дээ. Урсгал зардлаас хасахад аягүй хэцүү байна гээд. Энэ чинь сургууль, цэцэрлэгийн барилга, эмнэлгийн засваруудыг бид нар 3 жил дараалаад бариад байхаар чинь төсөвт өртөг чинь өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Хөрөнгө оруулалт руу орох ёстой энэ урсгал зардлууд чинь бүгдээрээ ийшээ явчхаад байна гэдэг ийм юунууд байна. Тэгээд энэ дээр эдгээр юунууд дээрээ хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт.

**Б.Жавхлан:** Шижир гишүүний асуултад хариулъя. Ер нь бараг олон гишүүний энэ дээр ижилхэн асуулт давхардаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн урсгал зардал ер нь багасахаар, аль, аль нь л дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд сөрөг нөлөөлнө. Зөвхөн дотоод, хөрөнгө оруулалт ч биш. Харин энэ зөрөө бидэнд шинэ даалгавар авчирч байна. Шинэ сорилт авчирч байна. Бодлогын том шинэ орон зайг хаанаас, яаж гаргаж ирэх вэ, олон талт хөрөнгө оруулалтууд, гаднын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, төрийн хийж болох ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр хийлгүүлж болох тэр том орон зайг нээх. Гагцхүү үүн дээр хувийн энэ оролцоонуудыг дэмжиж байгаа бид хууль, эрх зүйн орчин дээрээ нэлээн том өөрчлөлтүүд хийх шаардлагатай болж ирж байгаа. Товчхондоо энэ.

Тэр зураг төсөвгүй гээд таныг би ямар буруу ойлгосон байна гэлтэй нь биш. Би л буруу ойлгуулсан байх. Зураг төсөвгүйн учраас энэ 10 төсөл хасагдаагүй шүү. Үүнийг бид нар өөр шалгуур, өөр эрэмбээр тухайлбал, Дархан-Алтанбулагийн зам, Налайх-Тэрэлжийн замууд энд чинь шинүүд нь аль хэдийн зураг төсөв нь бэлэн болчихсон ийм зүйлүүд байгаа. Гагцхүү одоо нэгэнт тэнд суурилагдчихсан дэд бүтэц байгаа учраас өнөө маргаашдаа тулчихсан ажил биш байна. Тийм учраас нэг жилдээ төсвөөс хийхийг нь хойшлуулъя. Харин төр, хувийн хэвшлийн түншлэл рүү шилжүүлъя. Үүнийг олон нийтэд санал болгоод үзье, тэнд нь тариф тавиад үзье, тэнд бизнес эрхлэх боломжуудыг нь тавиад өгье гэдэг ийм шилжүүлэлтийг хийж, шилжилтүүдийг хийж байгаа гэсэн үг. Тоонуудын хувьд 38 шинэ төсөл байснаас 10 нь хойшилж байгаа юм шүү. 10 нь хойшлоод, 10-аасаа боломжтой нь төр, хувийн хэвшлийн түншлэл рүү шилжиж байгаа гэсэн үг хууль руу. Цаана нь 28 төсөл байгаа гэсэн үг. Тэгэхээр та тэр тоонуудыг нэг эргээд нэг хараадхаарай.

Хавдрын эмнэлэг дээр аливаа төсөл өөрөө дэд бүтцээсээ эхэлдэг. Тийм учраас зургийг нь хүлээлгүйгээр дэд бүтцийг нь эхлүүлж байгаа. Өөрөөр хэлбэл ингээд энэ хавдрын том цогцолбор эмнэлэг бүтээн байгуулалт нь гараанаас гарлаа гэсэн үг. Зураг нь ч гэсэн мөн ашгүй олон дахин тендер зарласны үр дүнд ямар ч байсан эзэнтэй болсон. Зургийнх нь ажил нь эхэлсэн байгаа. Болдог бол нэг жилд бүх төсвүүдийг л төслүүдийг л тавьчихмаар байна. 10 төслийг зэрэг эхлүүлэх, 10-ууланг нь болиод, 1 төсөл рүү оруулах хоёр нийгмийн үр өгөөж болон хүртээмжийн хувьд бол шал өөр болоод явчихна.

Дээрээс нь манай дотоодын компаниудын хүчин чадал гэдэг нэг асуудал байна. Ер нь 40, 50 тэрбумаас дээш төсөл байхад бий болоход хувийн компаниуд тендерт орж чадахгүй байна. Түүн дээр баталгаа гаргаж өгч чадахгүй байна, банкнууд тэр баталгааг нь гаргаж өгч чадахгүй. Ингээд л хамгийн наад захын зовлонгоос эхлээд энэ том төслүүд дээр манай аж ахуйн нэгжүүдийн маань багтаамж нэлээн хязгаарлагдмал байдаг юм байна.

**Д.Амарбаясгалан:** Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

**Ө.Шижир:** Сая миний хэлдэг 18 төслөөс 6 нь хасагдчихсан, 12 нь үлдсэн байна гэхэд би танд нэг жишээ уншиж өгье. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын харьяа байгууллагуудын их засвар гээд 2025 оны төсөв дээр 1.8 тэрбум төгрөг энэ нь өөрөө зураг төсөлгүй, магадлалын дүгнэлтгүй гээд аудитын дүгнэлт гарчихсан. Ийм 12 төсөл байна гэж асууж байгаа юм. Тийм, жишээ нь ийм төслүүд байна гэж байгаа юм.

Тэгээд ер нь бол тэр миний хэлж байгаа бол том 40, 50 тэрбум төгрөгийн барилга төсөл хөтөлбөр бол 2, 3 жил үргэлжилж болно. Эмнэлгийн их завсрын асуудлыг бид нар 2 жил дамжиж хийх чинь ямар зохистой үйл явдал юм бэ? Энэ чинь эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдэд маш хүндрэлтэй болно шүү дээ. Тэгэхээр ийм нийгмийн шинж чанартай барилга байгууламж засваруудаа нэг жилийн дотор хийдэг, 50 хүүхдийн ортой сургууль, цэцэрлэгийн барилгыг нэг жилийн дотор хийдэг болъё гээд ингээд юмаа шийдэж болдоггүй юм уу? Тэгэхгүй бол төсвийн өртөг ирэх жил дахиад төсөв өснө, өсөхөөрөө урсгал зардал өсчихнө. Урсгал зардал өсөхөөрөө хөрөнгө оруулалтын зардалд зарцуулах мөнгөнөөс чинь л аваад байгаа байхгүй юу. Тийм л зорилгоор хэлж байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Их засвар хэлсэн юм уу уучлаарай, би хөрөнгө оруулалтуудыг бүсийн хөрөнгө оруулалтуудыг ярьж байгаа юм гэж ойлгосон шүү. Засваруудыг бол аль болох түргэн дуусгах хэрэгтэй шүү дээ. Ирэх жилийн жишээ нь хавдрын эмнэлгийн засвар бол нэг жилд бүтэн төсөв нь тавигдаад бушуухан дуусгах хэрэгтэй. Одоо байгаа хавдрын эмнэлэг дээрээ. Тэгэхдээ энэ их засваруудыг нэг ингэж ойлгоорой. Бид Нэгжийн хуулиар их засвар, урсгал зардлуудыг орон нутаг бол, орон нутаг дээрээ байгаа өмчийн орон нутгийн өмчит газрууд дээрээ бол орон нутаг өөрсдөө хариуцдаг болчихсон байгаа. Улсын төсөв дээр тавьж байгаа нь голцуу Улаанбаатар хотод байдаг яг шууд яамнуудын харьяанд яамнуудын өмчлөл дээр ТӨБЗГ байдаг ийм объектууд дээр засварууд нь хийгдэхээр байгаа. Ер нь энэ нормт засваруудыг ялангуяа урсгал засваруудыг цаг тухай бүрд нь хийхгүй бол яваандаа их засварын дүн нь өөрөө их том болдог ийм эрсдэлтэй. Тийм учраас аль болох болж өгвөл жил дамжуулахгүй хийх хэрэгтэй. Том засваруудыг бүтэн жилийн дотор том эмнэлэг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тэгээд ажлын хэсэг төсвийн нэгдүгээр хэлэлцүүлэг дууссаны дараа дэмжигдсэний дараа ажлын хэсэг байгуулагдана. Улсын Их Хурлын гишүүдийг намын бүлэг болон бүлэгт харьяалалгүй гишүүдийг Улсын Их Хурлын Тамгын газарт саналаа ирүүлэхийг хэлсэн байгаа. Өнөөдөр дахиж хэлье. Маргааш ажлын хэсэг байгуулагдаад ажиллана. Ажлын хэсэг яах гэж байгуулагддаг зорилго бол энэ гарч байгаа санал, бүх зохицуулалтыг хийж, Төсвийн байнгын хороонд орж танилцуулж, батлуулах үүргийг хүлээдэг. Үүнийгээ хангалттай хийхгүйн улмаас гарч байгаа асуудлыг бид Улсын Их Хурал бүтнээрээ хамтдаа үүрэх ёстой. Тэгэхээр ажлын хэсэгт орж байгаа гишүүд илүү хариуцлагатай ажиллах ёстой гэдгийг бас давхар хэлье. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

**О.Номинчимэг:** Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Нэлээн олон гишүүдийн асуулттай давхцаж байгаа учраас 2 юм онцолж хэлээд, 1 асуулт товчхон асууя гэж бодож байна. Мэдээж төсөв ингээд алдагдалгүй орж ирж байна. Хөрөнгө оруулалтаасаа, урсгал зардлаасаа хасаж ирж байна. Сая Сангийн сайд болон Засгийн газрын гишүүдээс өгч байгаа тайлбар бол бид цаашид ч гэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, хувийн хэвшилд орон зайг нь гаргаж, төрийн бүтээмжийг сайжруулна, төрийн данхар бүтцийг багасгана гээд энэ санаануудыг яг бодитойгоор хэрэгжүүлэх хөшүүрэг маань энэ алдагдалгүй төсөв гэж хэлж байна. Тэгэхээр энэ дээр анх Жавхлан сайд энэ төсөв дээрээ танилцуулга хийхдээ хэлж байсан. Улсын Их Хурлаар баталсан хөрөнгө оруулалтын лист тэр чигээрээ ямар нэгэн өөрчлөлтгүй орж ирсэн. Мега төслүүдээс хасагдах нь хасагдаад гээд.

Тэгээд өмнө 11 сарын 8-нд энэ төсвийг батлахад хөрөнгө оруулалт дээр зарчимгүй хэд хэдэн санал хураагдаад, дэмжигдээд явчихсан ийм асуудал байгаа. Жишээлбэл Сүхбаатар аймагт цэцэрлэгийн барилгыг аудитын хөрөнгө оруулалтыг нь аудитын байгууллага худалдаж авна гээд. Золжаргал гишүүн гаргаж байсан санагдаж байна. Энэ Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх BPF 24.mn дрон бүтээх, турших үйлдвэрлэж, албанд нэвтрүүлэх гээд. Тэгээд энэ чинь угаасаа аль хэдийн хувийн хэвшил хийгээд, Японоос дроноо хийгээд цус зөөгөөд, цусны төвөөс эмнэлгүүд рүү зөөгөөд явж байгаа ажил шүү дээ. Хувийн хэвшил ингээд нэг ажил санаачлаад, нэг инновац хийгээд ороод ирэхээр төр нь зэрэгцээд хил хамгаалах дээрээ бид нар адилхан дрон бүтээнэ, туршина, хийнэ гээд хөрөнгө оруулалтаар ороод ирж байгаа.

Тэгээд яг эцэс сүүлдээ яадаг вэ гэхээр төрийн байгууллагууд дээр нэг юм хийнэ тэр нь нэг болох, бүтэхгүй ч юм уу ихэнх нь. Тэрийг нь бодвол ажиллуулж чаддаг хүн байхгүй, дахиад орон тоо нэмнэ, ашиглалтын зардал нь өндөр болно гээд дахиад нөгөө зардлууд маань өсдөг. Нэгэнт бэлэн хувийн хэвшил хийж болох ийм бизнесүүдийг битгий төр булааж авч, зэрэгцэж хийгээч. Энэ саналуудыг бид нар дахиж хасах ёстой ийм зарчимгүй, үнэхээр Засгийн газар энэ алдагдалгүй төсөв баталъя гээд ийм зарчим барьж байгаа бол бид хувийн хэвшлийн хийж чадаж байгаа, болж байгаа энэ асуудлуудыг төр зэрэгцэж хийхгүй гэж зарчим баримтлаад эд нарыг хасах хэрэгтэй гэж үзэж байна.

Гантөмөр сайд хэлж байна. Төрийн албыг цомхотгоно, цомхон ийм төрийн албатай болно гээд. Ер нь манай ингээд харахаар манай яамнуудын чадавч нэлээн суларчихсан байна. Яамнууд өөрөө 70-аас 80 хүнтэй гэхэд чадамж үнэхээр бага, бодлогоо боловсруулж чадахгүй байна бүрэн дүүрэн. Урьд нь ингээд яамнуудын доор баахан агентлаг байгуулчихдаг, тэгээд чиг үүрэг нь хоорондоо давхцадаг. Хэн нь, юугаа хийх гээд байгаа юм мэдэхгүй. Агентлаг байгуулах нь хуулиар ингээд байдаг болохоор сүүлдээ ерөөсөө энэ сайд нарын доор юм уу, ямар нэгэн газрын доор улсын өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг нэг бүтцээр албан бус ийм бүтцүүдийг баахан хийсэн. Хамгийн сүүлийн жишээ бол бүсчилсэн хөгжлийн төрийн үйлдвэрийн газар гээд байгаа. Уг нь бол бүсчилсэн хөгжил чинь Эдийн засаг, хөгжлийн яамныхаа бодлогын асуудал байх ёстой байтал ингээд салгаж ирээд, дахиад ийм бүтэц салангид юм хийж байгаа. Ингэхээр бодлого чинь ерөөсөө уялдахгүй, ямар ч хэрэггүй, үр дүн байхгүй баахан шинэ бүтцүүд гараад байна. Тэгээд эд нарыгаа цомхотгохоос та бүхэн эхлээрэй. Тэгэхгүй бол төр маань өөрөө 4 мөч нь маш том болчихсон, өөрөө бие нь энэ даахааргүй ийм туранхай болчихсон ийм яамнуудтай байгаад байгаа учраас энэ зохион байгуулалтын асуудал дээрээ эхлээд анхаараарай гэж хэлмээр байна.

Асуулт бол зээлийн ашиглалт дээр 666 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтыг бууруулж төсөв дээр орж ирсэн. Тэгээд 25, 2026 онд тэнцэл дахиад ашигтай тэнцэлтэй байна гээд ороод ирж байгаа. Энэ зээл болон зээлийн батлан даалтын орон зайд 25, 26 онд яаж өөрчлөгдөнө гэж та үзэж байна вэ? Сангийн сайдаас асууж байна. Энэтэй холбоотойгоор дэд бүтцийн төсөл.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан. Номинчимэг гишүүн 1 минут нэмж авъя.

**О.Номинчимэг:** Тэгээд хасагдаж байгааг нь харахаар ерөнхийдөө цэвэрлэх байгууламж, Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц, Солонго 1, 2 хороолол, газрын тос гээд бид нарын хийх ёстой ийм дэд бүтцийн болон чухал төслүүдээс зээлжилтийн, зээлийн ашиглалт нь багасчхаад байгаа юм. Энэ маань ер нь яг тогтсон хугацаандаа жишээ нь цэвэрлэх байгууламж ч юм уу, орон сууцын хорооллууд маань 25, 26 онд орно гээд төлөвлөгөөтэй байгаа. Түүний дагуу зээлээ багасгаснаар орж чадах юм уу гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт 25, 26 онд энэ зээлийн ашиглалт хэр буурах юм бэ? Түүнтэй холбоотойгоор бондод зээлийн баталгаа Засгийн газраас гаргадаг. Энэ ямар орон зай үлдэх вэ гэдгийг тодруулмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Номинчимэг гишүүний асуултад хариулъя. 2,2 их наяд төгрөгийн зээлийн ашиглалтыг бид сая тодотголоор энэ жилд хийж чадсан, энэ жил овоо ажил явчхаж байгаа юм. Ирэх жил уг нь энэ 2,2-оороо бариад орчихъё гэсэн ингээд боломж гарсангүй, нэлээн хумигдлаа. Ингээд 650 тэрбум төгрөгөөр багасаж байгаа юм. Ингээд 1.6. Ирэх жилүүдэд бид мөн л зээлийн ашиглалтыг нэг энэ хэмжээнд бариад орохыг хичээнэ дээ. Эндээс буулгахгүй байхаар.

Яг таны хэлсэнчлэн яг эрэмбэлж байгаад нэн тэргүүнд шаардлагатай орох төслүүдээ цаанаас ирж байгаа хүсэлтийг бол гүйцээж чадахгүй. Одоо ер нь энэ жил ч гүйцээж чадахгүй, хойтон ч гүйцээж чадахгүй. Тухайлбал нефть боловсруулах үйлдвэр бараг 1 их наяд төгрөгийн гүйцэтгэл гаргая гэж хүсэлт ирүүлдэг. Гэтэл энэ чинь бараг 108 төсөл хэрэгжиж байгаа сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд шүү, манай Засгийн газрын үед ч биш. Тэгээд энэ бүгдийн зээлийн ашиглалтыг ямар нэг байдлаар жигд хуваарилж, төслүүдийг зогсоохгүй явуулах нь бидний сорилтын зорилго байдаг. Тэгэхдээ эрэмбэ дараа үнэхээр эдийн засагт хурдан үр өгөөжийг нь амсмаар байгаа тухайлбал саяын тэр нефть боловсруулах үйлдвэр, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламж маш чухал байна. Мянганы сорилтын сангийн төсөл байна, Солонго 1, 2 хороолол байна, энэ орон сууцжуулах гээд гэх мэт төслүүдээ аль болох хугацаанд нь оруулахаар шахаж, тийшээгээ түлхүү санхүүжилтүүдийг нь тавих ийм бодлого барина.

Тийм учраас ирэх жил 1.6-г өөрөөр хэлбэл 2025 оны санхүүжилтийн дүнг бууруулахгүйгээр, 2026 ондоо тааруулах ийм бодлого бидний өмнө тулгарах байх даа. Тийм. Ер нь шинэ, шинэ даалгаврууд, шинэ, шинэ сорилтууд ирж байна гэсэн үг. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Лутаагийн Энхнасан, Лувсанн्याмын Гантөмөр Шадар сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Бид нар энэ төрийн албаа цомхон болгоё гэдэг ажил дээр бол миний, чиний гээд ингэж харж болохгүй. Бүгдээрээ бүх түвшинд цомхон болгох, чадварлаг болгох гэдэг рүүгээ алхъя тэгэх үү? Тэгэхгүй бол яамнууд сайд нар цомхотго, бусад нь хамаагүй гэдэг ч юм уу эсвэл бусдыгаа цомхотгоё бид нар хамаагүй ч гэдэг юм уу нэгэн рүүгээ бөмбөг шидэх шаардлагагүй гэж бодож байна. Ер нь урсгал зардлаа, та жишээлбэл дроны зардал бууруулмаар бол үүнийгээ олонхтойгоо яриад бууруулах шийдвэрээ гаргаад яв. Нэг үгээр хэлбэл одоо ингээд хаалга нээгдчихлээ. Их Хурал шийдвэрээ гаргачихсан, за бол ёогүй, ийшээгээ хэдүүлээ алхъя гэсэн бол алхъя л гэж байгаа. Түүнээс биш гишүүдийн тэр нэг итгэж ядаад байгаа дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, эдийн засгийн тэлэлт дээр та бүхэн битгий эргэлзээрэй. Энэ төрийн эдийн засагтай холбоотой, санхүүтэй холбоотой, бизнесийн орчинтой холбоотой.../минут дуусав

**Д.Амарбаясгалан:** Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя.

**Л.Энхнасан:** Гишүүддээ оройн мэндийг хүргэе. 2, 3 асуух юм байна. Боловсрол, эрүүл мэндийн салбар бол манай төрийн хамгийн чухал салбар байгаа. Энэ хөндөгдөөгүй салбар дээр зардал дээр нь бол Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан бол орсон байна. Харин нөгөө Сангийн сайд Жавхлан хориг тавьсны дараа мэдэгдэл хийхдээ энэ Боловсролын багц хуультай холбоотой зардлууд эргэж харна гэж байсан. Тэгэхээр нөгөө энэ боловсролын салбар дээр ямар нэгэн төсөв хасагдсан уу?

Нөгөөдөх нь болохоор бүтээн байгуулалтын энэ төслүүдийг би зарчмын хувьд ер нь дэмжиж, энэ өмнө нь төсвийг дэмжсэн. Өмнө та надад хэлж байхдаа Жавхлан сайд хэлж байхдаа энэ ач холбогдлоороо эрэмбэлж байгаа энэ эрчим хүч, боомтын өргөтгөл, төмөр зам улсын чанартай авто замуудыг бол нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж хэлж байсан. Энэ 14 мега төсөл харин энэ техник, эдийн засгийн үндэслэлүүдийг боловсруулахад 1 их наяд төгрөг төсөвлөсөн байсан. Эндээс хасагдсан уу, энэ эрэмбэлэгдсэн үү?

Дараачийн асуулт болохоор ер нь энэ цаашид улсын төсөвт нөгөө дарамт болж байгаа том төсөв нь халамжийн байна л даа, төсөв байна. Энэ халамжийн бодлогыг ер нь цэгцлэх эсхүл өөрчлөх шаардлагатай байна. Тэгээд одоогоор хэрэгжиж байгаа энэ хуулиа харахаар 1.4 их наядыг халамжид төсөвлөсөн байна. 28 он гэхэд энэ байдлаар хэрвээ явах юм бол 3.1 их наяд төгрөгийг нийгмийн халамж, тэтгэвэрт улсын төсвөөс зарцуулахаар байна. Энэ дээр ер нь Сангийн сайд болон салбарын сайд ямар байр суурьтай байдаг вэ? Дараа жилийн 2026 оны төсөв боловсруулахдаа үүнийгээ өөрчилнө гэж бодож байна уу?

Мөн энэ Хавдар судлалын үндэсний төвийн 2 дугаар барилгыг барина гээд энд төсөв оруулсан байна. Энэ баярлууштай байна. Энэ Хавдар судлалын үндэсний төвийн одоогийн барилгад засварт 2.9 тэрбум төлөвлөсөн юм байна. Харин энэ Хавдар судлалын үндэсний төвийн 2-т энэ дэд бүтцэд нь 5 тэрбум төсөвлөсөн байна гэж би ойлгож болох уу? Тэгээд асуух юм болохоороо саяхан энэ Хөгжлийн банкнаас манай Байнгын хороонд ингээд бичиг ирсэн. Энд Хөгжлийн банкны барьцаанд байгаа Ачлалт трейд ХХК эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ингээд зээл



аваад, харамсалтай нь нөгөө ашиглалтад орсон боловч 19, ковидоос болоод энэ ашигт ажиллагаа нь эрхлэлтээс өмнө талуудын гэрээ дуусгавар болоод энэ иргэний шүүхийн шүүхэд хандаад, шийдвэрлүүлээд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаагаар барьцаа хөрөнгөд үнэлгээ хийгдээд, тус эмнэлэг, эмнэлгийн барилга 89 тэрбумаар худалдаж борлуулах эсхүл өр төлбөрт нөгөө тооцон шилжүүлэх ийм нөхцөл байдалтай байна.

Тэгээд энэ сая Шижир гишүүн ч гэсэн ярьж байна. Энэ нөгөө ийм том хөрөнгө оруулалтын энэ эмнэлгүүдийг заавал олон жилээр ингэж төсөвлөхгүйгээр энэ бэлэн байгаа энэ барилгыг, энэ чинь орчин үеийн эмнэлгийн чанар шаардлагыг хангасан ингээд 10 мянган.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 1 минут нэмж өгье Энхнасан гишүүнд.

**Л.Энхнасан:** 1000м<sup>2</sup> талбай бүхий эмнэлэг бэлэн байгаа байхгүй юу. Үүнийг шууд худалдаад аваад эсвэл Хөгжлийн банк энд хамтарч ажиллана гэж байна. Яам ч энэ дээр дэмжих бодлого баримталж байгаа юм билээ. Энэ дээр төсөв тусгаад, өнөө маргаашгүй ингээд эмнэлэгтэй болох боломж байхгүй юу? Энэ дээр сайд ямар бодолтой байгаа вэ?

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Энхнасан гишүүний асуултад хариулъя. Тэр мега төслүүд дээр хооронд нь яагаад байх шиг байна. 9 сарын 1-нд өргөн барьсан өмнөх төсөл дээр 38 шинэ төсөл маань энэ дотор чинь 38 мега төсөл биш шүү, энэ чинь 38 бүсчилсэн хөгжлийг дэмжиж байгаа замын болон эрчим хүчний салбарын л бүс нутгийн ийм төслүүд юм байгаа юм. Тэрнээс мега төсөл гэж энэ дотор нэг ч байхгүй. Мега төсөлд орсноос яах вэ гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд гэвэл нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, хиймэл дагуул байсан хиймэл дагуул ингээд больчихлоо. Тэгэхээр одоо Эрдэнэбүрэн, нефть боловсруулах 2 үйлдвэр л байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ 2 төсөл бол аль нь ч зогсоогүй явдгаараа явна. Санхүүжих дүнгийн хувьд нэмэгдэх, хасагдах ийм асуудлууд гарах нь.

Яг энэнтэй холбоод түрүүн О.Номинчимэг асуусан. Зээлийн ашиглалт гэдэг дүнг гадна талдаа 10.2 их наяд хүлээгдэж байгаа юм. Энэ зээлийг ав, төслийг нь эхлүүлчихсэн 10.2 их наяд. Уг нь 2.2 гэсэн дүнгээр 4 жил явчихсан гүрийчихсэн бол энэ ер нь дэд бүтцийн төслүүд нэлээн хөөрхөн болчих байсан юм. Одоо яалт ч байхгүй ингээд дүнгүүд буурч байна. Тэгэхээр 4 жилд нэлээн цэгцэрчих байсан бол 6, 7 жил болж ингэж жигд хугацаа сунгахаас өөр аргагүй болж ирж байна. Тийм учраас мега төслүүдийн хувьд бол нэгэнт эхлүүлчихсэн төслүүд дотроо энэ төсвөөс болж хойшлуулж байгаа ч юм уу, зогсож байгаа нэг ч төсөл байхгүй шүү. Бүс нутгийн л ийм төслүүд байгаа гэсэн үг.

Боловсролын салбарынхыг сайдад нь хариулчих байх. Халамжийн бодлого дээр сайдад нь хариулчих байх. Тэр эмнэлэг, эмнэлэг ч бай, цэцэрлэг ч бай худалдаж авна гэдэг нэлээн ярвигтай шүү. Хэд, 89 тэрбум битгий хэл 1, 2 тэрбум төгрөгийн цэцэрлэг худалдаж авна гэж дүнгээ тавьчихсан. Тэгээд маш их асуудал гардаг энэ, маш их асуудал. Тухайн төсөлд зориулаад худалдаж авна гээд тавьчихдаг. Тэрний дараа маш олон төрийн албан хаагч нар хуулийн байгууллагад дуудагддаг. Тендерийн хуульд ч тийм зохицуулалт байхгүй, аль нэг объектыг

худалдаж авахаар төсөвт мөнгө тусгана гэдэг ойлголт байхгүй. Тийм учраас тэрийг нэлээн ул суурьтай хуулийн хүрээнд салбар нь өөрөө үүнийгээ эхлээд судлаад, тэрийг бодит үнэлгээг нь хийгээд, ямар хуулиар зохицуулдаг юм байгаа юм хэлж мэдэхгүй байна. Энэ бол нэг ийм асуудал шүү. Ганц эмнэлэг дээр гарч байгаа юм биш, маш олон муу жишээнүүд байгаа энэ дээр. Ийм зүйлүүд байна.

Тэгэхээр хэдүүлээ энэ эмнэлгийн хувьд үүнийг түрээслэх ч байдаг юм уу, өөр ямар бүтээлч байдлаар яамнаас нь санал гарч ирэх юм байгаа юм, тэгээд хамтраад энэ дээрээ судалцгаая. Хөгжлийн банкныг ч гэсэн оролцуулаад. Гэхдээ бид шинэ төслийг ерөөсөө орхиж боломгүй юм байна лээ. Шинэ төслөө бол ямар ч байсан ингээд гараанаас гарлаа, дэд бүтцээрээ эхэллээ. Тэр хооронд одоо байгаа эмнэлгээ ямар ч.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Энхнасан гишүүний асуултад хариулъя. Боловсролын салбар бол энэ 2025 оны урьд нь өргөн барьж батлагдсан байсан хориг тавиулахаас өмнөх төсвийн нийт хэмжээ бол 4 их наяд 422, уучлаарай 4 их наяд 574 тэрбум орчим төгрөг байсан нь одоо ингээд 152 тэрбум төгрөгөөр хасагдаж орж ирж байгаа юм, 152 тэрбумаар. Тэгээд энэ хэд хэдэн зарчим барьж байгаа. Ерөөсөө тэр багш нарын цалин, гүйцэтгэлийн үнэлгээ, хувьсах зардал, яг сургууль дээрээ очдог гүйлгэж болдог энэ зардлууд, ийм зардлууд огт хасагдахгүй. Бид энэ юунаасаа, энэ ялангуяа түрүүнд энэ яриад байна. Тэргүүн Шадар сайд ч яриад байна, энэ агентлагуудыг цомхотгох, энэ төрийн албанд цомхотгол явуулах энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Зарим нэгэн тийм өнөөдөр тэвчиж болох ийм зардлуудыг хасах замаар 150-аад тэрбумыг бүрэн хасах боломжтой гэж харж байгаа. Ер нь бол энэ боловсролын салбарт бусдаар гүйцэтгүүлэх энэ үйлчилгээ гэдэг чинь гол нь тэр хувьсах зардал эд нар байгаа, хувьсах зардал байж байгаа. Энэ зардлуудыг хасаж танаж болдоггүй юм. Тэр бол хасагдахгүй гэж ойлгож болно. Ер нь бол манай энэ салбар Тогтвортой хөгжлийн зорилтынхоо өмнө хүлээсэн үүрэг нь 20 хувь байгаа шүү дээ. Төсвийн зардлын 20 хувь хүртэл боловсролд зориулна гэсэн. Өнөөдөр харамсалтай нь 12.4 хувьтай л байгаа. Ийм нөхцөл байдалтай байгаа. Цаашдаа харин Тогтвортой хөгжлийн зорилтод хүргэх боловсролын салбарын нийт зардлыг ийм шаардлага байгаа гэж харж байгаа. Энэ тал дээр Түвшин гишүүн их зөв харж хэлж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Ер нь манай төсвийн энэ урсгал зардал өөрөө ингэж маш ихээр өсөөд байгаа нь бид хуулиар зохицуулж урсгал зардлыг нэмдэг ийм зохицуулалтуудыг өмнөх хугацаанд ингээд оруулж ирсэнтэй их холбоотой. Тэгээд энэнийх нь үр дагаврыг нь бид нар өөрсдөө ингээд хэлэлцээд сууж байгаа. Тийм учраас бол ер нь холбогдох яамнууд нь энэ хуулиар зохицуулж урсгал зардал нэмж байгаа асуудлуудыг зохицуулах ямар байдлаар үүнийг шийдвэрлэх ёстой вэ гэдэг дээр бол саналаа гаргаад, ер нь бид нар шийдээд явах ёстой байх гэж бодож байна.

Тэгээд энэ дээр энэтэй холбоотой төсөвтэй холбоотой 3 асуулт байгаад байна. 1 дүгээрт нь болохоор хувь хүний орлогын албан татварыг ирэх онд 2.9 их наяд болгож, 570 тэрбум төгрөгөөр өсөхөөр төсөвлөж оруулж ирсэн байгаа. Тэгэхээр ХХОАТ гэдэг чинь бол төрийн албан хаагчид, энэ ажил хийж байгаа хүмүүс, иргэд бүгдээрээ орж байгаа. Тэгэхээр ХХОАТ ойролцоогоор 24 хувиар өсөж байгаа юм. Тэгэхээр ямар хэмжээний хувь хүний орлогын татвар шинээр бий, татвар төлөх хүмүүс, иргэд бий болно гэж тооцсон бэ 1 дүгээрт? 2 дугаарт ер нь дундаж хүмүүсийн цалингийн орлого нь хэд нь өссөнөөс болоод хувь хүний орлогын татварыг хэдий хэмжээгээр нэмнэ гэж бодсон юм бэ? 3 дугаарт нь болохоор бол бусад орлогоо олж хувь хүний орлогын татвар төлдөг тийм байдлаар хэдэн хувийн татварыг бүрдүүлэхээр тооцсон бэ гэж бол 1 дүгээр асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нь, болохоор энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлээд, татварын зарлага гэдэг зүйл дээр бол ойролцоогоор 1.4 их наяд төгрөгийн ийм татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр тооцоолж оруулж иржээ. Энэ нь ойролцоогоор 2024 оныхоос бол 300 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэх юм байна. Тэгэхээр энэ ирэх жил бол сонсоод байхаар нэлээн татварын хөнгөлөлтийг боловсруулах үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгийн бүртгэлд орж байгаа тоног, төхөөрөмж дээр татварын хөнгөлөлт үзүүлнэ гээд олон заалтууд явж байгаа. Энэ татварын зарлага 1.4 их наяд маань ер нь 1 дүгээрт яаж тооцсон дүн бэ гэж нэг асуулт асуумаар байгаад байгаа юм?

Хоёрдугаарт нь, болохоор бол энэ татварын зарлага энэ чинь бол татварын зарлагыг бууруулах боломж байгаагүй юу гэж нэг асуулт байгаад байгаа юм? Өөрөөр хэлбэл 2024 онд 1.1 их наяд байсан юм бол одоо 1.4 болохоор чинь 300 тэрбум төгрөгийг бид нар өөр одоо урсгал зардалд юм уу, хөрөнгө оруулалтдаа, хөрөнгийн зардалдаа ашиглах боломж байсан юм биш үү гэсэн ийм 2 дугаар асуулт байгаад байгаа юм.

Гуравдугаар асуулт маань болохоор энэ тусгай сангууд. Боловсролын зээлийн сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гээд ийм, өнөөдөр Монгол Улсад арилжааны банкнууд нь, банк бус санхүүгийн байгууллагууд нь хийж чаддаг ажлыг Засгийн газрын тодорхой агентлагууд хийгээд байгаа ийм сангууд байна. Энэ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт болохоор хувийн секторын хийж чаддаг зүйлийг бол төр хийхгүй гэж тусгасан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ болохоор эдгээр 3 санг жишээлбэл Төрийн банкны үйл ажиллагаанд хамруулж болохгүй юу гэдэг нэг ийм асуулт байгаад байгаа юм 1 дүгээрт нь?

Хоёрдугаарт нь, болохоор одоо энэ дээр тавьсан байгаа энэ төсвийн зарлагын дүнгүүд болохоор бол эдгээр сангуудаар өнөөдөр баланс дээр нь байгаа дүнгүүд гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл шинээр татварын орлогоор эх үүсвэр бүрдүүлээд бий болгож байгаа дүн нь хэд вэ гэж ингэж асуумаар байна?

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье. Түрүүн Энхнасан гишүүний асуултад Л.Энх-Амгалан сайд хариулах байсан, дутуу өнгөрсөн байна, гүйцээж хариулна.

**Б.Жавхлан:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Яг тэр хууль тогтоомж, хөтөлбөр, захирамж гээд олон яг шат шатны төрийн шийдвэрээр шууд

зардлын нөлөөтэй 3.5 их наяд төгрөгийн ирэх жилийн зардлын өсөлт байна гэдгийг би дэлгэрэнгүй хүснэгтээр гишүүдэд хүргүүлсэн байгаа. Тэрийг дахин, дахин харна биз. Цаашдаа бид төсвийн зардлыг бууруулах, нэмэхгүй байх дээр энэ салбар салбарын шийдвэрийг бид нар харах ёстой байгаа. Тэндээс л энэ бүтцийн өөрчлөлт эхэлнэ. Тэндээс л энэ төсвийн шинэчлэл эхлэх юм байгаа юм. Тэд нарыгаа хийж чадах юм бол бид нар төсвийн хамгийн чанга дүрэмтэй явахад ямар ч асуудал байхгүй гэдгийг хэлье.

Хөдөлмөр эрхлэлтийн сан, ЖДҮ сан, нэг нь Боловсролын сан. Эдгээрийг Төрийн банкаар энэ ч арай болохгүй байх. Энэ бол арилжааны зорилготой ийм олгодог зүйлүүд биш. Энэ бас л Боловсролын сан гэхэд энэ чинь өмнө нь алдаа дутагдлууд гарсан. Тэрийг давтахгүй байх тал дээр сайд анхаарна байх гэж бодож байна. Цаашаагаа харин энэ чинь олгох энэ хэлбэрүүд нь төрийн бодлоготой, өөр бусад олон бодлоготой уялдах, салбар салбарын захиалгатай уялдах ийм шууд төрийн бодлого өөрөө үүгээрээ дамжиж хэрэгжих ийм учиртай зүйлүүд байгаа. Яах вэ зарим нэгийг нь хэсэгчилж юм уу, банкнудаар зээл олгодог мэргэжлийн байгууллагуудаар бол явуулж болохыг үгүйсгэхгүй. Энэ дээр сайд нар маань нарийн мэдээлэлтэй, мэдлэгтэй үүнийг хариулах болов уу гэж бодож байна. Хөдөлмөр эрхлэлтийн сан дээр Энх-Амгалан сайд хэлээдхээч, юугаар арилжааны банкаар хийж болох юм уу, болохгүй юм уу.

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд хариулт өгье.

**Л.Энх-Амгалан:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан тодорхой нэг хэсэг үүргээ гүйцэтгэсэн үү гүйцэтгэсэн. Тэгээд зориулалтууд нь нийгмийн нөгөө зорилтот бүлгүүд рүү амьжиргааг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжих энэ жижиг төслүүдийг дэмжиж явдаг ийм сан байгаад байгаа. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд, ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд гээд арилжааны банкнууд энэ хүмүүст зориулсан бүтээгдэхүүн 1 дүгээрт байхгүй.

2 дугаарт ер нь цаашдаа юу гэдэг юм энэ жижиг зээлүүдийг бид нар энэ жижиг, дунд бизнесийг дэмжих зээлүүдтэй хамтарч дундын бүтээгдэхүүнүүд гаргах, шаардлагатай бол бид нар энэ арилжааны банкнуудтай хамтарч дундын бүтээгдэхүүнүүд гаргах, инкубацийн жишээ нь 5-аас 10 сая төгрөгөөр эхлээд, тэгээд цаашаа дараагийн шат руу шилжихэд бол ЖДҮ сан, тэгээд цаашаа Зээлийн батлан даалтын сантай хамтраад ийм бүтээгдэхүүнүүд гаргаж болно Соронзонболд гишүүнээ. Энэ бол их чухал ажил хэрэгч санал байна гэж би харж байна. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Хүнс, хөдөө аж ахуйн сайд Жадамбаагийн Энхбаяр сайдад хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Жижиг, дунд үйлдвэрийн сан гэж байхгүй. Өнгөрсөн Их Хурлын үед татан буугдчихсан. Одоо Жижиг, дунд үйлдвэрийн газар гэж улсын агентлаг ажиллаж байгаа. Энэ бол яг хамгийн их ажлын байрыг бий болгож байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гадаад зах зээлд гаргах, гэрээ хэлэлцээрийг хийх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, ингээд намар болдог тэр намрын өдрүүд, ямар Хятадын, Оросын экспод, олон улсын тэр үзэсгэлэн худалдаанд оролцох гэсэн иймэрхүү бодлогын үйл ажиллагаа руугаа оччихсон. Зээл өгөөд байгаа эх үүсвэр харьцангуй үндсэндээ байхгүй. Энэ сан дээр байсан

улсын төлөх ёстой гадаад, дотоод зээлийн, Засгийн газрын бондын, Хөгжлийн банкны бүх өр зээлээ бүгдийг нь төлөөд дуусчихсан. Одоо үлдэгдэл ийм баланс дээрээ байж байгаа ийм үүрэг гүйцэтгэж байгаа агентлаг шүү дээ. Тэгэхээр ер нь сангууд байхгүй. Тариалан эрхлэлтийг дэмжих сан гээд байхгүй, Мал хамгаалах сан гээд байхгүй, Жижиг, дунд үйлдвэрийн сан гээд байхгүй. Сангуудыг нэлээн цэгцлээд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Энэ Боловсролын зээлийн санг Төрийн банк руу нийлүүлээд банк маягаар явуулчихъя гэсэн ийм санал ярьж байна. Энэ бол жоохон боломжгүй юм. Нийт зээлийн сангийн ерөөсөө 11 хувь нь яг ийм зээл байгаа юм. Боловсрол зориулсан. Бусад нь тэтгэлэг хэлбэрээр олгоод явж байгаа. Одоо багш болох улсууд, оюутны хөгжлийн тэтгэлэг эд нар гээд ийм тэтгэлэг, мөн зорилтот бүлгийн хүүхдэд зориулсан, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид олгох буцалтгүй тусламж гэх мэтийн ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр ер нь банкны яг шугамаар биш, энэ чинь аягүй нарийн шалгаруулалт явуулж байдаг ийм үйлчилгээ учраас энэ бол яг банкаар явуулах боломжгүй байдаг юм.

Энэ боловсролын бодлогод энэ нь өөрөө гажаад явчих ийм магадлалтай. Мөн яг банкаар гүйцэтгүүлэхээр өртөг нь ч нэмэгдэх ийм магадлал өндөртэй. Энэ чинь өөрөө тусдаа хуультай ийм Боловсролын зээлийн сан гээд үйл ажиллагаа явуулдаг ийм зүйл шүү. Үүнийг та бүхэн зөвөөр ойлгоорой.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын, төсвийн Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж дарга ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ХХОАТ-ыг бид нар улсын нийт цалингийн сангаас тооцдог байгаа. Цалингийн сангаас бид нар яаж тооцож байна гэхээр манайх цалин хөлсний мэдээллийн систем байгаа. Татвар дээр ХХОАТ-ын тооцоолол байдаг гэсэн үг. Харин Нийгмийн даатгалын сан дээр бас том мэдээллийн сан байгаа. Нийгмийн даатгалын сан авч байгаа улсын хэмжээний цалингийн сан. Үүн дээр бол анализ хийгээд, өмнөх онуудаас дараа онуудын өсөлтийг гаргаж ирэх, мөн тухайн оныг буюу 2024 оноо бид нар тооцдог байгаа. 2024 оны хувьд 1.7 их наяд төгрөгөөр бол ХХОАТ-ыг бид батлуулсан байгаа. Одоо эхний одоо хагас жилийн байдлаар бол ХХОАТ 1.1 нь орчихсон, 1.7-гоос 1.1 орчихсон. Өөрөөр хэлбэл 67.6 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн үг. Тэгэхээр энэ жилийн хувьд бол ХХОАТ бол бага зэрэг давалт байна гэж бол бид үзэж байгаа. Энэ хүрээндээ бол.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**М.Санжаадорж:** Энэ хүрээндээ ирэх жилийн ХХОАТ-ыг бид нар 546.9 тэрбум төгрөгөөр бол нэмэгдэнэ гэж тооцоод, 2.8 тэрбум, 8 их наяд төгрөгийг ХХОАТ дээр тооцож тавьсан байгаа. Түүнчлэн татварын хууль тогтоомжийн дагуу татварын зарлагыг бид нар тооцож тавьдаг. Энэ яг бүгд хуультай тогтоомжтой ийм заалтууд байгаа. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал бол зөвхөн Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийн дагуу явдаг. Ингээд ирэх жилийн хувьд бид нар



1.4 их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр байгаа. Нэр төрлөөр нь бол ААН-ийн орлогын татвар 600, НӨАТ 440, гааль 167, хүүгийн орлогын албан татвар 236,6 тэрбум төгрөг гэж тооцсон байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандухай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Түрүүн би хэлж байсан. Нөгөө эдийн засгийн бодит өсөлт 8 хувьтай, дотоодын нийт бүтээгдэхүүн 95 их наяд нэрлэсэн дүнгээрээ өөрчлөгдөөгүй орж ирсэн. Энэ 95 их наяд төгрөгийн 35.6 хувь буюу 33,9 бараг 34 их наяд төгрөгийн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг өөрөө бүрдүүлж байгаа. Энэ дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувьд нь яг хөдөө аж ахуйн салбар, салбараас бүрдэж байгаа вэ? Тэнцвэржүүлсэн нийт орлогын хэдэн хувь нь өөрөө хөдөө аж ахуйн салбараас бүрдэх вэ? Яагаад би ингэж асууж байна гэхээр задаргаа тооцоо хараагүй учраас тодруулах юм байгаад байна л даа. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн чиглэлээсээ энэ Засгийн газар энэ удаа ухраагүй биз дээ? Төсөвтөө оруулж ирэхдээ. Ялангуяа энэ 110 тэрбум төгрөгөөс бараг 89 тэрбум төгрөгийн урамшууллыг хасаж орж ирж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ хасаж байгаа урамшуулал чинь аль хөтөлбөрүүдээс хасагдаж байгаа юм бэ гэдгийг би холбогдох сайд нараас нэгд асууя.

Яагаад ингэж хэлж байна гэхээр бас нэг үүнтэй залгуулаад дахин өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа тодорхой зардлуудыг бууруулсан байгаа. Яг зөв зардлаа онож бууруулж, ач холбогдлын эрэмбээ зөв тогтоосон уу гэдгийг асуумаар байна. Тухайлбал сүүлийн өдрүүдэд энэ сошиал хуудсаар гараад байгаа Удирдлагын академийн үр ашиггүй зардлын талаар нэмэлт тодруулга бол авах хүсэлтэй байгаад байгаа. Жишээлбэл, Удирдлагын академийн захирал нь 30 сая төгрөгийн цалин авдаг, 400 сая төгрөгөөр кино жишээлбэл хийсэн гэх мэтчилэн ийм мэдээллүүд яваад байгаа. Энэ үнэн үү? Удирдлагын академийн үндсэндээ өмнөх зардал өөрөө 1 тэрбум төгрөгийн зардал гардаг байсан бол энэ удаа 6 тэрбум төгрөгийн зардлыг тусгасан байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар чинь эдийн засгаа эрчимжүүлье. Яг эдийн засгийг тэлэх дорвитой салбартаа тодорхой хэмжээний мөнгийг хийгээд, голлох эрчимжүүлэх төслүүдээ өөрөө бид нар хасчихсан байгаад байгаа. Энэ зайлшгүй шаардлагатай эсэх нь тодорхойгүй зардлуудаа бууруулсан эсэх дээр тодруулж асуумаар байна. Бүүр цаашлаад төрийн албан хаагчдын орон тоо яг хэд байгаа юм бэ? Энэ 226 мянган төрийн албан хаагч байдаг гэдэг тоо байгаад байдаг. Гэтэл энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс гэдэг дээр 1.9 их наяд төгрөгийн зардалд жишээлбэл боловсролын салбар, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл төлбөрийг төлж байгаа гэж би ойлгосон. Энэ яг бодитоор энэ хэдэн төрийн албан хаагч, хэдэн төрийн албан хаагчид Монгол Улсад ажиллаж байгаа юм бэ? Нэг төрийн албан хаагч хэдэн жил тогтмол ажиллаж байгаа юм бэ? Тэдгээрийг сургахад жил бүр 6 тэрбум төгрөгийг санхүүжүүлж сургаж байгаа гэж ойлгож байна. Энэ зөв үү гэдгийг холбогдох сайдуудаас асууя.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье. Дараа нь ХХААХҮ-ийн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгнө.

**Б.Жавхлан:** Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзэлж байгаа хувь хэмжээг Батхүү дарга байгаа юу? Энхбаяр дарга сайд хариулчих юм байна. Тэгээд ойлголоо. ХАА-тай холбоотой асуултыг ингэчих юм байна.

Би тэр төрийн албан хаагч нарын тоог би яг төсвийн хэллэгээр нь хэлье. Ирэх жил нийт төрийн албан хаагч нарт цалин, тэтгэвэр тэтгэмжээр дамжуулаад 226 мянган төрийн албан хаагч гэж төсөвлөсөн байгаа 2025 онд. Эндээс яг одоо орон тоон дээрээ ажиллаж байгаа нь хэд гэдэг нарийн тоонуудыг бол Хэрэг эрхлэх газраас гаргавал зүгээр байх. Тэр Академийн зардлыг энэ Хэрэг эрхлэх дээр байдаг зардал. Тэр киноны зардал энэ чинь нэлээн юм болж байгаад их олон жил яригдаж байгаад Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлээд явсан ийм зүйл. Яг өөр дээр нь байдаг зардлуудын талаарх задаргааг нь нарийвчилж хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагчаас нь сонсох нь зөв байх.

Тэдний дээр ер нь бол тэдний дээр үргүй зардал байдаг гэж би бол ерөөсөө бодохгүй байна. Илүү их тэнд сургалтын хөтөлбөрийн ийм даалгаврууд Засгийн газраас би очиж байгаа гэж бодож байна. Сүүлийн жилүүдэд ер нь дандаа тэгж байгаа. Шинэ сэргэлтийн бодлоготой холбоотой өнгөрсөн жилүүдэд ялангуяа орон нутагт нэг ч төрийн албан хаагч хоцроолгүйгээр сургалтад хамруулж байсан. Улаанбаатар хотод маш олон ийм сургалтууд явдаг. Зөвхөн тэр байшин дотроо үйл ажиллагаа явуулаад хязгаарлаад байдаггүй. Маш олон сургагч багш нарыг бэлдээд, тэд нараараа дамжуулаад маш өргөн хүрээтэй ийм сургалтын юмнууд явдаг. Тэгэхээр тэнд бол нэг айхтар хэтэрчихсэн үргүй тийм сургалт яваад байна гэж би ерөөсөө огт бодохгүй байгаа. Тэнд зүгээр нэг өөр л асуудал байгаа байх. Яг тэр зарцуулалтынх нь талаар шууд ерөнхийлөн захирагч нь хариулах нь зөв байх.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Лувсаннъямын Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Ер нь хөдөө аж ахуйн салбарын ирэх оны өсөлтийг бид нар 6.1 хувьтай байх болов уу гэж тооцож байгаа юм. 2024 онд бол -2.4 хувьтай гарах болов уу гэж. Тэгээд 8 хувийн өсөлт дотор бол хөдөө аж ахуйн салбар өөрөө 0.6 хувь хувийг эзэлж байгаа. 8 хувийг ингээд 1, 1 хувиар нь салбарууд авдаг бол 0.6 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байгаа. Ер нь Монголд нэг ийм буруу жишиг байгаад байгаа юм. Хамгийн их татаас авдаг нь явдаггүй, хамгийн их хөрийн аргаар бойжиж байгаанууд нь дээшээ яваад байдаг манай эдийн засгийн салбарууд. Тийм учраас хамгийн их анхаарал халамж тавиад байх тусам л нурмайгаад байдаг, бэлэнчлээд байдаг. Надад өгөх ёстой гэж бодоод байдаг. Хамгийн ширүүн аргаар хэн ч харж ханддаггүй нь дээшээ босож ирээд, өрсөлдөөд байдаг, бүх чадлаараа зүтгээд байдаг. Тэгэхээр бол ер нь цаашдаа бид нар хөдөө аж ахуйн салбараа яаж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хүнс, хөдөө аж ахуйн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Салбарын хэдэн тоо хэлье. Нийт Монгол Улсын нийт ажиллах хүчний үндсэндээ 50 хувь 2 хүний 1 буюу 600 мянган хүн энэ ХХААХҮ-ийн салбарт ажиллаж байна. Нийт Монгол Улсын экспортын 6.4 хувь буюу 960 орчим сая долларын экспорт хийж байна. Нийт дотоодын бүтээгдэхүүний 32 хувийг үйлдвэрлэж байгаад малын зүй бус хорогдолтой холбоотойгоор 30 хувийг үйлдвэрлэж байна. Нийт 1 их наядын зөвхөн 23-аас 2024 оны хугацаанд 1 их

наядын экспорт нэмэгдэж, 250 тэрбумын импорт багассан буюу өнгөрсөн хугацаанд хийгдсэн бодлогын арга хэмжээ үр дүнгээ үзүүлж эхэлж байгаа. Хамгийн гол нь нийгмийн тогтвортой байдлыг хангах гол хамгийн орон нутагт хүн ажиллаж, амьдрах тэр бололцоог үүсгэж байгаа тэр тогтвортой байдлыг хангаж байгаа салбар. Одоо.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Одоо бид бол экспортлогч болох зорилго тавиад явж байгаа. 2 бүтээгдэхүүн сайн явж байна, ноолуур 400 сая доллар давсан экспорт хийсэн үүнийг өсгөх бололцоотой. Одоо цагаан алтаар бид нар ноолуурынхаа угааж байгаа ноолуураа бүрэн самнаад, дотооддоо ээрэх хүчин чадлаа нэмэгдүүлбэл бид 300-гаад сая долларын нэмэгдэл олж чадна. Махны экспортын бүх зах зээлийг нээх талаар идэвхтэй ажиллаж байна. Махны экспорт амжилттай явж байна, 360 сая долларын экспортод хүрсэн байгаа. Ингээд бусад нь болохоор бусад хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, үр тариа, тосны ургамал, арьс шир гээд явж байгаа. Ер нь ойрын үед 2 тэрбум доллар болгочих ийм бололцоотой гэж үзэж байгаа. Төсвийн, төсөв 904 тэрбум төгрөгөөр төсөв батлагдсан байсан тодотгоод одоо 794 буюу 130-аад тэрбумаар багасаж байгаа. Гэхдээ энэ хуваагдлыг бид нар үндсэн хэрэгжүүлэх Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Манай яамны хэрэгжүүлэх үндсэн 4 том бодлого Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4, Шинэ хоршоо гэсэн 4 бодлого л байгаа. Эндээ аль болох жигд шингээх маягаар 130-н ачааллаа хуваагаад, тодотгол хийгээд зохицуулаад явж байна. Чамлахаар чанга атга гэж боломжийн бол эх үүсвэрүүд байгаа. Хамгийн гол нь зөв зохион байгуулаад ашиглаж чадвал үр дүнд хүрнэ. Зарчмын том өөрчлөлт бол яам хөрөнгө хуваахаасаа илүү арилжааны банкаар дамжуулаад бодит эдийн засгийн секторт нийт мөнгөний 95, 6 хувийг нь хүргэх энэ ажлыг л бид хийж байгаа. Гэхдээ энэ бол бодлогын ийм зээлүүд явна. Энэ 4 хөтөлбөрийн хүрээнд гэж ойлгоорой.

**Д.Амарбаясгалан:** Мэндсайханы Мандхай гишүүн тодруулж асууя.

**М.Мандхай:** Түрүүн тэр нөгөө Удирдлагын академитай холбоотой яг бүрэн гүйцэт хариултаа авч чадсангүй. Яагаад тэгж байна гэхээр Удирдлагын академи одоо энэ хөдөө орон нутгийн төрийн албан хаагчдыг заавал хотод авчраад, байр орон сууцаар хангаад байгаа ийм мэдээлэл бол байдаг. Энэ өөрөө зөв үү? Жишээлбэл энэ цахим орчноор жишээлбэл энэ суралцах боломжтой. Хотод байгаа төрийн албан хаагчдыг ч гэсэн цахимаар сургах боломжтой байдаг. Тэгэхээр нөгөө ерөнхийдөө тийм зөв юманд зарцуулсан байх гэдэг хариулт бол ерөөсөө хангалтгүй байгаад байгаа юм. 1 тэрбум төгрөгийн зарцуулалттай байсан байгууллага 6 тэрбум болтлоо зарцуулалт нь өөрөө нэмэгдэж байгаа нь энэний цаана яг ямар тоо яваад байгааг нь харахгүйгээр зүгээр тийм тайлбар бол үнэхээр хангалтгүй байна. Тэгээд 1 видео хийгээд байгууллагад тарааж өгч болно гэх мэт үр ашигтай зөв зарцуулалт хийх арга хэмжээг авч болдоггүй юм уу?

2 дугаарт би Эдийн засаг, хөгжлийн яамны сайдаас асуумаар байна. Бид нар уул уурхайгаас гарч байгаа татвараар бусад салбараа тэтгэж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Солонгоо байна уу? Энэ Удирдлагын академийн зардалтай холбоотой асуудлаар тодруулж орж ирж нэмэлт хариулт өгөөрэй. Ер нь төрийн албан хаагчдыг давтан сургаж байх зайлшгүй шаардлага байдаг Мандхай гишүүн. Түүнээс төрийн албанд нэг орчхоод ерөөсөө давтан сургалтад огт хамрагдахгүй явдаг гэдэг ойлголт аль ч улсад байдаггүй. Ялангуяа энэ төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх шаардлага цаг үргэлж тавигдаж байдаг учраас цаг үе, нийгмийнхээ хөгжил дэвшилтэй хөл нийлүүлж алхах, тэгээд бодлогын гүйцэтгэлийг ур чадвартай, хүртээмжтэйгээр гүйцэтгэдэг байлгах зорилготойгоор энэ сургалтыг байнга тогтмол хийж байгаа юм.

Ялангуяа Засгийн газраас барьж ажиллаж байгаа бодлого чиглэл хэрэгжүүлэх тал дээр бол энэ их тийм онцгой чухал үүрэгтэй байдаг. Зүгээр энэ зардал нь харин яг юуны зардал юм тэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тодруулаад хариулчихъя. Лувсаннъямын Гантөмөр Тэргүүн Шадар сайд нэмж хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Мандхай гишүүний хэлж байгаа ер нь энэ орж ирж байгаа мөнгөө бусад салбараа босгоход зориулахгүй юу гэдэг асуудал бол зөв. Таны зөв. Бусад салбар босгох ёстой. Тэгэхдээ зүгээр татаас хэлбэрээр яваад байхаар энэ болохгүй байна, босохгүй байна. Бид нар бүтээгдэхүүнийх нь өрсөлдөх чадварыг хэрхэн нэмэгдүүлэх тухай шинэ бодлого гаргахгүй бол цаашдаа явахгүй. Зүгээр мөнгө өгснөөр, мөнгө тарааснаар юм явдаггүй юм байна гэдгийг бид нар хатуу ойлголоо шүү дээ. Улс орон зээл авснаар хөгждөггүй юм байна гэдэгтэй яг адилхан харагдаж байгаа юм. Тийм учраас бид нар бол энэ Монголд үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүн аль ч салбарын бараа, бүтээгдэхүүнийг босгож ирэхэд өрсөлдөх чадварынх нь хөгжлийг дэмжих хөтөлбөрийг тусад нь гаргах хэрэгтэй юм байна лээ. Тэгээд энэ чиглэлээр явна. Хөдөө аж ахуйн салбар бол түрүүн Энхбаяр сая жоохон андуурсан байх, дотоодын нийт бүтээгдэхүүнд 10 хувийг л эзэлж байгаа. Цаашаагаа томрох ёстой. Энхбаяр сайдын хэлдгээр 20, 30 хувь руу очих ёстой. Энэ бид нарын Алсын хараа гэдгийг ойлгох хэрэгтэй. Нөгөө талдаа яг энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Мандхай гишүүний асуултад Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд нэмж хариулъя.

**П.Наранбаяр:** Энэ төрийн албаны энэ салбарыг асуугаад боловсролыг нэлээн сонирхоод байх шиг байна лээ. Тэгэхээр боловсролын салбарт бол нийтдээ 8860 төрийн үйлчилгээний болон захиргааны албан хаагчид ажиллаж байгаа. Үүнээс бол ерөнхий боловсролын сургуулиудад бол 53397, СӨБ-ын байгууллагуудад 31203 хүн, мэргэжлийн боловсролын сургуулийн сургалтын байгууллагуудад 2820 хүн, ингээд төрийн захиргааных нь албанд аймгуудын боловсролын газар, дүүргүүдийн, нийслэлийн тийм ээ, тэгээд энэ төв аппарат эд нарыг бүгдийг нь нийлүүлээд ТЗ буюу төрийн захиргааны 916 албан хаагч байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт болсон уу? Гантөмөр сайд нэмж хариулах уу? Тодруулга авах юм уу? Мэндсайханы Мандхай гишүүн тодруулж асууя. Мэндбаярын.

**М.Мандхай:** Эдийн засаг, хөгжлийн яамны сайд ингэж ярьж болохгүй байх. Яагаад гэхээр өмнөх үеийн урамшууллыг та бас бодоод байх шиг байна. Одоогийн энэ хөдөө аж ахуйн хэрэгжиж байгаа урамшуулал чинь өөрөө бүтэн төрийн алба биш, энэ чинь арилжааны банкаар, банкны эх үүсвэрээр гарч байгаа зээлд бид нар тодорхой хувьд нь татаас өгч байгаа. Тэгэхээр угаасаа бид нар нэгэнт үндэсний том хөдөлгөөнүүдийг хөдөлгөж байж хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлнэ гээд тодорхойлчихсон байгаа энэ хөдөлгөөнүүдийг тодорхой хувиар төр өөрөө бодлогоор санхүүгийн хувьд дэмжихгүй бол энэ өөрөө босож ирэх боломжгүй. Тэгэхээр миний хувьд бол та бас салбарынхаа хөдөө аж ахуйн салбарын энэ хөгжил хөдөлгөөний асуудлыг нэлээн сайн судалсан нь зүйтэй юм байна шүү. Энэ арилжааны банкаар дамжиж олгогдож байгаа зээл эх үүсвэр нь.

**Д.Амарбаясгалан:** Татаас өгөх, хөнгөлөлттэй зээл өгч, бизнес эрхлэх боломж олгох 2 тэс өөр гэдгийг нэмээд хэлчихье гэж бодож байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

**Ц.Идэрбат:** Гишүүддээ оройн мэнд хүргэе. Бид анх удаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын парламент 126 гишүүнтэй боллоо. Тэгээд анх удаа олон зүйлүүд давхцаж байна. Төсвөө бид нар 12 сарын 5 гэхэд эхний хэлэлцүүлгээ хийгээд сууж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч бүтнээр нь хориг тавилаа. Их Хурал анх удаа бүтнээр нь тавьсан хоригийг хүлээж авлаа. Мөн анх удаа нааштай зүйлүүд гарч ирж байгаа юм. Анх удаа төсвөө алдагдалгүй батлах ийм юм руугаа Монгол Улсын парламент, Засгийн газар ерөнхий, Засгийн газар, Их Хурал, Ерөнхийлөгчтэйгөө ингээд бүгд нэг тал руугаа ингээд харж байна гэж харж байна. Анх удаа Монгол Улсын парламент Монгол Улсын төсвийн хөрөнгийг 330 сум руу хэн нь илүү хуваах вэ гэдэг ийм уралдаан биш, Монгол Улсын цаашдын хөгжлийг хааш нь авч явах вэ гэдэг дээр бас шийдвэр гаргаж байгаа юм.

Тэгээд эцсийн дүндээ бол өнгөрсөн энэ хугацаанд чи, бидээ хүрч, чадамжтай, чадамгүйгээрээ дуудалцаж ингэж явлаа ч гэсэн өнөөдөр Монгол Улсын парламент анх удаа төсвөө энэ удаа алдагдалгүй батална, дараагийн жилүүдэд ч алдагдалгүй төсөв оруулж ирнэ гэдэг ийм зүйлтэйгээр Засгийн газар ингээд Их Хурал хэлэлцээд ингээд байж байгаа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ 126 гишүүнтэй болсон парламент тойрог болон жагсаалт гэж ингэж орж ирсэн энэ зохицуулалтууд зөв байжээ гэж харж байгаа юм.

Алдагдалгүй төсөв орж ирснээр зарим нэг зүйлүүд дээр анхаарах ёстой юм байна гэж харж байгаа. 1 дүгээрт бол зээлийн хүү буурах, манай бизнес эрхлэгчдийн гол хүсэж байгаа зүйл. Валютын ханшны тогтвортой байдал, зээлжих зэрэглэл сайжрах гээд улс орны хэмжээнд бол хүлээгдэж байгаа үр дүнгүүд нэлээн байна. Шадар сайдын танилцуулснаар бол эхний 2 дугаар улирлаас, хагас жилээс энэ үр дүнгүүд гарч эхэлнэ гэж өнөөдөр танилцуулж байна. Энэ бол их нааштай ийм зүйл.

Нөгөө талдаа Улсын Их Хурал хэдийгээр бид нар олсныхоо хэмжээнд зарцуулах ийм юманд орж байгаа ч гэсэн нөгөө улсын хөгжлийг явуулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг Улсын Их Хурлаар орж ирэхэд улс төржихгүй батлах, дэмжих, бодлогын дэмжлэг үзүүлэх ийм зайлшгүй шаардлага гарч ирж байна уу даа гэж миний хувьд бол харж байна. Яагаад гэвэл зөвхөн олсныгоо үрээд суудаг Их Хурал биш, энэ улсыг хөгжүүлэх үүрэгтэй ийм хүмүүс учраас дараа дараагийн энэ 14 мега төслүүд Их Хурлаар орж хэлэлцүүлэгдэхэд бид их нухацтай хандах



ёстой юм байна гэж харж байгаа. Эндээс төсөв орж ирж байгаа энэ ангиллуудыг харахад бол яах вэ үргэлжилж байгаа төслүүдийг нэлээн сайн явуулж дуусгана гэж байна. Тэгээд би бол Байнгын хороо, ажлын хэсэг дээр үргэлжилж байгаа төсвүүд дээр ямархуу асуудлууд байна вэ гэдгийг бол би нэлээн нухацтай үзнэ гэж бодож байгаа. Үргэлжилж байгаа төсвүүд гэдэг дотор хамаагүй зүйлүүд явж болохгүй гэж харж байгаа гэдгээ бас хэлчихье.

3 асуулт байгаа. Бид ингээд алдагдалгүй төсөв хэлэлцээд ирэхээр зөвхөн улс орны хэмжээний асуудлуудыг яриад эхлэхээр нөгөө аймаг дээр байгаа сумдад байгаа хөрөнгө оруулалтын асуудлуудыг бид нэг шийдэх орон зай хэдийгээр гарч эхлэх бол? Өмнөговь аймгийн Цогтцэций дээр сургуулийн барилга нурлаа гээд л өнөөдөр ярьж байна. Яг үүнтэй адилхан олон сумдад ийм асуудлууд хүлээгдэж байгаа учраас энэ рүү бид анхаарах бололцоо хэдийгээс гарч эхлэх болоо гэж 1 дүгээр асуулт?

2-т бол энэ төсвийн төсөл дээр тэтгэврийн нэмэгдлүүд бол орж ирнэ гэж байгаа. Энэ дээр бол би холбогдох яам нь байна, Сангийн яам байна. Бас нэлээн тодорхой мэдээлэл өгчих нь зөв байх. Ахмадууд энэ дээр бол нэлээн олон эргэлзээнүүд байх шиг байна. Төрийн албан хаагчдын цалинг инфляцтай нэмэгдүүлж уялдуулж нэмдэг энэ тогтолцоо энэ жилээс орж ирж байгаа. Энэ нөгөө өнгөрсөн жилүүдэд явсан.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт.

**Б.Жавхлан:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Үргэлжлэх төслүүд бол их чухал шүү. Үргэлжлэх төслүүдийгээ нэг эрсдэлд оруулахгүй, сунгачихгүй, сунгах тусам улам төсөвт өртөг нь нэмэгдээд, улам эрсдэлд ороод, баригдаж байх явцдаа бараг хуучраад эхэлдэг. Тийм учраас нэгэнт эхлүүлчихсэн бол бушуухан дуусгах хэрэгтэй. 20 он хүртэлх өмнө нь эхэлж байсан удсан төслүүдийг бол нэлээн цэгцэлсэн шүү. Одоо ер нь 10 жил явж байгаа, 10-аас дээш явж байгаа төслүүд ер нь тун цөөрсөн. Сүүлийн жилүүдэд эхлүүлсэн төслүүд бол ингээд 3 жилд хуваагаад тавьдаг, яг үүнийгээ бол бариад явж байгаа. Үүнийг бол маш хариуцлагатай хэлье. Тийм учраас бушуухан үүнийг дуусгах тусам дараагийн орон нутагт хийгдэх шинэ хөрөнгө оруулалтуудын орон зай нээгдэнэ гэсэн үг. Тэгэхээр үүнийгээ бушуухан дуусгах хэрэгтэй.

Мэдээж ингээд нэг жилдээ бид Бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалаар хөрөнгө оруулалтуудаа нэг туршаад, туршаад юу байх вэ энэ бодлогоо хэрэгжүүлж эхэлж байна. Мэдээж 2026 оноос 2027 онуудаас орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтууд төсвийн ямар боломж байх нь вэ. Гэхдээ төлөвлөлт дээрээ бид нар нэлээдгүй өөрчлөлтүүд орно. Тэрийг одоо юу гэдэг юм нэг хувь хүний эрэмбэ үзэмжээр биш, гишүүд уучлаарай энэ дээр. Тийм учраас ерөөсөө салбар салбарын яг big data дээр суурилсан, олон жилийн судалгаа, хэрэгцээ шаардлагыг маш ил тод, шударгаар эрэмбэ, тэр хүчин зүйлүүдийг нь тавьж байгаад хаана, ямар хэрэгцээтэй байгаа юм. Жишээ нь сургууль гэхэд хүн амынх нь өсөлттэй нь уялдуулна, тэнд нь одоо байгаа сургууль, цэцэрлэгийнх нь насжилттай нь уялдуулна, хамран сурагдалтынх нь коэффициенттой нь уялдуулна, боловсон хүчнийх нь боломжтой нь уялдуулна гэх мэтчилэн маш олон өгөгдлүүдийг хийж байгаад л яг тэр үзүүлэлтүүдээр нь эрэмбэлээд л номер нэг хаана ямар сургууль хэрэгтэй байна, номер нэг хаана цэцэрлэг хэрэгтэй байна яг тэрүүгээр л ингээд явна.

Цэцэрлэг, сургууль, дотуур байр, эмнэлэг төсвөөс хийгддэг бүх хөрөнгө оруулалтууд, сумд дээр ч гэсэн соёлын байгууллагууд, спортын байгууламжууд гээд бүгд яг ийм шалгуураар бараг л AI-ээр хийхээр төлөвлөж бэлтгэл ажил хангаж байгаа шүү гэдгийг хэлье. Болсон байх.

**Д.Амарбаясгалан:** Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууя.

**Д.Бум-Очир:** Гишүүддээ оройн мэнд хүргэе. Төсөв дээр нэг асуудлыг яриад байгаа, надаас өөр олон гишүүд ч ярьж байгаа. Эрэмбийн тухай асуудал. Эрэмбийг зарим талаар бол сайхан баримталжээ. Яамдаас 10 орчим хувийг танасан бололтой. Саяын тайлбарыг сонсож байхад Боловсролын яамнаас 7 хувийг танаж, боловсрол чухал гэдэгт ач холбогдол үзүүлж байгаагаа илэрхийлсэн байгаад баяртай байна. Гэхдээ цаг хугацаа бага байсан болоод тэр юм уу, зарим тал дээр энэ чухлын эрэмбээ нэг л сайн бариагүй зүйл харагдаж байна. Боловсролын салбараас 152 тэрбумыг танасан, түүний тодорхой хувь нь би эндээс уншъя, ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт 58 тэрбум 145 сая төгрөг, сургуулийн өмнөх насны боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилт 27 тэрбум, 735,5 тэрбум буюу нийтдээ 85 орчим тэрбум. Нийт энэ боловсролын салбараас танагдаж байгаа 52, 152 тэрбумын 60 орчим хувь байгаа.

Үүнийг түрүүн лавласан, тэгээд ямар тайлбар ирсэн бэ гэхээр багш нарын энэ гүйцэтгэлийн үнэлгээг бол 2025 оны хориг тавиулдаг төсөл дээр нэмж байснаа буцаагаад тодорхой хувиар буулгаад, танасан юм байна. Энд бол би бас жаахан сэтгэл гонсгор байгаагаа илэрхийлмээр байна. Бидний чухал салбар. Багш нарынхаа гүйцэтгэлийн үнэлгээг нэмж байсан бол тэрнээсээ буцаад жаахан буурсан нэг ийм зүйл гарч ирж байна. Энэ бол миний бол яриад байгаа нөгөө чухлын эрэмбэд дээгүүр байр эзлэх ёстой зүйл байсан болов уу.

Гэтэл үүнтэй харьцуулаад би нэг зүйлийг дурдмаар байна. Сангийн сайдын төсөв дотор Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл гээд 20 тэрбум тавьчихсан байгаа. Энэ багш нарын гүйцэтгэл чухал юм уу, энэ дүүжин тээвэр чухал юм уу гэдгийг бид бодмоор. Уг нь бол би бол дүүжин тээврийг сайн ойлгохгүй байгаа шүү. Үнэхээр энэ Улаанбаатар хотын түгжрэлд бодитой хувь нэмэр оруулах юм уу, үгүй юм уу гэдэг нэг ийм зүйл байгаа юм.

Цаашлаад үргэлжлүүлээд энэ эрэмбийн тухай асуудал ярихаар Соёлын яамны төсвөөс 10 биш, 12.6 хувиар таналт хийжээ. Маш олон хуулиудыг нь өөрчлөхөөр орж ирж байна. Нөгөө Кино урлагийг дэмжих тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль гэх мэт. Нэг зүйлийг хэлье. Монгол соёл байхгүй бол Монгол хүн байхгүй шүү нөхөд минь ээ. Энэ соёлын нэг тэр ваучер энэ тэр гэсэн юмаар соёлын салбар луу сүүлийн үед жаахан, жаахан дайраад, ингээд хамаагүй танаж болдог юм шиг ийм нэг юм байгаад байгаа юм. Тийм юм байхгүй шүү. Монгол соёл байхгүй бол Монгол хүн ч байхгүй, Монголын ард хүн ч байхгүй, Монгол Улс ч байхгүй шүү. Тэгэхээр энэнээс битгий юм харамлаарай гэдгийг би хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл намайг ингээд ярихаар 2 салбар ярьчихсан учраас салбараа өмөөрлөө гэх байх. Би салбараа өмөөрөөгүй. Монгол Улсын Их Хурлын хүн төвтэй бодлогыг өмөөрч энэ үгийг хэлж байна гэдгээ би хэлмээр байна. Хүн

төвтэй бодлого төвд нь Монгол хүний эрүүл мэнд, боловсрол, соёл байгаа шүү гэдгийг хэлье. Тэргүүн Шадар сайд түрүүн 126 гишүүн нэг өнгөөр дуугар гээд байна. Бид нэг өнгөөр дуугарч болохгүй. Нэг өнгөөр 126 гишүүн дуугарах боломж ч байхгүй. Хэрвээ дуугарвал энэ бол ардчилал биш, коммунизм болох байх гэдгийг би хэлмээр байна. Тийм учраас бид 126 өнгөөр дуугарсан хэвээрээ байх болно, тэгж байж энэ парламентын ардчилал ардчилсан зарчмаараа явах болов уу гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Үг хэлчихлээ. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

**Д.Үүрийнтуяа:** Эрхэм гишүүдэд оройн мэнд хүргэе. Бид сүүлийн 2 сар төсвийн хэмнэлтийн тухай ярилаа, нэлээн мэтгэлцлээ. Засгийн газар Ерөнхийлөгчийн тавьсан хориг, Улсын Их Хурлаас өгсөн үүрэг чиглэл гэж төсвөө 1.9 их наядаар бууруулж орж ирлээ. Тэгээд бид ер нь төсвийн хэмнэлтийг юунд хийх ёстой юм бэ гэдгээ олж хармаар байгаа юм. Би энэ хөрөнгө оруулалтын асуудал дээр бол барьсан зарчим дээр шилжиж байгаа ажлыг огт хөндөхгүйгээр явсан. 2025 онд шилжиж байгаа ажил дээр ямар нэгэн төсвийн магадлалаар нэмэгдсэн дүн байхгүй гэж Сангийн яам бол мэдэгдэж байгаа. Харин 2022, 2023, 2024 өмнөх онуудад эхэлчихсэн тухайн жилүүдэд магадлалаар өсчихсэн хөрөнгө оруулалтын төсвийн талаар бид ерөөсөө авч хэлэлцэхгүй байгаа юм, авч үзэхгүй байгаа юм.

Тэгээд дээрээ ганцхан хөх тэнгэртэй төсөвчид үүнийг баталчхаад, тавихаас өөр аргагүй гэдэг ийм зүйлийг яриад байдаг. Барилгын тухай хуулийн 34.1.10 барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг. Энд эксперт хийж байгаа экспертүүдийг сонгон шалгаруулах журмыг, өрсөлдөөнийх нь журмыг, мөн энэ эрхийг нь олгож байгаа хүн бол одоо Батсуурь сайд маань байх нь. Таны хариуцаж байгаа, эрхэлж байгаа асуудлын хүрээнд байна. Эдгээр экспертүүдэд ямар шаардлага, шалгуур тавих вэ, өрсөлдөөнийг ямар журмаар зохицуулах юм бэ гэдэг журмыг сайдын тушаалаар батлах ийм хуультай. Өнөөдөр энэ экспертүүд маань үнэн бодит ажиллаж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр надад хэд хэдэн баримттай эргэлзээ факт байгаа юм.

Ганцхан жишээ хэлье. Энэ удаагийн төсөв дээр оруулж ирсэн Шинжлэх ухааны академийн цогцолбор байгаа. 2020 оны төсөвт өртөг нь 94 тэрбум. Ерөөсөө хоёрхон жилийн дотор 60 тэрбумаар магадлал орчихсон. 60 тэрбумаар, орчихсон байна. Ороод тэр нь орж ирсэн гэнэ. Сангийн яамны оруулсан магадлалтай төсвөөр гэж байгаа шүү. Яг энэ хөрөнгө оруулалтын төлөвлөгөө дээр Баянзүрх болон Чингэлтэй дүүрэгт адилхан 240 хүүхдийн ортой цэцэрлэгийг хуучныг нь буулгаад шинээр барьж байгаа. Энэ хөрөнгө оруулалтын ажил гэхэд 2022 онд нэг нь 3.6 тэрбум, нэг нь 2.9 тэрбумаар батлагдаад, магадлал нь нэг нь 46 хувиар нэмэгддэг, нэг нь 2.3 дахин нэмэгддэг.

Тэгээд би бодит жишээ гэдэг нь Эрдэнэт үйлдвэр дээр ковидын үед яг ийм нөхцөл байдал үүссэн юм энэ улс орон даяар үүссэн асуудал. Ажлын хэсэг гаргаад магадлалаар орсон энэ төсвүүд дээр хөндлөнгийн олон улсын аудит ажиллуулаад, зөвхөн 5 ажлыг, хамгийн өндөр дүнтэй 5 ажлыг аваад үзэхэд 120 тэрбум төгрөгийн ажлаас 51 тэрбум төгрөгийг хэмнэсэн. Үндсэндээ 40-өөс 50 хувийн нэмэгдэл энэ төсвийн магадлал дотор яваад байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр Шинжлэх ухааны академийн энэ 60 тэрбумын өсөлт гэхэд бид нар юу хийж болох мөнгө юм

бэ. Өнөөдөр нөгөө ад үзээд л байгаа соёлын асуудал дээр ваучер гэж тараалаа гээд л ад үзээд байгаа. Тэр ваучерыг чинь 3.5 дахин үржүүлсэн хэмжээний зардал нэг төсөв дээр л нэмэгдэж байна шүү дээ.

Цалинтай ээж 50 мянган төгрөг, цалинтай ээж гэж нэрлэлээ гээд л манай 0-3 насны хүүхдүүдээ гэртээ хариад сууж байгаа ээжүүд бухимдаад л, цалин хөлсний хэмжээнд хүргээд өгөөч л гэдэг. Сард 500 мянган төгрөг өгье гэвэл жилд 67 мянган шинээр хүүхэд төрж байгаа юм. Энэ 67 мянган хүүхэд гаргасан ээжид сард 500 мянгаар бодоход бүтэн 2 сарын мөнгийг зөвхөн нэг ажлын үнийн өсөлтөөсөө л шийдэж байна шүү дээ. Тэгэхээр бид нарын цаашдаа төсвийн өсөлт юунаас болоод байгаа юм бэ гэдгийг анхаарах зүйл чинь яг энэ асуудал байгаа юм биш үү. Энэ асуудлаа олж харахгүйгээр төсвийн өсөлтийг хязгаарлах боломж бид нар өөрсдийнхөө урсгал зардал, өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг, төрийн албан хаагчдын цалин хөлсөнд орохдоо хүртэл тулаад ингээд явж байх нь байна шүү дээ. Тэгэхээр үүнийгээ хэдүүлээ нэг өөр өнцгөөс харвал яасан юм бэ? Энд Батсуурь сайд маань ямар хяналт, ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа юм бол? Даргаа 1 минутаа үргэлжлүүлээд авчихъя.

**Д.Амарбаясгалан:** Батсуурь сайд хариулт өгье. Үүрийнтуяа гишүүн минут нэмж авч, асуултаа гүйцээе гэж байна.

**Д.Үүрийнтуяа:** Тэгэхээр зэрэг энэ бол эрх олгож байгаа субъект хяналтаа хэрэгжүүлэх нь зүй ёсны хэрэг юм. Тэгэхээр энэ экспертүүд дээр энэ хяналт хэрэгжүүлэх асуудал дээр та ямар байр суурьтай ажиллаж байна вэ? Энэ төсөвт нэмэгдэж байгаа нэмэгдлийн асуудал дээр ямар тооцоо судалгаа байна вэ? Өнөөдөр би нэгтгэсэн дүн авъя гээд Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төв, Зам тээврийн төв энэ 3 төв рүү, Сангийн яам руу албан бичиг явуулсан. Одоогоор надад Барилга хөгжлийн төвөөс бусад нь ирээгүй байна. Барилга хөгжлийн төвийнх дөнгөж сая ирж байна. Тэгэхээр нэгтгэсэн дүн гаргаад энэ дээр тодорхой дүнгүүдийг харах нь зүйтэй байх гэж бодож байна. Нөгөө 2 хөгжлийн төвийн хувьд надад тооцоо, судалгаа бодит баримт байхгүй учраас би энд тодорхой тоо хэлж мэдэхгүй байна. Энэ дээр сайдын зүгээс ямар бодлого барьж байгаа вэ гэдгийг сонсьё.

**Д.Амарбаясгалан:** Батсуурь сайд эхлээд хариулт өгье.

**Ж.Батсуурь:** Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр хөрөнгө оруулалт бол ганцхан Барилгын хөгжлийн төв биш л дээ. Эрчмийн чиглэлийн том, том хөрөнгө оруулалт бол Эрчим хүчний төв дээрээ, зам бол маш их том хөрөнгө оруулалт эзэлдэг Замын хөгжлийн. Тэгэхээр тэр талыг бол би мэдэхгүй.

Ер нь сая Жавхлан сайд ч хэллээ, Гантөмөр сайд ч хэллээ. Хөрөнгө оруулалтыг удаашруулахгүй байх арга хэмжээг Засгийн газар авах ёстой. Тэр ч агуулгаараа 3 жилээс хэтрэхгүй байх хугацаанд тухайн хөрөнгө оруулалтыг дуусгах арга хэмжээг өмнөх парламентаас авсан. Энэ бол үр өгөөжөө өгсөн. Дээр нь та 2022, 2023 оны, 20-иод оны юмнууд ярьж байх шиг байна. Өнгөрсөн хугацаанд ийм асуудлууд гарч байсан уу гэвэл гарч байсан юм билээ. Гарч байсан юм билээ. Одоо Барилгын хөгжлийн төв дээр бид нар шинэчлэл, ажлын хэсэг гаргаад, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах боломжуудыг бол эрэлхийлж байна. Цаашид бол манай Барилгын хөгжлийн төв дээр барилга талаасаа бол ийм зүйл гарахгүй байх бүрэн боломжтой гэж үзэж байна. Эрчим хүчний хөгжлийн төв,

Замын хөгжлийн төвийг бол ямар байдгийг салбарын сайд нараас нь та тодруулах нь зөв байх гэж бодож байгаа юм.

Ер нь хөрөнгө оруулалт удааширна гэдэг нь өөрөө асуудал үүсгэдэг. Сая одоо бараг барьж байх явцдаа болохгүй болдог энэ тэр гэж ингэж ярьж байна шүү дээ. Тэгэхээр өмнөх парламентад бол 17, 18, 19 оны хөрөнгө оруулалтуудыг үндсэндээ цэгцлээд дуусаж байгаа шүү дээ. Үндсэндээ цэгцлээд дуусаж байгаа. Харин одоо энэ төсвийн хэмнэлттэй холбогдуулаад шилжиж байгаа барилгуудыг 2024 оны хөрөнгө оруулалтыг тавихгүй байгаа нь бол харамсал төрүүлж байгаа юм. Яагаад вэ гэхээр энэ цэгцэрч байсан хөрөнгө оруулалтуудыг дахиад уналтын хэлбэр лүү оруулах нэг хэлбэр болж байна. Гэхдээ одоо нэгэнт төсвийг алдагдалгүй болгоно, хөрөнгө оруулалтыг танана гээд ингээд орж ирж байгаа болохоор бүгдээрээ шийдэж байгаа болохоор үүнийг ялтай билээ.

Ер нь бол миний хувь гишүүний байр суурь бол төсвийн тэлэлтийг авах, хөрөнгө оруулалтыг хийж энэ дуусаагүй барилгуудыг богино хугацаанд дуусгах энэ асуудлыг цэгцлээд, цаашид энэ алдаа гаргахгүй байх асуудлыг бол манай яамны зүгээс бол онцгой анхаарч ажиллана. Зөвшөөрөл болон төлөвлөлт, хяналттай асуудлуудыг бол ойрын хугацаанд цэгцэлчихнэ. Энд бол гол үүрэг гүйцэтгэх зүйл бол Барилгын тухай хууль байж байгаа. Үүнийг бол хаврын чуулганд бид нар өргөн барих гээд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

**Д.Үүрийнтуяа:** Би 3 хөгжлийн төв байгааг мэдэж байгаа. Би танаас зөвхөн Барилга хөгжлийн төвтэй холбоотой асуудлыг асууж байгаа. 2024 оны 9 сард магадлагдсан Дундговь аймгийн театрын барилга 2012 онд анхны зураг төсөв 4 тэрбумаар хийгдсэн. Тэгээд одоо энэ чинь 10 тэрбумаар хийгдсэн уучлаарай, театрын 850 суудалтай театрын барилга. Сая 32 тэрбум болж нэмэгдсэн байна лээ. Яг ийм 850 хүнтэй театрын барилгыг Багануур дүүрэгт сая 9 сард тендер зарлаад 17 тэрбумаар гүйцэтгэгч сонгон шалгарсан байгаа юм. Үндсэндээ 2 дахин нэмэгдэж байна гэдэг юм харагдаад байгаа юм. Тэгэхээр ийм зүйл дээр бас 1 дүгээрт анхаарах хэрэгтэй байгаа юм.

2 дугаарт Гантөмөр сайд маань Эдийн засгийн хөгжлийн сайд энэ хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дээр ер нь яаж хяналт тавьж ажиллах ёстой юм бэ? Гүйцэтгэл нь гараагүй дутуу хаячихсан баахан компаниуд байна. Хөрөнгө оруулалтаа хаяад явчихсан. Одоо түрүүн Ганбаатар гишүүн асууж байсан. Цэцэрлэг, юу сургуулийн барилгын асуудал. Цогтцэцийн сургуулийн барилгын.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Өмнөх хэлэлцүүлгийн үеэр Засгийн газарт үүрэг өгсөн байгаа Улсын Их Хурал дээр. Тэнд юу байсан бэ гэхээр энэ сая оруулж ирж чадаагүй, багтаагүй үнийн өсөлтүүдийг нэг бөөгнүүлээд Их Хуралд танилцуулаарай гээд. 2022 оны 12 сард 81 дүгээр тогтоолоор ингэж Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгөөд, бид нар 2 жил, 3 жил дараалаад энэ яг ковидын үеийн үнийн өсөлт үеийн энэ ялангуяа энэ төслүүдийг зогсоохгүйн талаас, эрсдэл учруулахгүйн талаас нэлээн цэгцэлсэн юм. Тэгсэн ч гэсэн дуусахгүй байгаад байна. Ялангуяа энэ 22, 23, бүүр 22 онд хийгдсэн ТЭЗҮ,



зураг төсөвтэй төслүүдийн үнэ өртөг бас л нэмэгдээд байна. Тэгэхээр тэрийг аудитаар хийлгээд, аудитаас цааш өөр хаашаа аваачих вэ? Ямар ҮХЦ рүү.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

**М.Бадамсүрэн:** Ирэх оны төсвийг дахин өргөн мэдүүлснийг хэлэлцэж байна. Ер нь төсвийн бодлого гэж юу вэ гэж. Мэдээж Монгол Улс гэдэг нэг айл гэвэл айл бүрийнхээ өрх айлынхаа хөгжлийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах энэ чиглэл рүү гол бодлого явна гэж ойлгож байгаа. Ер нь ямар ч айлын аав хүн бол хүүхдийнхээ боловсрол, цалин, орон сууц, хувийн аж ахуй эрхлэх, нэмэлт орлого олох боломж гээд энэ зүйлийг дэмжинэ л дээ. Ер нь хөгжлийн түвшнээсээ үл хамаараад аль ч улс орон ахмад, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гээд эдгээр хүмүүсээ бол дэмжинэ, тэтгэнэ. Бусад хөдөлмөрийн насны хүмүүс нь бүгд ажил хөдөлмөр хийх, хувийн аж ахуй эрхэлж орлого олох, өрх гэрээ авч явах энэ бодлогыг л бүрдүүлэхийг зорьдог.

Төрийн албан хаагчдын тоо олон байна гээд байна бараг 230 мянга болж байгаа юм уу даа энэ тоо дүнгээр. Хувийн хэвшилд яаж ажлын байр гаргах вэ гэдэгт л манай Монгол төрийн бодлого чиглэх ёстой шүү дээ. Энэ хүрээндээ хувийн хэвшлийг дэмжихийн тулд дэд бүтцээр дэмжих ёстой. Дэд бүтэц бол ингээд орон нутагт нэн чухал хэрэгтэй байгаа юм. Ялангуяа зах хязгаар аймаг, сумдад. Тэнд чинь бараа, бүтээгдэхүүний үнэ маш өндөр байгаа. Энэ өндөр байгаа дүнг яаж бууруулах вэ, хүнсний барааны барааг тээвэр, логистик, боомтын хүндрэл, валютын ханшийн өсөлт гээд олон зүйлээс шалтгаалж байгаа. Тэгэхээр энэний нэг гол хүчин зүйлийг арилгахын тулд л энэ дэд бүтцийн хөгжлийг түргэтгэе гэдэг зорилт тавьсан шүү дээ.

Тэгээд далайд гарцгүй орны хувьд бол энэ тээврийн зардалд хамгийн их өртөг эзэлж байгаа юм. Энэ үүднээсээ дэд бүтцийн төслүүдээс томоохон замын ажлууд бол энэ дахин өргөн мэдүүлж байгаа төсвүүд хасагдсанд бол би бол маш их сэтгэл дундуур байна. Яах вэ хойшлуулж байгаа гэдэг томъёолол орж ирж байгаа. Ирэх оны төсөв дээр үүнийг орж ирэх байх гэдэгт найдаж байна. Ялангуяа манай зүүн бүс нутаг гэхэд түүхийн аялал жуулчлалын бүс нутаг гээд төрөлжсөн бүс нутаг. Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд юу гол хийх вэ мэдээж дэд бүтэц. Нисэх онгоцны буудал, хатуу хучилттай авто зам, боомт гээд энэ зүйлүүд маань хойшилж байна л даа. Яагаад гэвэл дэд бүтцийн ажлууд чинь хойшлох нь их уршигтай. Нөгөө 3, 4 жилийн хугацаанд хэрэгжиж байж энэ чинь ашиглалтад орно, тэгээд үр дүн нь гарна. Тэгээд өөр хойшлуулж болох зүйлүүдийг уг нь хойшлуулсан бол их сайн байсан юм.

Хувийн хэвшлээ дэмжих нөгөө нэг зүйл бол хөнгөлөлттэй зээлийн бодлого. Түрүүн Их Хуралд энд бас төсөв анх өргөн барьсан төсвийг хэлэлцэж байхад манай Хөдөө аж ахуйн сайд хэлж байсан. Энэ ЖДҮ-лэлийн газар чинь ажилгүй болох гээд байна. Тэгэхээр энэ сангийн мөнгө нь 59 тэрбум төгрөг байх ёстой гээд. Тэгээд санал хураалтаар Их Хурлын гишүүд Байнгын хороон дээр дэмжсэн, үүнийг бол хүүгийн татааст өгье гэсэн бодлого ингээд унасан л дээ. Тэгэхээр өнөөдөр сайдын хувьд энэ зөвхөн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа агентлаг юм гээд аягүй зөв хариулж байна. Өнөөдөр бол зөв хариуллаа Энхбаяр сайд.

Яагаад гэхээр энэ бол зээл олгодог байгууллага биш, Жижиг, дунд үйлдвэрийн газар бол жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлдэг газар байх ёстой гэдгийг бид бүгдээрээ ойлгох хэрэгтэй. Үүнийг дэмждэг, сургалт хийдэг, гадаад, дотоодод дэмжлэг үзүүлдэг. Тэгэхээр цаашдаа ингэж төр зээл олгодог байдлыг таслан зогсоох, харин энэ цагаан алт, хүнсний хувьсгал гээд энэ бодлогуудыг бол 100 хувь дэмжиж байгаа. Иргэдийг бизнес эрхэлье гэхээр Монгол хүмүүс чадна. Ганцхан дутагддаг вэ гэхээр хөнгөлөлттэй зээл олдохгүй л байгаа шүү дээ. Яг бодит амьдрал дээр. Хөрсөн дээр буугаад үзэхэд. Энэ нь хөнгөлөлттэй зээл олголоо гэхэд ингээд эргээд төлөгдөхгүй гээд байгаа юм. Энэ чинь 400 тэрбум төгрөгийн зээлд 40 тэрбумыг эх үүсвэр болгоод гаргахаар 10 хувийн татвар ороход л.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмэлт 1 минут өгье Бадамсүрэн гишүүнд.

**М.Бадамсүрэн:** Энэ ийм учиртай юм. Тэгэхээр энэ эдийн засгийг маш сайн бодож ойлгож, эцсийн дүн нь өрх айлдаа яаж орлого нь нэмэгдэж, зарлага нь буурах вэ, ирээдүйдээ яаж итгэлтэй амьдрах вэ гэдэг зүйлийг бодох ёстой. Иргэдэд өөрсдөд нь боломж олгох ёстой, иргэдэд өөрсдөд нь хариуцлага үүрүүлэх ёстой, иргэдэд өөрсдөд нь энэ төрөөс халамж гэхээс илүүтэй бизнес эрхлэх боломжийг нь бүрдүүлэхийн тулд бидний бүх бодлого чиглэх ёстой. Энэ зүйлээсээ танаж байгаа, энэ зүйлийг дэмжихгүй байгаад бол би гишүүнийхээ хувьд бол маш их гомдолтой байгаа. Яагаад гэвэл сонгуулиар бүх намууд амласан шүү дээ. Иргэдэд хөнгөлөлттэй зээлийн бодлого хэрэгжүүлнэ гээд. Тэгээд энэнээсээ яагаад ухарсан байдалтай байгаа юм бэ гэдэгт л их гайхаж байна.

Тэгээд дараагийнх нь орон нутгийн төсөвтэй холбоотой. Энэ дээр бол суурь өөрчлөлт хийх хэрэгтэй. Одоо нас биед хүрсэн хүүхдээ ингээд боломжийг нь олгох хэрэгтэй шүү дээ. Тэрэнтэй адилхан орон нутагт боломж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн Шадар сайд Лувсаннямын Гантөмөр сайд хариулна.

**Л.Гантөмөр:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Бид нар аль нэг салбарыг бодлогоор боомилох, аль нэг бодлогыг бодлогоор зогсоох гэдэг ч юм уу тийм зүйл энэ Төсвийн шинэ хуулиа боловсруулахдаа тийм зүйлийг хийгээгүй. Үнэхээр төсвийг хэмнэ, алдагдалгүй болго гэдэг шийдвэрийг Их Хурал гаргасан. Энэ бодлого эргэлзээгүйгээр Засгийн газарт ийм үүрэг өгөгдсөн гэж бид харж байгаа. Жишээлбэл, тухайн үед ямар санал гараад, цаашаа явсан бэ гэхээр зардлаа 15 хувиар бууруул гэсэн. Боловсролын салбарын зардлыг 15 хувиар бууруулсан бол боловсролын салбараас гэхэд 600 тэрбум төгрөг хасах учиртай болж байгаа. Энэ удаа 150-г хасаад ороод ирэхээр та нар ямар их хасдаг юм бэ гэдэг ийм яриа гарч байгаа юм.

Тийм учраас яагаад энэ төсөв өргөн баригдсан бэ гэдэг дээрээ та бүхэн бодлогоо гаргаач гэж байгаа байхгүй юу. Их Хурал ажлын хэсгээ түрүүн Их Хурлын дарга хэлсэн. 2 өдөр сайн ажиллуулаад, бодлогоо гаргаад, ингээд нэгдсэн шийдэлд хүрмээр байна. Түүнээс биш та бүхэн одоо орж ирэхээр Засгийн газар яагаад энэ хөнгөлөлттэй зээлийг унагачхав, яагаад орон сууцын санхүүжилт алга болчхов, яагаад тэр ингэв гэдэг ийм зүйлийг яриад байх юм уу. Энэ П.Сайнзориг гишүүн, Б.Батжаргал гишүүн гээд яг байгаа байдлыг байгаагаар нь дүгнэж байгаа гишүүд их олон байна шүү дээ. Тэгээд та бүхнийг би бол байгаа зүйлээ байгаагаар

нь хүлээж аваад, ажлын хэсгээ сайн ажиллуулаад, төсвөө батлаач л гэж хүсэж байгаа юм. Түүнээс биш ямар нэгэн байдлаар аль нэг салбарыг хорлох, унагах, багасгах тийм бодлого энд байхгүй.

Ер нь Засгийн газрын зорилтыг бол бүрэн хэрэгжүүлнэ. Энэ дээрээ бид нар бол хатуу байгаа, бууж өгөхгүй. Тийм учраас энэ жил, ирэх жилд бол жишээ нь Улаанбаатар хотын түгжрэлийг арилгах, орон сууцын дэд бүтцийг сайжруулахад бид нар хангалттай хөрөнгө зарж байгаа. Бид нэг ч гэсэн асуудлыг шийдэхийн төлөө байгаа. Таны хэлж байгаа зүүн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг бид заавал шийдэх хэрэгтэй. Хэрхэн, хэзээ, яаж вэ. Хөдөө аж ахуйн салбараа босгож ирэх асуудлыг заавал шийдэх хэрэгтэй. Хэрхэн, хэзээ, яаж вэ. Их Хурал бодлогоо гаргана. Их Хурлын анхны бодлого бол бидэнд хөтөлбөр баталж өгсөн, төлөвлөгөө баталж өгсөн, төсвийг хэмнэ гэсэн, тана гэсэн. Бид хэмнэсэн, танасан. Одоо энэ дээр бодлогоо гаргаад өгөөч л гэж байгаа юм.

Түүнээс та бүхэн маань ингээд 2 тал болоод ч юм уу, аль нэг салбар луу хандаад, аль нэг бүсээ төлөөлөөд ингээд мэтгэлцэхийг бол тоглоом энэ бол одоо бидэнд тийм цаг хугацаа байхгүй. 4 сар ярьсан. Энэ төсөв батлагдлаа гээд аль нэг салбар уначих юм бол байхгүй. Улс орны эдийн засаг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

**Б.Мөнхсоёл:** Оройн мэнд. Олон гишүүдээс асуулт асуучихсан, зөндөө хариулт сонслоо. Аль болохоор давхцахгүйг хичээе. Тэгээд энэ олон гишүүдийн хэлсний дараа дүгнээд үзэхэд цаашдаа энэ төсөвтэй холбоотой асуудлууд дээр бид нар 1 дүгээрт нь цаглавар цаг хугацаа хангалттай байх, дэс, 2 дугаарт нь эрэмбэ, дэс дараалал бүх зүйл дээр зөвхөн хөрөнгө оруулалтын төслүүд биш, хэлэлцүүлэг дээр ч гэсэн хэрхэн оролцох дээр тэр эрэмбэ дараалал, тэгээд хамгийн гол нь оролцоо энэ 3 зүйл чухал юм болов уу гэж бодож байгаа. Оролцоо дээр энэ чиглэлээр ажилладаг экспертүүд, судлаачдын үг, олон нийтийн хэлэлцүүлэг энэ тэр чухал байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газрын гаргасан энэ тайлангуудыг ер нь маш сайн хэлэлцдэг байх энэ горимын саналыг анхнаас нь тавьсаар ирсэн. Сая ч гэсэн богино хугацаанд нэг шөнийн дотор, 1, 2 өдрийн дотор тайлангууд, дүгнэлтүүд гаргасан байна. Тэндээс нэг зүйлтэй онцлон дурдаад, санал нэг байгаа илэрхийлэх гэсэн юм. Тэр нь юу вэ гэхээр эдийн засгийн ангилал дээр бүтцийн өөрчлөлт хийе гэдэг энэ санал. Өөрөөр хэлбэл бид нар төсвийн анхны хэлэлцүүлгээс өгсүүлээд, нийгмийн даатгалын шимтгэл чинь татвар биш дээ гээд нийт социал сүлжээ дээр яригдаад эхэлсэн шүү дээ. Тэгэхээр яг энэ Олон улсын валютын сангийн Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлагын 14 гээд энэ гарын авлагын стандартын дагуу нийгмийн даатгалын шимтгэлээ тусад нь гаргавал яасан юм бэ гэсэн энэ боломжтой юу гэсэн асуултыг Жавхлан сайдаас асуумаар байна. Энэ удаа биш л дээ, дараагийн удаа. Одоо бол нэгэнт ингэж яваад батлагдана шүү дээ.

Хоёрдугаарт нь, энэ зөвлөл болон Үндэсний аудитын газраас гаргасан тайлан дээр зарчмын зөрүүтэй саналуудыг ер нь хэн, хаана, яаж, хэрхэн хагалж байх ёстой юм бэ? Энэ дээр Их Хурлын Тамгын газар үүрэг хариуцлага нь яаж оролцдог юм бол? Тодруулж асуумаар байгаа юм. Энэ зөндөө саналууд гарчхаж байгаа шүү дээ энэ тайлангууд. Тэр хэсэг бол ихэнх нь Төсвийн тогтвортой

байдлын хуулийн заалт, шалгууруудыг биелүүлж байгаа боловч гэж байгаад ганц, хоёр эргэж харах зүйлүүд байна. Энэ 2 тайлан дээр хоёулан дээр нь мөн гишүүд орлого бүрдэх болов уу гэдэг дээр санаа зовоод асууцгаагаад байна. Тэгээд энэ гэх мэт энэ зарчмын зөрүүтэй саналыг хэрхэн яаж хэлэлцэж байх ёстой юм бол цаашдаа? Одоо бол төсвөө батлахын төлөө явж байна.

Би нэг зүйл дээрээ зүгээр санаа зовоод нэмж хэлэхэд гадагшаа бол иргэд энэ дотор юу, яг хэрхэн хороод Байнгын хороод дээр ч, энэ чуулганы хуралдаан дээр ч хэрхэн хэлэлцэгдэж байгааг төдийлөн сайн бүрэн мэдээлэл авахад хомс шүү дээ. Тэгэхээр итгэлцэл гэдэг зүйлийг анх ээлжит бус чуулган дээр хэлж байсан. Итгэлцлийг нэмэгдүүлэхэд энэ мэдээллийн урсгал маш чухал. Энэ Засгийн газрын төсвийн ерөнхийлөн захирагчид буюу сайд нар асуултад хариулахдаа зарим тохиолдолд зөв үг хэллэг хэрэглэмээр юм шиг санагдаад байгаа юм. Жишээлбэл танана, хэмнэнэ гэдэг 2 чинь 2 өөр утгатай ч юм шиг. Түрүүн манай ХҮН намын гишүүн Найдалаа хэлээд байна лээ. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд хэвээрээ байх юм байна. Энэ төсөв буурсан ч гэсэн 8 хувьтай байх юм байна. Инфляц яах вэ бага зэрэг өсөөд 7.2 хувьтай төсөөлөгдөж байгаа юм байна энэ тэр гээд ярьж байна шүү дээ. Тэгээд түүн дээр төсөв хасаж байгаа ч гэсэн хэвээрээ байж байна гэдэг ийм ойлголтыг, зөрөөтэй ойлголтыг өгчих гээд байгаа байхгүй юу. Гэтэл цаанаа энэ чинь яагаад гэдгээ зөв тайлбарлахгүй бол дахиад л төсөв хуумгай явчихсан юм шиг ийм нэг мэдээллийн зөрөө, энэ үг хэллэгийн асуудал байна гэж хэлмээр санагдаад байна.

Энэ хугацаа дуусахаас өмнө МСС 26, МСС Мянганы сорилтын сангийнхан 2026 оны 3 сард төсөл нь дуусах юм билээ. Манай талаас.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 1 минут нэмж өгье.

**Б.Мөнхсоёл:** 2026 оны 3 сард төсөл нь дуусах юм байна лээ. Нөгөө ус, саарал ус гаргах тэр стандартыг яг стандартын дагуу усаа цэвэршүүлж гаргахад манай Монгол талаас funding гаргах ёстой шүү дээ. Matching funding зардал хуваалцах механизмаар. Тэр нь тусгагдсан болов уу гэдгийг тодруулж асуугаад, угаасаа Сангийн сайд Жавхлан өөрөө энэ ТУЗ-ийнх нь дарга байгаа байх тэр төслийн. Үүнийг тодруулж асуумаар байна. Төсвийн байнгын хорооны хүрээнд магадгүй ажлын хэсэг гараад, энэ дээр бас үнэлэлт, хяналт тавих боломжтой юу гэдгийг асуумаар байна? Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Манайхан энэ эдийн засгийн өсөлт 8 хувьтай байх дээр эргэлзээд байна. Тоогоо бүгдээрээ их сайн хараарай. Дотоодын нийт бүтээгдэхүүнд одоо бид нарын зардал хасагдаж байгаа зардал чинь дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 2.5 орчим хувь шүү. 2 аравны дотоодын нийт бүтээгдэхүүн гэхээр бид нар 95 их наядын тухай ярьж байгаа юм. 95 их наяд төгрөгийн эдийн засаг дотор 2, 2.3 их наядыг төсөв дотроосоо бууруулах тухай ярьж байгаа шүү. Энэ өөрөө биднээс ямар даалгавар шаардаж байгаа вэ гэхээр 700-аас 1 тэрбум, 700 саяас 1 тэрбум долларын гадаад хөрөнгө оруулалтыг нэмэх тэр орчныг бүрдүүлж өгөөч гэдэг даалгаврыг шаардаж байгаа.

Би энгийнээр хэлэхэд зэс боловсруулах үйлдвэрийг нэг жил ч гэсэн өмнө оруулахыг Засгийн газарт даалгаж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Түүнээс биш энэ

2.3 их наяд төгрөг өөрөө төсвийн хөрөнгө оруулалт дээрээ жин дарж байгаа боловчиг нийт 95 их наяд дотор өөрөө 2 аравны хэдэн хувь байхгүй юу, дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, 2 аравны хэдэн хувь гэж ойлгох хэрэгтэй. Тийм учраас эдийн засгийн өсөлт энэтэйгээ шууд уялдах юм шигээр битгий бодоорой. Эдийн засгийн өсөлт бол хадгалагдана, хадгалагдана.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Тэр нийгмийн даатгалын та сан гэж хэлэх гэж байгаа байх шимтгэл. Нийгмийн даатгалын сангийн, Эрүүл мэндийн даатгалын сан гээд бид нар чинь тус тусдаа төсөвтэй. Тэгэхээр Нийгмийн даатгалын санг бид төсвөөс шууд салгаж, улсын төсвөөс шууд салгаж гаргах бол бидэнд ер нь наанадаж 20 жилийн хугацаа хэрэгтэй. 20 жилийн хугацаа. Энэ 34 жилийн хугацаанд юу хийсэн бэ гэхээр бид улсын төсвөөс Нийгмийн даатгалын санг хамаарлыг нь улам нэмэгдүүлээд байгаа, улам л нэмэгдүүлээд байгаа. Нөгөө 7 жилийг 5 жил болгосон, тэтгэвэрт гарах насыг наашлуулсан, Монгол хүний нас, насжилт дундаж насжилт өсөөд байдаг, тэтгэвэрт гарах насыг нь наашлуулаад байдаг. Тэр зөрөө дээр Нийгмийн даатгалын сан чинь улам татаас нь нэмэгдээд байгаа юм. Өнөөдөр татвар төлөгчдийн мөнгөөр тэтгэвэр тавьдаг энэ тогтолцоо маань улам төсвөөсөө хамааралтай, улам л шигдээд байгаа юм. Буруу тийшээгээ яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг бид дорвитой өөрчлөх цаг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд товч тодорхой хариулъя.

**Б.Жавхлан:** Тэгэхээр энийг яг салбарынх нь энэ тогтолцооны энэ хуулийг бүүр орвонгоор нь бид өөрчлөх ёстой юм байгаа юм. Тийм учраас тэр санг бид товчхондоо ойрын жилүүдэд бие даалгах, төсвөөс гаргах бол ямар ч боломж байхгүй. Тэгэхийн тулд тэтгэвэрт гардаг насыг нь илүү ахиулах хэрэгтэй байна. Одоо юун нөгөө нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах манатай, бууруулах тусам татаас нэмэгдээд энэ чинь улам зууралдаад ингээд яваад байна. Ийм юм байна. Бариулж дуусаагүй байхад та гараа өргөөд өөдөөс үймүүлээд байх юм, байж байгаарай.

Тэр Мянганы сорилтын сангийн тийм Сангийн яаман дээр ирсэн сүүлийн 3 жил. Яах вэ нэлээн бид нар эрчтэй явуулж байгаа шүү, төслийнхөн ч гэсэн их сэтгэл хангалуун байгаа. Хугацаанд нь дуусгачих гээд үзээд байна. Энэ жил сая тодотголоор тавьчихсан байсан хиймэл дагуулын 68 тэрбум төгрөгийг бид нар энэ жилийн гүйцэтгэл дээр тийш нь шилжүүлж ийм зохицуулалт хийгээд, ажлуудыг нэлээн урагшлуулаад явна. Гэх мэтчилэн хэрвээ гишүүн болгон энэ төсөв танаж байгаа, энэ хэмнэж байгаа ийм үед.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Минутаа авчихсан даа. Баатаржавын Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

**Б.Мөнхсоёл:** Энэ Лодойсамбуу гишүүн миний минутаас. Би түрүүн буруу ойлгуулчхаж, уучлаарай. Би бүр тэтгэврийн реформын шинжтэй юм асуугаагүй, тийм гүн утгатай юм асуугаагүй. Зүгээр татварын орлого дээр НӨАТ, ААНОАТ, ХХОАТ гээд татварын орлого дотор нийгмийн даатгалын шимтгэл чинь ороод хүмүүс дургүйцээд, бид нар нийгмийн даатгалын шимтгэл төлж байхад яагаад татварын орлого гээд байгаа юм бэ, энэ чинь татвар биш гээд үл ойлголцол



үүсгээд, зөрчил үүсгээд байна. Тэрийг л зүгээр бүтэц, нөгөө ангилал, баланс дээр татварын орлого, нийгмийн даатгалын шимтгэл тусдаа, бусад орлого гээд явъя гэдэг ийм энгийн санал хэлж байгаа шүү, уучлаарай.

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд нэмж хариулах уу? Нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Нийгмийн даатгалын шимтгэл маань өөрөө Нийгмийн даатгалын сангийн төсвийг бүрдүүлдэг орлого юм байгаа юм. Тэрнээс бол тэнцвэржүүлсэн орлогод ордог татварын орлоготой ижилхэн татварын орлогыг бүрдүүлдэг хэсэг огт биш шүү. Тийм биш юм байгаа юм. Тийм учраас тэр өөр ойлголт, Засгийн газар талаас ч юм уу эсвэл татвар талаас юм уу энэ чинь татвар шүү, бусад өөр татварын орлоготой холилдоод, ингээд төсвийн орлого бүрдүүлдэг юм гэж ийм тодорхойлолт гаргадаггүй. Аль болох үүнийг зөв тайлбарлах гээд хичээгээд байдаг юм шүү. Тэгээд буруу зөрүү ойлгуулж байгаа бол илүү сайн үүнийг ойлгуулах, мэдээлэл өгөх хэрэгтэй юм байна. Мянганы сорилтын санг хариулчихъя.

**Д.Амарбаясгалан:** Болдын Уянга гишүүн асуулт асууя.

**Б.Уянга:** Эрхэм гишүүддээ оройн мэнд хүргэе. 2 аягүй тийм энгийн асуултыг асууя. Энэ 2025 оны дахин хэлэлцэж байгаа төсвийн төсөлд гадаад зээлийн ашиглалтыг 660 тэрбум төгрөгөөр бууруулж орж ирж байгаа. Тэрний 448.4 тэрбум төгрөгийг хэрэгжихээр зэхэж байсан төслүүдээс танаж орж иржээ. Төслүүдээ хэрхэн эрэмбэлж, хөрөнгө оруулалтынх нь хэмжээг нь бууруулсан юм бол? 2024 оны 9 сарын 01-ний өдөр өргөн барьсан 2025 оны нөгөө эхний бид нарын батлаад, дараа нь хориг тавиулсан төсөвт газрын тос боловсруулах үйлдвэрт жишээ нь 449.9 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байсан. Одоо энэ орж ирж байгаа 2025 оны төсвийн төсөлд болохоор энэ төсвийг 209.9 тэрбум болгож бараг 50-аас дээш хувиар бол танаж орж ирсэн байна. Эхний өргөн барьсан төсөлдөө 449-өөр оруулж болж байсан тэрийг нь тэр хэвээр нь явуулах ёстой байсан юм биш үү? Ийм байдлаар танагдахад Туваан сайдаас асуух хэрэгтэй байна. 2027 оны 8 дугаар сард дуусах байсан энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн хугацаа хойшлогдох уу? Тэгээд Гантөмөр сайдаас яг энэ таналтыг хийхдээ ямар эрэмбийг ашигласан юм бол? Зарим төслүүд нь нэлээн их хэмжээгээр танагдсан байна. Энэ дээр хариулт авмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Манай ажилтай холбоотой асуултаа би хариулъя. Уянга гишүүний асуултад. Яг тухайлан төсөл асууж байгаа учраас нефть боловсруулах үйлдвэрийг бид аль болох хугацаанд нь ашиглалтад оруулахыг хичээнэ. Уг төсөл маань ирэх жил жишээ нь дор хаяж 1 их наяд төгрөгийн санхүүжилт биднээс хүсэж байгаа юм. 1 их наяд төгрөгийн зээлийн ашиглалт. 2.2 их наядын бид төсөв багтаасан ч гэсэн 1 төсөл дээр ингэж бид чадахгүй. Ер нь нэг ингээд таллаад 500 их наяд, нийт 2.2-ын төсвийн зээлийн ашиглалтын багтаамж авснаас 500 тэрбум л уг төсөл дээр бид төсөвлөж байсан. Ингээд 2.2 маань 1.6 болчихоор энэ дүн дээр бол тодорхой хэмжээнд бол нөлөөлнө. Нэгэнт Уянга гишүүнээ бүгдээрээ алдагдалгүй төсөв батлах гээд хичээгээд ингэж байгаа үед төсөл төслийг дурдаад, тэндээс хасаж болохгүй, эндээс хасаж болохгүй гэмээргүй байгаа юм. Одоо ямар ч байсан алдагдалгүй төсвөө баталж аваад, бусад өөр боломжуудаа бид нээж өгөх энэ тал руугаа л том бодлогын шилжилтүүд хийх хэрэгтэй гэж ингэж харж байна.

Тэгэхээр яг тулчихсан номер нэг төсөл бол ерөөсөө яг энэ шүү. Нефьт боловсруулах үйлдвэр юм байгаа юм. Санхүүжих дүнг том яг төслөөс өөрийнх нь хүсэж байгаа дүнг өгч чадахгүй ч гэсэн бусад төслүүдийнхээ эрэмбэ дээр нэгд байна. Ийшээгээ бид хамгийн том боломжийг нь бид ийшээгээ тавьж өгнө. 2026 онд ашиглалтад орох ёстой, нэлээн л хичээнэ. Ирэх жил төсөв нь нэмэгдэхээр байгаа. Энэтхэгийн талаас нэмж санхүүжүүлэхээ бэлэн гэдгээ илэрхийлсэн. Удахгүй орж ирнэ Их Хурал дээр. Үүнийг дэмжиж өгөөрэй.

Тэгээд эрэмбэ, тэр нөгөө 38 төслөөс та яаж эрэмбэлсэн бэ гэж байна. Ерөөсөө 10 төсөл хойшилж байгаа. Мөн бусад төр, хувийн хэвшлийн түншлэл ч юм уу ийм боломжууд руу шилжиж байгаа. Тэгэхээр тэнд номер нэг эрэмбэ бол одоо байгаа суурилагдсан дэд бүтэцтэй замууд дээр жишээ нь нэг жил хойшлуулж байгаа. Дархан-Алтанбулагийн зам гэхэд одоо зам байж байгаа шүү дээ хатуу хучилттай суурилагдсан дэд бүтэц байж байна. Тэнд одоо бүр яг гацаад, түгжрэл үүссэн зүйл байхгүй. Ер нь эрсдэлтэй, өртөг өндөртэй гээд олон улсын тээвэрчид бол манай энүүгээр явахыг бол их цааргалдаг. Нэлээн өндөр үнэ хэлүүлж байж ингэж наашаага орж ирдэг юм байгаа юм. Тэгэхээр уг нь замыг нь засчихсан бол өртөг нь хямдраад, урсгал нь нэмэгдээд, манай импортууд хямдраад ингээд явах боломжууд нээгдэх юм.

Тэгэхдээ яах вэ нэг жил төсвөөс хойшилж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл рүү шилжүүлнэ. Налайх-Тэрэлжийн зам ч гэсэн мөн адилхан ийм хэлбэрээр. Мөн өөр тэр Архангайн, Архангайд хойд талаар нь явах тэр зам баруун аймаг руу явдаг зам Архангайгаар дамждаг. Энэ бол нэмэлт дараагийн өөр ийм solution юм байгаа юм, зэрэгцээд параллель нь явдаг. Тэгэхээр одоо ямар ч байсан төв зам нь бол нээлттэй хэвээрээ байж байгаа. Говийн бүс дээр бол 2.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Болдын Уянга гишүүн тодруулж асууя.

**Б.Уянга:** Ойлголоо, баярлалаа. Тэгээд яах вэ зүгээр энэ 2025 оны улсын төсөвт улсын төсвийг одоо яг энэ алдагдалгүй байдлаар баталж байгаа байдлыг харахаар нөгөө 6 төсөвт орлого төвлөрүүлдэг аймагт бол 14 тэрбум хүртэлх төсөвт төвлөрүүлэх тийм шаардлага нэмэгдээд, тэгээд 6 аймгаас. Бусад нөгөө татаас өгдөг аймгууд нь болохоор 10 хүртэл тэрбумаар татаасыг дутуу өгөх ийм нөхцөл байдал бол үүссэн байна. Тэгэхээр яах вэ зүгээр энэ нь өнөөгийн төсвөө яг өнөөгийн нөхцөл байдалд ингэж алдагдалгүй батлах үед зайлшгүй хийх ёстой л өөрчлөлт байх. Гэхдээ яах вэ зүгээр дараа дараагийн жилүүдийн төсвийн төсөөллийг хийх үед бол аймгуудаас төсөвт төвлөрүүлэх хэмжээ нь багасаад, аймгуудад өгдөг дэмжлэг нь нэмэгддэг байдлаар батлахын төлөө бид ажиллах ёс байх. Энэний нэг жишээ нь манайх бол эрдэс баялгийн салбарт ийм дэлхийн хэмжээний том тоглогч болох бүрэн боломжтой улс. Үүнийгээ зөв засаглаад хэрэглэх хэрэгтэй. Үүн дээр хамтарч ажиллах.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Санал хэллээ. Хажекберийн Жангабыл гишүүн асуулт асууна.

**Х.Жангабыл:** Та бүхэнд энэ өдрийн оройн мэндийг хүргэе. Засгийн газраас оруулж ирсэн 2025 оны нэгдсэн төсвийн төслийг дэмжиж байна, асуудалгүй. Гэхдээ Ерөнхийлөгч бидний баталсан 2025 оны төсвийн тухай хууль болон хамт

баталсан хууль тогтоомжид бүхэлд нь хоригийг тавьсан. Бид бол хүлээж авсан. Ерөнхийлөгч төсөвт бол тохируулга хийх л асуудлыг ярьсан шүү дээ. 8 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын өргөн барьсан 2025 оны төсөв дотор үр ашиггүй, тэвчиж болох зардлуудыг хасах нь зүйтэй гэж би өөрөө ойлгосон. Дэлхийн жишиг ч гэсэн тийм байгаа. Дэлхийд бараг л энэ алдагдалгүй төсөв баталж байгаа улс орон гэж 3-хан л улс орон байгаа юм байна шүү дээ. Алдагдалгүй тийм. Бид зорилготой, тэмүүлэлтэй, амбицтай ийм алдагдалтай төсөв батлах ёстой байсан. Сүүлийн 4 жил Монгол Улсын энэ орлого давж биелсэн байна. Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэсэн нэртэй хамтарсан Засгийн газар байгуулсан

Тэгэхээр 1 дэх асуулт энэ тэвчиж болох зардлуудаа хасаад, тэгээд энэ алдагдалтай төсөв оруулж ирж болоогүй юм уу? Тэгж л санагдаад байна. Одоо нэгэнт Засгийн газар алдагдалгүй төсөв оруулаад ирсэн байна. Өнөөдөр оруулж ирсэн энэ аудитын дүгнэлтийг харахаар зэрэг 3.4 их наяд төгрөгийн орлого тусламжийн дүн байна. Энэ тусламжийн дүнгээс хараад байхад татварын орлогоос 31 их наяд төгрөгийг төвлөрүүлэх юм байна. 1.9 наяд тэрбум төгрөгийг бол татварын бус орлогоосоо олох юм байна. Энэ татвараас олж ирсэн орлогын 70 хувийг бид урсгал зардалд зарцуулаад, ямар ч зорилт зорилгогүй ийм төсөв болчихсон байна гэж би өөрөө бодоод байгаа юм. Тэгээд алдагдалгүй төсөв батлах зорилгоор хоёрын хооронд бэлэн болсон орон нутгийн хөрөнгө оруулалтуудыг хасчихсан.

Тухайлбал Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн 100 ортой дотуур байрны 880 сая төгрөг хассан жишээний. Орон нутагт энэ анхаарч үзэхгүй бол болохгүй байна Сангийн сайд. Сая та яриандаа хэлж байна лээ. Дараа жилээс бол дэмжинэ. Гэхдээ юутай болзолтой. Тэр болзлыг хангасан Баян-Өлгий аймгийн сумуудад зөндөө олон барилга байгууламжууд байна, байгаа. Дараа жилээс та дэмжиж өгөөрэй. Алдагдалгүй төсөв баталснаар мөнгөний нийлүүлэлт багасаж, бодлогын хүү буурна, арилжааны хүү бууна, валютын ханш тогтвортой болно гээд ярьж байна. Төрийн албан хаагч нарыг багасгаснаар урсгал зардлыг бол багасна гээд, Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ гээд Гантөмөр сайд бас тайлбарлаж ярьж байна. Сая энэ аудитын дүгнэлт орж ирсэн, 14 зүйл заалт байна дүгнэлт дээр. Бас танилцсан. Эд нараас харахад олигтой юм харахгүй байна. Тэгэхээр алдагдалгүй төсөв баталснаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн ямар ач холбогдолтой вэ? Үүнийг Сангийн сайд та нэг сайхан тайлбарлаад өгөөч.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Лувсаннъямын Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр бид Ерөнхийлөгч хориг тавьсан гээд Ерөнхийлөгч рүүгээ чихээд байж болохгүй. Их Хурал тогтоол баталсан Их Хурлын гишүүдээ. Төсвийг дахин боловсруулж оруулж ир гэдэг тогтоол Их Хурал олонхоороо баталсан шүү. Тэгэхээр өдийд бол Засгийн газар төсвийн тодотгол өргөн барьж байх учиртай. Ямар тогтоол вэ гэхээр ялгаа байхгүй алдагдалгүй төсөв өргөн барьж гэдэг тогтоолыг Их Хурал өөрөө баталчихсан. Одоо хэдүүлээ ингээд төөрөөд, хэн нэгэн рүү юмыг чихээд хэрэггүй гэж хэлмээр байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь хөгжлийн төлөвлөгөөгөө хэдүүлээ хэрэгжүүлэхийн тулд уул уурхайн салбар маань ирэх жилээс үнэхээр завгүй болно. Боомтын сайд асар их ажил хийх шаардлагатай болж байгаа. Жишээлбэл Ханги мандалаар гарч байгаа нүүрсний хэмжээг дахиад 10 сая тонноор нэмэгдүүлэх шаардлагатай болж

байгаа. Шивээхүрэнгийн тэр терминалыг бүрэн ашиглалтад оруулах хэрэгтэй болж байгаа. Нарийн, Гашуунсухайт-Ганцмодыг холбосон терминалыг хил холболтыг бид яаралтай ажилд оруулах шаардлага тулгарч байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө юу хэлж байна вэ гэхээр бид уул уурхайгаас орлого олдог учраас болгоомжтой хандаад байгаа. Их Хурлын гаргасан шийдвэрийг бид яагаад хүндэтгэлтэй хүлээж аваад байна вэ гэхээр уул уурхайн салбараас хэт хамааралтай учраас эрсдэл байна, тийм учраас та нар төсвөө жоохон бага хэмжээгээр тооцоолоод ороод ирээч гэсэн гаргасан Их Хурлын тогтоолыг Засгийн газар хүндэтгэлтэй хүлээж авсан шүү гишүүнээ.

Түүнээс биш бид Ерөнхийлөгч рүүгээ бухаад, хэн нэгэн рүү бухаад, алдагдалгүй гэдэг үг дээр тоглоод байх бид нарт ямар ч шаардлага байхгүй. Бид бол улам их уул уурхайгаас орж ирж байгаа орлогыг нөөцөлдөг болно. Дээр нь бид Баялгийн сан дээрээ хуримтлал бий болгодог болно. Ингэж байж нийгмийн даатгалын санд байгаа өрөө төлнө. Бидэнд өр төлбөрийн асуудал ч их байна. Тийм учраас ингэж байгаа юм.

Нөгөө талдаа хасагдаж байгаа хөрөнгө оруулалт гэх юм бол тендер нь зарлагдаагүй, эзэн нь тодроогүй, нөгөө барьдаг хүн нь тодроогүй. Одоо бид нар 12 сард барьдаг хүн тодруулаад, хэзээ тэр хүн төсвийн гүйцэтгэлээ авах вэ. Тийм учраас тэр төсөл хөтөлбөрүүдийг түр зуур хойшлуулъя гэдэг ийм шийдэл гаргаж байгаа юм. Тэгэхээр Их Хурал маань ажлын хэсэг гаргаж ажиллаад, хөрөнгө оруулалт дээр хөдөлгөж бас болно шүү дээ. Бид нэг их айхтар гүрийгээд байгаа юм ерөөсөө байхгүй. Их Хурлын өгсөн чиглэл тогтоол, сүүлд гарсан хориг, Их Хурлын буцаасан буцаалтад бид яг гаргасан саналын дагуу төслөө өргөн барьж байгаа гэдгийг гишүүд маань ойлгоосой гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууя.

**Ч.Лодойсамбуу:** Үдшийн мэнд. Төсөв, эдийн засагтай холбоотой асуудал ярьж байна. Надад нэг төсвийн орлого, эдийн засгийн тусгаар тогтнолтой холбоотой нэг асуулт байна. Манай Монгол Улсын төсвийн ер нь нийт орлого ер нь татвар төлөгчдийнхөө нуруун дээр явж байдаг, татварын орлогоор бүрддэг гэж хэлэхэд хилсдэхгүй. Тэгээд жил болгон бид топ 100 аж ахуйн нэгж гээд Төрийн ордондоо уриад, дурсгалын зүйл гардуулаад юм болдог. Нөгөө гараараа бид дандаа тэр бүтээгчид, бизнес эрхлэгчид, татвар төлөгчдөө өшиглөж унагаадаг ийм ажлыг ер нь сүүлийн үеийн Засгийн газар, Улсын Их Хурлууд хийдэг болсон.

Тэгээд хэвлэл мэдээллээс нэг мэдээлэл үзээд, хэд хэдэн сайдаас асуусан, үнэн юм байна. Монгол Улс Евро-Азийн эдийн засгийн холбоонд нэгдээд, тэр холбоонд байдаг Зөвлөлтийн харьяанд байсан хэдэн улсуудтай худалдааны гэрээ байгуулаад, ойролцоогоор 1 мянга орчим бүтээгдэхүүнийг татваргүйгээр импортлох, зөрүүлээд нэг хэдэн юу ч юм хэдэн юмаа зарах ийм хэлэлцээрийг энэ 12 сардаа багтаж хийх гэж байгаа гэж. Өнгөрсөн хугацаанд өнгөрсөн парламент, Засгийн газар цементийн үйлдвэрүүд дээр яг ийм ажил хийсэн. Арай гэж нэг хэдэн жилийн өмнө би сайн санаж байна, сонинд ажиллаж байсан тэгэхэд. Хэдэн жилийн өмнө дотооддоо цементээ үйлдвэрлэдэг болохгүй бол бид ингээд урд хөршөөсөө цементээ худалдаж аваад үнийн дарамтад орчихсон байна гээд. Тэгээд төр нь бодлогоороо цементийн үйлдвэрүүдээ босгож ирсэн.

Дараа нь энэний өмнөх Засгийн газар гаалийн татвараар ингээд хөнгөлөөд, дотоодынхоо цементийн үйлдвэрүүдийг үндсэндээ өвдөглүүлсэн. Дараа нь гурилын үйлдвэр. Манай тариаланчид бас л өвдөглөчихсөн байж байгаа, сөхрөхөд бэлэн болчихсон. Одоо хүнсний салбар луугаа явж орж байгаа юм байна. Гаалийн татваргүй хүнсний бүтээгдэхүүнүүдээ оруулж ирнэ гэж байгаа. Ингээд Монгол Улс үндсэндээ үеийн үед нэг ийм 2 нүүр гаргаж ирсэн. Нэг бол чөлөөт эдийн засагтай, ардчилсан орон гээд ардчилсан нүүрээ үзүүлээд ингээд бизнес эрхлэгчдээ дэмжинэ гэдэг, нөгөө нүүр нь татан сунаж, даран унагаадаг нэг ийм нүүртэй. Эдийн засгийн хөгжлийн сайдаас асууж байгаа энэ хэлэлцээр яг болох гэж байгаа юм уу? Энэ хэзээнээс, ямар санаатайгаар ийм хэлэлцээр хийж байгаа, ямар зорилготойгоор хийж байгаа юм бэ? Манайх яг юу зарах гээд, нөгөө талаасаа яг юу худалдаж авах гээд, ямар шаардлагатай болоод энэ хэлэлцээрийг хийх гэж байгаа вэ?

Тэгээд хууль дээрээ Улсын Их Хурлын бүрэн эрх байж байгаа. Энэ олон улсын 2 талт болон олон талт гэрээ хэлэлцээрийг Улсын Их Хурал соёрхон батална, Улсын Их Хуралтайгаа зөвшилцөнө гээд. Тэгээд Их Хурлын гишүүд хэзээ энэ тухай мэдээлэл олж авах вэ? Хэвлэлээс мэдэж аваад, сайд нараас өрөө өрөөгөөр нь орж асууж байж мэдэж авлаа л даа. Тэгээд 12 сард 20-оор гэж байх шиг байна. Энэ хэлэлцээрийг батална гэж. Тэгэхээр гишүүддээ нэг мэдээлэл өгөөд, бид энэ нэг эдийн засгийн хувьд нэг тусгаар тогтносон өөрсдөө юмаа бүтээгээд хэрэглэж чаддаг, нөгөө Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгал бас юу болох вэ энэ? Өмнө бид Атрын 3 дугаар аян гээд том, арай гэж газар тариалангаа өндийлгөж аваад л 2008, 2009 онд. Тэрийгээ одоо ингээд унагаагаад авсан. Ерөнхийлөгчийн тэр хүнсний хувьсгал гээд өөрсдөө эрүүл стандарттай, өөрсдөө түүхий эдээрээ хүнсээ үйлдвэрлэдэг ийм чанартай хүнстэй болъё гэдэг бодлого нь ингээд бас байхгүй болох юм уу? Энэ асуултад хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн шадар сайд Лувсаннъямын Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Эрхэм гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Монгол төрийн ой санамж гэж юм байдаг. Бид 2050 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр хуулиа бол баталчихсан. Энэ хүрээнд 2023 оны байна уу даа, сэргэлтийн шинэ сэргэлтийн жил гэж зарласан байдаг. Энэ хүрээнд экспортыг нэмэгдүүлнэ гэдэг бодлогыг Монгол Улсын Засгийн газар төрөөс гаргасан. Ингээд яаж экспорт нэмэгдүүлэх вэ гэхээр 2 хөршдөө бол бид бараг эдийн засгийн хоригт орсон байна гэдэг ийм зүйлийг Засгийн газар мэдэгдсэн. Ер нь хоригт байгаа. Яагаад хориг вэ гэхээр маш өндөр татварын орчныг Монгол Улсад өгчихсөн байгаа.

Тэгэхээр энэ 3.5 сая хүнтэй зах зээлээ хамгаалахын төлөө байх уу 30, 40 сая хүнтэй, 300, 400 сая хүнтэй зах зээл рүү бид гарахын төлөө байх уу гэдэг ийм итгэл үнэмшлийн тухай яриа тэр үед яригдсан юм билээ. Тэгээд сонголт бол 300 сая хүнтэй зах зээл рүү гаръя гэдэг сонголт руу очсон. Хэлэлцээр өнгөрсөн 2 жил явагдсан, 5 удаагийн хэлэлцээр явсан байх. Одоо эцсийн шатдаа орсон байгаа. Юм болгоныг эцсийн шатдаа орсны дараа гэнэт ухаарсан юм шигээр тал талд мэдэгдэл хийж, тал талд бослого гаргадаг энэ байдлыг болих хэрэгтэй.

Мэдээлэл хаана нэг газар нуугдсан юм бол байхгүй. Мэдээлэл бол ил тод. Хөгжлийн төлөвлөгөө дотор хүртэл энэ эдийн засаг, худалдааны хэлэлцээрүүдийн тухай заалт байгаа. Яг хэлэлцээрийн нарийн явцыг манай Эдийн засгийн яамны



ТНБД танд тайлбарлах байх. Ер нь бид том зах зээлийг олж авахын төлөө. Жишээлбэл Хятад улсын нүүрсний зах зээлийг олж авахын төлөө энэ Засгийн газар сүүлийн байгуулагдсан цагаасаа хойш 4 сар мачийж байна шүү дээ. Тэр зах зээлийг бид авах ёстой. Энэ зах зээлийг үнэлж болохгүй. Олоод авчихсаны дараа харин том хөрөнгө оруулалт Монгол руу орж ирнэ. Яг түүн шиг бид гадаадын зах зээлийг олж аваад, тэр лүүгээ тэмүүлсэн бодлого хөтөлбөр хийж чадах юм бол том хөрөнгө оруулалт Монгол руу орж ирнэ. Ингэж байж хувийн хэвшил босно, ингэж байж өрсөлддөг болно, ингэж байж юм үйлдвэрлэдэг болно, ингэж байж ажилгүйдэл алга болно.

Одоо манай гишүүд санаа зовоод байгаа юм. Яаж ажилгүйдэл алга болох юм бэ гэж. Бид экспорт хийдэг болж, тэндээс орлого олдог болж байж л ажилгүйдэл алга болно. Түүнээс биш нэг хэсэг нь хөдөлмөрлөөд, нөгөө хэсгээ хооллодог, дотоод эргэлтийг хамгаалъя гэх юм бол яг л нөгөө Манжийн үеийн бодлого. Нэг хэсэг нь ажилгүй байна, нөгөө хэсэг нь тэжээнэ л гэсэн үг. Бүгдээрээ хөдөлмөрлөж, бүгдээрээ мөнгө олдог больё гэх юм бол том зах зээлийг бид олж авах ёстой. Энэ хэлэлцээрийг би яваасай гэж бодож байгаа юм. Хийх учиртай гэж бодож байгаа юм. Тухайн үеийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү, ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

**И.Батхүү:** Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш бол урд хөрш улс байдаг. 2 дахь том түнш маань хойд хөрш Оросын Холбооны Улс нь. ОХУ нь өөрөө ЕАЭЗХ-ны гишүүн улс учраас ОХУ-тай хийх худалдааны хэлэлцээр бол энэ эдийн засгийн холбоотой нь хийгдэх тийм эрх зүйн зохицуулалттай байгаа. Гишүүний асуултад дурдагдсан Евро-Азийн эдийн засгийн холбоонд элсэх асуудал огтхон ч байхгүй. 3 жилийн хугацаатай чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулж байгаа. Чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулж байгаа шалтгаан маш энгийн ойлгомжтой.

Монгол Улсаас ОХУ Евро-Азийн эдийн засгийн холбоонд гаргаж байгаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний татвар 15-аас 50 хувийн импортын татвартай байгаа. Энэ хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн дээр тавигддаг бас техникийн зохицуулалтын шаардлага маш өндөр. Гаалийн үйл ажиллагаа хүнд сурталтай, дамжин өнгөрөх тээвэрлэлтэд саатал гардаг, тохирлын гэрчилгээ авахад нь 4-өөс 6 сар хүлээдэг гэх мэтчилэн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**И.Батхүү:** Санкцтай гэж яриад байгаа шалтгаан нь тэр. Гадаад худалдааны бүтцийн хувьд бол Монгол Улсад хийгдэж байгаа импортын хэмжээ 2.5 тэрбум доллар, Монгол Улсаас гаргаж чадсан нь ердөө 143 сая доллар буюу 96-г харьцах нь 4-ийн алдагдалтай байгаа. Эдийн засгийг төрөлжүүлэх, экспортыг төрөлжүүлэх зорилгын хүрээнд бол энэ худалдааны тэнцлийн алдагдлыг багасгах, илүү таатай худалдааны нөхцөлийг гаргах, хөдөө аж ахуйн салбарын гол бүтээгдэхүүн ноос ноолуур, мах махан бүтээгдэхүүн, арьс ширний экспортын зах зээлийг тэлэх боломж үнэхээр байгаа. Энэ чиглэлээр бол өнгөрсөн хугацаанд хэлэлцээр хийж ирсэн байгаа.

**Д.Амарбаясгалан:** Лодойсамбуу гишүүн импорт асуугаад байсан. Импорт дээр тодруулж нэмж хариулах уу? ТНБД Батхүү.

**И.Батхүү:** Сая дурдсан 2.5 тэрбум долларын импортын гол юу нь бол нефть, шатахууны бүтээгдэхүүн, эрчим хүчний худалдан авалт. Тэгээд манай уул уурхай, газар тариаланд хамгийн их хэрэглэгддэг тэсрэх бодис, бордооны асуудлууд байдаг. Манай эдийн засгийн өсөлтөд тэртээ тэргүй чухал асуудлууд байгаа.

**Д.Амарбаясгалан:** Лодойсамбуу гишүүний асууж байгаа нь импортоор орж ирж байгаа хүнсний бараа, бүтээгдэхүүний татвар хөнгөлөгдчихөөд, дотоодын зах зээлд хүндрэл учруулах юм биш үү гэж асуугаад байна шүү дээ.

**И.Батхүү:** Манай Монгол Улсын импортын татварын хувь хэмжээ бол 5 хувь байгаа. Сая дурдсан Оросын холбооны авч байгаа нь бол 15-аас 50 хувь байгаа. Одоо бид импортын бараан дээр оруулж ирж байгаа бараа дээр хүнсний ерөөсөө 5-хан хувийн татвар нэмэгдэж байгаа гэсэн үг. Тэгэхээр дотоодын хөдөө аж ахуйн салбар, хүнс боловсруулах салбар маань өөрсдөө өрсөлдөх чадвараа сайжруулж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвараар өрсөлдөж, зах зээлээ тэлэх шаардлагатай. Үүгээрээ дамжаад илүү их ажлын байр бий болно. Уул уурхайгаас бусад салбарын өсөлтөө дэмжих гол гарц нь тэр байгаа. Зөвхөн ОХУ Евро-Ази эдийн засгийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тодруулж асууя. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн тодруулж асууя.

**Ч.Лодойсамбуу:** Том зах зээл рүү гарна гэдэг бол Монголчуудын мөнхийн л мөрөөдөл зорилго. Үүнийг бол ойлгож байгаа. Гэхдээ энэ арай өндөр төлбөртэй биш үү. 300 сая хүнтэй зах зээл рүү бид гарах гэж байгаа нь гээд 3 сая хүнтэй зах зээл дээр арай гэж өндийсөн хүнсний үйлдвэрлэлүүдээ татаж унагана гэдэг чинь төлбөр нь арай өндөр биш юм уу? Дараа нь эргээд эрчим хүч, энэ бензин шатахуун энэтэйгээ адилхан тэд нар эргээд хүнс нийлүүлэхдээ бид нарын ходоодыг, хөргөгчийг тэр чигт нь базчих юм биш үү? Тэгээд эргээд бид өөрсдөө стратегийн гол бүтээгдэхүүнийг хүнсээ өөрсдөө хийж чаддаггүй нөхцөл байдалд хүрээд, хоолоо айлаас гуйдаг болчих юм биш үү? Энэ төлбөр нь арай өндөр биш юм уу? Ийм зовлонг бид бүгдээрээ үзээд байж байгаа шүү дээ. Хэдэн ширхэг мах зарах гээд байгаа юм байна л даа. Махаа, арьсаа зарах гээд. Тэд нар бид нарын мах, арьсаар дутахгүй гээд хаалгаа хаачихад бид яах юм бэ? Хүнсний үйлдвэргүй, хөргөгч нь хоосон, тэгээд дээрэлхүүлдэг бас нэг сэдэвтэй ийм болох юм биш үү гэдэг санаа зовж байна.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Үгүй яах вэ бид Монголчууд мах, гурилтайгаа байхад болно доо гэдэг энэ үг дээр л Лодойсамбуу гишүүний санаа гарч ирээд байгаа юм. Мах, гурилтайгаа байна, байна асуудал байхгүй. Бид мах, гурилаа экспортолъё л гэж байгаа юм. Монголын мах ч өрсөлдөнө чадалтай, Монголын гурил ч өрсөлдөнө чадалтай. Тийм учраас энэ дээр эмзэглээд, эргэлзээд байх юм байхгүй. Тодорхой бүтээгдэхүүн унахаар үнэхээр Монголчуудын дотоодод үйлдвэрлэж байгаа тодорхой бүтээгдэхүүн унахаар бол энэ дээрээ бид онцгой арга хэмжээ авч болно.

Бид гаалийн татварын тухай л ярьж байгаа шүү дээ. Онцгой татвар бид яриагүй. Тодорхой квотын асуудал бид яриагүй.

Тэгэхээр бид жоохон итгэлтэй л баймаар байгаа юм л даа. Зах зээлээ олж авч чадахгүй болохоор яг өнөөдөр компаниуд маань юу болж байгаа вэ гэхээр гадагшаа явлаа гээд байгаа байхгүй юу. Гадагшаа гарч хөрөнгө оруулъя, гадагшаа гарч мөнгө хийе гэдэг ийм урсгал чинь одоо эхэлчихсэн байна шүү дээ. Дотоод.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт хангалтгүй гэж үзвэл 1 минут өгөх боломж байгаа. Лодойсамбуу гишүүнд 1 минут өгье.

**Ч.Лодойсамбуу:** Бид энэ мал аж ахуй ингээд малаа, махаа зараад яваад байна гэдэгтээ үнэхээр өндөр итгэлтэй байгаад байдаг. Нөгөө талдаа манай төр чинь өөрөө малаа битгий зар, 10 мянга болгож үржүүл, мянгат малчин бол гэдэг ийм бодлого хэрэгжүүлээд байдаг. Нүүдэлчин соёлоо бид хадгалж үлдэх ёстой. Одоо бол яг үнэндээ малчид нэг их бүгдээрээ махаа зарах гээд тэвдээд, зах дээр очерлоод байгаа юм байхгүй. Мянга болгохыг хүлээгээд л, ингээд зуднаар зуу зуугаар нь, мянга мянгаар нь алдаад байж байдаг. Тэгэхээр бид өнөөдөр нэг ийм нэг тийшээ зах зээлээ тэлнэ гэдэг, зах зээл том зах зээл рүү бид орно гэдэг бол энэ их зөв. Энэ эрсдэлтэй тал нь үнэхээр бодитой шүү. Тийм болохоор энэ Их Хурлын гишүүдийгээ би уриалж байгаа. Энэ талаар нарийн деталь мэдээллүүдийг нэхэж аваад, энэ дээр онцгой анхаарч үзэхгүй бол бид эргээд бүх ходоод, хоол бүх юмаараа дахиад бүр гарц байхгүйгээр хараат болох гэж байгаа ийм эрсдэл рүү орж байна шүү.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь бид жоохон олон улсын харилцаагаа тоглоомын түвшинд хөнгөхөн хармааргүй байгаа юм. Хэлэлцээр эхлүүлсэн үеийнхээ сэтгэл зүйг эргээд харах хэрэгтэй. Төр юм бол хариуцлагатай байх хэрэгтэй. Хийхгүй байсан юм бол хэлэлцээр эхэлж болохгүй байхгүй юу. Эхлүүлээд 2 жил явчихсан, бүх дарга нар нь очоод гуйчихсан, чухам юмаа та нарт зармаар байна гээд байдаг. Тэгсэн мөртөө яг хийе гэхээр хойшоо ухардаг. Ерөөсөө энэ Монголын төрийн гэм биш зан болсон байна шүү. Арай гэж тохироод ажил хийдэг, яг хийх болохоороо гацаадаг. Бүх төмөр зам, гаднын хөрөнгө оруулалт, энэ Оюу толгой бүгд тийм. Эхлэхдээ их доргио эхлээд, дуусах болохоороо бүгд гацдаг. Тийм учраас бид.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Евро-Азийн эдийн засгийн холбоотой хийх хэлэлцээрт Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт давуу тал ялангуяа боловсруулах салбарт ирнэ. Гэхдээ бид тодорхой хохирол, эрсдэл амсана. Ялангуяа хүнсний хувьсгалын хүрээнд 19 нэр төрлийн барааг дотоодод тарьж ургуулах гэж зорьсон зорилт, нэлээн амжилттай байгаа манай улаан буудай, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, шувуу гээд хэд хэдэн салбар нэлээн хүчтэй цохилтод орно. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд миний өдөр танд яриад байсан энэ боловсруулах салбарын тоног, төхөөрөмжийн гаалийн, НӨАТ-ын татвар дээр зайлшгүй хөдөө аж ахуйн салбарыг оруулж өгч байж энэ талдаа 5 хувь алдаад, энэ талдаа бид 5 хувийн

боломжийг тэгшитгэж байж хөдлөхгүй бол импорт нэмэгдээд, мөн Евро-Азитай хийх худалдаанд 5 хувь нь дахиад татварын цохилтод орчихвол дөнгөж бий болж байгаа энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тилеуханы Аубакир гишүүн асуулт асууя.

**Т.Аубакир:** Гантөмөр сайдыг өглөөнөөс хойш анзаарлаа. Нэлээн харизмтай, нэлээн зөв саналууд дэвшүүлээд байгаа юм. Зарим бодлогууд бол маш зөв байна. Тэгэхдээ би саяын яг хүнсний хангамжийн асуудал дээр бол Лодойсамбуу гишүүнтэй санал нэг байна. Маш өндөр үнээр бид айлын хөргөгчид хүнсээ хадгалуулах гэж байгаа шүү. Үүнийг бол бид эргэж харах ёстой.

Тийм учраас Энхбаяр сайд ч гэсэн, салбарын сайд ч гэсэн энэ дээр анхаараад ажиллаад явж байгаа. Сангийн сайд дэмжээд явж байгаа. Бид нарын хувьд Монгол Улсын хувьд Орос улстай гурил, улаан буудайн зах зээл дээр өрсөлдөх ямар ч потенциал байхгүй. Байхгүй, гадагшаа экспортод гаргана гээд хөөрцөглөх бол дэмий байх. Бусад асуудал дээр би түрүүнээс хойш анзаарлаа. Та маш зөв, зөв өнцгүүдийг гаргаж байна, харизмтай ярьж байна.

2, 3-хан тодорхой асуулт байна. Энэ хүнсний хангамжтай холбоотой 2022 оны 11 сарын 11-ний өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болж байгаа. Энэ дээр нэг асуудал маань 38.4 дээр орж ирж байгаа Сангийн сайдаа. Боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрийн зориулалттай тоног, төхөөрөмжийн иж бүрдлийг гаалийн татвараас чөлөөлнө гэхэж байгаа юм. Энэ дээр чинь хөдөө аж ахуйн салбар дээр ажиллах ёстой трактор, техникийн асуудал үндсэндээ буцаад татвартай болчих юм шиг харагдаад байгаа юм. Гэхдээ би түрүүн Төсвийн байнгын хороон дээр бол байгаагүй. Зарчмын хувьд тохирсон гэж би ойлгосон. Хөдөө аж ахуйд ажилладаг трактор, техникийн асуудлыг гаалийн татвараас чөлөөлөхгүй бол бид хүнсний хангамжийн асуудал ярьж байгаа, дээрээс нь Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн хүнсний хангамжийн бодлогын хүрээнд бид Монгол Улс маань трактор битгий хэл 1 боолт ч үйлдвэрлэдэггүй улс шүү дээ.

Тэгээд тэр үнэтэй техникээр, энэ сүүлийн үед хүнсний хангамжийн хүрээнд манай нарийн ногоо, төмс, хүнсний ногооны хангамж бол маш сайн дээшилсэн, маш сайн дээшилсэн. Атрын 3 дугаар аяны хүрээнд бид Монгол Улсын газар тариалангийн агротехнологи буюу механикжуулалтын асуудлыг тодорхой хэмжээнд шийдсэн байгаа. Бид энэ ажлыг тасалдуулж болохгүй, цаашаа үргэлжлүүлээд явах хэрэгтэй. Техник гэдэг оруулж ирээд 20, 30 жил ажиллах бололцоо байхгүй. Өөрөө 10-аас, 10 хүрэхгүй жилийн хугацаатай, одоо үндсэндээ элэгдэл хорогдол нь дуусаад, дахиад шинэчлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ цаг үед агротехнологийн ажлыг ихэнх ажлыг трактор техникээр гүйцэтгэж байгаа учраас 38.4-ийн заалт дээрээ боловсруулах үйлдвэр, газар тариалангийн трактор, тоног, төхөөрөмж гэж нэмэх нь зөв байх. Бид нарын энэ өглөөнөөс хойш маргалдаж байгаа энэ сүүлийн 3 сарын хугацаанд маргалдаж байгаа бүтээмжтэй байа гэдгийн чинь нэг хэлбэр Монгол Улс өөрсдийнхөө иддэг, уудаг хоол ундыг айлын хөргөгчид хадгалуулахгүй байх гэсэн энэ бодлоготой нийцнэ гэж ойлгож байгаа.

Түрүүн 2, 3 гишүүн хэллээ. Жавхлан сайд энэ усны комплект буюу энэ ус хангамжийн хүрээнд оруулж, сүүлийн 30 жилд оруулсан хамгийн том хөрөнгө

оруулалт энэ Америкийн талаас 400 орчим сая доллар, Монгол Улсын Засгийн газраас 110 сая орчим доллар гаргаад усыг гүн цэвэршүүлэх энэ үйлдвэрийн асуудал яригдаад явж байгаа юм байна. Энэ дээр холбоотой Батсуурь сайдаа яг танай салбарын харьяа энэ төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх асуудал маш ээдрээтэй болчихсон юм байна шүү. Энэ төв цэвэрлэх байгууламжийн ажил дуусахгүйгээр нөгөө гүн цэвэрлэх байгууламж чинь ашиглалтад орох бололцоо байхгүй юм байна. Өнөөдөр бид энэ Монгол Улсын парламент дахь Америк Монголын парламентын бүлгийн гишүүд бид тэр сангийн нөхдүүдтэй уулзлаа. Тийм учраас Батсуурь сайдаа та үүнийг маш анхааралтай байхгүй бол сүүлийн 30 жилийн түүхэнд хийсэн энэ том хөрөнгө оруулалт чинь талаар өнгөрөх нь байна шүү. Монголын талаас буюу энэ төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн барилгын асуудал маш ээдрээтэй болчихсон юм байна. Шүүхийн маргаантай нэлээн л асуудал болчихсон. Гэтэл энэ ундны усны асуудлыг бид зайлшгүй авч үзэх ёстой энэ цаг үед энэ орж ирсэн боломжийг энэ 2026 оны хэдэн сард 3 сард гэсэн билүү дээ шууд гараад явчих юм байна шүү дээ Америкийн тал чинь. Тийм учраас үүнийг анхаарах хэрэгтэй.

Төсвийг хэмнэх буюу үр ашигтай байх хүрээнд авч хэрэгжүүлж байгаа бодлогыг тууштай дэмжиж байгаа. Валютын сан буюу Дэлхийн банкнаас өгч байгаа зөвлөгөө бол алдагдалгүй байх гэхээсээ илүү энэ төсвийг үр ашигтай зарцуулах тал дээр илүү анхаарах зөвлөгөөг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Лувсаннъямын Л.Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Үнэндээ Засгийн газрын 2 жил хийсэн хэлэлцээрийг би энд үгүйсгээд суух надад тийм нүүр бол байхгүй Аубакир гишүүн. Яагаад гэвэл энэ бол гадаад хэлэлцээр. Дотоод улс төр биш. Би бол ичиж байна. Тэгэхдээ энэ бол хэлэлцээр. Тийм учраас яг ямар бүтээгдэхүүн дээр бид татвараа үлдээх вэ гэдэг саналаа Байнгын хороод гаргаад өгөөрэй. Тэгээд энэ хэлэлцээр лүүгээ үргэлжлүүлээд явах хэрэгтэй. Та хэд жишээлбэл гурил битгий оруул гэвэл гурилаа хас гэдэг шаардлага тавина. Тариа битгий оруул гэх юм бол тариагаа хас гэдэг шаардлага тавина. Тэгэхээр үүнийгээ их тодорхой гаргаж өгөөрэй.

Гадуур ингээд янз бүрийн хов жив их дэгдэж эхэлж байна шүү. Тэгэхгүй бол Монголчуудын нэг ийм муухай занг бид цаашаагаа өвлөөд яваад байж энэ парламент, Монголын төр болохгүй гэсэн ийм байр суурьтай байгаа. Түүнээс биш одоо явчхаагүй байгаа ажлыг өнөөдөр ярьж байгаа бол хэдүүлээ нээлттэй яриад зогсоож болно. Яваад, Хүрэлбаатар сайд уулзалтууд хийгээд, ажлын хэсэг гаргаад, нөгөө талаас нь Эдийн засаг, хөгжлийг хариуцсан Шадар сайд нь ахлаад, тэр хүн нь бүр энэ ажлыг бүтээнэ гээд зүтгэж байгаа үед гэнэт ингээд Монголд дуулиан боллоо, хүнсээ хүний хөргөгчид өгч байгаа юм байна гэдэг яриа гарлаа. Бид нарын бүх яриаг сонсож байгаа шүү дээ. Мэддэг юм байна лээ. Сая Макрон Ерөнхийлөгч хүртэл Монгол Улсын Ерөнхий сайдтай уулзахдаа уг нь тэр эсэргүүцээд байгаа гишүүн чинь тэр өндрийн технологийг сайн мэддэг л хүн байна лээ гэж ярьж байна лээ шүү дээ. Тэгэхээр бид энд ярьж байгаа зүйлээ гадаад хүн, гаднын улс орон мэддэггүй гэж боддог их буруу шүү. Тийм учраас бид бол яг үнэндээ аль бүтээгдэхүүн дээр юм бэ гэдгээ ингээд бүлэг дээрээ яриад та бүхэн гаргаад өг. Тэгэхгүй шууд гацаана, зогсооно гэдэг бол ичгэвтэртэй хэрэг болох байх гэж би бодож байгаа. Миний байр суурь тийм л байгаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.



**Б.Жавхлан:** Аубакир гишүүний гаальтай холбоотой асуулт дээр нэмэлт мэдээлэл өгье. Энд нэг ийм ойлголтын мэдээлэл дутуу зөрөө гараад байх шиг байна. Тэр машин механизмтай холбоотой гаалийн татварын чөлөөлөлт хугацаа 1 сарын 01-нээс дуусах гэж байна гээд байх юм. Энэ чинь бүр 2022 онд дуусчихсан шүү. 2022 онд аль хэдийн дуусчихсан. Одоо бид нарын хэлдгээр нөгөө хөдөө аж ахуйн тоног, төхөөрөмж, тариалалтын комбайн, машин механизм бүгд татвараа төлж байгаа. Бүгд татвараа төлж байгаа. Харин НӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа. НӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа хэсэг нь 1 сарын 01-нээс ингээд дуусаж байгаа юм. Тэгэхээр өмнө нь бол ингээд гаалийн татвар технологийн тоног, төхөөрөмжийн хөнгөлөлт, чөлөөлөхдөө салбаруудыг сонгодог байсан бол одоо больё. Бүх салбаруудыг хамаръя, ганцхан хөдөө аж ахуй биш гээд.

Тэгээд тэр хөдөө аж ахуй гэдэг хэсгийг нь хүчингүй болоод давхардаж байгаа учраас нийт салбаруудаа оруулж ирж байгаа юм. Тэгэхдээ энэ дотор нөгөө салбарын боловсруулах.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Салбарын хувьд онцлог яригдаад байгаа юм. Газар тариалан гэдэг чинь нэг байшин дотор явагддаг үйлдвэрлэл биш шүү дээ. Ингээд л газар боловсруулахаас эхлээд, хавраас эхлээд, намар хурааж аваад, тэгээд нөгөө үр тариагаа хадгалах хүртлээ, гараад лангуун дээр очтолоо энэ чинь үйлдвэрлэл явж байдаг. Эдгээр юуг нь салбарын онцлогийг нь харгалзаад яг үндсэн машин механизм, комбайн, тэр үрсэлгээ хийдэг, хураадаг ерөөсөө бүх төрлийн усалгааны ч юм уу энэ яг үйлдвэрлэлд оролцдог үндсэн хөрөнгө дээр бүртгэгддэг эдгээрийг нь үйлдвэрлэлийн технологийн тоног, төхөөрөмж гэдэг ойлголтод нь оруулаад салбарыг бүхэлд нь хамруулаад ингээд явах ойлголтууд байж болно. Үүнийг хэлэлцүүлгийн явцад анхааръя гэж ярилцацгаасан байгаа. Тэрнээс тэр гаалийн татвар бол одоо төлж байгаа шүү дээ. Тэрийг чөлөөлөх гээд байгаа, юу чөлөөлж байгааг нь дуусгах гээд байгаа ойлголт бол биш шүү.

**Д.Амарбаясгалан:** Жамбын Батсуурь сайд нэмж хариулт өгье.

**Ж.Батсуурь:** Яах вэ ер нь тэгээд манай гишүүд 2 талтай юм яриад байгаа юм л даа. Энэ дуусаагүй хөрөнгө оруулалтуудыг дуусгая, их хэмжээний том төслүүдийг дуусгая, эдийн засгаа тэлье, хөрөнгө оруулалтаа нэмье гээд тэгэнгүүт бол төсвөө тана, ашигтай төсөв, алдагдалгүй төсөв оруул гээд. Алдагдалгүй төсвийг нь оруулахаар бид нарт хуваадаг, хумьдаг юм гэж байхгүй болчихсон. Яг үнэндээ цэвэрлэх байгууламжийн асуудлуудыг бол 1 минут, 2 минутад ярих биш бараг нэг цаг ярьсан ч болохоор ийм үүхтэй түүхтэй. Арваад жилийн түүхтэй цэвэрлэх байгууламжаас ашиглалтад, ирэх жил ашиглалтад оруулна гэж байгаа. Тэндээс гарах усыг амдаж Мянганы сорилтын сангаар цэвэршүүлээд саарал усыг 3, 4 дүгээр цахилгаан станцад өгнө гэсэн ийм л тооцоотой явж байсан.

Гэтэл цэвэрлэх байгууламжийг эхлэхэд Монгол Улсын усны бохирдлын стандарт нь 13 оны түвшнээр өгчихсөн. Гэтэл 24 онд түүний бохирдол нь хэд дахин илүү болчихсон.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя, Батсуурь сайд.

**Ж.Батсуурь:** Бохирдол нь хэд дахин илүү болчихсон, одоо цэвэрлэх байгууламж ашиглалтад орлоо гэхэд Улаанбаатар хотын бохирдлыг цэвэрлээд гарч байгаа тэр стандарт нь МСС-гаас тэр 300 гаруй сая доллароор хийж байгаа цэвэрлэх байгууламжийг хүлээж авах тэр стандартаар гарахгүй болох ийм л зүйлүүд байгаа байхгүй юу. Энэ чинь гэхдээ өнөөдөр бий болоогүй, 10 гаруй жилийн өмнөөс одоо юу гэдэг юм 11, 2 жилийн өмнөөс эхэлчихсэн. Гэвч ирэх онд бол заавал дуусгая гэж байгаа юм. Дуусгахад мөн 35 сая долларын үнийн зөрөөтэй ийм асуудлууд байж байгаа. 35 сая доллар гэдэг чинь өнөөдөр 100 гаруй тэрбум төгрөг ярих гэж байна. 100 гаруй тэрбум төгрөгийг мөн Сангийн яамтайгаа ярья гэхээр үндсэндээ энэ төсөвт танаж байгаа, энэ эдийн засгийг хумьж байгаа энэ тохиолдолд бол энэ төсөл рүү өгч болохгүй юм л гэсэн ийм байр суурьтай л явж байгаа. Тэгэхээр 1 гараараа төсвөө дуусаагүй байгууламжуудаа энэ том төслүүдээ дуусга гээд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тилеуханы Аубакир гишүүн тодруулж асууя.

**Т.Аубакир:** Тийм тийм яах вэ шийдэх ёстой л асуудлуудын нэг л болчихсон юм байна лээ. Энэ сүүлийн 30 жилийн хугацаанд анх удаа энэ Улаанбаатар хотын усан хангамж дээр оруулж байгаа том хөрөнгө оруулалт. Гантөмөр сайдаа бид амлачихсан юм гээд бас нэг том юм тавиад туучхаж болохгүй байх л даа. Бид нарт Монгол Улсын хувьд тусгаар тогтносон улс юм бол зарим зүйлийг хамгаалж авч үлдэх тийм салбар бий. Өнгөрсөн жил сая хаврын гурилын үнийн импортыг чөлөөлсөн нь тодорхой хэмжээнд тухайн үед асуудлаа шийдчихсэн, үүргээ гүйцэтгэчихсэн. Гурилын үйлдвэрүүдэд сануулга өгчихлөө. Бид дахиад ярилцах ёстой зүйл гэсэн санаагаар би хэлж байгаа юм шүү.

Тэгээд энэ төсвийн энэ нэлээн танасан асуудал Баян-Өлгий аймаг дээр гэсэн бидний хийчихье барьчихъя гэсэн төлөвлөж байсан ажлууд бий, нэлээн зүйл хасагдчихсан байна. Гэхдээ энэ дээр бол гоншигнох зүйл байхгүй. Манай аймгийн хувьд нэгдсэн том эмнэлэг барьчихсан дотор нь тавих тоног, төхөөрөмжийн асуудал, хүүхэд хөгжлийн төвийн төхөөрөмжийн асуудал, утаа гэдэг чинь аймгууд дээр гамшгийн түвшинд оччихсон, шийдмээр байна. Нутгийн зам хөтөлбөрийн хүрээнд шийдэх ёстой зүйлүүд байна. Тийм учраас дараа дараагийнхаа юун дээр хэмнэлттэй.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жамбын Батсуурь сайд гүйцээж хариулъя.

**Ж.Батсуурь:** Энэ чинь хэдэн минутынх нь байна вэ. Аубакир гишүүн их чухал юм хөндчихлөө л дөө. Тэгэхээр нөгөө ам нээхээр уушги нээ гэж яг үнэндээ МСС-ийнхан бол 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд, ирэх 4 жилд хаяж явна шүү, орхиж явна шүү гэж байгаа, та бүхэнд хэлж байгаа мэдээ чинь үнэн. Орхиулахгүй л гэвэл 35 сая доллар буюу 100 гаруй тэрбум төгрөгийн асуудлыг шийдэж байж Монголын тал өнөөдөр цэвэрлэх байгууламжийг бүрэн ашиглалтад авах ийм боломж байгаа. Тэгэхдээ энэ бол өнөөдөр бий болчихсон биш, өнгөрсөн арваад жилийн асуудлыг ирэх жилд нь багтаагаад Мянганы сорилтын сантай хийсэн гэрээндээ Монгол орон, Монгол Улс өөрөө үүргээ гүйцэтгээд, Монгол Улс өөрөө хамгийн том анхны цэвэрлэх байгууламжуудаа ашиглалтад оруулахад бол 35 сая долларын асуудал байгаа. Тэгэхээр үүнийг мөн ажлын хэсгийн явцад яриад өгчих юм бол ирэх жил 7 сар, 8 сар гэхэд бол цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.

**Д.Амарбаясгалан:** Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

**Д.Батлут:** Гишүүддээ оройн мэндийг хүргэе. Бид алдагдалгүй төсөв батлах гэж байна. Аудитын тайлан дээр харахаар орлого талаа их өөдрөгөөр төсөөлж, уул уурхайн бүтээгдэхүүний үнийг ирэх оны дэлхийн үнийн прогнозоос нэлээн өндөр тавьж төлөвлөсөн байна гэж байна. Тухайлбал манайх уул уурхайгаас хамааралтай улс орон. Түүний 53-ыг дангаараа бүрдүүлдэг нүүрсийг гэхэд, нүүрс ирэх онд 35 доллароор үнэ нь унахаар тийм прогноз байна гэж байхад бид яаж орлогоо бүрдүүлнэ гэж ойлгож байгаа юм бол? Эсвэл бид нарт өөр нөөц төлөвлөгөө байгаа юм уу, эсвэл он гаргаад удахгүй төсвийн тодотгол хийх гээд байгаа юм уу? Энэ тал дээр нэг тодорхой нэг хариулт өгөөч гэж хүсмээр байна.

Хоёрдугаарт нь, төсвийн хүрээний мэдэгдэл дээр Засгийн газрын өр нэг дүнгээр, дээрээс нь 2025 оны төсвийн төсөл дээр бас өөр дүнгээр байгаад байх юм. Яг зөрөөтэй мэдээллүүд байгаад байна гэж. Үүнийгээ нэг тайлбарлаад өгөөч. Яагаад ийм зөрөө гараад байгаа юм бэ гэж. У нь нэгдсэн ойлголт байх ёстой гэж би хараад байна.

3 дугаарт нь манай Эрдэнэттэй холбоотой асуудал даа. Эрдэнэт үйлдвэрээс 20 хувийн Амнат авч байгаа одоо. Тэгсэн манай Эрдэнэт үйлдвэр чинь бол зэс баяжуулдаг молибден баяжуулаад гаргадаг үйлдвэр шүү дээ технологи нь тийм. Гэтэл тэр дотор байгаа хөнгөн цагаан, хар тугалга, цайр гэх мэтчилний бүтээгдэхүүнүүдээс Амнат авч байгаа. Тэрийгээ бол эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гэж нэрлэж байгаа юм. Тэгээд эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гэдгийг хэн, хаана, яаж тодорхойлоод байгаа юм бэ? Ингээд нэг болж бүтэж байгаа үйлдвэрээ ингээд байнга ноолоод, одоо тэр үйлдвэр нь яаж байгаа вэ гэхээр б...аа ижил төстэй уурхайнуудаас авчирч олборлолт хийдэг. Техник технологийн шинэчлэл хийж чадахгүй, дэлхийн жишиг үйлдвэр нэртэй, дэлхийн жишиг цалин байхгүй тэр үйлдвэрт ийм л нөхцөл байдалд байгаад байна.

Харин бид илүүтэй технологийн шинэчлэлд нь хөрөнгө оруулалт хийх боломжийг нь бүрдүүлж өгч байж, илүү үр өгөөжтэй ажиллах боломжийг гаргах ёстой гэж хараад байгаа юм. Уул уурхайн олборлолтын ажил нь доошлох тусмаа л агуулга багатай болж эхэлж байгаа юм. Энэ бүхэн рүү чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийж өгөөч. Тэгэхгүйгээр ингээд нэг дагалдах элемент, эдийн засгийн ач холбогдолтой дагалдах элемент гэж нэрлээд, тэрийг нь хэн, яаж тэр элементүүдийг нь тодорхойлох ёстой нь мэдэгдэхгүй зүйл хийгээд байгаа юм. Яг үнэндээ төсвийн тэлэлтэд хамгийн их нөлөө үзүүлдэг аймгууд өөрсдөө төсвийн хямралд орчихоод байгаа шүү. Манай Эрдэнэтэд гэхэд эрчим хүч манай Монгол Улс эрчим хүчний хараат гэсэн, өнөөдөр усаа буцалгаж чадахгүй хэмжээнд эрчим хүч уналтад орчихсон, хүчдэлийн уналтад орчихсон, айл өрхүүд цөөнгүй байна. Зөвхөн Эрдэнэт ийм байгаа юм чинь Булган, Хөвсгөл гээд олон газрууд юм байгаа. Тэнд тэгвэл хүмүүс яаж очиж амьдрах юм бэ, тэнд яаж ЖДҮ-лэлүүд хөгжих юм бэ,

Тэгээд энэ бүхэн рүү чиглэсэн хөрөнгө оруулалтыг яаж, хэзээ хийх юм бэ? 2025 онд бид ямар ч хөрөнгө оруулалтууд байхгүй байгаа юм. Улаанбаатар хот руу чиглэсэн томоохон хөрөнгө оруулалтыг хөдөө орон нутгаас сонгогдсон төлөөлөл гишүүд маань нэг удаа, нэг удаа гэсэн байдлаар хэд хэдэн удаа шийдсэн. Үр дүн нь ямар байгааг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Ингээд хөдөө орон нутгаа хаяад байхаар нөгөө төвлөрөл чинь яаж саарах юм. Тэнд хүн амьдрах

боломжийг бий болгож байж л төвлөрлийг сааруулах бодлого чинь давхар үр дүнгээ өгнө гэж хараад байгаа юм. Энэ бүхэн дээр та бүхэн нэг хариулт өгөөч гэж хүсье.

**Д.Амарбаясгалан:** Туваан сайд хариулт өгье.

**Ц.Туваан:** Батлут гишүүн маш чухал асуудлуудыг хөндөж байна. Ирэх жилийн улсын төсөв бол мэдээж уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос бүрдэнэ. Тэгэхээр бид бол ирэх жил энэ жилийнхтэй бараг адилхан буюу 83 сая тонн нүүрс тавьсан байгаа. Үнэ бол өдөр хүмүүсийн ялангуяа энэ Төсвийн тогтвортой байдлынхны яриад байгаа шиг 120 хэдэн доллароор бол тавиагүй, 150 доллароор буюу дундчилсан байдлаар. Өөрөөр хэлбэл 10 жилийн үнүүдийн 105, тийм 10 жилийн үнүүдийн дунджийг авч ингэж тавьдаг. Тэгэхээр бол зах зээлийн үнэ буюу өндөр үнэ тавьдаггүй учраас энэ нэг тийм ноцтой биелэхэд хүндрэлтэй үнэ бол биш. Бид бол өнөөдрийн байдлаар биржээрээ коксжих 1/3 коксжих эрчим хүчний нүүрснүүдийг янз янзын үнээр зарж байгаа. Тэгэхдээ дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээ бол тийм муугүй байгаа, муугүй төлөвтэй байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр энэ дээр бол энэ жилийн түвшиндээ л бараг экспорт гарах хэмжээнийхээр тавьж өгсөн гэдгийг энэ ташрамд хэлье.

Эрдэнэт дээр тойргоос сонгогдсон гишүүний хувьд бол зайлшгүй нарийн асуудал хөндөж байна. Тэр нь Эрдэнэтийн бид зэсийн Амнат-ыг 20 хувиар авч байгаа үнэн. Энэ бол ер нь дэлхий дээр их өндөрт тооцогдох ийм амнат-ыг авч байгаа. Энэ дээр бид ярьж байгаа, яриагүй биш. Одоо яг бусад зэсийн ордуудыг ашиглах ч юм уу, ингээд асуудлуудыг ярихад энэ амнат-ыг эргэж ярихаас өөр аргагүй. Энэний нөгөө талд нь Сангийн яамныхан маань улсын төсөв бүрдүүлэх гэдэг хүнд асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бол голчийг нь олоод шийдэхээр бид бол ярьж байгаа. Оюу толгойн амнат бол бид 5 байгаа. Тэгэхээр бол та бас аргагүй яг тойргийн хүний хувьд бол үүнийг ярихаас өөр аргагүй.

Тэр дагалдах элемент, хөнгөн цагаан, хар тугалга, цайраас бол Ашигт малтмалын тухай хуулиараа амнат тооцож авч байгаа. Энэ дээр бол Эрдэнэтийнхэн маань шүүх дээр асуудлуудаа тавиад, шүүхдээд энэ дээр ялчихсан ийм асуудлууд байдаг. Тэгэхээр энэ бол одоо тийм бас л Эрдэнэтэд нэлээн дарамттай байгаа ийм асуудлууд ярьж байгаа. Мэдээж Эрдэнэтийн ордын ашиглах олон жил ашигласантай холбогдуулаад нэлээн гүн болж байгаа, ашиглалтын зардал өсөж байгаа. Тэндээс агууламж, хүдрийн агууламж багасаж байгаа асуудлууд бол байгаа. Үүнийг бол бид Засаг дээр нэлээн ярьж байгаа. Мэдээж одоо тэнд бол бид дараагийн асуудлуудыг нь Эрдэнэтийн иргэдийг орлоготой байлгах асуудал дээр бол үйлдвэр технологийн паркийн байдлаар хуулийнхаа дагуу зэс боловсруулах үйлдвэрийг боловсруулж, тэнд нэмүү өртөг шингэх, ажлын байр бий болгох асуудлыг нэлээн шуурхай Засаг дээр ярьж байгаа. Ойрын хугацаанд энэ Эрдэнэтийн орд боловсон хүчнийхээ нөөцийг түшиглэж энэ асуудлаа шийднэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Манай гишүүд түрүүн 2, 3 хүн хэлчих шиг боллоо. Нүүрсний үнийг бид бол татвар тооцож байгаа үнээ, орлого тооцож байгаа үнээ 105 доллар гэж харж байгаа юм. 24 оны дундаж үнэ бол 110 доллар байсан юм. Тэгээд бууруулаад 105 доллар, тэнцвэржүүлсэн үнэ 129 доллар нь юу юм бэ гэхээр 129

доллороос давсан мөнгийг Тогтворжуулалтын сандаа шууд хийнэ гэж байгаа юм. 129 доллороос давах юм бол тэр зөрөөг Тогтворжуулалтын сан руугаа шууд хийнэ гэж байгаа юм. Тэгэхээр бол 129 доллороос бага яваад байх юм бол Тогтворжуулалтын сан руу мөнгө очихгүй гэж ойлгох хэрэгтэй нүүрснээс. 35 доллороор буурна гэдэг ийм айхтар прогноз бол байхгүй шүү. Ер нь үгүй, үгүй яах вэ дээ тэгээд энэ чинь шууд л 35 доллороор ирэх жил унах юм байна Хятадын нүүрс гэдгийг хэн мэдээд байгаа юм. Австрали, Хятад 2-ын харилцааг хэн мэдээд байгаа юм. Ер нь Трамп гарснаар яг ний нуугүй хэлэхэд Трамп гарснаар.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Батлут гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Энэ тэнцвэржүүлсэн тэнцэл гэдэг ийм ойлголт байдаг. Дэлхийн нийт улс орнуудаас Олон улсын валютын сан, Дэлхийн банк, НҮБ-д бүртгэлтэй улс орнуудаас 10 гаруй улс энэ тэнцвэржүүлсэн тэнцэл гэдэг дүрмийг баримталдаг. Өөрөөр хэлбэл уул уурхайгаас хамааралтай явдаг ийм улсууд энэ үнийн савлагаануудыгаа 20 жилийн дунджаар авдаг, Олон улсын валютын сангийн гаргасан дүрмээр дундчилж явдаг гэсэн үг. Тэгээд аль багаар нь шүү. Аль багаар нь. Тухайлбал ирэх жил зэсийг бид 7469-р төсвийн орлогоо тооцоолсон байгаа. Одоо зах зээлийн үнэ 10 мянган доллар, 2500 доллороор унахад бид зэсээс олох орлогоо барина. 7500-аас дээшээ орж байгаа орлогууд нь 10 мянган доллар хүртэл орж байгаа орлогууд нь бүгд Тогтворжуулалтын сан руу хуримтлагддаг. Нүүрс дээрээс яг ижилхэн. Тэгэхдээ эсрэгээрээ зах зээлийн үнэ энэ удаа бага байгаа. Тэнцвэржүүлсэн үнэ 129 гээд өндөр байгаа. 105.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя. Сангийн сайд Болдын Жавхлан асуултад нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Нүүрс дээр 105-аараа бид аль багаар нь авчихсан, 129 хоёрын хоорондох нь төсвийн давсан орлого, 120-оос дээших нь тэнцвэржүүлсэн санд хуримтлагдаад явдаг. Өнөөдрийн байдлаар тэнцвэржүүлэлтийн санд 2.4 их наяд төгрөг хуримтлагдчихаад байгаа. Ирэх жил үнийн савлагаанаас хэрэв алдагдалд орох юм үүгээр бид нөхөх ийм эх үүсвэр бидэнд байгаа гэсэн үг 1 дүгээрт.

Хоёрдугаарт, төсвийн хүрээн дээр байгаа Засгийн газрын өрийн үлдэгдэл бол дээд хязгаар юм байгаа юм. Үүнээс хэтэрч болохгүй шүү гэдэг. Манай дээр байгаа харуулаад байгаа тоо бол гүйцэтгэл юм байгаа юм. Тэгэхээр ирэх жил 55 хувиас хэтэрч болохгүй, манай гүйцэтгэл бол 45 хувиас хэтрэхгүй гарна. Тэгээд 10 хувийн ийм нөөц байгаа гэсэн үг. Бодлогын нөөц байна гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

**Д.Жаргалсайхан:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Аймгууд хуралдаад, бас Нийслэл ч хуралдчихлаа. Энэ хуралдаж байгаа зөв үү? Энэ дээр ямар чиглэл өгч байгаа вэ? Энэ нэг асуудал.

2-т нь Хүнс, хөдөө аж ахуйн яам маань Дархан-Уул аймаг руу нүүсэн. Ер нь бидний хувьд утаа, түгжрэл, хотын төвлөрлийг бууруулах гэж маш их хөрөнгө оруулалтууд хийж байна. Тэр тусмаа нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудыг ч гэсэн бид бол гар хүрэхгүй, үүнийг бол бүтнээр нь явуулна гээд.



Тэгэхээр энэ Энхбаяр сайд бол үнэхээр ажил хийж байгаа гэдгийг би энэ чуулганд бол хэлмээр байгаа юм. Олон жил энэ утааг, төвлөрлийг сааруулах гэж зүтгэсэн. Энэний төлөө бол ажил хийж байгаа ийм сайд. Тэгэхээр энэ бусад энэ төрийн байгууллагууд, их, дээд сургуулиудыг түгжрэл, утаанаас гаргах дээр ямар бодлого барьж байна вэ? Энэ дээр ямар арга хэмжээ зохион байгуулахаар та бүхэн маань төлөвлөж байгаа вэ гэдгийг асуумаар байна. Хэдүүлээ нэг ажил хиймээр байна шүү дээ, зөндөө л цаас гаргаж байна бидний хувьд, зөндөө л юм ярьж байна. Тэгээд нэг ажил болгомоор байна. Энэ тал дээр ямар бодлого барьж байгаа вэ? Энхбаяр сайд энэ дээр яг ямар үр дүн гарч байгааг яримаар байгаа юм. Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр үр дүнг ярьсан. Тэр бол бидний яг төсөөлж байсан тэр үр дүнг ярьж чадсан гэж ингэж харж байгаа, гарсан үр дүнгүүдийг яриад өгөөрэй гэдгийг хүсэж байгаа юм.

Бидний энэ орж ирж байгаа төсөв дээр нэг асуудал байгаа. Бидний мэдэхгүй нэг төсөв яваад байгаа. Анхны төсөвт өртгөөрөө ингээд батлагдаад тендерийн сонгон шалгаруулалт нь хийгдчихдэг. Тэгээд энэ Барилга хөгжлийн төв энэ магадлангаар үнээ нэмүүлдэг. Тэгээд л нэг жоохон ажил хийж байгаад орхичихдог. Тэгээд 1 жил дамнуулаад л, 2 жил дамнуулаад л үнээ нэмүүлээд л байдаг. Одоо та бүхэн энэ төсөв дээр ороод ирснийг хараарай. Анхны үнэ нь тэдэн тэрбум гэж байснаа нэмэгдээд, ерөөсөө шууд нэмэгдээд л явчихдаг. Тэгээд энэ дээр ямар хязгаарлалт, ямар хяналт хийж байна вэ? Үүнээс энэ нэмэгдсэн энэ үнүүдийг ер нь яаж, жишээ нь нэг онд яг адилхан ажил, арга хэмжээ. Тэгтэл нөгөөдөх нь нэмэгдээгүй байхад бусад ажлууд нэмэгдсэн байж байх жишээний. Тэгэхээр энэ дээр ямар ажил, арга хэмжээ хийж байгаа вэ? Үүнийг яаж зогсоох вэ? Яг энэний цаана энэ авлигал, хээл хахууль чинь явж байна, мөнгө угаалт явж байна. Тэгээд энэ чинь Улсын Их Хурал нь нөгөө гишүүд нь мэддэггүй. 10 тэрбумаар хийх ажил 2, 3 жил хийхгүй байж байгаад, ингээд 15 тэрбум болчихсон. Энэ ажлууд дээр яаж хяналт хийж байгаа юм бэ?

Дараагийн асуудал манай энэ гишүүдээс хариулт авч байна. 24 онд гэрээ хийгдэж чадаагүй ажлууд тэрийг хойшлуулж байгаа гээд. Яг энэ дээр ямар ажил байгаа вэ гэхээр Төрийн ордны барилга гээд 24 оны төсвийн тодотголоор нэлээн том өндөр дүнтэй тоо тавигдсан. Миний санаж байгаагаар бол тодотгол дээр 200 орчим тэрбум тавигдсан гэж санаад байна. Одоо би яг, сая бол яачихлаа. Энэний гэрээ хийгдсэн үү, энэ хасагдаж байгаа юу гэсэн ийм асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

**Н.Учрал:** 2025 оны төсвийн тухай хууль болон дагалдах хууль тогтоомжид тавьсан хоригийг Их Хурал хүлээн авч, тэдгээр хуулиудыг хүчингүй болгосон. Тэгэхээр Засгийн газрын тухай хуульд орон нутгийн удирдлага, зохион байгуулалт, Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах ийм эрх Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад байдаг. Энэ хүрээндээ 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр орон нутгийн төсвийн төслийг хэлэлцэх хугацааны тухай албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Энэ албан бичиг дээр тодорхой заасан. Гэтэл улсын төсвийг батлаагүй байхад Нийслэл, Төв аймаг, Завхан аймаг зэрэг аймгуудын ИТХ-д төсвөө баталсан нь Хурлын тогтоол нь хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна гэж үзэж байгаа.

Та бүхэн мэдэж байгаа. Төсвийн хууль батлагдсан. Төсвийн хууль батлагдсанаараа 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс хойш буюу Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлтээр бол улсын төсвийг дахин өргөн мэдүүлэх тохиолдолд нөгөө цаглаврыг баримтлахгүйгээр дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө батлахаар тодорхой тусгаж өгсөн. Гэтэл ингээд улсын төсөв батлагдахаас өмнө аймаг, орон нутгийн иргэдийн Хурал хуралдаанаа зохион байгуулаад, төсвөө баталсан нь хууль зөрчиж байгаа юм. Төрийн байгууламжийн хувьд манай улс нэгдмэл улс. Тийм учраас холбогдох чиглэлүүдийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн.

Яг өнөөдрийн байдлаар энэ асуудлаар зөвлөмжүүдийг хүргэлээ. Тэгээд зөвлөмжүүд нь юу юм бэ гэхээр аймаг, нийслэлийн иргэдийн Хурал бол энэ хууль зөрчиж баталсан төсвөө Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль зөрчсөн шийдвэрээ өөрийн санаачилгаар хүчингүй болгох нэг боломж байна. Эсвэл Засаг дарга өөрийн санаачилгаар эсвэл Ерөнхий сайдын даалгаснаар хориг тавих, мөн хуульд заасны дагуу Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хүчингүй болгох асуудлаар иргэдийн Хуралдаа тогтоол санаачилж оруулаад, төсвөө хүчингүй болгоод, улсын төсөв батлагдсаны дараа нийцүүлэх гэсэн ийм хууль зүйн боломж байна. Тэгэхээр аймаг, нийслэл, дүүрэг, бусад шатны иргэдийн Хурал буюу орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад тус зөвлөмжийг өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын албан бичгээр хүргүүлсэн гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Жаргалсайхан гишүүний асуултад нэмж хариулъя. Тэр төсөвт өртөгтэй холбоотой хэд хэдэн шалтгаанууд байдаг юм. Нэлээн ч олон гишүүн асуулаа. Нэгдүгээрт бэлтгэл ажил нь бүрэн хангагдаагүй төслүүдийг хэлэлцүүлгийн шатад нэмж оруулдаг энэ байдал сүүлийн жилүүдэд нэлээн байсан. Цаашдаа ийм зүйл битгий гараасай гэж ингэж бодож байна. Төсвийн хууль дээр энэ маш тодорхой улам нарийн заалттай ороод байгаа. Та хараарай, энэ жил 12 сарын 02-ны байдлаар гэрээ хийх нь битгий хэл, тендерээ зарлаж чадахгүй байгаа төслүүд байна. Тэдгээрийн хэд нь өнгөрсөн жил Их Хурал дээр хэлэлцүүлгийн үед орсныг хараарай. Тэгэхээр энэ жил бас тийм юм орох вий. Энэ дээр гишүүд нэлээн хичээх байх, илүү хариуцлагатай байх болов уу гэж би найдаж байна. Эндээс орсон төслүүд голцуу.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Жишиг зургаар гээд яваад орчихдог. Тэгэхээр жишиг зураг гэж байдаггүй. Тэр зургийг хааш нь харуулж барихаас эхлээд л тухайн газар нутаг дээрээ үнэлгээ нь шал өөр болоод явчихдаг. Байгаль орчны үнэлгээ, хөрсний шинжилгээ хийгээд төслүүд нь шал өөр төсөвт өртөг болоод явчихдаг. Дандаа тийм төслүүд одоо ингээд тендер нь зарлаж чадахгүй байгаад байгаа. Тийм төслүүдийг хойтон үргэлжлүүлэхгүй. Төсөл нь бүрэн хэмжээгээр бол хасагдахгүй. 12 сарын 31 хүртэл гэрээ хийгдэж чадах юм бол 2026 онд үргэлжилнэ, 2025 онд үргэлжлэхгүй гэсэн үг.

Дээрээс нь ковидын үед бол үнэхээр энэ биднээс үл шалтгаалсан гадаад хүчин зүйлээс маш их төсөвт өртгүүд нэмэгдсэн. Төсөвт өртгүүд нэмэгдсэн. Үүнийг нэлээн цэгцэлсэн, нэлээн цэгцлээд ирсэн байгаа шүү. Одоо харин шинэ төслүүд

дээр бас төсөвт өртгийн нэмэгдлүүд гарч ирээд байна. Тэрийг сая өмнөх хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын тогтоол дээр 1 өгүүлбэр орсон. Ирэх 1 дүгээр улиралд багтааж Их Хуралд танилцуулаарай гээд. Тэрийг дахиад оруулаад өгөөрэй, танилцуулна.

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Наранбаяр нэмж хариулъя.

**П.Наранбаяр:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Ер нь төвлөрлийг сааруулах энэ бүсчилсэн хөгжлийн хүрээнд болохоороо энэ сургалт, эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолборын төлөвлөлт гэж ийм асуудал ийм бодлого байдаг. Энэ дээр бол бид жишээлбэл хөдөө орон нутагт бол 21500 оюутан сургах хэмжээнд, Хөшигийн хөндийд бол 22 мянган оюутан сургах ийм төлөвлөлт бий. Энэ дээр бол, жишээлбэл Ховдод 5 мянган оюутан, Орхон аймагт 5 мянга, Дарханд 5 мянга, Дорнодод 3,5 мянга, Өмнөговьд 3 мянган оюутан. Өмнөговийнх нь бол ТЭЗҮ нь гарсан байх жишээтэй. Өнөөдөр энэ Хөшигийн хөндий рүү 506 га газар бэлтгэгдээд тэндээ оюутны хотхон кампус хэлбэрээр хөгжих ийм төлөвлөлт явж байгаа. Тэгэхээр энэ орон нутгийн энэ их, дээд сургуулиудыг дэмжих ийм бодлогын хүрээнд мөн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр сайд товчхон хариулт өгөх үү, Нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үндсэндээ 70-аас 90 хувь нь төвийн бүсэд төвлөрч байгаа. Нийт газар тариалангийн эргэлтийн газар, төмс, хүнсний ногооны аж ахуй, эрчимжсэн аж ахуйнууд, гахай, тахиа, өндөг, сүүний аж ахуйнууд, хүлэмжийн аж ахуй, хүнсний үйлдвэрүүд, хөнгөн үйлдвэрүүд гээд. Нөгөө талаас хүн амын 60 хувь. Өөр Монгол Улс цаг уурын ийм газар тариалан эрхлэх, эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх боломж туйлын хязгаарлагдмал. Тэр нөөц нь өөрөө энэ төвийн бүсэд байгаа.

Хоёрдугаарт, аж үйлдвэржилтийг хөгжүүлэхэд Монгол Улсын хэмжээнд зөвхөн Дархан хотод үйлдвэрлэлийн уур, ус, дэд бүтэц, тог цахилгааны нөөц байна. Үүнийг ашиглахын тулд энэ тавьсан зорилтыг биелүүлэхийн тулд хүнс, хөдөө аж ахуйн төвийн бүс Дархан хотод төвлөрч байгаа. Хүн амыг нь дагаад, салбарыг дагаад 40 гаруй аж ахуйн нэгж дилер дистрибьютер компаниуд нүүж шилжиж байна.

**Д.Амарбаясгалан:** Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Гишүүддээ оройн мэндийг хүргэе. Төсвийн хэлэлцүүлгийг нэлээн ул суурьтай харж, яг энэ төвийн суудлаас бол нэлээн төвийг сахисан байдалтай бол оролцож байгаа. Үндсэндээ энэ хугацаанд саналаа хэлэх хэд хэдэн зүйлүүд байгаа юм. Саяын ярьсан асуудлуудтай холбогдолтой Энхбаяр сайдын маань явуулж байгаа бодлого, арга хэмжээнүүд бол дэмжиж байгаа. Гэхдээ үлдсэн тэр 40 хувь, хөдөө аж ахуйн салбарын бусад энэ салбаруудынхаа энэ хөгжлийн зүйлүүдийг бас анхаараарай гээд би нэг санал хэлчихье гэж бодож байгаа юм.

Бүсчилсэн хөгжлийн 6 бүс нутгийн зорилтын 1 зорилт нь төвийн бүсийг хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс болгох тухай асуудал байгаа. Хангайн бүс дээр энэ уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс болгох тухай асуудал байгаа. Зүүн бүс дээр түүхэн аялал жуулчлал, төрөлжсөн эрчимжсэн хөдөө аж ахуй дэд зорилт нь

болоод орсон байгаа. Тэгэхээр яамаа төвийн бүс рүү шилжүүлсэнтэй адилхан бүх бодлогоо төвийн бүс гэж аль болох харахгүй байгаасай гэж би сануулж хэлмээр байна. Сүүлийн үг болгон дээрээ ер нь зөвхөн төвийн бүсийн тухай асуудлыг яриад байгаа. Тэгэхээр зүүн бүсийн хувьд ч тэр, бусад баруун бүсийн хувьд ч тэр аж үйлдвэрийн паркууд шаардлагатай, бодлого тодорхойгүй.

Мөнхтулга гишүүний хэлж байгаа энэ асуудлууд маш зөв асуудлуудыг бол хөндсөн. Тодорхой дэд бүтцийн асуудлуудыг бид энэ он болон ирэх онуудад төлөвлөж байж энэ 4 жилийн хугацаанд энэ бүс орон нутгийн хувьд бол энэ зорилтууд хэрэгжих нөхцөл нь бүрдэнэ. Нөгөө Ховдын аж үйлдвэрийн паркийн төсөл яагаад дурдагдахаа болив, Дорнодод яригдаж байсан төсөл яагаад дурдагдахаа болив? Тэгэхээр энэ чиглэлийн асуудлуудаа өргөн хүрээнд нь харж, салбарын бодлогыг улсын хэмжээнд харж ажиллаасай гэдэг энэ саналыг түрүүлээд би хэлчихье.

2 дахь нь чөлөөт худалдааны хэлэлцээртэй холбогдолтой асуудал дээр нэлээн дэлгэрүүлж ярих юм байна гэдэг ийм ойлголтыг бол авлаа. Үндсэндээ өмнөх, өмнөх чөлөөт худалдааны хэлэлцээрүүд Монголын талд ашигтай байсан уу, үгүй юү гэдгээсээ эхлэх ёстой болов уу? 2015 онд бид Японтой ер нь олон, олон улсуудтай бол хийсэн. Гэхдээ Монголд оруулж ирж байгаа импортын бүтээгдэхүүнүүд нь нэмэгдээд, бидний экспорт бол төдийлөн нэмэгдэж чадахгүй байгаа асуудлууд юундаа байна вэ гэдэг дээр дүгнэлт хийж байж дараагийнхаа хэлэлцээрүүдийг хийх нь зөв болов уу гэж бодож байна. 2 талын нөхцөл байдлыг бол сайн ойлгож байна.

Монгол Улс үйлдвэрлэгч орон болохтой холбогдолтой боловсруулах үйлдвэрийн тоног, төхөөрөмжийг орж ирэх гаалийн албан татвараас чөлөөлөхтэй холбогдолтой энэ асуудлыг өргөн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа Засгийн газрын бодлогыг бол дэмжиж байна. Ажлын хэсэг дээр энийг явж байгаа хөдөө аж ахуйн гаралтай тоног, төхөөрөмжийг хасуулахгүй байх, редакцын болон энэ агуулгыг багтаах чиглэл дээр анхаарал хандуулж ажиллах дээр санал нэг байгаагаа дурдъя.

Үндсэндээ Наранбаяр сайдаас би яг тодорхой 3 асуултыг асууя. Өмнө нь ч гэсэндээ би асуугаад байгаа. Хүүхдийн сүү хөтөлбөр гэж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон байгаа. Энэ хөтөлбөр энэ шинэ төсөл дээр хасагдсан зүйл байхгүй биз дээ? 2 төрлийн ач холбогдолтой байгаа. Эрүүл мэнд талаасаа хүүхдүүдэд өндөр ач холбогдолтой. Нөгөө талаасаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн талаасаа бол яг энэ хоршоодоороо дамжуулаад сум орон нутгаасаа малчдаа дэмжээд авах энэ холбоог нь хийгээд өгчихвөл сайн хөтөлбөр болно. Нөгөө багийн бага сургуулийн асуудал, малчдыг сургахтай холбогдолтой асуудал гээд ингээд 3 зүйлийг би яг Боловсролын яамтай холбогдуулаад яриад байгаа. Тэгэхээр эдгээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлууд хасагдсан, нэмэгдсэн зүйлүүд бол байхгүй биз дээ гэдэг дээр тодорхой та хариулт өгөөсэй гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Жамбын Батсуурь сайд хариулъя. Асуултаа анхааралтай сонсоогүй байна. Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ 3 асуултын тухайд Сүү хөтөлбөр бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусчихсан байгаа. Өнөөдрийн байдлаар бол

2023 оны 9 дүгээр сараас эхлээд Дундговь аймгийн Засаг дарга Мөнхбат дарга байх үеэсээ энэ удирдлагууд нь, Засаг дарга нь Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд өнөөдрийн байдлаар Нийслэл, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймгийн 173 сургууль, цэцэрлэгийн 53874 хүүхэд орон нутгийн төсөв болон эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр долоо хоногийн 1-ээс 3 өдөрт бол нэмэлтээр сүү ууж байгаа. Энэ сүү хөтөлбөрийг ингээд бид жишээлбэл 1-ээс 5 дугаар ангид үдийн хоол хөтөлбөрт нь шингээгээд оруулчхаж болж байгаа. Энэ дээр хоолны нөгөө нэмэлт зардлаа оруулчихсан учраас боломжтой. Энэ төсөв бол огт хасагдаагүй.

Цаашдаа дунд сургуульд 6 дугаар ангиас нь хүүхдүүдийг сүүгээр хангах эд нар бодлого барих ёстой. Тэгээд бид тооцоо хийгээд үзэхээр зөвхөн 6 дугаар ангийн 69143 хүүхдэд хэрвээ сүү өгье гэвэл нийтдээ 3,4 тэрбум төгрөгийн ийм санхүүжилт шаардлагатай болох юм. Дээшээгээ ингээд нийт хүүхдүүдийг ингээд хамруулах юм бол ер нь 45,3 тэрбум хэрэгтэй болно. Тэгээд энэ цаашдаа энэ боловсролын төсөв боломжтой болоод ирэхээрээ нэмээд явах боломжтой.

Багийн бага сургуулийн тухайд бол энэ ажил урагшаа явж байгаа. Одоо судалгаанууд нь явж байна. Хөтөлбөр боловсруулах ажил нь эхэлж байна. Мөн хямд төсөр аргаар сургууль барих ийм боломжуудыг судалж байгаа. Энэ дээр энэ төсөвт бага зэрэг мөнгө суулгасан тэр нь бол хасагдаагүй. Малчдын сургалтын тухайд бол бид энэ төсөв бол хасагдаагүй гэдгийг хэлье. Ер нь бол багийн бага сургууль бид 71 багийн бага сургууль өнөөдөр байж байгаа. Тэгээд энэ багийн бага сургуулийнхаа хөтөлбөрийг шинээр боловсруулах энэ ажил явж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайдад Ганхүлэг гишүүн ер нь санал хэлчихсэн. Хариулт өгье тэгвэл, нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ховдын үйлдвэр технологийн паркт энэ удаагийн төсөв дээр 18,2 тэрбум төгрөг тавигдчихсан. 25 онд үндсэн ажил ингээд дуусна. Ховд бол баруун бүсийн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах гол ажилд үйлдвэр технологийн парк ажилдаа орно гэж ойлгож байгаа.

Тэр сүү хөтөлбөрийн асуудал хөндөгдлөө. Үнэхээр их чухал байгаа. Сүүгээр дамжуулж бид ирээдүй болсон хүүхэд багачуудаа эрүүлжүүлэх бодлогыг хийх нь зүйтэй. Хүүхдийн шүд яс гээд ер нь суурь өвчлөл энэ олон хөгжлийн асуудлыг сүүгээр дамжуулаад шийдэх бололцоотой нь манай урд, хойд хөршүүд амжилттай харуулж байгаа. Тэгэхээр энэ нийт 10 жилийн нийт хүүхдийн сургуулийн сүүг хангахын тулд нөгөө хөдөө аж ахуйгаа эрчимжүүлэх, үхэр сүргийнхээ чанарыг сайжруулах, тэжээлийн баазаа нэмэгдүүлнэ гэсэн бодлоготой хосолж чадвал их үр дүнтэй төсөл болох байх гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

**М.Ганхүлэг:** Арьс, ширний үйлдвэрүүдтэй холбогдолтой асуудал дээрээ тодорхой бодлогууд, бүсчилсэн хөгжлийн зорилттойгоо уялдуулаад бүс болгон дээр байдаг юм уу, ядаж баруун, зүүн бүсүүд дээрээ оруулах тал дээрээ зайлшгүй анхаарах нь, илүү тодорхой болох хэрэгцээ байгаа юм гэдэг энэ саналыг би голчилж уламжлаад байгаа юм. Тэгээд энэ бол зайлшгүй хүлээгдээд байгаа асуудал байгаа.



Энх-Амгалан сайдаас би нэмээд асууж болох болов уу? Энэ залуучуудын орон сууцын асуудалтай холбогдолтой санал Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгуулсан байгаа. Үүнтэй холбогдолтой нэлээн тодорхой асуудал байгаа, хэлэлцүүлгүүд өрнөөд явж байгаа юм байна лээ. Тэгэхээр шинэ төсөлтэй холбогдолтой Засгийн газрын энэ орон сууцын реформыг үргэлжлүүлэх, энэ өрнүүлэх чиглэл дээр тодорхой хасаж, нэмэгдэж байгаа зүйлүүд ямар байгаа талаар мэдээллийг өгөх нь зөв байх. Ялангуяа залуу гэр бүлийг дэмжих чиглэл дээр орон нутагт очиж ажиллах залуучуудыг дэмжих чиглэл дээр чиглүүлэх тал дээр ямар бодолтой байгаа вэ гэсэн асуултыг.

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд хариулт өгье.

**Л.Энх-Амгалан:** Ерөнхий сайдаар ахлуулсан Баялгийн сан, Орон сууцжуулалтын үндэсний хороо байгуулагдаад 2 сар гаруй болж байна. Тэгээд энэ хорооны гол зорилго Монгол Улсад байгаа ипотекийн энэ зээлийн хүрэлцээг 1 дүгээрт яаж нэмэгдүүлэх вэ, 2 дугаарт нь ер нь зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн энэ орон сууцын санхүүжилтийн тогтвортой, урт хугацааны санхүүжилтийн тогтолцоонуудыг яаж бий болгох вэ гэдгийг бид бий болгохоор ингээд ажиллаж байгаа. Батсуурь сайд маань мэдээж санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдэхэд яг энэ залуучуудад зориулсан 50м<sup>2</sup> дахь хямд төсөр орон сууцын шийдлүүдийг ямар шийдлүүд хийж байгаа вэ? Гэр хороололд ямархуу шийдлүүд байх вэ гэдгийг бол Батсуурь сайд бас илүү хариулт өгөх нь зүйтэй болов уу гэж би бодож байна.

Ирэх жил Монгол Улсын Засгийн газар залуучуудын жил болгож зарлаж байгаа. Энэ хүрээндээ ямар ч байсан энэ анх удаа орон сууц авах гэж байгаа, урьд нь орон сууц авч байгаагүй ингээд хоёулаа ажил хөдөлмөр эрхэлдэг эсхүл.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Залуучуудад зориулсан яг энэ жилд зориулж залуучуудын энэ ипотекийн зээлийн хүрэлцээгээр нь хангая. Гэхдээ хамгийн гол нь хамгийн түрүүнд нь хавтгайруулж өгөх биш хоёулаа НДШ-ээ төлж байгаа, хоёулаа ажил хөдөлмөр эрхэлж байгаа, 2-оос 3 хүүхэдтэй байгаа энэ залуучууд 50м<sup>2</sup> хүртэлх энэ орон сууцын ипотекийн зээлүүдийн бүтээгдэхүүнүүдийг гаргах, урьдчилгаа төлбөрүүдийг нь багасгах тодорхой урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсгийг зээлийн батлан даалтын сангаар гаргуулах ийм шийдлүүд дээр бид ажиллаж байна. 12 сард Үндэсний хороо хуралдаж, энэ шийдлүүдээ гаргана. Гагцхүү нөгөө талдаа санхүүжилтийн асуудлыг шийдэж болно. Нийлүүлэлтийн асуудал дээр энэ хямд төсөр орлогод нийцсэн орон сууцуудынхаа шийдэл дээр Батсуурь сайд илүү барьж байгаа бодлогоо жаахан дэлгэрүүлж хэлэх нь зүйтэй болов уу гэж би бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Жамбын Батсуурь сайд нэмж хариулъя.

**Ж.Батсуурь:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Ер нь бол хамтарсан Засгийн газар ирэх 4 жилд 150 мянган айлын хүртэлх айлын орон сууцыг ашиглалтад оруулна гэж үзэж байгаа. Үүний 60 орчим мянга нь бол ипотекийн зээлээр. Энэний 50 хүртэлх хувь нь бол залуучуудад, хөгжлийн бэрхшээлтэй бас ингээд орлогод нийцсэн гэсэн байдлаар ангилж өгье. Мөн орон нутагт илүү

дэмжинэ. Орон нутагт залуучууд авах юм бол ипотекийн зээлийг 3 хүртэлх хувийн хүүтэй болтол хямдруулж зөрөөг татаасаар олгох ийм боломж байж байгаа. Орон нутагт төрийн алба эрхэлж байгаа залуу гэр бүл, залуучуудад тогтвор суурьшилтай байгаад ажилласан жилээр нь ипотекийн зээлийг хямдруулах ийм боломжийг олгоё гэж ингэж явж байгаа. Дээр нь амины орон сууцыг ипотект хамруулах, амины орон сууц гэдэг бол өөрөө бидний мэддэгээр бол хашаа байшин гэсэн үг. Ажлын байртайгаа хамт асуудлыг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жамбын Батсуурь сайд гүйцээж хариулъя. Тэгэхээр амины орон сууц гэдэг бол бидний мэддэгээр бол хашаа байшин гэсэн үг. Гэхдээ энэ нь өөрөө дулааны алдагдалгүй байх ёстой. Ерөөсөө бидний Дэлхийн банк бусад донор орнуудаас бид нарт өгч байгаа зөвлөгөө бол орон сууц, ер нь Монголчууд олсон мөнгөнийхөө ихэнхийг эрчим хүчний алдагдал, цахилгааны алдагдалд өгчихдөг юм байна гэсэн. Тэгэхээр бид амины орон сууцыг байгалийн гамшигт тэсвэртэй 4 ханаараа, тааз, шалаараа дулааны алдагдалгүй байх энэ боломжийг нь бүрдүүлсэн нөхцөлийг хангасан тохиолдолд бол ипотекийн зээлд хамруулах боломжийг олгоё гэж байгаа.

Дээр нь төрийн албан хаагчдын орон сууцыг 90 хүртэлх сумд 8 хүртэлх айлын орон сууцыг жишиг байдлаар дулааны алдагдалгүй, ногоон байдлаар барьж, үүнийгээ хөдөөд, аймагт, сумд шинэ залуу боловсон хүчнийг тогтоон барих, нарийн мэргэжлийн хүмүүсийг ажиллах боломжийг нь хангая гэсэн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Өнөөдөр, одоо 5 гишүүн асуулт асууж, хариулт авч дууссаны дараа үг хэлэх гишүүд нэрсээ өгнө. Үг хэлсний дараа санал хураалтыг өнөөдөр гүйцээн явуулна. Маргааш өглөө 9 цагт Төсвийн байнгын хороо хуралдаж, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэх учраас бид өнөөдөр энэ санал хураалтыг хийж дуусгах зайлшгүй шаардлагатай байгаа. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Баярлалаа оройны мэнд. Тэгээд ер нь бол асуулт асууя гэж байсан асуултууд гишүүд нэлээн асуучихсан учраас саналаа хэлчихье гэж бодож байна. Тэгэхээр ер нь бол энэ төсвийн төслийг даруй хэлэлцэж батлах нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа. Тэгээд энд яагаад вэ гэхээр ер нь бол сая хэлэлцүүлэх явцад энэ алдагдалгүй төсөв орж ирж байгаа нь бодлогын асар том өөрчлөлт, шинэчлэлт хийх энэ бололцоо боломжуудыг нээж байгаа юм. Тэгэхээр төсвийн, улсын төсвийн зардал багасаад ирэхээр бусад жишээлбэл сангууд нийслэлийн, аймаг, нийслэлийн төсвүүд дээр ч гэсэн яг иймэрхүү байдлаар хандах, илүү бүтээмжээ сайжруулах ийм бололцоо боломжуудыг нээж байна.

Дээр нь энэ төсвийн урсгал зардлуудыг сайжруулах, ТӨК-удын бүтээмжийг сайжруулах гэх мэтчилнээр асар олон давуу талуудыг энэ төсөв дээр авчирна. Тэгээд ДНБ-ийг тооцдог жишээлбэл эцсийн хэрэглээний аргаар тооцоход энэ төсвийн зарлага бол зөвхөн нэг хэсэг нь байгаа. Тэгэхээр 5 жишээлбэл өөр хүчин зүйлүүд байгаа. Дотоодын хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импорт гэх мэтчилэн. Өөрөөр хэлбэл төсвийн зарлагыг жишээлбэл энэ алдагдалгүй болгосноор л энэ эдийн засгийн хөгжил саарах юм шиг буруу ойлгож болохгүй гэж бодож байна. Эдийн засгийн өсөлтийг өөр хувийн хэвшлийн бусад гадаадын хөрөнгө оруулалт гэх мэтчилэн ийм бололцоо, боломжууд хөгжүүлэх

бололцоонууд байгаа. Тэгэхээр энэ бодлого руу шилжих том алхам болж байгаа гэж бодож байгаа.

Тэгээд дэлхий дээр энэ алдагдалгүй төсөв баталдаг олон орнуудын гол шалтгаан нь бол 4 үндсэн шалтгаан байдаг юм байна лээ. Тэгэхээр 1 дүгээрт нь уул уурхайн, төсөв нь уул уурхайгаас хамааралтай ийм улсуудын хувьд алдагдалгүй батлах энэ чиглэл рүү явдаг, мөчлөг сөрдөг. 2 дугаарт нь баялгийн сандаа хуримтлал хийх гэж байгаа улсуудын хувьд, 3 дугаарт нь эдийн засгаа солонгоруулах ийм хүсэл сонирхолтой, уул уурхайн бус салбаруудаа хөгжиж сайжруулах, 4 дүгээрт нь энэ гаднын зээл шаардлагагүй, гаднын зээлийн хэмжээгээ нэмэгдүүлэхгүй байх гэсэн зорилгоор алдагдалгүй төсөв баталдаг асар олон газрууд байгаа. Уул уурхайгаас ялангуяа хамааралтай газрууд байгаа юм. Тэгэхээр энийг бол гайхаж жишээлбэл алдагдалтай төсөв, алдагдалгүй төсөв батлах нь энэ хөгжлийг хязгаарлаж байгаа юм шигээр ойлгож болохгүй гэж бодож энийг хэлье гэж бодож байна.

Дээр нь энэ алдагдалгүй төсөв батлах нь эдийн засгийг илүү хурднаар хөгжүүлэх гол хөдөлгүүр болсон хувийн хэвшлийг дэмжих энэ боллоцоогоо, хувийн хэвшлийг дэмжихэд хамгийн том юм бол татварын асуудал байгаа юм. Тэгэхээр төсөв ашигтай болоод ирэхээр энэ нь буцаагаад татвар дээр, төсвийн бодлогууд дээр боллоцоо боломжууд илүү нээгддэг. Жишээлбэл манай улсын хувьд татварын хэмжээ эрс нэмэгдсэн ийм дүр зургууд харагдаж байгаа. Тэгэхээр хэрвээ бид ашигтай, энэ алдагдалгүй төсөв, тэгээд энэ уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн зарим орлогууд төсөөлснөөс илүү орж ирж, орлогууд орж ирвэл бид нарт энэ татварын хувь хэмжээгээ бууруулах орон зайнууд нэмэгдэнэ.

Тэгэхээр жишээлбэл татварын өр харьцуулаад үзэхээр жилийн, 6 сарын дотор татварын өр 58 хувиар нэмэгдэж, бараг 5,4 их наядын татвар, НДШ-ийн өр бий болсон байна. Өөрөөр хэлбэл энэ юу гэсэн үг гэхээр ер нь бол эдийн засаг дээр ачаалал бол өндөр байгааг харуулж байгаа. Дээр нь энэ татварын нэмэгдэж байгаа ачааллыг бууруулах боломжуудыг энэ төсвийг илүү сахилга баттай болгосноор хангах боллоцоо байгаа гэж бодож байна.

Дараа нь нэг зүгээр хэлэх санаа болохоор энэ удаагийн төсвийн хэлэлцүүлэг бол нэлээн өргөн явагдлаа. Өмнөх төсвийн хэлэлцүүлгүүдийг бол сайн мэдэхгүй байна. Нэлээн өргөн, иргэдийн хувьд ч гэсэн, Ерөнхийлөгч маань хүртэл ингэж оролцож, энэ хэлэлцүүлэг нэлээн өргөн явсны үр дүнд сайжруулах боллоцоо боломжуудыг нээсэн гэж бодож байна. Тэгээд энэ удаагийн парламентын хувьд ч гэсэн Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авч, өмнө баталсан төсвөө хүчингүй болгосон.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

**Н.Наранбаатар:** Асуулт асууя. Зам, тээврийн сайдаас асуулт асууя. Тэгээд түрүүн өргөн баригдсан төсөв дээр Өмнөговь аймгаас төвлөрүүлэх орлого 1,7 их наяд гэж байсан. Сая дахиад өргөн барихдаа 10 тэрбумыг нэмчихсэн л байна лээ. Тэгээд 5 аймаг нийтдээ 1,9 их наядыг төвлөрүүлэх юм байна лээ. Тэрний 90 хэдэн хувь нь буюу Өмнөговь ганцаараа 1,7 их наядыг төвлөрүүлэх юм байна.

Нөгөө талд нь ганцхан зам тавигдсан байсан юм Өмнөговьд. Шивээхүрэнгийн боомтыг холбо, одоо 80км л дутаад байгаа юм. Тэгээд энэ 80-ыг

нь холбочихёе гээд уг нь түрүүчийнх дээр тавьсан байсан. Сая дахиж орж ирэхдээ тэр 80 нь байхгүй болчихоод байгаа юм л даа. Тэгээд уг нь улсад 1,7 их наядыг төвлөрүүлчхээд, тэгээд 1 ганцхан зам 80км-ийг нь ингээд хасаад оруулаад ирэх юм. Уг нь хөрөнгө оруулалтаа эрэмбэлэх юм бол Шивээхүрэнгийн зам бол ач холбогдолтой л доо. Яагаад гэвэл Шивээхүрэн бол манай нүүрсний экспортын 40 хувийг нь дангаараа экспортлоод байгаа юм. Бидний ярьж байгаа орлогын нэлээн эзлэх хувийг бол манай Шивээхүрэн боомт яах юм. Тэгээд маш олон унаа тэрэг явдаг, ачаалал өндөртэй. Тэр Нарийнсухайтын уурхайн бүх ажилчдын автобус, хоол хүнс, ард иргэд, хил боомтын бүх ачаанууд явж байдаг ийм маш чухал боомт байгаа юм. Тэгээд улсын төсөв бүрдүүлэхэд их том үүрэг гүйцэтгэдэг ийм боомт байгаа юм. Тийм учраас энийг буцаагаад оруулчих боломж байна уу, үгүй юу гэсэн асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Говийн бүс нутгаас сонгогдсон Зам, тээвэр хөгжлийн сайд Дэлгэрсайхан хариулт өгье.

**Б.Дэлгэрсайхан:** Наранбаатар гишүүнийхээ асуултад хариулъя. Тэгээд бүгдээрээ мэдэж байгаа ингээд алдагдалтай төсөв орж ирээд, алдагдалгүй болго гэдэг ийм үүргийг өгсөн. Тэгээд үүний дагуу Сангийн яам маань эрэмбэлээд, энэ удаадаа түр хойшлуулсан байгаа. Тэгээд дараа бол ямар ч байсан мэдээж хийгдэнэ. Энэ бол том бүтээн байгуулалт, ойлгож байгаа. Тэгээд би ч гэсэн энэ дээр өөртэй чинь адилхан бол санал нэгтэй байгаа нэгд. Хоёрдож бол манай Сангийн сайд маань дэлгэрүүлээд хариулах байх гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Наранбаатар гишүүн мөн манай говийн бүсийн гишүүд ч гэсэн ер нь адилхан асуулттай байгаа байх. Энд нэг ийм шалгуур байгаа юм шүү. Гурвантэсийн чиглэлийн зам бол хувийн хэвшлээр явж байгаа шүү дээ. Хувийн хэвшлээр явж байгаа, ор тас тэр төсөл эхлээгүй, явахгүй байгаа зүйл бол биш. Тэгэхээр яг тэр төсөв дээрээс хийгдэх хэсгийг нь бол нэг жил ингээд хойшлуулж байна. Мөн яах вэ тэр, хувийн хэвшлийн түншлэлээр тэнд бол явах боломжууд байгаа. Ингээд нэг жил ажиллаадахъя. Тэгээд дахиад 26 оноос хийгдэх боломжууд бол гарч байна. Тэрнээс биш төсөл бол огт зогссон зүйл биш шүү 1-д.

2 зам яригдах байх. Нөгөө Мандалговиос Чойрын чиглэлийн зам яригдах байх. Мандалговиос, Чойроос ер нь бол энэ чинь бүүр Хэнтийгээс эхэлж байгаа шүү дээ. Хэнтий, Чойр, Мандалговь, Арвайхээр, Архангай гээд ингээд урдуураа явчих юм байгаа юм. Тийм, тэгэхээр энэ төсөл 3 цэгээсээ энэ жил эхэлчихсэн явж байгаа. Мандалговиос ч эхэлчихсэн, Чойроос Арвайхээр рүү ч эхэлчихсэн, Арвайхээрээсээ буцаагаад наашаа.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя. Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Энэ говийн 2 гишүүн хоорондоо асууж, хариулаад, тэгээд та 2, та 2-ын юун дотор л орчих шиг боллоо. Тэгээд одоо тэр Мандалговиос Чойр луугаа, Чойроосоо Арвайхээр лүү, Арвайхээрээсээ буцаад Чойр луу 3 цэгээсээ энэ жил эхэлчихсэн байхгүй юу. Тэгэхээр хойтон энэ ажлууд нь үргэлжилнэ. Энийг түргэтгэхийн тулд Мандалговиос, Чойроос Мандалговь руу 50км-ийг нэмээд тавьчихсан байсан юм. Тэр нэмэлт ажил нь л нэг жил хойшилж байгаа болохоос

биш төсөл бол үргэлжилдгээрээ үргэлжилнэ. Энэ жил эхэлчихсэн, хойтон үргэлжилнэ.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

**Х.Баасанжаргал:** 3 багц асуулт байна. 1 дүгээрт хүүхдийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой Эрүүл мэндийн сайд болоод мөн Боловсролын сайд бас давхар энэ асуултад хариулах нь зөв байх. 2 дугаарт энэ тэгш бус байдал, хүүхдийн боловсролын асуудалтай холбоотой 2 дахь асуулт. 3 дахь нь шүүхийн төсөв болоод мөн хууль зүйн салбарын төсөвтэй холбоотой асуулт гэсэн ийм 3 багц асуулт асууя.

Энэ одоо утаатай холбоотой эд хүүхдийн өвчлөлийн асуудал маш өндөр байна. Наад зах нь гэхэд Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороонд амьдардаг иргэн хүүхдээ шөнө эмнэлэгт аваачихын тулд дор хаяж нэг талдаа 15-аас 25 мянган төгрөгөөр таксидаж байж Яармагийн эмнэлэгт юм уу, Нисэхийн эмнэлэгт бид хүүхдээ аваачиж үзүүлж байна. Тэгэхээр энэ эмнэлгийн хүртээмжийн асуудал ялангуяа энэ хүүхдийн эмнэлгийн хүртээмжийн асуудлыг дараа дараагийн төсөвт хэрхэн яаж эрэмбэлж оруулж ирэх вэ? Энэ эмнэлгийн хүртээмжийн асуудлыг бид цаашид яах вэ, ямар итгэл найдвар байна вэ гэдгийг нэг яг нэг тодорхой хариултыг Эрүүл мэндийн сайдыг өгөөч гэж хүсэх байна.

2 дугаарт утаатай холбоотой бүх манай сайд бүгдээрээ санаж байвал бүх яамдын чиг үүрэг дээр хамгийн сүүлд нь агаарын бохирдолтой тэмцэх гэдэг чиг үүрэг бүх яамд дээр байгаа. Тэгэхээр бид агаарын бохирдол гээд ярихаар дандаа нөгөө хотын Засаг дарга хаана байна гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол Боловсролын сайдаас жишээ нь ингэж асуух гээд байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт боловсролын байгууллага, сургууль, цэцэрлэгийн байгууллагын дотоод агаарын орчноо шүүдэг, агаарын шүүлтүүртэй, агаараа цэвэршүүлдэг хэчнээн байгууллага байна вэ? Дотоод орчны агаарын бохирдлоо сайжруулах төсөв энэ удаагийн төсөв дээр чинь тавигдсан уу? Ядаж хүүхдүүд сургуульд ангидаа ороод цэвэр агаараар амьсгалах энэ боломжийг нь наад зах нь боловсролын байгууллага төсөв дээрээ яаж тавьж байгаа вэ гэж асуух гээд байгаа юм.

2 дугаарт яг боловсролтой холбоотой анги дүүргэлтийн асуудал. Жишээ нь 24 онд 3 ээлжээр хичээллэж байгаа 46, 47 сургууль, 16 онд 3 ээлжээр хичээллэж байсан 24 сургууль байна. Тэгэхээр жил ирэх тусам 3 ээлжийн сургуулиуд нэмэгдээд байна. Уг нь бол бууруулах бодлого баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр дараа дараагийн жилүүдэд энэ анги дүүргэлтийн асуудлыг бууруулах ямар бодлого барьж байна вэ? Хувийн сургуульд өгч байгаа энэ татаас гээд байгаа мөнгөө энэ анги дүүргэлтэд 3 ээлжээр хичээллэж байгаа энэ анги танхимын асуудлыг шийдэхэд хамгийн түрүүнд зарцуулж болохгүй юм уу? Тэртээ тэргүй эцэг, эхээс нь төлбөр авч байгаа энэ сургуулиудад өгч байгаа энэ татаасны асуудлыг нэг талдаа жаахан төр азнавал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Хамгийн сүүлд 3 дахь багц асуулт. Энэ шүүхийн төсөв Жавхлан сайд Сангийн сайд түрүүн хариулахдаа шүүхийн төсвөөс ШЕЗ-ийн төсвөөс ерөөсөө хасагдаагүй гэж хариулсан. 3,9 тэрбум төгрөг хасагдчихсан байна. Яг ингээд тоог нь харахаар. Тэгээд тэр дундаа нөгөө тоног, төхөөрөмж 3,9 тэрбум хасагдчихсан. Тэгэхээр нөгөө үүний өмнө бид төсөв хэлэлцэж байхдаа ярьсан шүү дээ. Шүүхийн



тухай хууль дээр өөр дээр нь энэ нөгөө тусдаа төсвийн хэлэлцүүлдэг тусдаа горимтой. Тэгэхээр энэ горимыг нь Сангийн яам, ЗГ зөрчиж оруулж ирээд байна гээд нэг бөөн юм болж, Байнгын хороогоор баталж, нэмж оруулж ирж байсан. Тэгэхээр дахиад энэ дээр зөрчиж орж ирээд байгаа ийм асуудал харагдаад байна. Тэгэхээр энэ 3 дээр тодорхой хариулт өгөөч гэж хүсэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан хариулъя.

**Т.Мөнхсайхан:** Энэ хүүхдийн өвчлөл ер нь манай улсын хувьд нэлээн их байгаа. Ингээд ирэх жилүүдэд ер нь хүүхдийн өвчлөлийг бууруулах томоохон бодлогууд хийж эхэлж байгаа. Нярайн эрт илрүүлэг скрийнингийн асуудал, сургуульд суурилсан эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний асуудал гэх мэтчилэн ер нь хүүхдүүд рүү чиглэсэн бодлого их хэрэгжиж байна. Ингээд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хувьд бол яг зуны дэлгэр цагт бол хүүхдийн эмнэлгийн дутагдалд орохгүй байгаад байгаа юм. Яг өвөл болох нь тодорхой, өвөл болоод хүйтэрдэг, ингээд ханиад томууны эд дэгдэлтийн үе эхэлдэг. Энэ үед энэ утааны хэмжээ бол энэ хүүхдийн эрүүл мэндэд, амьсгалын замын өвчлөлд их өндөр нөлөөлөл үзүүлээд байгаа. Тэгэхээр бид яриад байгаа энэ өвчлөлөөсөө яаж урьдчилан сэргийлэх вэ гэдэг энэ асуудал руу бол бид түлхүү орохгүй бол одоо баахан хүүхдийн эмнэлэг төлөвлөөд бид барьчихлаа гэж бодъё. Тэгэх юм бол өвлийн цагт яг томууны энэ эд дэгдэлтийн үед энэ эмнэлгүүд маань ачаалалтай байх нь. Ингээд бусад 3 улиралд нь ямар нэгэн тусламж, үйлчилгээний бол ачаалал байхгүй. Ингээд эмнэлгүүд маань үйл ажиллагаагаа дийлж явуулахгүй хэмжээний ийм асуудал үүсэх юм. Тэгэхээр бид энэ хүүхдүүдээ яаж өвчлөлийг нь багасгах вэ, эрт илрүүлж оношлох вэ гэдэг асуудал 1 дүгээрт.

2 дугаарт яг энэ улирлын чанартай өвчлөлөөс бид хэрхэн яаж сэргийлэх вэ гэдэг асуудлыг ярихаар бид эрүүл мэндийн боловсролын асуудал руу яригдаж байна. Дээрээс нь энэ утааны асуудлыг бид бууруулахгүй бол үнэхээр энэ ялангуяа хүүхдийн дунд амьсгалын замын өвчлөл бол үнэхээр буурахгүй байна. Бид энэ жил өнгөрсөн жилээс 200 орыг илүү дэлгэж, Улаанбаатарын хэмжээнд бэлдсэн. Түрүүн бас хэлсэн. Нийслэлийн эрүүл мэндийн газраас Нийслэлийн хэмжээнд бол 1300 орыг бэлдсэн, ЭМЯ-ны харьяа байгууллагуудад бол 1100 орыг бэлдсэн. Ингээд нийтдээ 2400 ор буюу өнгөрсөн жилийнхээс 200 орыг илүү бид дэлгэж бэлдсэн. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ вакцинжуулалт яаж сэргийлэх вэ гэдэг бодлогын нөлөөллийн ажил, энэ эрүүл мэндийн боловсрол олгох ажлуудыг бүгдийг нь хийсэн боловч өнөөдөр орны ачаалал дийлдэхгүй хэмжээнд энэ хүрч байгаа асуудал бол Улаанбаатарын утаатай холбоотой асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ тухайн утааг хариуцсан Улаанбаатар хот, нийслэлийн удирдлагууд, агаарын бохирдлын асуудлыг хариуцсан Байгаль орчны яам энэ дээр авч хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээнийхээ талаар тодорхой дэлгэрэнгүй мэдээллийг өгөх байх гэж ингэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Боловсролын сайд Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Баярлалаа энэ 3 ээлжийн асуудлыг хөндлөө. Тэгэхээр нийслэлд бол нийтдээ 163 төрийн өмчийн сургуульд 397338 хүүхэд байж байгаа. 3 ээлжид орчихсон 10 сургууль байсан. Энийг бол энэ жил цөөрүүлэх ажил хийж түрээслэх замаар эд нар явсаар энэ 2 сургууль болсон. Энэ 2 сургуулийг 3 ээлжээс

гаргах юм бол энэ жилдээ бол ачаалал нь 1,5 ээлжийн коэффициенттой болно. Ер нь бид энэ агааржуулалтын асуудал дээр 2024 оны төсвийнхөө хүрээнд 300 сая төгрөгөөр агаар шүүгч бол авч сургуулиуд дээр тавьсан байгаа. Цаашдаа энэ ер нь өнөөдөр шинээр баригдаж байгаа барилгын стандартуудыг энэ автомат удирдлагатай агаар сэлгэгчтэй ийм болгохыг төсөвт суулгаж байгаа. Гэхдээ бид өнөөдөр, энэ нэмэлт цаг авъя.

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**П.Наранбаяр:** Гэхдээ өнөөдөр 152 тэрбум төгрөгөөр боловсролын салбарын юу танагдаж байна. Яг энэ бүх агааржуулалтыг шийдвэрлэе гэвэл энэ хангалтгүй байгаад байгаа. Тийм учраас Сангийн яам болоод Эдийн засгийн хөгжлийн яам, донор байгууллагууд ялангуяа Дэлхийн банк, АХБ зэрэг донор байгууллагуудаас энэ чиглэлээр өгөх энэ дэмжлэг, мөн хөнгөлөлттэй зээлүүдийг зөвшөөрөөд өгөх юм бол бид энэ ажлыг бол хийхэд болно. Мөн сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр үнэхээрийн эдгээр байгууллагууд бол санаачилгатай ингэж ажилладаг, хамтран ажиллахад бол бэлэн байдаг ийм байгаа. Хэрвээ гишүүн та ч гэсэн дэмжээд ингээд өгөөд явах юм бол бид энийг бол ажил хэрэг болгож болно гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Бид өмнөх төсөв хэлэлцэж байх үед төсөв зардал хэмнэнэ, танана гээд, хасна гээд уралдаан болж байсан. Одоо хасаж болохгүй, танаж болохгүй, алдагдалтай төсөв байх ёстой гэдэг бас нэг тийм сөрсөн уралдаан болох гээд байх юм. Битгий тэгээч гэмээр байна. Нэгэнт бид бүгдээрээ алдагдалгүй төсөв гэдэг дээрээ л суурилж, энэ дээрээ санал нэгдэцгээгээд энэ рүүгээ зорьж байгаа. Хүнд байгаа. Гэхдээ ямар ч байсан энийгээ эерэг талаас нь хараад, гарах нэмэлт даалгавар сорилтуудаа өмнөө тавьж байгаад, энэнийхээ төлөө зүтгэе, хөгжлийнхөө зорилтуудаас ухрахгүй шүү гэдэг ийм шийдэлтэйгээр Засгийн газар төсвөө өргөн бариад, ингээд хэлэлцээд явж байгаа. Тийм учраас салбар салбарын төлөөллүүд гарч ирээд, зардлаа ярьж байгаад, зардлаа хамгаалаад.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

**Б.Жаргалан:** Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. Дөнгөж сая ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн жагсаалтад Монгол Улсаас нэр дэвшүүлсэн Монгол Монгол нүүдлийн зан үйл өв бүртгэгдсэн байна. Тэгэхээр энэ дээр энэхүү үйл хэрэгт хүчин зүтгэсэн нийт байгууллага, хүмүүстээ баяр хүргэе.

2 дугаарт нь болохоор бид нэгэнт энэ улсын төсвөө 3 дахь сардаа үргэлжлүүлээд хэлэлцэж байгаа учраас шууд детальдаа оръё гэж бодож байна. Тэгэхээр өнөөдөр шинээр өргөн баригдсан төсвийн төсөлд аудитаас дүгнэлт ирүүлсэн байна. Тэгээд үүн дээр болохоор нэг ийм зүйл дурдагдсан байх юм. Дахин өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд нийт 26 төсөл, арга хэмжээ нэмж төлөвлөснөөс шинээр хэрэгжих 56,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ийм тодорхой төсвийн арга хэмжээнүүд явсан гэж байна. Тэгэхээр ийм бүүр цоо шинээр өмнөх сая 9 дүгээр сарын 1-нээс өмнө өргөн баригдсан төсвийн төсөлд байхгүй байсан зүйлүүд орж ирээд байгаа юм уу гэсэн асуулт байна.

2 дугаарт нь улсын хэмжээнд тоног, төхөөрөмж худалдан авах нэршлээр багцалсан 253,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсвийн арга хэмжээг төлөвлөсөн байна гэсэн байна. Тэгэхээр тавилгыг бол 100 хувь хасаж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тоног, төхөөрөмж гэдэг дээр болохоор нэг байгууллага болгон дээр 500 сая, 1 тэрбум энэ тэр гээд л тоног, төхөөрөмж гэсэн зардлууд яваад байгаа. Үүн дээр бас нэмэлт хэмнэлт хийх боломж байгаагүй юу? Хэрэв тэгвэл магадгүй нөгөө гишүүдийн дурдаад байгаа хөрөнгө оруулалтаас хассан зарим танасан зарим зүйлүүд дээр нэмж мөнгө төсөвлөх боломж үүсэх байсан юм биш үү гэсэн ийм асуулт байна.

Мөн сая нэлээн олон хүмүүсийн яриан дээр гарлаа. Энэ манай төсвийн, манай төсөв дээр бол ер нь хүүгийн, зээлийн хүүгийн татаас гээд нэлээн их хэмжээний хөрөнгө мөнгө төсөвлөгдсөн ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр бол нийт банк, арилжааны банкнууд дээр байгаа бизнесийн зээлийн хэмжээ 15, 6 их наяд төгрөг байгаа шүү дээ. Гэтэл тэдгээрийн бараг 1/3 нь юм уу, 4, 5 их наяд нь болохоор ийм татаасанд хамрагддаг зээлүүд болчихоод байгаа юм. Тэгэхээр яах вэ жишээ нь зөвхөн Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр биш бусад өөр яамнууд дээр байгаад байгаа. Тэгэхээр энэ нь болохоор ийм давхар зах зээл үүсгээд байгаа гэсэн асуудал дээр бол санаа зовниж байгаа юм. Яагаад гэхээр зарим компаниуд нь болохоор 30 хувийн зээлийн хүүтэй явж байдаг, зарим нь 3 хувийн зээлийн хүүтэй явж байдаг ч гэдэг юм уу. Тэгэхээр үүн дээр хариулт өгнө үү? Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

**Б.Жавхлан:** Түрүүний Баасанжаргал гишүүний асуулттай цуг хариулчихъя. Жаргалан гишүүний нэг асуулт явчихлаа. Тоног, төхөөрөмж, тэр тавилга 2 эдийн засгийн ангилал нь өөр юм байгаа юм шүү. Тэр тавилга нь бага үнэтэй, өдөр тутам хэрэглэгддэг, урсгал зардал дээрээсээ авдаг ийм ойр зуурын тавилга гэсэн үг. Нөгөө тоног, төхөөрөмж бол энэ шинээр барилга, сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг, спортын ордон, соёлын төвүүд ашиглалтад ороход хов хоосон байж болохгүй. Тэнд шаардлагатай тоног, төхөөрөмжүүдийг авдаг ийм зардал юм байгаа юм.

Би эндээс ганцхан жишээ хэлье. Боловсролын яам маань 120 тэрбум төгрөгийн тоног, төхөөрөмж ирэх жил авъя гэж санал ирсэн 8 сард. Тусгаж чадсан нь багтсан нь 32-хон тэрбум төгрөг, бүх салбарт. Тэгэхдээ хамгийн том нь л эднийх байгаа. Яах вэ Боловсролын яам маань Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг энэ тоног, төхөөрөмжийн хуваарилалтуудад нь бол үнэхээр хаанаа ч хүрэлцэхгүй байгаа. Тэдний дээр 60 тэрбум төгрөг тавигдаж байгаа. Сая 1 төгрөг ч бууруулаагүй. Боловсролын яамны хүсэж байгаа нь 120 тэрбум төгрөг. Ирэх жил 48 сургууль ашиглалтад орно. 48 сургууль, зөвхөн сургуульд нь зориулагдсан тоног, төхөөрөмж нь өсөлт нь бол 35 тэрбум. Цаана нь тоног, төхөөрөмжгүй дотуур байр, цэцэрлэгүүд байгаа гэсэн үг. Тэгэхээр хуваарилагдсан 32 тэрбум төгрөгөөрөө сургуульдаа ч хуваарилах нь байна, цэцэрлэгтээ ч хуваарилна, дотуур байрандаа ч хуваарилна. Хаанаа ч бас хүрэхгүй байгаа байх. Энэ 32 тэрбум төгрөгөөсөө дахиад 20 хувиа тануулж байгаа. Тоног, төхөөрөмж дээр бол тэгж байгаа.

Шүүх дээр ч гэсэн адилхан. Шүүхийн хувьд цалин, шүүхийн хамгийн тулчихсан асуудал бол тэр шинэ байрнуудын хөрөнгө оруулалтын асуудал байгаа шүү. Тэдгээр нь огт хөдлөөгүй. Харин тоног, төхөөрөмж нь 20 тэрбум тавигдсан

байсан бусад бүх салбарын адилхан 20 хувь буюу 4 тэрбумаар танагдаад 16 тэрбум болж байгаа. Энэнээс болоод үйл ажиллагаа нь би доголдохгүй болов уу гэж бодож байна. Харин бушуухан барилгуудаа 3 жилийн дотор санхүүжилтийг нь бүрэн өгөөд, бушуухан дуусгах хэрэгтэй. Тэрний дараа бол тоног, төхөөрөмжийн асуудлууд дахиад яригдана. Тэгэхээр энэ салбарын тоног, төхөөрөмжийн асуудлууд бол 440 тэрбум төгрөгөөр орж ирсэн. Нийт ирсэн өсөлт нь 1,9 их наяд байсан. Ирсэн өсөлтөөсөө бараг 5 дахин бага ийм багтаамжтайгаар орсон байгаа. Тийм учраас эндээсээ дахиад 20 хувь хасуулчихсан тоног, төхөөрөмжүүд дээрээ ирэх жил шинээр ашиглалтад орох, зайлшгүй солигдох эдгээр тоног, төхөөрөмжөөрөө үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх ийм шинэ сорилт гэх үү дээ, ийм даалгавартай болж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Жадамбын Энхбаяр сайд нэмж хариулах уу? Жаргалан гишүүний асуултад, хөдөө аж ахуйгаас. Наранбаяр сайд нэмж хариулъя.

**П.Наранбаяр:** Жавхлан сайд яг хэллээ л дээ. Яг бидний хүссэн хүсэлтийг бараг 4 дахин бууруулсан. Тэгээд энэ дээр тоног, төхөөрөмжүүд дээр чинь байгалийн ухаан, технологийн хичээлийн лабораторийн тоног, төхөөрөмжүүд, гал тогоо, СӨБ-ын тэр цэцэрлэгүүдийн чинь гал тогооны хэрэгслүүд, тэгээд сургуулийн дотуур байранд шаардлагатай тоног, төхөөрөмжүүд гээд бүхий л юмнууд байгаа юм. Энийг хэрвээ ингээд хасах дээрээ тулбал ерөөсөө наад боловсролын салбар чинь зүгээр зогсоно шүү. Тэгэхээр эрхэм гишүүн ийм юм ярихдаа их бодолтой яриарай. Энэ чинь ийм тоног, төхөөрөмжгүй сургуулиудаар яах юм бэ, яаж чадах юм бэ. Сандал, ширээ, самбаргүй болчихвол юу болох юм. Ийм л байгаа шүү дээ. Нөхцөл байдал хүнд байгаа шүү гэдгийг дахин, дахин хэлье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд чинь асуулт байхгүй гэсэн шүү дээ. Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалан:** Би тоног, төхөөрөмж гэж дурдахдаа болохоор боловсролын салбарыг тусгайлан дурдсан зүйл байхгүй. Тоног, төхөөрөмж гээд ингээд бусад захиргааны байгууллагууд дээр ч гэсэндээ 500 саяар, 1 тэрбумаар энэ тэр гээд ийм жижиг сажиг зардлууд яваад байна гэдгийг онцгойлон хэлж байгаа. Тэрийг тодруулахыг хүссэн юм.

**Д.Амарбаясгалан:** Хэн хариулах юм бэ? Жавхлан сайд, Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Би тэгэхээр тэрийг бөөн дүнд нь л ярина шүү дээ Жаргалан гишүүнээ. Нийтдээ 1,9 их наядын хүсэлт яамнуудаас ирсэн байдаг юм. Тэрийг 440 тэрбум төгрөг рүү 5 дахин багасгаж ингэж багтааж төсөвт оруулсан. Жижиг, том бүхий л байгууллагууд байгаа. Тэр тоног, төхөөрөмж бол сая Наранбаяр сайдын хэлдэг шиг ер нь янз янзын зориулалттай байгаа. Өөрсдийнхөө тусгай чиг үүргийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байхаар тусгай тоног, төхөөрөмжүүд ч байна. Ингээд ер нь маш тэгж нэлээн бүсээ чангалж энэ тоног, төхөөрөмжүүдийнхээ хангалтыг ирэх жил хийнэ л гэж ойлгох хэрэгтэй. Жижиг, том байгууллага гэлтгүй. Тавилгыг бол тэр бага үнэтэй, цөөхөн, нэг удаагийн ийм шинжтэй тавилгуудыг бол нэг жил тэглээд үзье гэж байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

**Д.Ганмаа:** Оройн мэнд хүргэе. 2, 3 асуулт байна. 1 дүгээрт энэ Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80км хучилттай авто зам. Энийг зарим гишүүд асуусан зүгээр би энэ дээр эрүүл мэндийнх нь талаас тэнд амьдарч байгаа хүн ард түмнийх нь энэ дэндүү хуурай, тоосжилттой, тэрнээс үүссэн өвчлөл, үүсэж байгаа нөхцөл байдалтай холбоотой энэ замыг аль болохоор түргэн шуурхай шиг оруулж өгөөрэй, битгий хасаарай гэдэг дээр 1 дүгээрт хүсэлт тавьж байна.

2 дугаарт энийг би Байнгын хороон дээр ч ярьж байсан, бүлэг дээр ч ярьж байсан. Ер нь энэ эрүүл мэндийн хувьд нийт хүн ардын Элэг бүтэн Монгол гэж байгаа, Эрүүл Монгол гэж байгаа, Эрт илрүүлэг гэж байгаа, Эрүүл шүд гэж байгаа. Энэ мэдээ мэдээллийн датаг би ил болгоод өгөөч, харъя, ямар өвчлөл нь буурсан юм юм бэ, нас баралтыг багасгасан уу? Бид нарын хэрэгжүүлж байгаа интервенц нь яг зөв явж байна уу, судалгаа шинжилгээ дээр үндэслэгдэж байна уу, үгүй юү? Жишээлбэл эрүүл шүд гээд тэгэхэд чинь бараг 80 хувийн хүүхдүүд нь шүдний цооролттой гээд гарч байна. 5-аас доош насны хүүхдүүдийн хамгийн гол өвчилж байгаа шалтгаан нь амьсгалын замын хурц халдварт өвчин гэж байна.

2017 онд Хүнсний баяжуулалтын хуулийн суурь судалгааг бид хийсэн. Гурилыг баяжуулах, тосыг баяжуулах, сүүг баяжуулах, гурвууланг нь баяжуулахад ямар үр нөлөө эрүүл мэндэд гарах вэ гэдэг дээр. Энэний мэдээ мэдээлэл, мониторинг инибилюшн гэж ярьдаг юм. Энийг хийсэн үү, хийх гэж байна уу? Энэтэй холбоотой өвчлөлийг бууруулах маш том бодитой судалгааны үр дүн гарчихсан байгаа. Энийг анхаарч өгөөч. Энэ дээр мэдээ мэдээллийг бид нарт ил болгож өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Ганмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь бид энэ цаашдаа энэ хийгдэж байгаа энэ үйл ажиллагаануудынхаа мэдээ мэдээллийг ил тод, ялангуяа энэ судалгааны материалд ашиглахад энэ боломжтой байдлаар нээлттэй болгоё гэж байгаа юм. Цаашдаа хийгдэж байгаа ялангуяа энэ эрт илрүүлэг, түрүүний хэлсэн энэ нярайн, сургуульд суурилсан эрт илрүүлгийн энэ асуудлуудыг. Энэ өнгөрсөн хугацаанд манай улсад сүүлийн 3 жил хийгдсэн эрт илрүүлгийн тайлан мэдээлэл энэ бүх зүйлийг ил, нэг газраас авдаг энэ мэдээллийн санг нь бид бий болгоё гэж байгаа.

Жишээ нь бид 6 настай хүүхдүүдэд хийгдэж байгаа энэ нүд, шүд, зүрхний үзлэгийн энэ мэдээллийг бол ил тавиад явж байгаа. Өнөөдрийн байдлаар гэхэд 6 настай 20 мянга гаруй хүүхэд энэ үзлэгүүддээ орчихсон байна. Яг хэдэн хувь нь 21 хувь нь нүдний өөрчлөлттэй байна, 85 хувь нь шүдний өөрчлөлттэй байна, 11 хувь нь зүрх судасны системийн өөрчлөлттэй байна гээд энэ мэдээллүүдийг шууд бүгдийг нь аваад, хараад ингээд явах боломжтой байдлаар зохион байгуулалтыг хийж байгаа. Тэгэхээр цаашдаа бол энэ мэдээллүүд бүгдээрээ илүү их энэ судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн байдлаар ил тод тавигдаад явна гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж асууя.

**Д.Ганмаа:** Хүнсний баяжуулалт хийсэнтэй холбоотой Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан хэсэг, ажлын хэсэг явагдсан. Тэр



баяжуулалт ямар шатдаа явж байна вэ? Судалгаа хийсэн юм байна уу? Баяжуулалт явагдсанаар өвчлөл бодитойгоор буурах ёстой. Буурахгүй байгаа нь ямар учиртай юм бэ? Implementation шат дээрээ, хэрэгжүүлэлт дээрээ унаад байна уу, яагаад байна вэ? Энэ дээр мэдээ мэдээлэл хариулах хүн байна уу?

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгөх, Гантөмөр сайд хариулах уу Ганмаа гишүүний асуултад. Тогтмолын Мөнхсайхан гишүүн сайд нэмж хариулъя.

**Т.Мөнхсайхан:** Энэ эрүүл мэндэд бол энэ хүнсний бүтээгдэхүүнүүдийн ялангуяа хүнсний хэрэглээ, зөв зохистой хэрэглээний асуудал бол сөрөг нөлөөлөлтэй байгаа судалгаанууд маш их гарч байгаа шүү дээ. Жишээ нь хорт хавдрыг үүсгэж байгаа шалтгааны 35 хувь нь хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой, зөв зохистой хэрэглээтэй холбоотой байна гэж байгаа юм. Энэ дээр бид нэг гол авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол энэ хүнсний нэмэлт баяжуулсан бүтээгдэхүүнүүд байгаа. Манай улсын хувьд бол өнгөрсөн хугацаанд нэлээдгүй ийм, жишээ нь иоджуулсан давсыг бид хэрэглэснээрээ нэлээн том өөрчлөлт хийгдэж байсан бол цаашдаа бид жишээ нь шүдэн дээр бол энэ шүдний өвчлөлийг бууруулахын тулд энэ хүнсний хэрэглээний сүүг фторжуулах энэ асуудлыг бид шийдэх гэх мэтчилэн энэ хүнсний бүтээгдэхүүнүүдийг нэмж баяжуулах энэ асуудал бол хүүхдүүдийн ялангуяа эрүүл мэндэд их туйлын чухал.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 8 Улсын Их Хурлын гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

**С.Эрдэнэбат:** Маш товчхон санал хэлчихье. Түрүүн Сангийн сайдаас асуусан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал хуулиараа тооцоод үзэхээр нийт төсвийн 0,5 гэхээр 130 тэрбум төгрөг уг нь бол байх ёстой. Сая андуураагүй бол 3,5 гээд хэлчихлээ. Тэгэхээр бүх энэ төсөв захирагч нарт хуулиар олгогдсон үүргийнхээ дагуу тэр 0,5 хувийн зардлыг гарга гэдэг байдлаар энэ төсөвт оруулж болох уу?

Энэ утааны улирал гээд хүмүүс нэлээн асуудал дэгдээгээд байх шиг байна. Утааны хордлогын улмаас, энэ утааг нь дийлэхгүй юм гэж бодоход, тэр хордлогыг нь сааруулах, хуульдаа байдаг ажилтнуудынхаа тэр уушги, эрүүл мэндийн үзлэгийг жилд яг ийм үед бол дор хаяж 2-оос доошгүй удаа хийх энэ тэр гээд. Тэгээд ийм байдлаар нэг шийдчихэж болохгүй юу? Тусгайлан зардал бол мэдээж бол тавихгүй. Төсөв дотор, дотор нь байгаа төсвийнхөө 0,5 хувийг нь ингээд шийд гэдэг байдлаар бүх төсөв захирагч нарт Улсын Их Хурлын төсөв дагасан тогтоолоор тийм чиглэл өгөөд, шийдэх боломж гаргаж өгөөч гэдэг ийм санал хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Оройн мэнд. Ерөнхийдөө төслийг дэмжиж байгаа. Хэдүүлээ тэгээд шуурхай батлаад явъя. Ер нь өнөөдөр Улаанбаатарт амьсгалмаар байна гээд жагсаал цуглаан болсон байна. Энэ утааны нөхцөл байдал үнэхээр амаргүй хэцүү байна. Энэ шийдэл нь ерөөсөө л эрчим хүч, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлж, эргээд энэ орон сууцжуулах бодлогыг л дэмжих асуудал байгаа. Тэгээд энэ бодлогыг хэрэгжүүлэхэд дэд бүтцийн нэг хэсэг болсон цэвэрлэх байгууламж жишээ нь ингээд саатаж байх жишээтэй.

Эргээд энэ гадаад худалдааны тэнцэл дээр хамгийн их алдагдал хүлээдэг нефть бүтээгдэхүүний худалдан авалт дээр 1 тэрбум төгрөгийг, 1 тэрбум долларыг бид зарцуулж байгаа шүү дээ. Энийгээ багасгах, нефтийн үйлдвэрийг буюу боловсруулах энэ үйлдвэрийг санхүүжүүлэх төсөв ирэх жил ингээд 2 дахин багасаад явчхаж байна. Гэх зэрэг энэ мега төслүүд гэж хэлж болох ерөнхийдөө улс орны эдийн засгийн суурь асуудалд нэлээн түлхэц өгөх, энэ хэмжээгээрээ бид экспортыг дэмжих, импортыг орлуулах бүтээгдэхүүнийг оруулж ирэх энэ зүйлүүд дээрээ хөрөнгө оруулалтыг нэлээн нэмэгдүүлэх бодлогыг барихыг ажлын хэсэг гарвал хичээж ажиллаач гэдэг зүйлийг би хүсэж байгаа юм. Энэ дээр ч гэсэн бас яах вэ ер нь зарим хувилбарыг би бол хэлсэн. Төрийн албан хаагчдын олгох цалингийн нэмэгдлийг 7 сарын 1-нээс олгоё. Энэнээсээ хэмнэх зардлыг ийшээ оруулъя гэдэг зүйл байгаа.

2 дугаарт энэ хувийн хэвшлийн сургуулиудад олгож байгаа дунд сургууль, ерөнхий боловсролын сургуульд олгож байгаа хувьсах зардлыг больё. Үүнийхээ оронд харин 3 ээлжээр хичээллэж байгаа болон тэр дотуур байр, энэ шаардлагатай тоног, төхөөрөмжийг нь орлуулах ажил дээр зарцуулъя гэж байгаа юм.

Дээрээс нь нэг зүйл байна. Энэ яамнуудын ажил чиг үүрэгтэй маш их хэмжээний давхацсан энэ комисс, хороо, үндэсний зөвлөлүүдийг буулгах ажлыг зоригтой хийчихмээр байна. Энэ байгууллагууд үндсэндээ яг бие дааж нэг их сүртэй ажлууд хийж байгаа юм алга. Тэгээд ерөөсөө хурал зөвлөгөөн зохион байгуулаад, яамнуудын ажилтнуудыг дуудаж, ингэ тэг гэсэн баахан чиглэл өгсөн, бичиг явуулсан ийм зүйл байна. Тэгээд би энийг бол нэр заагаад хэлмээр байгаа юм. Хуультайгаас бусад комисс, үндэсний зөвлөл, хороодыг буулгаж, энэнээс үүссэн хэмнэлтээрээ төрийн албан хаагчдынхаа цалин энэ тэрийг нэмэгдүүлье. Ингэж яг энэ бодитой юмнуудыг шийдээд явахгүй бол болохгүй байна.

Тэгээд ер нь төсвийн бодлого, зарчим дээрээ нэг зүйлийг баримтлаач гэж хүсэж байгаа юм. Бяслагийн үйлдвэр гээд бид хэд ярьж байгаа юм. Уг нь тэр бяслагийг онцлогийг нь харуулсан тэр газар зүйн заалт буюу яагаад энэ бяслал чанартай, үнэтэй байх ёстой вэ гэдэг газар зүйн заалтын судалгааг нь төр энэ аймаг аймгаар нь хийж өгмөөр байна. Энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлье гэвэл ерөөсөө энэ шүү дээ. Тэгэхээр бид магадгүй Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын өвс ногоо ийм онцлогтой учраас энийг идсэн өвс нь ийм сүү гаргаад, ийм бяслал чанартай байгаа юм гээд. Ингэж байж бид нарын нөгөө энэ газар зүйн заалт дээрээ бяслал цаашдаа өрсөлдөх чадвартай, үнэд хүрдэг ийм зүйл байна гэх зэрэг. Энийг би зүгээр жишээ аваад ярьж байгаа юм. Ийм зүйлүүд дээр зарчмаар бид ханддаг баймаар байгаа юм. Бусдыг нь хувийн хэвшил хийж чадна шүү дээ.

Тийм учраас одоо Улсын Их Хурлын ажлын хэсэг гарна. Ажлын хэсэгт ажиллах нөхдөдөө би энэ чиглэлдээ бол анхаарч өгөөч гэдэг зүйлийг л би хүсэж байна. Тэгээд энэ улс орныхоо цаашдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, тэтгэврийг нэмэгдүүлэх, хүүхдийн мөнгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил, бизнес хийх орон зайг тэлэх тэр суурь дэд бүтцүүддээ хэдүүлээ яаж ийж байгаад нэг орон зай гаргаж өгье. Ингэж байж бид харин бодитойгоор цаашдаа тогтвортой эдийн засгаа тэлж, тэтгэврийг нэмэх, цалинг нэмэх, хүүхдийн мөнгийг нэмэх бололцоо бүрдэнэ шүү. Түүнээс биш өнөөдөр бүх зүйл сайхан болох гэж байгаа юм шиг, урсгал зардалдаа

дарлуулчихсан ийм байдлаар явж болохгүй гэдэг зүйлийг хэлмээр байна. Тэгээд хуулийн төслийг дэмжиж байна.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн үг хэлнэ.

**П.Мөнхтулга:** Сая нэлээн олон гишүүдээс энэ бүсчилсэн хөгжлийн загварын тухай асууж байна. Яг тодорхой хариултууд сайдууд хэлсэнгүй. Хаана яг юу баригдах юм бэ, аль бүс дээр ямар хөдөө аж ахуйн үйлдвэрүүд баригдах юм бэ? Сая төсөв дээрээс харж байхад 800 сая төгрөгөөр Хөдөө аж ахуйн яам нүүчихсэн байсан. Улаанбаатар хот өнөөдөр түгжрэл, утаандаа баригдчихсан, төвлөрлөө саармагжуулж чадахгүй байгаа. Тэгэхээр 800 сая төгрөгөөр Хөдөө аж ахуйн яамыг дагаад 40 аж ахуйн нэгж Дархан хот руу нүүсэн статистик байна. Улаанбаатар хотын Зайсангийн хэсэгт 40 мянга гаруй иргэд, өглөө болгон 10 мянга гаруй оюутнуудтай Зайсангийн Туулын нарийхан гүүрэн дээр 2, 3 цаг түгжирдэг. Зайсанд хөдөө аж ахуйн ямар ч судлагдахуун байхгүй. Зайсанд газар тариалан байхгүй, Зайсанд 5 хошуу мал байхгүй, Зайсанд сарлаг байхгүй. Тэгэхээр энэ Хөдөө аж ахуйн сургууль яагаад заавал Зайсанд байх ёстой юм. Хөдөө аж ахуйн сургуулийг дараагийн нэг бүс рүү, бид бүсийн бүсчилсэн хөгжлийн загварыг тодорхойлохдоо тухайн бүсийн эдийн засгийг дэмжих гэж хийж байгаа юм. Тэгэхээр Хөдөө аж ахуйн сургуулийг судлагдахуунтай бүс нутаг руу нь шилжүүлбэл яасан юм бэ? Хангайн бүс бол сарлагтай, дээрээс нь дэд бүтэц нь бэлэн байгаа.

Багшийн сургууль гээд 1500 оюутны хүчин чадалтай сургууль байгаа. Тэгэхээр Боловсролын сайдад маш тодорхой санал хэлэх гээд байгаа юм. 800 сая төгрөгөөр бүтэн яам нүүгээд, маш олон аж ахуйн нэгжийг дагуулаад төвлөрлийг саармагжуулж болж байна. Хөдөө аж ахуйн сургуулийн тодорхой хэсэг факультетыг судлагдахуунтай газар луу нь нүүлгэх саналыг маш тодорхойгоор тавьж байна. Тэнд барилга байгууламж, боловсон хүчин бүх юм нь байгаа. Тийм болохоор энэ төсвийн хэлэлцүүлгийг, төсвийн хэлэлцүүлгийн явцад энэ дээр та нэг бодлого боловсруулж оруулж ирээч. Би зарчмын зөрүүтэй санал гаргая. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үг хэлнэ.

**О.Номинчимэг:** Товчхон үг хэлье. Ерөнхийдөө төсвийн төслийг дэмжиж байна. Гэхдээ нэг зүйл анхааруулж хэлмээр байна. Ялангуяа Засгийн газрын сайд нарт. Гишүүдээс асуулт асуухаар дутуу дулимаг эсвэл тойруулж хариулж байна. Энэ гишүүдээс гарч байгаа тэр 10 сая төгрөгийн төлбөртэй хувийн сургуульд хувьсах зардлыг бууруулах тал дээр санал нэг байна. Тэгээд баахан зовлон тоочдог, 3 ээлж гээд тоочдог, гэхдээ хувийн ингээд 10 сая төгрөгийн үнэтэй сургуулиудад хувьсах зардал өгөөд байгаа чинь хэр шударга юм бэ? Энэ дээрээ тодорхой юмаа хэлэхгүй, Наранбаяр сайд зайлсхийгээд байна шүү.

Түрүүн хэлсэн, төрийн бүтээмжийн талаар хэлэхэд бараг энэ миний хэлсэн юмыг ойлгоогүй Гантөмөр сайд хариу хэлж байх шиг байна лээ. Тэгэхээр хүний ярьж байгаа өнцгийг ойлгосныхоо дараа шууд нэг ийм хамгаалалтад орно гэхээсээ илүү жоохон ойлгож байгаад хариулмаар байна. Бас нэг юман дээр маш тодорхойгүй байна. Тэр нь юу вэ гэхээр энэ жилдээ бид алдагдалгүй төсөв баталж байгаа юм байна. Гэхдээ 25, 26 онд 26, 27 оны төсвөө заавал алдагдалгүй батлах ямар шаардлага байгааг би ерөөсөө сайд нарын үгнээс хариуцсан сайд буюу

Эдийн засаг, хөгжлийн сайд, Жавхлан сайдын үгнээс би ойлгосонгүй. Тэгээд энэ маань өөрөө эдийн засаг тэлэхэд эсвэл боломжоо алдахад ямар нөлөөтэй байгаа дээр дорвитой ерөөсөө мэдээлэл авсангүй. Энийг Улсын Их Хурал хэлэлцүүлгийн шатдаа эргэж харж, дараа дараагийн төсөв дээр бид ямар бодлого баримтлах ёстой вэ гэдгээ дахиж нухацтай харах ёстой гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Жудагийн Баярмаа гишүүн үг хэлнэ.

**Ж.Баярмаа:** Ямар ч байсан дэвшил гарч байна. 2,3-аас 4 их наяд буурна гэдэг бол маш том дэвшил. Тэгээд төсөв мэдээж энэ төрийн мөнгөний бодлоготойгоо уялдах ёстой. Тэгээд энэ Монголбанкны судалгаа дээр байна шүү дээ. ДНБ-д эзлэх хувь нь 37 аравны жишээлбэл 7 байхад л 1-ээс 2 хувийн инфляцыг өдөөдөг гээд. Манай Монголбанк өөрөө энэ судалгаандаа дүгнэчихсэн байгаа юм. Тэгэхээр би яах вэ дахиад нэг давтаад нэг зүйлийг хэлэхийг хүсэж байгаа нь юу гэвэл энэ дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг хэтэрхий өөдрөгөөр төсөөлөөд байна. Ярих юм байхгүй, хэтэрхий оптимист байна, ядаж реалистик буюу жоохон бодит баймаар байна.

Өмнөх жилүүдийнхийг харьцуулбал энэ яагаад ч 95 их наядад хүрэхээргүй байгаа юм. Тэгэхээр угаасаа түрүүн ч зөндөө олон хүн, би ч хэлсэн. Олон улсын байгууллагууд бол манай эдийн засгийн өсөлтийг багаар тооцоод байгаа. Тэгэхээр эргээд нөгөө олох орлого бүх зүйл нь багасаад ирэхийн цагт бид нарын нөгөө алдагдалгүй баталсан төсөв маань хасах руу орох вий дээ гэсэн ийм аюул байгаа. Тэгэхээр нэмэхтэй баталж байж магадгүй янз бүрийн эрсдэл гарсан тохиолдолд тэр нь нөхөгдөж баланс буюу жинхэнэ ийм алдагдалгүй төсөв болох вий гэж ингэж бодож байгаа юм.

2 дугаарт энэ нөгөө шилжих төсөв дээр маш их мафаан байдаг. Түрүүн бас зөндөө ярьсан. 3-аас 4 дахин, 5 дахин нэмэгдчихсэн. Тэгэхээр магадгүй энэ шилжих төсөв ер нь яагаад ингээд нэмэгдээд байдаг тал дээр Улсын Их Хурал маш их хариуцлагатайгаар хяналт шинжилгээ хийх ёстой байх. Магадгүй энэ дээр сонсгол, нөгөө нийтийн сонсгол, түр хороо энэ тэр байгуулж, энэ яагаад ийм 5, 6 дахин нэмэгдээд байдаг дээр Улсын Их Хурал хяналт шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзэж байна. Яагаад гэвэл бид энд ерөөсөө тэр дүнг бид тогтоохгүй байгаа байхгүй юу. Барилгын хөгжлийн төв тогтоодог. Гэтэл яг яаж тогтоогоод юун дээр суурилад байгаа нь тодорхойгүй. Энэний ард дандаа нөгөө авлига, хээл хахууль явдаг гэдэг яриаг бол бид бүгд мэддэг. Тэгээд нэг тодорхой тооны компаниуд байнга тендерт ороод авч байдаг гэж байгаа юм. Тэгээд тэнд хар жагсаалт гэж байхгүй. Тэгээд дахиад авч байдаг, дахиад балардаг. Хугацаандаа юмаа хийж чадахгүй, дахиад л авдаг нэг ийм. Тэгэхээр энэ төсөвт өртгүүд яагаад асар ихээр нэмэгдээд байгаа дээр Улсын Их Хурал ер нь нэг дорвитой арга хэмжээ авч, хяналт шалгалт, нийтийн сонсгол, бараг түр хороо байгуулж ажиллах нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байгаа.

**Д.Амарбаясгалан:** Тилеуханы Аубакир гишүүн үг хэлье.

**Т.Аубакир:** Энэ жилийн төсвийн хувьд тодорхой хэмжээний алдагдалгүй болгоод, хэмнэлт хийсэн байдалтай төсөв баталж байна даа. Тэгээд ирэх жилүүдэд эрхэм сайдуудад буюу Засгийн газрын гишүүдэд хэлэхэд шилжиж байгаа төсөл хөтөлбөрүүд бий. Энэ чинь 20, 19 онд, 20 онд, 17, 8 онуудад хийгдсэн төсвөөр явж байгаад зогсчихсон, шийдэх ёстой, зайлшгүй шийдэх ёстой ийм

хөрөнгө оруулалтуудын ажлууд зогсчихсон байгаа. Энийг бид нэгэнт тэр улсын төсөвт тодорхой хэмжээний өчнөөн тэрбум төгрөг газар ухаад л фундаментыг нь цутгаад хаячихсан, хаячхаж бас болдоггүй, шийдвэрлэх ёстой нийгэм, эдийн засгийн зайлшгүй шаардлага бий болчихсон ийм хөрөнгө оруулалтууд дээр анхаараад явах нь зөв байх.

Тэгээд энэ 2024 оны парламентын сонгууль бол их онцлогтой болсон. Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмээд, пропорциональ, мажоритар тогтолцоогоор оруулж ирсэн. Миний хувьд бол энэ удаагийн парламентад сэтгэл хангалуун байна. Хэдий яах вэ дээ тэгээд нийгэмд хоорондоо маргалдаад, мэтгэлцээд, нэг нэгийгээ элдвээр хэлээд байгаа юм шиг харагдаж байгаа боловчиг парламент чинь өөрөө мэтгэлцээний талбар. Би энэ шинээр орж ирсэн гишүүдэд талархалтай хандаж байгаа. Өмнөх парламентууд ч гэсэн Монгол Улсын түүхэнд тийм муу үүрэг бас гүйцэтгээгүй шүү. Өмнөх парламентын үед яаж явж байсан юм пүүх паах байх гээд байх юм ерөөсөө байхгүй. Энэ цаг үеийнхээ хувьд 126 болоод тодорхой хэмжээнд жагсаалтаар орж ирээд, зарим нь тойргоос гарч ирсэн хэдий боловчиг яг өнөөдрийн энэ асуудалд хандаж байгаа, өөр өнцөг гарч ирж байгаа, манай жагсаалтаар гарч ирсэн гишүүдийн дэвшүүлж байгаа санал бодол энэ тэр бид сая орон нутгийн сонгууль дээр та бүхнээр бахархаад л явсан. Бас л олон ургалч үзэл гарч ирж байгаа.

Тийм учраас хэдүүлээ ингээд нэг парламентаа муухай харагдуулж байгаа юм шиг, өмнө нь та нар яаж явж байсан юм, бид л ингэлээ ийм байдалтай байж болохгүй. Бид нарын урд чилийсэн 3 жил хагас хугацаа байна. Тийм учраас бид нэг нэгийгээ ойлголцоод, та бүхний гаргаж тавьж байгаа, дэвшүүлж байгаа санал санаачилгыг бид тууштай дэмжээд явна. Бид хамтраад өнөөдрийн энэ төсвийг хэлэлцэж байгаа юм шиг тал талаас нь шинэ санал бодлуудаа дэвшүүлээд, олонхын саналыг хүндэтгээд ингээд цаашдаа явах ёстой. Тийм учраас дараа дараагийн төсөв дээр алдагдалгүй гээд байхаасаа илүү үр дүнтэй төсөв батлах тал дээр ялангуяа манай эдийн засагч гишүүд маань илүүтэй анхаарах ёстой тэгээд. Тийм учраас дараа дараагийн төсвүүд дээр зайлшгүй шийдэх ёстой яг тойрог дээр үнэхээр тулгамдчихсан асуудлууд байдаг юм шүү. Энэ дээр нэг хэтэрхий нэг тийм өөр өнцгөөс хандаад байх, гайхаад байх зүйл ерөөсөө байхгүй.

Манай аймгийн хувьд ч гэсэн шийдэх ёстой, зайлшгүй шийдэх ёстой утааны асуудал байж байна. Бид дулааны 2 дугаар эх үүсвэрийг Баян-Өлгий аймаг дээр, ганцхан Баян-Өлгий ч биш байх. Би зүгээр тойргийн асуудал ярьж байгаа учраас. Утааны асуудал бол Улаанбаатар хотоос аймшигтай түвшинд л байгаа. Энийг бид шийдмээр байна. Хүн амын өсөлттэй уялдуулаад бид сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ шаардлагыг хангах зайлшгүй асуудлууд байна. Бид нар энэ нутгийн зам хөтөлбөрийн хүрээнд сумдаа засмал замаар холбох зайлшгүй шаардлага байна. Зарим боомтуудын сэргэлтийн хүрээнд бид боомтуудаа засмал замаар холбох зайлшгүй шаардлага байна. Бид хэмнэж байгаа нь тэр гээд л явж байгаа төсөл хөтөлбөрөөс шууд танаад ингээд яваад байдаг байдлаа эргэж харах нь зөв байх. Тэгээд анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн үг хэлнэ.

**Х.Булгантуяа:** Сая ер нь төсвийн хэлэлцүүлгийг би бүрэн сууж сонслоо. Тэгээд би нэг хэдхэн саналыг хэлэх гэсэн юм. 1 дүгээрт гишүүдээс маань энэ нэг хувийн сургуулиуд мөнгө аваад байна, хувийн эмнэлгүүд мөнгө аваад байна



үүнийг болиулмаар байна ч гэдэг юм уу, хувийн хэвшил рүүгээ дайрсан тийм нэг саналууд цухалзаад байх юм. Бид, хэрвээ ингэх юм бол төр бүгдийг хийдэг нийгэм болно шүү. Бид яг үнэнийг хэлэхэд ардчилсан нийгмийг, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлнэ, төр заримаас нь татгалзаад, хувийн хэвшил маань ашгаа олоод, хувийн хэвшил маань бэхжээсэй гэж бодож байгаа бол бид үүнээсээ татгалзах хэрэгтэй шүү. Эсрэгээрээ бид үүнийг харин бий болгоно гэж дэмжээд, эрх зүйн реформуудыг нь хийгээд, эхнээсээ зарим нь ашиг олж байг л дээ. Ашиг олдоггүй хувийн хэвшил гэж юу байсан юм бэ. Хэрвээ түүнийг хийх гэж байгаа бол төр бүгдийг нь хийе, төсөв маань харин даахгүй шүү. Тэгэхээр энэ бол өөртөө, бид өөрөө өөрсдөдөө юу яах хэрэгтэй, үнэлэлт дүгнэлт өгөх хэрэгтэй.

Дээрээс нь нэмээд бид 2017 онд, эдийн засаг 2016 оны 3 дугаар улиралд хасахтай гарч байсан. 2017 онд бид Валютын сангийн хөтөлбөрт ороод, төсөв төр тэр чигээрээ бид бүсээ чангалсан. Түүний шийдвэрүүдийг хамтдаа гаргалцаж байсан манай гишүүд ч гэсэн сууж байна. Аймаг, орон нутагт бараг Орон нутгийн хөгжлийн санд нохойгоо алах мөнгөгүй боллоо шүү дээ гэж ярьж байсан цаг үе байсан. Тийм болтол нь бид чангалж байсан. Төрийн албан хаагчдыг 2 төрийн албан хаагч тэтгэвэрт гарахад оронд нь ганцханыг авна гэдэг шийдвэр хүртэл бид гаргаж байсан. Зарим татваруудыг нэмж байсан, НДШ-ийн хувь хэмжээг нэмж байж Нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулж байсан.

Одоо бүгдийг нь эсрэгээр нь больё гэвэл энэ үр дагавар ахиад л 5, 6-хан жилийн дараа дахиад давтагдана шүү. Валютын сангийн хөтөлбөрт дахиад бид нарт орох нэг их тийм хол бас биш шүү. Өнөөдрийн нэг нүүрсний үнэ, зэсийн үнэ дээр бүгдээрээ дөрөөлөөд арай гэж нэг хийсэн зарим нэг амжилтуудаа ухраая гэвэл энэ бол улс төржөөд ухраая гэвэл их амархан шүү. 2019 онд арай гэж эдийн засаг сайжраад, Валютын сангийн хөтөлбөрөөс гарангуут бид цар тахалтай нүүр тулсан. Тэр үед бол ерөөсөө эрүүл мэндээ хамгаалъя, иргэдийн амьжиргааг жоохон дэмжье гэдэгт бүх зүйл чиглэгдсэн. Тэгээд түүний дараагаар арай гэж эдийн засгаа тэлэх гэж байсан энэ цаг үед бид хэдүүлээ улс төржих юм бол, хэт улс төржих юм бол эсрэгээрээ үр дагавар гарна шүү.

Тэгэхдээ яах вэ Их Хурлын гишүүдээсээ бид хамгийн том зүгээр бодох ёстой юм нь Эдийн засаг, хөгжлийн сайдыг Гантөмөр сайдыг Эдийн засгийн хөгжлийн яамыг бид байгуулахад төсөв ярьдаг 2 хүнтэй болохоосоо илүүтэйгээр эдийн засгийн зөв загвараа бүгдээрээ яг бодитоор гаргадаг ийм яамтай болох юм сан л гэж байгуулсан гэж би бодож байгаа. Хэдүүлээ социал демократ загварыг сонгох юм уу. Тэгвэл төр өөрөө нийгмийн даатгалыг, боловсролыг, эрүүл мэндийг бүгдээрэнг нь төр өөрөө хариуцдаг ийм нийгмийг тэгвэл бий болгоно гэсэн үг. Хэрвээ тэгнэ гэх юм бол бид нарын татвар, шимтгэлүүд эсрэгээрээ өндөр болно гэсэн үг. Хэрвээ хувийн хэвшил хариуцдаг, хувь хүн өөрөө хариуцдаг тэтгэвэртэй байх уу, үгүй юу, нийгмийн хамгаалалттай байх уу, үгүй юу, сайн сургуульд хүүхдээ өгөх үү, үгүй юу, сайн аймаг, дүүрэгт амьдрах уу, үгүй юу гэдгээ татвараараа хүн өөрөө сонгодог ийм нийгмийг байгуулъя гэвэл арай өөр загварыг сонгоно гэсэн үг.

Одоо манайх алдагдал төсөв яагаад байнга үйлдвэрлээд байна вэ гэхээр манай орлого нь болохоороо либерал, зарлага нь болохоороо социал демократ. Төр бүгдийг хариуцах ёстой гэдэг. Өгөх болохоороо үгүй ээ бид өгмөөргүй байна гэдэг. Ингээд энэ хоёрын дундаас бол төсөв үргэлж алдагдал үйлдвэрлэнэ. Энэ жил хэдүүлээ 2025 оныхоо төсөв дээр нэг жоохон бараа, бүтээгдэхүүний үнэ гайгүй байгаа учраас яах вэ алдагдалгүй төсөв баталж болно. Тэгэхдээ хэрвээ хэдүүлээ

энэ олон хувийн сургуулиудыг хаая гэж байгаа бол, санхүүжүүлэхгүй гэж байгаа бол, хувийн эмнэлгүүдийг ажиллуулахгүй гэж байгаа бол ЭМД-ын шимтгэл төлж байгаа би зөвхөн төрийн эмнэлгээр үйлчлүүлэх ёстой гэж байгаа бол арай өөр нийгмийг бүтээх ёстой шүү. Тэгээд тийм бодлогоо хэрвээ бид өнөөдөр боловсруулж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт явагдана. Санал хураалт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 69 гишүүн дэмжиж, 66,3 хувиар санал дэмжигдлээ. Миний саналыг дэмжсэнд протоколд бүртгүүлье, төхөөрөмждөө уншуулж чадсангүй. Батжаргал, Жигжидийн Батжаргал гишүүнд микрофон өгье.

**Ж.Батжаргал:** Дэмжиж санал өгсөн, хурууны хээ уншигдаж, төхөөрөмж дээр дэмжсэнээр гарсангүй. Тийм учраас протоколд дэмжсэнээр тусгаж өгөхийг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Хэрлэн гишүүн.

**Б.Хэрлэн:** Протоколд дэмжсэнээр тэмдэглэнэ үү, би хоцорчихлоо.

**Д.Амарбаясгалан:** 2 гишүүн дэмжиж, протоколд нэмж тэмдэглүүлээ. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороод, мөн Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлээ.

23.24 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулган өндөрлөснийг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.УЯНГА